НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

# БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
# /2025 оны жилийн эцсийн/

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

## АГУУЛГА


**БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ........ 8**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ........ 9**

**1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** ........ 10

**1.2. Авто үйлчилгээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, авто үйлчилгээний салбарт баталгаат үйлчилгээний тогтолцоог сайжруулна. 9.3.19.** ........ 13

**1.3. Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх ажлын хүрээнд зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлнэ. 9.3.21. НХТ 2025-106, НХТЖҮЧ-9.21.2.** ........ 15

1.3.1 Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ, чиглэлийг оновчилж, хүн амын нягтаршилд тохируулан нийтийн тээврийн хэрэгслийг хүртээмжтэй байдлаар төлөвлөх ажлын хүрээнд: ........ 15

1.3.2 Нийтийн тээврийн үйлчилгээнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, бодит шийдэл гаргах, сүлжээний төлөвлөлтийн оновчтой хувилбар, загварыг боловсруулах систем хөгжүүлэлтийг хийлгэн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн судалгаа, шинжилгээний байгууллагуудтай холбогдох уулзалтуудыг зохион байгуулж ажилласан талаар: ........ 17

1.3.3 Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх ажлын талаар: ........ 19

1.4.1 Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолтой чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулж салбарын чадавхыг бэхжүүлэх талаар: ........ 20

1.4.2 Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолын барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж ажилласан талаар. ........ 24

1.4.3 Нийтийн тээврийн чиглэл, зогсоолын мэдээллийн санд баяжилт хийсэн талаар. ........ 24

**1.5. Сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ. 9.3.23.** ........ 29

**1.6.Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлнэ. 9.3.25.** ........ 31

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙТИЙН ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ, НАЙДВАРТАЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАМААР ХУВИЙН АВТОМАШИНЫ ХЭРЭГЛЭЭГ БАГАСГАЖ, НИЙТИЙН ТЭЭВРЭЭР ЗОРЧИХ ЗОРЧИЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ. НЗДҮАХ-1.5. ........ 33**

**2.1. Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолтой чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулж салбарын чадавхыг бэхжүүлнэ. НЗДҮАХ 1.5.2. гэсэн тэргүүлэх зорилтын хүрээнд:** ........ 33

2.1.1Нийтийн тээврийн хэрэгслийн замналын дагуух саравчтай болон дулаан зогсоолуудын тоог нэмэгдүүлэх; НХТЖҮЧ-9.22.3 ........ 33

2.1.2.Нийтийн тээврийн автобусны дулаан зогсоолуудыг камерын нэгдсэн хяналттай болгох ажлын хүрээнд УБЗАА-нд санал хүргүүлнэ. ........ 34

2.1.3.Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчтой төлөвлөн эрэлтэд нийцсэн нийтийн тээвэр, зорчих зогсоолыг хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ. НЗДҮАХ-1.5.1 ........ 35

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ. МУХТ 2025-2.2.2 ........ 38**

**3.1. Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох МУХТ 2025-2.2.2.3.** ........ 38

**3.2. Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих НХТ 2025-111**... 39

**3.3.Хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлт хийж гүйцэтгэнэ.** ........ 39

**3.4.Нийтийн тээврийн мастер төлөвлөгөөнд санал тусгах НХТ 2025-98, НХТЖҮЧ-9.23.1** ........ 40

**3.5.Дүүжин замын тээвэр, Метро, BRT, Трамвай төслийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд мэдээ, мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж хамтран ажиллах. НХТ 100, 101, 102, НХТЖҮЧ 9.21.1. МУХТ 2025-2.2.2.1, 2.2.2.2.** ........ 42

3.8.1.Тодорхой төрлийн нийтийн тээврийн төрөл, автозамын төсөл арга хэмжээний талаар. ........ 42

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: ........ 46**

**4.1.2025 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу үндсэн үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж** ажиллана. ........ 46

**4.2.2025 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.** ........ 47

**4.3.Улаанбаатар смарт карт ХХК-аас ирүүлсэн тухайн сарын ажлын гүйцэтгэл, шугамын орлого, зорчигчийн мэдээг хянаж машин цагийн зардлын санхүүжилтийг тооцон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад олгоно.** ........ 48

**4.4.Сургуулийн автобусны санхүүжилт:** ........ 49

**4.5.Нийтийн тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж, орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийтийн тээврийн төлбөрийн систем нэвтрүүлнэ. НХТ-424.** ........ 50

**4.6.Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ.** ........ 51

**4.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу төрийн худалдан авах ажиллагааны (tender.gov.mn) цахим системээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана**... 52

**4.8.Холбогдох хуулийн дагуу нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих иргэдийн зорчилтын гүйцэтгэлд үндэслэн нөхөн олговрыг тээврийн үйлчилгээг эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад олгоно.** ........ 53

**4.9.Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах.** ........ 54

**4.10. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.** ........ 56

**4.11. Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.** ........ 57

**4.12.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.** ........ 57

**4.13.Тээврийн салбарын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хүрээнд:** ........ 58

4.13.1.Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, сунгах, цуцлах, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулах; ........ 58

**4.14.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.** ........ 63

**4.15.Тээврийн хэрэгслийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагуудыг мөрдүүлж, хяналтыг сайжруулах. НХТ-426** ........ 64

**4.16. Сонгинохайрхан дүүрэг /Тахилт/ 110 нийтийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний авто бааз барих ажилд санал хүргүүлнэ.** ........ 68

**4.17. Нийтийн тээврийн бүлэг хотын стандартыг мөрдүүлэхэд чиглэсэн сургалт, арга зүйгээр хангах, хяналт шалгалт зохион байгуулах.** ........ 68

**4.18. Нийтийн тээврийн стандарт, нормын талаар албан хаагчид, нийтийн тээврийн байгууллагуудад сурталчлан таниулах.** ........ 69

**4.19. Нийтийн тээврийн дулаан зогсоол хотын стандартын төсөл боловсруулж батлуулахад шаардлагатай тоон мэдээ, судалгаа гаргаж санал өгч хамтран ажиллах** ........ 84

**ТАВДУГААР БҮЛЭГ. "ДҮРЭМ"-ЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: /А/536/** ........ **85**

**5.1. Газрын "Дүрэм"-ээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллана.** ........ 85

**5.2. Нийтийн тээврийн үйлчилгээний зорчих үнэ, тариф, машин цагийн зардлыг шинэчлэн тогтоох талаар шаардлагатай тооцоо, судалгааг хийж санал боловсруулах, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хяналт тавина. Дүрмийн 4.1.1.1** ........ 86

**5.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангах Дүрмийн 4.1.2.1** ........ 87

5.3.1. Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ, чиглэлийг оновчилж, хүн амын нягтаршилд тохируулан нийтийн тээврийн хэрэгслийг хүртээмжтэй байдлаар төлөвлөх ажлын хүрээнд: ........ 88

**5.4. Хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн сүлжээ, төлөвлөлт, үйлчилгээний чиглэлийг тогтоох, чиглэл, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх, бүртгэл хийх, цагийн хуваарь тогтооно. Дүрмийн 4.1.2.2** ........ 91

5.4.1 Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх ажлын талаар: ........ 91

**5.5. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолын барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, тохижилт болон урсгал засварын нэгдсэн төсөв гаргаж хэрэгжүүлнэ. Дүрмийн 4.1.2.3** ........ 93

**5.6. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулна. Дүрмийн 4.1.2.4** ........ 95

**5.7. Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах. Дүрмийн 4.1.2.5** ........ 96

**5.8. Аюултай болон тусгай ачаа тээврийн зохицуулалтыг төлөвлөж, бүртгэх, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангана. Дүрмийн 4.1.2.6** ........ 100

**5.9.Ачаа тээвэр, логистикийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ачаа тээврийн үйлчилгээг зохион байгуулах, хөгжүүлнэ. Дүрмийн 4.1.2.8** ........ 103

**5.10.Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах Дүрмийн 4.1.3.1** ........ 107

**5.11.Нийтийн тээврийн салбарт дэвшилтэт шинэ техник, технологи болон шинэ төрлийн тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлэх, хөгжүүлэх, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлнэ. Дүрмийн 4.1.3.2** ........ 108

**5.12. Дэвшилтэт техник технологид суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн цогц үйлчилгээ, тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх, нийтийн тээврийн хөтөлбөрийн менежментийн систем, тоног төхөөрөмжийг суурилуулж бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, засвар үйлчилгээний ажлыг зохион байгуулна; Дүрмийн 4.1.3.3** ........ 108

**5.13.Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, өргөжүүлэх, программ хангамжийг сайжруулах, төлбөр төлөх системд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. Дүрмийн 4.1.3.4** ........ 112

5.13.1. “Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн систем”, Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн системийн программ хангамжид хөгжүүлэлт хийх санал боловсруулан хүргүүлж, хөгжүүлэлтийн явцад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна. ........ 112

**5.14. Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлнэ. Дүрмийн 4.1.4.1** ........ 119

5.14.1. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх; ........ 119

Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын жолооч нарт 20 минутын хот үндэсний хороо, Тээврийн Цагдаагийн албатай хамтран газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд хуваарийн дагуу 17 удаагийн сургалтыг зохион байгуулав. ........ 124

**5.15. Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автобус, таксины зогсоол, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ байранд саад учруулж буй тээврийн хэрэгслийг чөлөөлөх, хариуцлага тооцно. Дүрмийн 4.1.4.2** ........ 127

**5.16.Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, ачаа тээврийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулна. Дүрмийн 4.1.4.4** ........ 128

**5.17. Газар нь хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, чиг үүргийн удирдлагаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу ажиллана. Дүрмийн 6.5** ........ 129

**5.18. Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, дүрэм, журам баталж мөрдүүлнэ. Дүрмийн 7.1.1** ........ 130

**5.19. Батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд холбогдох хууль журмын дагуу ажилтнуудыг томилох, чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулна. Дүрмийн 7.1.2** ........ 131

**5.20. Хэлтэс /нэгж/-ийн дарга, төрийн захиргааны албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Дүрмийн 7.1.3** ........ 132

**5.21. Сахилга, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. Дүрмийн 7.1.4** ........ 132

**5.22. Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд мэргэшүүлэх багц сургалт болон холбогдох сургалтад албан хаагчдыг хамруулна. Дүрмийн 7.1.5** ........ 133

**5.23. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Дүрмийн 7.1.11** ........ 134

5.23.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны хэрэгжилт ........ 134

**5.24. Тээвэрлэлт гүйцэтгэх шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулах сунгах, цуцлах, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулна. /Санхүүжилтийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих/ Дүрмийн 7.1.12** 141

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: ........ 141**

**6.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэлд ЕС, ТҮР зөвшөөрлийг “Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем” ашиглан цахимаар олгоно.** ........ 141

**6.2.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч болон авто үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг Нийслэлийн хэмжээнд зохион байгуулна.** ...... 142

Арга хэмжээ 2.5. Холбогдох журмын дагуу "Авто үйлчилгээ"-ний талаарх статистик мэдээ тайланг хагас болон бүтэн жилээр гаргах; ...... 148

Арга хэмжээ 2.6. Өндөр технологийн цахим үйлчилгээг авто үйлчилгээний салбарт нэвтрүүлэх, авто үйлчилгээ эрхлэгчдийн чанар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх; ...... 149

Арга хэмжээ 2.7. Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэгч авто үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Автотээврийн тухай хууль, дүрэм, журам, стандартын талаарх мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулах; ...... 150

Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд "Зөвлөн туслах" үйлчилгээ үзүүлэх; ...... 150

**ДОЛООДУГААР БҮЛЭГ. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД: ...... 153**

**7.1.Автотээврийн салбарын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд:** ...... 153

**НАЙМДУГААР БҮЛЭГ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН САНАЛ ...... 161**

## БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нийтийн тээврийн бодлогын газар нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 141 дүгээр тогтоолыг үндэслэн Тээврийн яамны сайдын 1969 оны 07 дугаар сарын 22-ны өдөр 275 дугаар тушаалаар "Улаанбаатар хотын тээврийг удирдах газар" нэртэйгээр байгуулагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор "Нийтийн тээврийн газар"-ын нэрийг өөрчлөн "Нийтийн тээврийн бодлогын газар" гэж баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/443 дугаар захирамжаар Нийтийн тээврийн бодлогын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн, 2024 оны А/1403 дугаартай захирамжийн нэгдүгээр хавсралтын 1 дэх хэсэгт заасан "Нийтийн тээврийн бодлогын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжид "9.Хуулийн хэлтэс" гэж нэмснээр 9 хэлтэс, 350 албан хаагчтайгаар батлагдсан. 2025 оны 07 дугаар сарын байдлаар тус газарт 172 албан хаагч ажиллаж байгаагаас төрийн захиргааны 29, төрийн үйлчилгээний 143 байна. Сул орон тоо 50,9% буюу 178 байгаагаас төрийн захиргааны албан тушаал 45, төрийн үйлчилгээний албан тушаал 133 байна.

Бүтэц зохион байгуулалтын мэдээлэл

| Д/д | Хэлтэс нэгж | Албан тушаал, нэр | Бүтэц | Сул орон тоо | Сул орон тоо хувиар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Удирдлага | Төрийн албаны тухай хуулийн 44.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны Б/113 дугаар тушаалаар Нийтийн тээврийн бодлогын газрын даргаар Д.Отгонжаргал томилогдон ажиллаж байна. | 1 | 0 | 0% |
| 2 | Захиргаа, удирдлагын хэлтэс | Хэлтсийн дарга З.Цэвээндорж | 21 | 6 | 28,6% |
| 3 | Тээврийн бодлого, судалгааны хэлтэс | Сүлжээ төлөвлөлтийн мэргэжилтэн Д.Баясгалангаар хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж байна. /Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны Б/188 дугаар тушаал/ | 20 | 7 | 35% |
| 4 | Санхүү, аж ахуйн хэлтэс | Эдийн засаг, төсвийн мэргэжилтэн Б.Бадамдоржоор хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж байна. /Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2024 оны Б/18 дугаар тушаал/ | 15 | 4 | 26,5% |
| 5 | Бүртгэл техник, технологийн хэлтэс | Хэлтсийн дарга М.Мөнхбаяр | 42 | 31 | 73,8% |
| 6 | Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтэс | Хэлтсийн дарга Л.Нямдаваа | 15 | 3 | 20% |
| 7 | Зорчигч тээврийн хэлтэс | Тээврийн зохицуулалт хариуцсан, ахлах мэргэжилтэн Х.Баасансүрэн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж байна. | 23 | 9 | 39,1% |
| 8 | Хяналт шалгалтын хэлтэс | Хэлтсийн дарга Ц.Мягмар | 194 | 105 | 54,1% |
| 9 | Хуулийн хэлтэс | Сул орон тоо | 13 | 7 | 53,8% |
| 10 | Олон төрөлт нийтийн тээврийн хэлтэс | Сул орон тоо | 6 | 6 | 100% |
| | | **Нийт** | **350** | **178** | **50,9%** |

*Хүснэгт 1.Бүтэц зохион байгуулалт*




*Зураг №1.Бүтэц зохион байгуулалтын зураглал*

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын болон Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын Зам, тээврийн салбарт хамтран ажиллах "Санамж бичиг"-т тусгагдсан зорилтууд, бусад арга хэмжээг Автотээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлж Монгол Улсын Засгийн газрын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" 43 дугаар тогтоолын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж тайлант хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны 2020-2025 оны байдлаар явцын хэрэгжилт;

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж 100 хувь;

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан тус газарт хамаарал бүхий арга хэмжээний явцын хэрэгжилт; Хэрэгжилтийн дундаж хувь 91.6 хувь байна.

Зам, тээврийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын Зам, тээврийн салбарт хамтран ажиллах “Санамж бичиг”-т туссан хамаарал бүхий арга хэмжээний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилт 85 хувь;

Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн 13 арга хэмжээний хэрэгжилт 93,5 хувь;

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт;

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт;

Нийслэлийн 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт 91,25;

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн”-ийн хэрэгжилтийн дундаж 100 хувь;

“Нийтийн тээврийн бодлогын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дундаж 95,8 хувь байна.

### 1.1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Тусгагдсан арга хэмжээ 9.2.13.Авто тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэн, агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг орон сууцжуулах асуудлыг шат дараатай, системтэй хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулна.

Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын Даргын “Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай” 2025 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан хуваарийн дагуу хаврын ээлжит техникийн хяналтын үзлэгийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулан ажилласан.

Нийт өссөн дүнгээр нийт 1507 тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийгдсэн. Үүнээс:

Ажилчдын автобус-206

Хүүхдийн автобус-213

Үндсэн чиглэл-584

Төр захиргааны тээврийн хэрэгсэл-281

Таксийн чиглэл-199

Буухиа-24 байна.

***Тэнцсэн-1491,***

***Тэнцээгүй-16.***

***Хувь-99%***



*Зураг №2. “Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай” тушаал*




*Зураг № 6. Тээврийн хэрэгслийн явах эд ангийн үзлэг хийж байгаа нь*

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн "Намрын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай" А/103 дугаар тушаалаар батлагдсан хуваарийн дагуу 10 дугаар сарын 08-ны өдрөөс 11 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 920 тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийгдэхээс 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар нийт 849 тээврийн хэрэгсэл хамрагдсан. Үүнд:

Үндсэн чиглэлийн автобус 664 — Тэнцсэн-847

Таксины чиглэлийн 162, — Тэнцээгүй-3,Хувь-92,1%

Буухиа чиглэлийн 23 тээврийн хэрэгсэл тус тус хамрагдсан.



*Зураг №7. "Газрын даргын А/103 дугаар" тушаал*

Нийтийн тээврийн бодлогын газар нь 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 2809 тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулан ажиллалаа. Үүнээс:

- Үндсэн чиглэлийн автобус 1245
- Ажилчдын автобус 354,
- Сургуулийн автобус 500,
- Төр, захиргааны байгууллагын 290,
- Таксины чиглэлийн 366,
- Буухиа чиглэлийн 54 тээврийн хэрэгсэл тус тус /давхардсан тоогоор/ хамрагдсан.

## ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН ТӨВИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

*Хүснэгт 2. 2024 оны мөн үетэй харьцуулбал:*

| Д/д | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Үзүүлэлт | Үндсэн чиглэл /Том, дунд/ | Буухиа чиглэл /бага/ | Такси чиглэл /суудлын/ | Ажилчдын автобус | Төр захиргааны тээврийн хэрэгсэл | Хүүхдийн автобус | - |
| 2024 он | 1223 | 28 | 406 | 305 | 104 | 259 | 2325 |
| 2025 он | 1245 | 54 | 366 | 354 | 290 | 500 | 2809 |

*Хүснэгт 3. 2025 оны орлогын мэдээлэл:*

| Сар | Төлөвлөгөө | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 1 Сар | 11,400,000 | 1,945,000 | 17% |
| 2 Сар | 11,400,000 | 5,361,000 | 47% |
| 3 Сар | 11,400,000 | 8,538,500 | 75% |
| 4 Сар | 14,700,000 | 21,029,000 | 125% |
| 5 Сар | 14,700,000 | 5,224,000 | 42,8% |
| 6 Сар | 11,400,000 | 2,358,000 | 20,2% |
| 7 Сар | 5,000,000 | 1,776,000 | 35,5% |
| 8 Сар | 5,000,000 | 5,927,000 | 118,5% |
| 9 Сар | 14,700,000 | 3,231,000 | 22% |
| 10 Сар | 14,700,000 | 24,963,500 | 169,3% |
| 11 Сар | 11,400,000 | 3,200,000 | 28% |
| 12 Сар | 11,400,000 | | |
| НИЙТ | 137,245,000 | 84,233,000 | 61% |

*Хүснэгт 4. 2024 оны мөн үетэй харьцуулбал:*

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2024 он | 179,904,900 | 58,729,400 | 33% |
| 2 | 2025 он | 137,245,000 | 84,233,000 | 61% |

## 1.2. Авто үйлчилгээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, авто үйлчилгээний салбарт баталгаат үйлчилгээний тогтолцоог сайжруулна. 9.3.19.

“Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан”-гийн программ хангамжийг 2022 онд хэрэглээнд нэвтрүүлсэн боловч программ хангамж нь хэрэглэгчийн шаардлага хангаагүй тул шинэчлэх шаардлага үүсэж уг программ хангамжийн хөгжүүлэлтийн хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Ай Си Ти Групп ХХК -тай хамтран ажиллах талаар танилцуулга уулзалтыг зохион байгуулан ажилласан.

“Авто үйлчилгээний бүртгэл, мэдээллийн сан”-гийн программ хангамжийг хөгжүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллах тухай 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/04/1406 дугаартай албан бичгээр Ай Си Ти Групп ХХК-нд хүргүүлсэн.

Дээрх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны “Үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Төрийн үйлчилгээг нэг цонхноос цомхон бүтцээр оновчтой зохион байгуулах” заалтын хүрээнд “Авто үйлчилгээний бүртгэл, мэдээллийн сан”-гийн программ хангамжид шаардагдах хөрөнгийг тусган шийдвэрлүүлэх, үйлчилгээг нэг цонхноос цахимаар авах программ хангамжийн ажлын даалгаврыг шинээр боловсруулж, төрийн цахим системтэй холбох зэрэг ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байна.



*Зураг № 8.Авто үйлчилгээний программын танилцуулга уулзалт*

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолоор тохирлын баталгаанд заавал хамруулах, тохирлын үнэлгээг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 23.1.2, MNS ISO/IEC17065:2013 стандартын шаардлагыг хангасан байгууллагаар хийлгэх шаардлагатай ба тохирлын үнэлгээ хийлгэсэн нөхцөлд ангиллаа тогтоолгон үйл ажиллагаа явуулах боломжтой гэж заасны дагуу 2025 онд нийслэлийн нутаг дэвсгэрт автомашины засварын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 18 иргэн, 42 аж ахуйн нэгж, байгууллагын 358 ажил үйлчилгээнд тохирлын үнэлгээний баталгаажуулалт хийлгэн, ангилал тогтоогоод байна.

2025 онд тохирлын үнэлгээ хийлгэсэн
авто үйлчилгээ эрхлэгчид

*Хүснэгт 5*

| № | Ажил үйлчилгээний төрөл | Нийт | ААНБ | Иргэн | Баянгол | Баянзүрх | Хан-Уул | Сонгинохайрхан | Чингэлтэй | Сүхбаатар | Багахангай | Багануур | Налайх |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Агрегат зангилаа механизмын оношилгоо, засвар | 43 | 27 | 16 | 9 | 10 | 6 | 2 | 4 | 5 | 0 | 0 | 0 |
| 2 | Техникийн үйлчилгээ | 48 | 31 | 17 | 9 | 13 | 5 | 3 | 4 | 7 | 0 | 0 | 0 |
| 3 | Хөдөлгүүрийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 54 | 39 | 15 | 11 | 17 | 8 | 8 | 4 | 10 | 0 | 0 | 0 |
| 4 | Түлшний систем засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 23 | 20 | 3 | 5 | 9 | 6 | 7 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| 5 | Ажилласан хий (утаа)-г зайлуулах систем, яндангийн дуу, чимээ намсгагч, ажилласан хийг гаргах систем (EGR), DFP, DOC, катализаторын хувиргагч гэх мэт оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохиргоо, зүгшрүүлэлт | 10 | 10 | 0 | 1 | 2 | 3 | 2 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| 6 | Радиатор, хөргөлт, агааржуулалтын системийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 15 | 15 | 0 | 2 | 4 | 4 | 3 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| 7 | Хурдны хайрцаг, хүч дамжуулах ангийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар | 17 | 14 | 3 | 2 | 4 | 3 | 6 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| 8 | Жолооны механизм, явах ангийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 24 | 21 | 3 | 3 | 8 | 5 | 5 | 0 | 3 | 0 | 0 | 0 |
| 9 | Их биеийн засвар | 5 | 5 | 0 | 0 | 3 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 10 | Угаалга, цэвэрлэгээ үйлчилгээ | 2 | 0 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 11 | Цахилгаан систем, түүний тоноглол, хэрэгсэл болон цахилгаан хөдөлгүүрийн системийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 1 | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 12 | Резин дугуй засвар, дугуйн баланс тохируулга, зүгшрүүлэлт | 5 | 4 | 1 | 2 | 1 | 1 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Автомашины шил засварлах, суурилуулах үйлчилгээ | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 14 | Автотээврийн хэрэгсэл | 10 | 8 | 2 | 2 | 2 | 3 | 2 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| 15 | Автотээврийн хэрэгслийн сэлбэг, хэрэгсэл | 44 | 30 | 14 | 9 | 16 | 5 | 4 | 4 | 6 | 0 | 0 | 0 |
| 16 | Тос, тосолгооны болон ашиглалтын бусад материал | 52 | 38 | 14 | 10 | 18 | 7 | 5 | 4 | 8 | 0 | 0 | 0 |
| 17 | Оёдол доторлогоо үйлчилгээ | 3 | 3 | 0 | 1 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 18 | Тээврийн хэрэгслийн резин дугуй, обуд | 2 | 2 | 0 | 0 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 19 | Авто зогсоол | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 20 | Тээврийн хэрэгслийн агрегат зангилаа, эд анги, сэлбэг, хэрэгсэл хадгалах | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Нийт | | 358 | 268 | 90 | 65 | 115 | 57 | 53 | 20 | 48 | 0 | 0 | 0 |

**Хүрсэн үр дүн:** Нийслэлийн нутаг дэвсгэрт автомашины засварын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 18 иргэн, 42 аж ахуйн нэгж, байгууллагын 358 ажил үйлчилгээнд тохирлын үнэлгээ баталгаажуулалт хийлгэн ангилал тогтоон гэрээ байгуулан ажилласан.

## 1.3. Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх ажлын хүрээнд зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлнэ. 9.3.21. НХТ 2025-106, НХТЖҮЧ-9.21.2.

### 1.3.1 Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ, чиглэлийг оновчилж, хүн амын нягтаршилд тохируулан нийтийн тээврийн хэрэгслийг хүртээмжтэй байдлаар төлөвлөх ажлын хүрээнд:

2025 оны жилийн эцсийн байдлаар Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч төрийн ОНӨААТҮГ-ын 5, хувийн хэвшлийн 13 буюу нийт 18 аж ахуйн нэгж байгууллага 139 чиглэлд ажлын өдөр 1182, амралтын өдөр 1008 тээврийн хэрэгслийн гаралттай, 1280 автобусны зогсоолыг дайран өнгөрч өдөрт 450-500 мянган зорчигчдод үйлчилгээ үзүүлж байна.

Улаанбаатар хотын хаяа дагуул тосгодын 20 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 21 чиглэлд өдөр тутам 81 тээврийн хэрэгслээр хүргэж байна.

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Ютонг бус” ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын их багтаамжийн 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авч, Багануур, Багахангай дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг хангах зорилгоор:

Х:17 Тэнгэр плаза-Багануур,
Х:18 Тэнгэр плаза-Багахангай чиглэлийн үйлчилгээнд 3 тээврийн хэрэгсэл,
Чингис хаан олон улсын нисэх буудал руу:
Х:19 “ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол”,
Х:20 "ЧХНОУНБ-5 шар",
ШҮ:4 "Сүхбаатарын талбай-Чингис хаан ОУНБ" гэсэн 3 чиглэлд нийт 7 тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлсэн.




*Зураг №9. Х:19 чиглэлийн зураглал, Х:20 чиглэлийн зураглал*

Нийтийн тээвригйг хөгжүүлэх сангийн санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, “Yutong bus” ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын евро-5 дизель хөдөлгүүртэй, их багтаамжийн 10 автобусаар парк шинэчлэлт хийж, Багахангай дүүргийн чиглэлд 1, Багануур дүүргийн чиглэлд 2, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлын чиглэлд 7 автобусыг тус тус үйлчилгээнд гаргасан. Баянгол дүүрэг, Хан-Уул дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 192/ШШ2025/05784 дүгээр шүүхийн шийдвэрийн дагуу Нийслэлийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/1349 дүгээр захирамжаар БНХАУ-д 2023 онд үйлдвэрлэгдсэн SKYWELL NJL6106BEV загварын их багтаамжийн 15 ширхэг бүрэн цахилгаан автобус, 11 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжүүдийг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авах ажлыг хоёр үе шаттай зохион байгуулж, 2025 оны 09 дүгээр сарын 28, 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд хүлээн авч, гэрээнд заагдсан төлбөр 11,222.3 сая төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл 590.6 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд шилжүүлсэн.

Тус их багтаамжийн цахилгаан хөдөлгүүртэй 15 автобусыг нийтийн тээврийн М:1 “5 шар - Офицеруудын ордон”, Ч:28 “Сэлх-7 Буудал-Ард кино театр”, Ч:42 "Сүлжмэл - Нарны гүүр - Зайсан" Ч:57 "Улаанчулуут -Их наран - МУИС" чиглэлүүдэд үйлчилгээнд гарган ажиллаж байна.




*Зураг №10. Шинээр нээсэн үйлчилгээний чиглэл маршрут*

Нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэр хорооллын дундах авто замуудын нөхцөл байдлыг газар дээр нь судалж холбогдох төлөвлөлтийг боловсруулсан. Судалгаанд СХД-ийн 14, 21, 31, 43-р хороо БГД-ийн 10, 22-р хороо Баянзүрх дүүргийн 17,18,19, 27-р хорооны 11 байршил хамрагдаж, дунд оврын тээврийн хэрэгслийн үйлчилгээг нээх боломжийг судалсан.

Энэ онд дунд оврын дараах чиглэлүүдийн чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан буюу шинээр нээсэн. Үүнд:

1. СХД-ийн 31 дүгээр хорооны иргэдийн зорчих эрэлтийг хангах зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Д:4 "Хайрханы шинэ эцэс-Алтай-Цамбагарав-176-р цэцэрлэг" чиглэлийн замналд өөрчлөлт оруулан 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс дунд багтаамжийн 1 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн.

2. БЗД-ийн 10, 24, 35 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйлчилгээ хүрээгүй суурьшлын бүсийн авто замын нөхцөл байдал, зорчих эрэлтийн судалгааг хийж, төлөвлөлтийг боловсруулан 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/106 дугаар тушаалаар Д:1 "Шархад-Хангамж-Ботаник",



*Зураг № 11. Д:1 чиглэлийн зураглал*

3. Д:11 "Офицеруудын ордон-Цахлай-Баянзүрх дүүргийн 24-р хороо",




*Зураг № 12. Д:11 чиглэлийн зураглал*

4. Д:12 "Баянзүрх дүүргийн 35 дугаар хороо-Улиастайн шинэ эцэс",

5. Д:13 "Улиастайн шинэ эцэс-Шархадны эцэс" чиглэлүүдийг баталж, 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс дунд багтаамжийн 7 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн.



*Зураг №13. Гэр хороолол шинээр хүрсэн чиглэлүүдийн хамрах хүрээний зураглал*

### 1.3.2 Нийтийн тээврийн үйлчилгээнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, бодит шийдэл гаргах, сүлжээний төлөвлөлтийн оновчтой хувилбар, загварыг боловсруулах систем хөгжүүлэлтийг хийлгэн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн судалгаа, шинжилгээний байгууллагуудтай холбогдох уулзалтуудыг зохион байгуулж ажилласан талаар:

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/405 дугаар захирамжаар байгуулагдсан "Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн сүлжээ төлөвлөлтийг судалж, санал дүгнэлт боловсруулах" ажлын хэсэг, 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/344 дугаар захирамжаар байгуулагдсан "Үр дүнд суурилсан үнэлгээ" (KPI)

тогтолцоонд шилжүүлэх танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгээс нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийг математик загварчлалаар оновчлох систем хөгжүүлэлтийг хийлгэж ашиглах нь зүйтэй гэж дүгнэсэн.




*Зураг № 14.KPI*

Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/75 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлаас нийтийн тээврийн сүлжээний төлөвлөлтийг оновчлох систем хөгжүүлэлтийн ажлыг шуурхай зохион байгуулж хийлгэхийг тус газарт даалгасан.

Дээрх ажлын хүрээнд их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны 10 гаруй байгууллагад нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийн оновчлол, зорчигч урсгал, хүртээмж, үйлчилгээний чанарын үнэлгээ зэрэгт судалгаа, дүн шинжилгээ хийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах санал тавин албан бичиг хүргүүлж, хариуг авч нэгтгэсэн.

Тус газраас Нийтийн тээврийн бодлогын газрын хурлын танхимд 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр “Нийтийн тээврийн салбарт тулгамдаж байгаа асуудал”, “Нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлт, чиглэлийн оновчлол” сэдвээр төр, хувийн хэвшлийн аж, ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөлтэй харилцан мэдээлэл солилцсон уулзалтыг зохион байгуулсан.

Уулзалтад Нийслэлийн Ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Д.Бадарсан, Нэгдсэн төслийн удирдлагын газрын дарга Х.Өнөржаргал, МУИС-ийн багш М.Мэнд-Амар нар болон холбогдох албаны хүмүүс оролцсон.

Мөн Тус газраас нийтийн тээврийг оновчлон тээврийн хэрэгслийн цаг даалгавар, хуваарь боловсруулах системийн хөгжүүлэлтийг хийх хүсэлтээ илэрхийлсэн 3 компанийн мэдээлэлтэй танилцсан.

Уг системийг нэвтрүүлж, хөгжүүлэлт хийгдсэнээр цугларсан дата мэдээллүүдийг бүрэн ашиглан дүн шинжилгээ, симуляц хийгдэж, нийтийн тээврийн зорчигч урсгалын загварчлал, оновчлол бүхий нийтийн тээврийн чиглэлийн хуваарь, төлөвлөгөө боловсруулагдан, иргэдэд хүргэх нийтийн тээврийн чанар хүртээмж дээшилж, нийтийн тээврээр үйлчлүүлэхийг сонгох иргэдийн тоо нэмэгдэнэ.

Мөн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын гүйцэтгэлийг KPI систем рүү шилжүүлснээр үйл ажиллагааг бодитоор үнэлэх, хянах, өөрчлөлт хийх, идэвхжүүлэх, үйлчилгээний чанар сайжрах, өрсөлдөх чадварыг бий болгох, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт хийхэд чухал нөлөөтэй.

Нийтийн тээврийн чиглэлийг оновчлох, хуваарь төлөвлөгөөг боловсруулах систем хөгжүүлэлтийн зөвлөх ажлыг мэргэжлийн судлаач, эрдэмтэн, судалгааны байгууллагаар математик загварчлалын аргаар гүйцэтгүүлэхээр холбогдох бэлтгэл ажлыг хангаж Нийслэлийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн зөвлөлийн хуралд Нийтийн тээврийн чиглэлийг оновчлох, хуваарь төлөвлөгөөг боловсруулах систем хөгжүүлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт хийх тухай танилцуулан, шаардагдах хөрөнгийг нийтийн тээврийг хөгжүүлэх сангаас гаргахаар дэмжигдэн шийдвэрлэгдсэнээр Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1111 дүгээр захирамжаар сонгон шалгаруулах тендер зарлагдаж Эм эм Си Жи ХХК шалгарсан байна.







*Зураг № 15.Систем хөгжүүлэлтийн ажлын танилцуулга, Нийслэлийн засаг даргын А/1111 дүгээр захирамж*




*Зураг № 16. Худалдан авах ажиллагааг зарлаж, нээсэн байдал*

### 1.3.3 Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх ажлын талаар:

Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн парк шинэчлэлтийн хүрээнд Нийслэлийн Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн 3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Юүтонг бус" ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу 2025 онд Багануур, Багахангай дүүрэг болон Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал руу иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээнд зориулж БНХАУ-ын үйлдвэрлэгчээс Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011 стандартын 8.1.1 "... Улс хоорондын, хот хоорондын, хот орчмын үйлчилгээнд ажиллах автобус нь 1-нээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар олон суудал, гар тээшний тавиураар тоноглогдсон, тээш хадгалах хонгил байна." дэх шаардлагыг хангасан 10 автобусыг худалдан авах ажиллагааг зохион байгуулагдсан.

Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээнд тээвэрлэлт гүйцэтгэдэг их багтаамжийн автобус 25 зорчигчийн суудалтай байдгаас даруй 20 суудлаар их буюу 45 зорчигчийг тээвэрлэх боломжтой болсон.

Уг тээврийн хэрэгслүүдээр 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс Х:18 "Тэнгэр плаза-Багахангай" чиглэлд, 04 дүгээр сарын 30-ны өдрөөс Х:17 "Тэнгэр плаза-Багануур", Чингис хаан олон улсын нисэх буудал руу 05 дугаар сарын 02-ны өдрөөс Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар" чиглэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс иргэдэд үйлчилж байна.




*Зураг №17.шинээр нээсэн үйлчилгээний чиглэл маршрут*

Улаанбаатар хотын хаяа дагуул тосгодын 20 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 21 чиглэлд өдөр тутам 81 тээврийн хэрэгслээр хүргэж байна.

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, “Юүтонг бус” ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын их багтаамжийн 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авч, Багануур, Багахангай дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг хангах зорилгоор:

- Х:17 Тэнгэр плаза-Багануур,
- Х:18 Тэнгэр плаза-Багахангай чиглэлийн үйлчилгээнд 3 тээврийн хэрэгсэл,

Чингис хаан олон улсын нисэх буудал руу:

- Х:19 “ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол”,
- Х:20 "ЧХНОУНБ-5 шар",
- ШҮ:4 "Сүхбаатарын талбай-Чингис хаан ОУНБ" гэсэн 3 чиглэлд нийт 7 тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлсэн.

## 1.4.Нийслэлд зорчигч тээврийн терминал байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Зорчигч тээврийн терминал байгуулах боломжит байршлыг судлан танилцуулна. 9.3.22

### 1.4.1 Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолтой чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулж салбарын чадавхыг бэхжүүлэх талаар:

Нийтийн тээврийн дулаан зогсоол Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын төсөл боловсруулж батлуулахад шаардлагатай тоон мэдээллийг 2024 оны 12 дугаар сард гарган өгсөн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/10 дугаар тогтоолоор USC1601A:2025 Нийтийн тээврийн зогсоолын зорчигчийн хүлээлгийн танхимд тавигдах ерөнхий шаардлага батлагдсан.



*Зураг № 18. USC1601A:2025 Нийтийн тээврийн зогсоолын зорчигчийн хүлээлгийн танхимд тавигдах ерөнхий шаардлага*

2025 онд Нийслэл Улаанбаатар хотын 3 байршилд шинээр хийгдсэн дулаан зогсоолыг байнгын ашиглалтад оруулсан.Үүнд:

- Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас захиалсан Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхорын эцсийн автобусны зогсоолын тохижилтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр;

- Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны шинэ эцэс, хуучин эцэст дулаан автобусны зогсоолыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Улсын комисст ажиллан байнгын ашиглалтад тус тус хүлээн авсан.



*Зураг №19.БЗД 11-р хороо - Хонхорын эцсийн автобусны зогсоол*



*Зураг №20. Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны хуучин эцэс*



*Зураг №21. Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны шинэ эцэс*

-Нийтийн тээврийн автобусны дулаан зогсоолуудыг камерын нэгдсэн хяналттай болгох зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 01/02/1058 тоот бичгээр дүүргүүдээс шинээр хийгдсэн дулаан зогсоолуудын мэдээллийг авч автобусны зогсоолын мэдээллийн сан бүрдүүлж УБЗАА-нд нэгдсэн камерын хяналттай болгох санал хүргүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Улаанбаатар хотоос зүүн аймаг, дүүрэг рүү чиглэх зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүртээмжтэй хүргэхэд 2025 оноос MNS 6300: 2011 стандартын "B"ангилал стандартад нийцсэн өдөрт 5000 хүртэл хүнд үйлчлэх хүчин чадалтай зорчигч болон дотоодын ачаа тээврийн цэгийг байгуулахаар төслийн ажил эхлүүлэх гэж байгаа мэдээллийг "Тэнгэр" ХХК-иас ирүүлсэн. Уг ажил нь хотын алслагдсан Багануур, Багахангай дүүргийн иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэг нөлөө үзүүлэхээр байгаа тул төслийг дэмжиж Хот байгуулалтын газарт 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/02/1022 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.

Тус газраас Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/618 дугаар захирамжаар байгуулагдсан Нийтийн тээврийн эцсийн зогсоолыг иж бүрэн тохижуулах, одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, төлөвлөлтийн шийдэл боловсруулах, хөрөнгө оруулалтын судалгааг гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Ажлын хэсэгт нийтийн тээврийн үйлчилгээний жолооч нарын ажлын нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор эцсийн зогсоолуудын ариун цэврийн өрөөний судалгааг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 байгууллагаас авч нэгтгэн, ажлын хэсэгт эхний ээлжид 25 эцсийн зогсоолын байршилд капсул байршуулах тооцооллыг танилцуулсан.

| № | Зогсоолын нэр | Өдөрт ирдэг чиглэлийн тоо | Өдөрт ирдэг т/х-ийн тоо | Ариун цэврийн өрөөтэй эсэх |
|---|---|---|---|---|
| | Зайлшгүй шаардлагатай | | | |
| 1 | Офицеруудын ордон /урд/ | 6 | 104 | Байхгүй |
| 2 | Офицеруудын ордон /хойд/ | 5 | 44 | Байхгүй |
| 3 | 5 шар /урд/ | 12 | 69 | Байхгүй |
| 4 | 5 шар /хойд/ | 3 | 74 | Байхгүй |
| 5 | ТЭЦ 3 | 10 | 100 | Өвөл хөлдөөд ажилладаггүй. |
| 6 | Хайлаастын шинэ эцэс | 2 | 24 | Байхгүй. |
| 7 | Зайсан | 6 | 58 | Байхгүй. |
| 8 | 3,4-р хорооллын эцэс | 4 | 42 | Байхгүй |
| 9 | Шадивлангийн эцэс | 1 | 10 | Байхгүй |
| 10 | Халдвартын эцэс | 4 | 26 | Байхгүй |
| | Шаардлагатай | | | |
| 11 | Шархад | 4 | 82 | Байхгүй |
| 12 | Цагаан даваа | 5 | 38 | Байхгүй |
| 13 | Архивын ерөнхий газар | 4 | 33 | Байхгүй |
| 14 | Ард кино театр | 5 | 65 | Байхгүй |
| 15 | Вокзал | 7 | 54 | Байхгүй |
| 16 | Тоосгоны үйлдвэр | 2 | 19 | Байхгүй |
| 17 | Улаанхуарангийн эцэс | 3 | 42 | Байхгүй |
| 18 | Гачууртын эцэс | 2 | 8 | Байхгүй |
| 19 | Гадна тойруу | 1 | 12 | Байхгүй |
| 20 | Толгойт | 1 | 3 | Байхгүй |
| 21 | Тахилт | 1 | 14 | Байхгүй |
| 22 | Дэнжийн 1000 | 3 | 26 | Байхгүй |
| 23 | Зунжин | 3 | 33 | Байхгүй |
| 24 | Нарангийн гол | 2 | 24 | Байхгүй |
| 25 | Улаанчулуут | 2 | 26 | Байхгүй |

*Хүснэгт №6.эцсийн зогсоолын байршилд капсул байршуулах тооцоолол*

Нийтийн тээврийн зогсоолын байгууламж дахь чиглэлийн мэдээллийн зураглалын боловсруулалтыг автоматжуулах ажлын хэрэгцээ шаардлагыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, тус ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах 200,000,000 (хоёр зуун

сая) төгрөгийг Нийтийн тээврийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/13 дугаар захирамжаар батлуулсан.

Тус захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Нийтийн тээврийн зогсоолын байгууламжийн чиглэлийн мэдээллийн зураглалыг автоматаар боловсруулах ажил үйлчилгээний даалгавар, Нийтийн тээврийн бодлогын газрын 2025 оны худалдан авах төлөвлөгөөг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан.

Нийтийн тээврийн бодлогын газрын https://www.transport.ub.gov.mn/ цахим хуудас болон цахим нүүр хуудаст нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдөж буй нийтийн тээврийн чиглэлийн мэдээллийн зураглалыг боловсруулах системийг нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгох нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох урилгыг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байршуулсан.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах "Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн зогсоолын байгууламжийн чиглэлийн мэдээллийн зураглалыг автоматаар боловсруулах систем" НТБГ/20250103002 дугаартай тендер шалгаруулалтад 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр зарлагдаж Дата дэүс ХХК-ний тендерийн санал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт заасны дагуу "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгарч хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гэрээ байгуулагдсан.



ТЕНДЕРИЙН УРИЛГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: 2025-04-10

Тендер шалгаруулалтын нэр: Нийтийн тээврийн зогсоолын байгууламж дахь чиглэлийн мэдээллийн зураглалыг автоматжуулах систем байгуулах тухай

Тендер шалгаруулалтын дугаар: НТБГ/20250103002

1. Нийтийн тээврийн бодлогын газар нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ:

3. Тендерийг 2025 оны 04 -р сарын 30 -ны өдрийн 09 цаг 00 минут -аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу илгээх ба тендерийг 2025 оны 04 -р сарын 30 -ны өдрийн 09 цаг 30 минут-д нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: Зөвшөөрөхгүй
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: 1,000,000 төгрөг. Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичигийн заасан үнийн дүн бүхий тендерийн баталгаар холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
10. Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтын баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд үйлчилгээний хураамж "50000 төгрөг"-ийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй байна.

Монгол, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 23-р хороо , Хангарьд цогцолбор НЗДТГазар, Б блок, 4 давхарт
11325067
teever@transport.ub.gov.mn

Хаах

*Зураг №22. "Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн зогсоолын байгууламжийн чиглэлийн мэдээллийн зураглалыг автоматаар боловсруулах систем" НТБГ/20250103002 дугаартай тендер*




*Зураг №23.Чиглэлийн мэдээллийн зураглал /загвар/*




*Зураг №24.Чиглэлийн мэдээллийн зураглал /загвар/*

### 1.4.2 Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолын барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж ажилласан талаар.

Тайлант хугацаанд нийтийн тээврийн автобусны эцсийн болон дундын зогсоолуудад хяналт шалгалт тогтмол зохион байгуулж, нийт 15 зогсоолд газар дээр нь үзлэг шалгалт хийсэн. Үзлэгээр илэрсэн эвдрэл гэмтлийг хариуцагч байгууллагуудад мэдэгдэн засварлуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/119 дүгээр тушаалаар байгууллагын дансанд бүртгэлтэй автобусны эцсийн 6 зогсоолын барилга байгууламжийг дахин үнэлэх ажлын хэсэг байгуулагдсан. Нийтийн тээврийн үйлчилгээний жолооч, шалгагч нарын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор бий болсон Шархад, Нисэх, Баянхошуу, Дэнжийн мянгын автобусны эцсийн зогсоолын барилга байгууламж нь “Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, бэхжүүлэх зорилтын хүрээнд хийгдсэн өмч ашиглалтын гэрээтэйгээр ашиглагдаж байна.

Нарангийн гол, Улиастай автобусны эцсийн зогсоолын ашиглалтын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн өмчийн харилцааны газар болон хуулийн хэлтэст холбогдох материалыг танилцуулан шийдвэрлүүлэх хүсэлт өгсөн.

Ажлын хэсгээс газар эзэмших гэрчилгээгүй Баянхошуу, Нисэхийн автобусны эцсийн зогсоолын газруудыг 2026 оны газар эзэмших төлөвлөгөөнд оруулах, Дэнжийн 1000-ын автобусны эцсийн зогсоолын газар эзэмших гэрчилгээний хугацааг сунгуулах зэрэг ажлыг эхлүүлэн холбогдох материалыг бүрдүүлэн Нийслэлийн нэг цэгийн үйлчилгээний төвд хандсан.

### 1.4.3 Нийтийн тээврийн чиглэл, зогсоолын мэдээллийн санд баяжилт хийсэн талаар.

Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолыг удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системд 10 байршилд орсон өөрчлөлтийг бүртгэн оруулсан. Үүнд:

1. Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/05 тоот тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж Ү:19, Ү:20, Ч:6, Ч:13, Ч:40, Х:8 чиглэлүүдэд “Гармын зогсоол”-ыг,

2.Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/18 тоот тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж М:6, Ч:61, Ч:70, чиглэлүүдэд “Дэлгэр хотхон” зогсоолыг,

3.Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/18 тоот тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж Ү:30, М:5 чиглэлүүдэд “Эрдэнэдрийлинг” зогсоолыг тус тус нэмж батлуулсан.

4.Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/66 дугаар тушаалаар нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны

зогсоолын хоорондын зайг ойртуулж Ч:28 "Сэлх - 7 Буудал - Ард кино театр" чиглэлд "Түмэн баялаг дэлгүүр" зогсоолыг нэмж батлуулсан.

5.Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/98 дугаар тушаалаар Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр зорчих эрэлтийг хангах зорилгоор Ч:84 "Бага тэнгэр сити - Хан хиллс хотхон - 120 мянгат" чиглэлийг шинээр нээж, "Бага тэнгэр сити" зогсоолыг шинээр нээсэн.
6.Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/105 дугаар тушаалаар нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Х:8 "Найрамдал зуслан - 5 шар" чиглэлд "Найрамдал 1-р зогсоол", "Найрамдал 2-р зогсоол", "Найрамдал 3-р зогсоол", "Найрамдал 4-р зогсоол","Найрамдал 5-р зогсоол", "Найрамдал 6-р зогсоол", "Найрамдал 7-р зогсоол", чиглэлийн замналд тус зогсоолуудыг нэмсэн.

7. Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/05 тоот тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж Ү:19, Ү:20, Ч:6, Ч:13, Ч:40, Х:8 чиглэлүүдэд “Гармын зогсоол”-ыг нэмсэн.

8.Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/18 тоот тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж М:6, Ч:61, Ч:70, чиглэлүүдэд “Дэлгэр хотхон” зогсоолыг нэмсэн.

9.Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/18 тоот тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж Ү:30, М:5 чиглэлүүдэд “Эрдэнэдрийлинг” ” зогсоолыг нэмсэн.

10. 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/115 дугаар тушаалаар Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны иргэдийг нийтийн тээврийн хэрэгслээр зорчих эрэлтийг хангах зорилгоор Ү:24 "Ургах наран хороолол - Офицеруудын ордон" чиглэлийн замналд өөрчлөлт оруулан “Зоорь1 баруун”, “Зоорь 1 зүүн”, “Зоорь” зогсоолуудыг нэмсэн байна.




*Зураг №25.Зогсоолын мэдээллийн санд баяжилт хийж байна.*

1.НЗДТГ-аас захиалсан Буянт-Ухаа цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбайн чиглэлд олон төрөлт тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төслийн зураг, УБЗЗАГ-аас захиалсан Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Туул зөрлөгөөс уулын зам хүртэлх 1.7 км авто замын зураг

2.НЗХГ-аас захиалсан Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо, Сонсголонгийн замаас Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн хойд талаар товчооны 1 дүгээр гудамж хүртэлх авто замын зураг, Нийслэлийн замын хөгжлийн газартай Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хороо Найрамдалын зам дагуух зам засварын ажил,

3. ХУД 8-р хороо Архивчдын гудамж, Морин тойруулга, Наадамчдын талбайн гудамжаас Нүхтийн авто замтай холбогдох авто замын зураг төсөл,

4.Цагаан давааны авто замаас Ландфилийн талбай хүртэлх авто замын зураг төсөл,

5. Буянт Ухаа цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл /трам/ нэвтрүүлэх төслийн зураг,

6. Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо Дэнжийн 11 дүгээр гудамжнаас ХУД 5, 6, 7 дугаар хороонд байрлах гэр хорооллын дундуур 4 дүгээр хороо Арцат 17 дугаар гудамж хүртэлх авто замын зураг,

7.Сүхбаатар дүүргийн 15, 16 ,17, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах автобусны талбайн тохижилтын зураг,

8.Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороонд 1,7 км авто замын зураг төсөв боловсруулах ажлын зурагтай тус тус танилцаж стандартын дагуу санал тусгуулж ажилласан.

Тайлант хугацаанд нийт 8 авто замын зураг төслийг зөвшилцсөн байна.

“Шинэ тойрог авто зам” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах ажлын хүрээнд Гуандун мужийн зам тээврийн төлөвлөлт зураг төслийн хүрээлэн групп ХХК-ийн инженертэй 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр уулзалт зохион байгуулж трассын сонголт болон нийтийн тээврийн зогсоол байгуулах санал өгч тусгуулан батлуулсан.

Нэгдүгээр тойрог замын зураг төсөлд 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/01/1399 дугаар, Хоёрдугаар тойрог замын зураг төсөлд 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 01/02/1864 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Өнөр хорооллын гудамж болон Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг цогц гудамж зам болгон хөгжүүлэх, шинэчлэх ажлын хүрээнд 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 02/1678 дугаартай албан тоот бичгээр тухайн гудамжинд байрлах нийтийн тээврийн үйлчилгээний автобусны зогсоолуудыг тохижуулах ажлын гүйцэтгэгчийг төслийн ажлын хүрээнд шийдвэрлэх, мөн тухайн гудамжны авто замыг шинэчлэн засварлах ажлын зураг төсөлд тусгагдсан ПК0+518 болон ПК0+520 хэсэгт байрлах автобусны зогсоолын зурагтай зөвшилцөж санал хүргүүлсэн.




*Зураг №26.Зогсоолын мэдээллийн санд баяжилт хийж байна.*



*Зураг №27. Авто зам засварын үеийн төлөвлөлтийн зураглал*

Судалгаа дүн шинжилгээ хийж ажилласан талаар

Зорчигч урсгалын судалгааг тухай бүр өссөн дүнгээр шинэчлэн гаргаж байна. Энэ оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийтийн тээврээр үйлчлүүлсэн зорчилтын тоо tbox.uscc.mn системээр 60,542,701 зорчигч, нийтийн тээврийн төлбөрийн төлбөрийн менежментийн системээр 1,961,040 зорчигч, бэлэн мөнгөөр зорчилтын орлого 4,090,606,246

төгрөг буюу 4,090,606 зорчилт байгаагаар тооцвол нийт зорчилт 66,594,347 зорчигч нийтийн тээврээр үйлчлүүлсэн тоо мэдээтэй байна.

Энэ нь өмнөх 2024 оны мөн үеийн 58,385,896 зорчилттой харьцуулахад нийтийн тээврээр үйлчлүүлсэн зорчигчийн тоо 8,9%-иар өссөн үзүүлэлтэй байна.

Тээврийн бодлого, судалгааны хэлтэст 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хоорондох хугацаанд нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой 109 удаагийн судалгаа хийгдсэн байна. Судалгааг хийгдсэн чиглэлээр нь авч үзвэл:

1. Зорчигч урсгалын 52 судалгаа 47.7%
2. Чиглэлийн 21 судалгаа 19.2%
3. Зогсоолын 6 судалгаа 5.5%
4. Жолоочийн ажиллах нөхцөлийн 4.58%
5. Тарифтай холбоотой 4 судалгаа 3.66%
6. Төслийн 4 судалгаа 3.66%
7. Эцсийн зогсоолын 4 судалгаа 3.66%
8. Капсулын 3 судалгаа 2.75%
9. Чиглэлийн давхцалын 3 судалгаа 2.75%
10. Автобусны багтаамжийн 3 судалгаа 2.74%
11. Сургуулийн автобусны 2 судалгаа 1.83% -д хийгдсэн байна

Иргэдээс удаа дараа ирүүлсэн санал хүсэлтийн дагуу Ч:71 “120 мянгат-Хүннү 2222-Баянмонгол хороолол-МУБИС-Сүхбаатарын талбай” чиглэлийн зорчигч урсгал болон эрэлтийн судалгааг хийж, тухайн чиглэлд өөрчлөлт оруулах төлөвлөлтийг боловсруулсан. Төлөвлөлтөөр Ч:71 “120 мянгат-Хүннү 2222-Баянмонгол хороолол-МУБИС-Сүхбаатарын талбай” чиглэлийн гаралтын тоог нэмэгдүүлж хүлээлгийн хугацааг багасгах, мөн чиглэлийн замналд өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Б.Мягмар 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 04/35 дугаартай албан бичгээр, Хан-Уул дүүргийн 22 дугаар хорооны иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх зорилгоор Архивын ерөнхий газраас Яармаг, Уулын замаар Богины ам, Хийморь хотхоноор дайруулан автобусны шинэ чиглэл нээх санал ирүүлсний дагуу холбогдох судалгааг хийж 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/02/763 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг google form ашиглан нийт 507 хүнээс цахимаар авч нэгтгэн дүгнэлт гарган тодорхой чиглэлүүдийн цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан. Судалгаа авсан линк: https://forms.gle/T56njCYnpy1BfVze7

Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 64.9% нь өдөр бүр нийтийн тээврээр үйлчлүүлдэг, 75.5% нь нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж өмнөх оноос сайжирсан гэж хариулсан байна.



*График 1. Сэтгэл ханамжийн үзүүлэлт*




*График 2. Иргэдийн нийтийн тээврээр үйлчлүүлдэг давтамж*

Судалгаанд хамрагдсан иргэдийн 64% нь өдөр бүр нийтийн тээврээр үйлчлүүлдэг гэж хариулсан байна.




*График 3. Насны ангилал*

Судалгаанд хамрагдсан иргэдийн хамгийн их 31.5% нь 36-45 нас, 31.3% нь 46-55 нас, 19.1% нь 26-35 нас, 11.8% нь 19-25 нас, 9.6% нь 55-аас дээш нас, 7.3% нь 0-18 настай байна.

Улаанбаатар хотын хүн ам, суурьшлын статистик тоон мэдээллийг авахаар Нийслэлийн Статистикийн газарт 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01/02/1029 тоот албан бичгээр хандаж 2024 оны жилийн эцсийн байдлаарх тоон мэдээллийг авч нэгтгэн харьцуулсан дүгнэлт гаргаж холбогдох тоон мэдээллийг өдөр тутмын төлөвлөлтийн ажилд ашиглаж байна.

| Д/д | Нийт өрхийн тоо | Хүн амын тоо, бүгд | Хүйс | | Ахмад настан | | Хүүхэд /0-18 нас/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрэгтэй | Эмэгтэй | Эр /60+/ | Эм /55+/ | |
| Багануур | 8952 | 29152 | 14297 | 14855 | 1342 | 2733 | 10789 |
| Багахангай | 1293 | 4549 | 2397 | 2152 | 195 | 382 | 1619 |
| Баянгол | 71371 | 259411 | 122420 | 136991 | 8875 | 21378 | 99362 |
| Баянзүрх | 131827 | 450873 | 217754 | 233119 | 14548 | 32894 | 173354 |
| Налайх | 10991 | 40674 | 20266 | 20408 | 1672 | 3280 | 15786 |
| Сонгинохайрхан | 96524 | 343439 | 169576 | 173863 | 12164 | 25716 | 132980 |
| Сүхбаатар | 40445 | 143332 | 69105 | 74227 | 6187 | 13101 | 52229 |
| Хан-Уул | 76857 | 273398 | 129842 | 143556 | 9036 | 20088 | 111035 |
| Чингэлтэй | 36857 | 133044 | 65146 | 67898 | 5698 | 12453 | 48094 |
| Улаанбаатар | 475117 | 1677872 | 810803 | 867069 | 59717 | 132025 | 645248 |

*Хүснэгт 7. Хүн амын тоон мэдээ*

Улаанбаатар хотын хүн амын өсөлт




*График 4. Хүн амын өсөлтийн үзүүлэлт*

Улаанбаатар хотын хүн ам 2023 онтой харьцуулахад 2,9%-иар өссөн үзүүлэлттэй байна. Хамгийн их хүн амтай дүүрэг Баянзүрх, хамгийн бага хүн амтай дүүрэг Багахангай байна.

## 1.5. Сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ. 9.3.23.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110, А/546, А/1285 дугаар захирамжийн хүрээнд сургуулийн автобусны үйлчилгээнд ажилласан. Сургуулийн автобусны үйлчилгээнд ажилласан 5 ОНӨААТҮГ, нийслэлийн 3 дүүргээс өдөр тутам тээвэр зохицуулагч нарт ирүүлдэг мэдээг замын хуудастай тулгаж хяналт тавьж нэгтгэн сар бүрийн рейсийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлж ажилласан.

2024-2025 оны хичээлийн жилд 83 сургуулийн 69 чиглэлд 69 хүүхдийн автобусаар 1,503,095 сурагч тээвэрлэсэн байна. 2025 оны эхний 11 сарын 27-ны өдрийн байдлаар 83 сургуулийн 67 чиглэлд 67 хүүхэд тээвэрлэх автобусаар 31,541 рейс гүйцэтгэж 1,244,754 сурагч тээвэрлэсэн байна.

Сургуулийн автобусны гүйцэтгэл

(2022-2025)

*Хүснэгт 8.*

| Он | Сар | ААНБ-ын тоо | Чиглэлийн тоо | Сургуулийн тоо | Тээврийн хэрэгслийн тоо | Ажилласан өдөр | Гүйцэтгэсэн рейс | Тээвэрлэсэн хүүхдийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2022 | 9 | 3 | 23 | 23 | 23 | 20 | 901.5 | 74431 |
| | 10 | 3 | 23 | 23 | 23 | 21 | 956.5 | 86994 |
| | 11 | 3 | 23 | 23 | 23 | 15 | 653.5 | 62905 |
| | 12 | 3 | 22 | 22 | 22 | 12 | 517.5 | 48423 |
| **2022 оны дүн** | | | | | | | **3029** | **272753** |
| 2023 | 1 | 2 | 19 | 22 | 22 | 18 | 729 | 64224 |
| | 3 | 2 | 19 | 22 | 19 | 18 | 681 | 59995 |
| | 4 | 11 | 69 | 86 | 57 | 20 | 1939.5 | 149890 |
| | 5 | 11 | 69 | 86 | 58 | 23 | 4531 | 165302 |
| | 6 | 4 | 21 | 43 | 21 | 6 | 286 | 4606 |
| | 9 | 11 | 56 | 51 | 56 | 20 | 4076 | 163664 |
| | 10 | 11 | 58 | 56 | 58 | 22 | 4381 | 190526 |
| | 11 | 11 | 53 | 56 | 53 | 16 | 3303 | 135434 |
| | 12 | 11 | 52 | 42 | 52 | 16 | 3058 | 128659 |
| **2023 оны дүн** | | | | | | | **22984.5** | **1062300** |
| 2024 | 1 | 11 | 53 | 51 | 53 | 3 | 763 | 23619 |
| | 2 | 11 | 54 | 51 | 54 | 20 | | 158312 |
| | 3 | 11 | 58 | 56 | 58 | 20 | 730 | 186989 |
| | 4 | 11 | 58 | 69 | 58 | 17 | 661 | 153553 |
| | 5 | 11 | 57 | 67 | 57 | 22 | 843 | 171846 |
| | 6 | 11 | 43 | 53 | 43 | 10 | 358 | 26891 |
| | 9 | 8 | 69 | 83 | 69 | 21 | 4990 | 164944 |
| | 10 | 8 | 62 | 77 | 62 | 22 | 4376.5 | 171406 |
| | 11 | 8 | 66 | 81 | 66 | 19 | 4902 | 185590 |
| | 12 | 8 | 65 | 80 | 65 | 20 | **5296** | 195406 |
| **2024 оны дүн** | | | | | | | | **1438556** |
| 2025 | 1 | 8 | 66 | 82 | 66 | 5 | 1337 | 50374 |
| | 2 | 8 | 66 | 81 | 66 | 20 | 5296 | 192162 |
| | 3 | 8 | 66 | 82 | 66 | 17 | 4680 | 165406 |
| | 4 | 8 | 66 | 82 | 66 | 13 | 3640 | 131172 |
| | 5 | 8 | 66 | 81 | 66 | 22 | 6132 | 211921 |
| | 6 | 8 | 64 | 78 | 64 | 5 | 1342 | 34714 |
| | 9 | 8 | 63 | 80 | 63 | 20 | 5597 | 186584 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 10 | 8 | 64 | 81 | 64 | 18 | 3517 | 121868 |
| | 11 | 8 | 67 | 83 | 67 | 17 | | 150553 |
| 2025 оны эхний 11 сарын дүн | | | | | | | **31541** | **1244754** |
| | | | | | | | | |
| **2025 оны эхний 4 сар** | | | | | | | **22427** | **785749** |
| **2022-2025** | | | | | | | **80474** | **4018363** |

**Тээвэрлэсэн хүүхдийн тоо**

*Хүснэгт 9.*

| Он | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 9 сар | 10 сар | 11 сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2024 | 23619 | 158312 | 186989 | 153553 | 171846 | 26891 | 164944 | 171406 | 185590 |
| 2025 | 50374 | 192162 | 165406 | 131172 | 211921 | 34714 | 186584 | 121868 | 150553 |

*График 1*




*График 5.2024-2025 оны эхний 11 сарын тээвэрлэсэн хүүхдийн тооны харьцуулалт*

Үйл ажиллагааны үр дүн: Сургуулийн автобусны үйлчилгээнд ажилласан тээврийн хэрэгслүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэсэн рейс, тээвэрлэсэн хүүхдийн тоог нэгтгэн гаргаж Санхүү, аж ахуйн  хэлтэст хүргүүлсэн. 2024-2025 оны эхний 11 сард тээвэрлэсэн хүүхдийн тоог харьцуулахад 1,604 буюу 0,13 хувиар өссөн байна.



*Зураг №28. Сурагчийн автобусны парк шинэчлэлт*

Хан-Уул дүүргийн 178, 181 дүгээр сургуулиудыг "Сургуулийн автобус" төсөлд хамруулах зорилгоор авто замын нөхцөл байдалтай судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын ахлах инженерийн хамт газар дээр нь очиж ажилласан.



*Зураг №29. 178-р сургууль, 181-р сургууль*

Нийслэлийн Ерөнхий боловсролын 178 дугаар сургуулийн хүсэлтэд дурдсан 1,2 км шороон зам нь хатуу хучилтгүй огцом өгсүүр, уруу эвдрэл бүхий замын хэсгүүдтэй, хүйтний улиралд мөстөн халтиргаа үүссэн байдалтай байгаа нь зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлэхэд эрсдэлтэй, замын хөдөлгөөний аюулгүй байдал хангахгүй, мөн 181 дүгээр сургуулиас Элеганс хороолол хүртэлх 1,5 км асфальтан хучилттай авто замын төгсгөлд автобус эргэх эцсийн зогсоолын талбайгүй нь Нийтийн тээвэр. Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага MNS 5879:2012 стандартын 7.4-д Замналын эцсийн зогсоолд зорчигч буух, суух, хүлээх, нийтийн тээврийн хэрэгсэл эргэх, сэлгэн байрлах, сул зогсох талбайтай байхаар заасныг хангахгүй байх тул одоогоор дээрх 2 сургуульд сургуулийн автобусны үйлчилгээг хүргэх боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан.



*Зураг №30. 178-р сургуулийн автобусны замналын зураг*



*Зураг №31. 181-р сургуулийн сургуулийн автобусны замналын зураг*

## 1.6.Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэн замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлнэ. 9.3.25.

Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийн төслийн нэгжтэй хамтран ажиллаж байна.

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн Бүрэлдэхүүн хэсэг 2-ын хүрээнд хэрэгжүүлж буй "Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний гэрээ 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр байгуулагдсан.

Гэрээний тусгай нөхцөлийн 11.1-т Захиалагч гэрээг баталснаас хойш хуанлийн 7 хоногийн дараа гэрээ хүчин төгөлдөр болно, 13.3-т гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш хуанлийн 7 хоногт зөвлөх үйлчилгээ эхэлнэ гэж заасны дагуу "Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ"-ний 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ажил албан ёсоор эхэлсэн.

Зөвлөх үйлчилгээний багаас Эхлэлийн уулзалтыг 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр 11:00 цагт Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ (PTS-C1-1)-ийн гэрээт баг Дэлхийн банк болон төсөл хэрэгжүүлэгч нэгжтэй хамтран тус газарт уулзалт зохион байгуулав.

Мөн зөвлөхөөс боловсруулсан “Эхлэлийн тайлан”-д тусгах саналыг өгч, УБХТАЗТ төсөл хэрэгжүүлэгч нэгжээс зөвлөх үйлчилгээний багт 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр хүргүүлж, Зөвлөх баг саналыг тусган зассан тайланг 4 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн бөгөөд тус тайлантай танилцаж, хянан зөвлөх багт холбогдох засваруудыг хийлгэхээр буцаасан байна.

2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр тус газартай уулзалт зохион байгуулж, тус зөвлөх үйлчилгээний хүрээнд холбогдох баримт бичиг, мэдээллийг хэрхэн авах, цаашид зөвлөх багийн голлох гадаад мэргэжилтнүүд Монгол улсад ажиллахад хэрхэн мэдээлэл өгч, хамтран ажиллах талаар хэлэлцэн санал солилцов. Тус зөвлөх үйлчилгээний голлох мэргэжилтэн Монгол Улсад ирж ажиллахтай Холбогдуулан Монгол талын зөвлөхтэй 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр уулзалт зохион байгуулж одоогийн ашиглаж буй Тээврийн удирдлагын төвийн үйл ажиллагааг танилцуулж, 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр тус газар болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай уулзалт товлосон. Транс консалтинг ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд уулзалт зохион байгуулж, мэдээлэл солилцов.

Төсөл хэрэгжүүлэх нэгжээс Зөвлөх багийн боловсруулсан “Нийтийн тээврийн удирдлагын төвийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ”-ний эхлэлийн тайланг тус газарт 10 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсэн.

Мөн уг төвд шаардлагатай тоног төхөөрөмжийн мэдээллийг авахаар 10 дугаар сарын 31-ний өдөр албан бичиг ирүүлсний дагуу 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр холбогдох саналыг Улаанбаатар хотын тогтвортой авто зам тээврийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэгч нэгжид хүргүүлсэн.

“Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төслийг боловсруулах" зөвлөх үйлчилгээг TransCo.Ltd. гэрээ байгуулан ажиллаж байна. Зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Эхлэлийн тайлан, Дундын ТЭЗҮ, Эцсийн ТЭЗҮ, Нарийвчилсан зураг төсөл, тендерийн баримт бичиг тус, тус боловсруулагдана.

Эхлэлийн тайлан болон тодруулга бүхий асуултыг тус газарт 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн бөгөөд дундын тайланг 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 461 дугаартай албан бичгээр ирүүлсэн. Тус газраас хүргүүлсэн “Нийтийн тээврийн удирдлагын төв”-ийг шинэчлэх хүрээнд нэгдсэн мэдээллийн платформыг бүрдүүлж, бодит цагийн хяналт, ослын менежмент болон зорчигчийн мэдээллийн системийг нэвтрүүлэх, холбогдох хууль, дүрэм журам, стандартад нийцүүлэх, Нийтийн тээврийн бодлогын газрын хэлтэс, нэгжийн нэршлийг зөв бичих, Шуурхай ажиллагааны үед хамтран ажиллах байгууллагуудад даатгалын салбарыг оруулж хамтын ажиллагааг уялдуулах саналын дагуу Зөвлөх багаас сайжруулалт хийж, тайланг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 534 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

Нийтийн тээврийн удирдлагын төвийн ТЭЗҮ болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний Техник, эдийн засгийн үндэслэлийн дундын тайланг эцэслэх ажил 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 95% гүйцэтгэлтэй үргэлжилж байна.



*Зураг №32. Нийтийн тээврийн бодлогын газрын даргын зөвлөлийн хурлаар Нийтийн тээврийн удирдлагын төвийг шинэчлэх ТЭЗҮ-ийн дундын тайлангийн төслийг танилцуулж, санал солилцов.*



*Зураг №33. Дундын тайлан*

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙТИЙН ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ, НАЙДВАРТАЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАМААР ХУВИЙН АВТОМАШИНЫ ХЭРЭГЛЭЭГ БАГАСГАЖ, НИЙТИЙН ТЭЭВРЭЭР ЗОРЧИХ ЗОРЧИЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ. НЗДҮАХ-1.5.

### 2.1. Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолтой чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулж салбарын чадавхыг бэхжүүлнэ. НЗДҮАХ 1.5.2. гэсэн тэргүүлэх зорилтын хүрээнд:

2.1.1Нийтийн тээврийн хэрэгслийн замналын дагуух саравчтай болон дулаан зогсоолуудын тоог нэмэгдүүлэх; НХТЖҮЧ-9.22.3.

Улаанбаатар хотын 8 байршилд шинээр  дулаан зогсоолыг байнгын ашиглалтад оруулсан.Үүнд:

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас захиалсан Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхорын эцсийн автобусны зогсоолын тохижилтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр;



*Зураг №34. БЗД 11-р хороо - Хонхорын эцсийн автобусны зогсоол*

Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны шинэ эцэс, хуучин эцэст дулаан автобусны зогсоолыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр;



*Зураг №35. Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны хуучин эцэс*



*Зураг №36. Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны шинэ эцэс*

Сонгинохайрхан дүүргийн 1, 11, 26, 33, 36 дугаар хорооны 5 байршилд шинээр дулаан автобусны зогсоолыг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр байнгын ашиглалтад оруулж тус тус хүлээн авсан.



*Зураг №37. СХД 1 дүгээр хороонд байрлах СХД 1-р хороо автобусны зогсоол*

Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/111 дүгээр захирамжаар нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол шинээр барих,

шинэчлэх ажлыг баталсан бөгөөд дээрх захирамжийн хүрээнд хоёр удаагийн тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тул Хот байгуулалт хотын стандартын газраар ажлын даалгаврыг шинэчлэн батлуулж 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр 14 байршилд саравчтай болон дулаан зогсоол байгуулах худалдан авах ажиллагааг зарлаад байна.




*График 6. Саравчтай зогсоолуудын мэдээлэл*

Нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 547 саравчтай зогсоол ашиглагдаж байна.



*Зураг №38. Эрх шилжүүлсэн захирамж*



*Зураг №39. Төсөв*

### 2.1.2.Нийтийн тээврийн автобусны дулаан зогсоолуудыг камерын нэгдсэн хяналттай болгох ажлын хүрээнд УБЗАА-нд санал хүргүүлнэ.

Нийтийн тээврийн автобусны дулаан зогсоолуудыг камерын нэгдсэн хяналттай болгох зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/02/1058 дугаартай албан бичгээр дүүргүүдээс шинээр хийгдсэн дулаан зогсоолуудын мэдээллийг авч автобусны зогсоолын мэдээллийн сан бүрдүүлсэн.





*Зураг №40. Явсан болон ирүүлсэн албан бичиг*



ДҮҮРГҮҮДИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

Нийтийн тээврийн зогсоолын мэдээлэл ирүүлэх тухай

Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд 2025 онд хийгдэхээр төлөвлөгдсөн нийтийн тээврийн автобусны зогсоолын талаарх холбогдох тоон мэдээ, судалгааг хавсралтаар хүргүүлсэн хүснэгтийн дагуу гарган тус газрын зогсоолын төлөвлөлт, сүлжээний инженер Б.Амарзаяагийн (amarzayakym@gmail.com) цахим хаягаар 2025 оны 06 дугаар сарын 13-ны дотор ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудастай.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
ОТГОНЖАРГАЛ
2025.06.08 14:11

*Зураг №41. Дүүргүүдэд хүргүүлсэн албан бичиг*



НИЙТИЙН ТЭЭВРИЙН АВТОБУСНЫ ЗОГСООЛЫН СУДАЛГАА

2025 оны 01 дугаар сарын 20-ны өдөр — Улаанбаатар хот

Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээнд өдөр тутам 1280 зогсоол, эцсийн зогсоолоор ашиглаж байгаа 140 зогсоол байна. Үүнээс
- Шилэн саравчтай 347 зогсоол
- Битүү хийцлэлтэй 61 зогсоол
- Дулаан 21 зогсоол байна.

Тухайн зогсоолуудыг хөрөнгө оруулалтын хувьд авч үзвэл
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 24 зогсоол
- Буцалтгүй тусламжаар хийгдсэн 22 зогсоол
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 65 зогсоол
- Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 111 зогсоол
- Жей Си Декогийн 229 зогсоол хийгдсэн байна.

Нийт 1280 зогсоолоос 34% нь тохижилттой, үлдэхдэл 66% тохижилтгүй байна. Тохижилттой зогсоолын 81 хувийг саравчтай зогсоол, 15 хувийг битүү зогсоол, 4 хувийг дулаан зогсоол эзэлж байна.

Жей Си Деко ХХК-ийн хөрөнгө оруулалтаар нийт 229 байршилд автобусны зогсоолын тохижилт хийж гүйцэтгэсэн бөгөөд 2026 онд 13 байршилд шинээр тохижилт хийхээр ажиллаж байна.



*Зураг №42. Зогсоолын судалгаа*

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/120 дугаар “Тээврийн хэрэгслийн зогсоолд үзлэг шалгалт зохион байгуулах тухай” тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээний автобусны эцсийн болон дундын зогсоолуудын байршлыг тогтоох, замын хөдөлгөөний аюулгүй байдал, стандартын шаардлагад нийцүүлэх асуудлыг холбогдох газруудтай хамтарч шийдвэрлэхээр НЗХГ, НХБХСГ, ТЦА хамтарсан 3 баг, дүүргүүдийн автобусны зогсоолуудын тооллогыг зохион байгуулж ажилласан.

Улаанбаатар хотын хэмжээнд нийт 1282 автобусны зогсоол тоологдсоноос 7,8% буюу 101 зогсоол хяналтын камертай байна. Мөн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлах дулаан зогсоолуудыг "Телекамерын хяналтын дэд төв"-д холбон, цэвэрлэгээ үйлчилгээ, арчлалт хамгаалалтыг тогтмолжуулан, байнгын ажиллагаатай байлгах тухай 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/02/2437 дугаартай албан бичгийг дүүргүүдийн засаг дарга нарт хүргүүлсэн.



*Зураг №43. Яармагийн эцсийн автобусны зогсоолд байрлах хяналтын камер*

## 2.1.3.Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчтой төлөвлөн эрэлтэд нийцсэн нийтийн тээвэр, зорчих зогсоолыг хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ. НЗДҮАХ-1.5.1.

Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны дарга, Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-ын захирал нарын хамтарсан А/72, А/78, А/34 дугаар тушаалаар 2025-2026 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолыг чөлөөлөх, замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий шуурхай ажиллагааны баг байгуулагдаж 2025 оны 08 дугаар сарын 18-аас 09 дүгээр сарын 19-ний өдрийг дуусталх

хугацаанд Нийтийн тээврийн бодлогын газрын 51 албан хаагч, 3 тээврийн хэрэгсэл тус тус ажилласан.


ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ ДАРГА,
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА,
"ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВ" ОНӨТҮГ-ЫН ЗАХИРЛЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

Шуурхай ажиллагааны баг байгуулах тухай


ШУУРХАЙ БАГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

ГУРАВ. ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУД

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

*Зураг №44. Тушаал болон ажлын удирдамж*





*Зураг №45. Ажлын хэсэг*

Замын хөдөлгөөний удирдлагын төвийн Хөдөлгөөн зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, Тээврийн цагдаагийн алба хаагч нартай хамтран замын хөдөлгөөний ачааллаас шалтгаалан бөөгнөрөл үүсэхээс сэргийлж, Энхтайваны өргөн чөлөөнд хөдөлгөөнд оролцож буй нийт 3247 нийтийн тээврийн хэрэгслийг 1 дүгээр эгнээгээр чөлөөтэй нэвтрүүлэх зохицуулалтыг тухай бүр хийж ажилласан.




*График 7. Зохицуулалт хийсэн тээврийн хэрэгслийн тоо*







*Зураг №46. Зохицуулалт хийх үеийн камерын хяналтын зураг*

Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолыг чөлөөлөх, замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий шуурхай ажиллагааны баг ажиллаж эхэлснээр Энхтайваны өргөн

чөлөөнд нийтийн тээврийн ашиглалтын  дундаж хурд 10.6 км/цаг байсан нь 12.9 км/цаг болж 18%-иар өссөн.




*График 8. Ашиглалтын хурдны үзүүлэлт*

Энхтайваны өргөн чөлөөнд нийтийн тээврийн ашиглалтын  дундаж хурд 2024 онд 10.1 км/цаг байсан нь 2025 онд 12.8 км/цаг болж 21%-иар өссөн.

Цаашид чиглэлийн тээврийн хэрэгсэлд зориулсан эгнээг нэмэгдүүлэхээр 3,4-р хорооллын эцсээс Цайз захын уулзвар хүртэл, 120 мянгатын уулзвараас Нисэхийн тойрог хүртэлх авто замыг чөлөөлөх асуудлыг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.



*Зураг №47. Шинээр камер байрлуулах шаардлагатай байршлын зураглал*

Тус газраас 2025 онд иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, түгжрэлээс шалтгаалсан нийтийн тээврийн хүлээгдлийн хугацааг багасгах зорилгоор богино эргэлтийн чиглэлүүдийг төлөвлөх ажлыг эхлүүлсэн.

Үүнд: Энхтайваны өргөн чөлөө дагуу М:1а "5 шар - Мөнгөн завъяа", М:1б "Офицеруудын ордон - Сүхбаатарын  талбай" чиглэлийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр нээсэн. Үндсэн М:1 "5 шар - Офицеруудын ордон" чиглэлийн энэ оны 01 дүгээр сарын зорчилт 1,357,280 байсан нь 04 дүгээр сард зорчилт нэмэгдсэн чиглэлүүдийн нийлбэрийн хамт 1,485,809 болж 128,529 зорчилтоор буюу 9.4 хувиар  нэмэгдсэн дүн гарсан.

Мөн Хан-Уул дүүрэгт зорчдог иргэдийн нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор богино эргэлтийн Ч:7А "Нисэх - 5 Богд компани", М:3А "Архивын ерөнхий газар - Таван богд компани" чиглэлийн үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс шинээр нээсэн.

Газрын даргын тушаалаар 3 чиглэлд зогсоол нэмэгдүүлсэн. Үүнд:

1.Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/05 дугаар тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж Ү:19, Ү:20, Ч:6, Ч:13, Ч:40, Х:8 чиглэлүүдэд "Гармын зогсоол"

2.Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/18 дугаар тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж М:6, Ч:61, Ч:70, чиглэлүүдэд “Дэлгэр хотхон” зогсоол

3.Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/18 дугаар тушаалаар автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж Ү:30, М:5 чиглэлүүдэд “Эрдэнэдрийлинг” ” зогсоолыг тус тус нэмж баяжилт хийсэн.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ. МУХТ 2025-2.2.2

### 3.1. Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох МУХТ 2025-2.2.2.3.

Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан автобусны элэгдлийн зардлыг ажилласан машин цагийн зардлаас суутган Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрүүлэх ажлыг тогтмол хийж хэвшсэн.

2025 оны эхний 10 сарын байдлаар 2024 онд их багтаамжийн автобус худалдан авсан хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас “Нийтийн тээврийн хэрэгслийг төлбөртэй ашиглуулах гэрээ”-ний дагуу 9,023.3 сая төгрөг, Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын санхүүжилтээс элэгдлийн зардалд 17,727.0 сая төгрөг, нийт 26,750.3 сая төгрөг төгрөгийг суутгаж, мөн улсын төсвийн хөрөнгөөр 2009 онд худалдан авсан 400 ширхэг автобусны өр төлбөрөөс автобус худалдан авсан Сутайн буянт ХХК, Автобус нэгдэл ХХК, Эрдэмтранс ХХК нийт 324.0 сая төгрөгийг тус тус төлүүлж Нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрүүлсэн байна.

Дээрх санд төвлөрсөн орлогоос 2025 онд хот орчмын зориулалттай их багтаамжийн 10 автобус, тусгай тоноглолтой 2 автобус, их багтаамжийн цахилгаан 15 ширхэг автобус, 11 ширхэг цэнэглэх төхөөрөмж, зогсоолын чиглэлийн мэдээллийн зураглалын үнэ төлбөр зэргийг шийдвэрлэсэн.




*График 9. Төвлөрүүлсэн мөнгөн дүн /2024-2025 оны эхний 10 сар, сая.төг/*



*График 2: 2025 онд Нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрсөн хөрөнгөөс шийдвэрлэсэн төсөл, арга хэмжээний жагсаалт*

2009 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 400 автобусны хуримтлагдсан өр төлбөрт 2 аж ахуйн нэгж байгууллага 180.1 сая төгрөгийн төлөлт хийсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээний орлого зардлын зөрүүг бууруулах, орлогоороо зардлаа нөхөн алдагдалгүй ажиллах бодлогын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд иргэд өдөрт 1000 төгрөгөөр хугацаа харгалзахгүйгээр өдөрт 4 удаа зорчих боломжийг бүрдүүлсэн. Боловсролын тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу оюутнууд хөлс төлж зорчиж эхэлсэн.

Мөн төлбөр тооцооны шинэ системийг хөгжүүлж, зорчигч төлбөрийн олон төрлөөс сонгон төлбөрөө төлөх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Шинэ тарифыг мөрдөж эхэлсэн 2025 оны 02 дугаар сард Нийтийн тээврээр 12.1 сая зорчигч тээвэрлэж, 4,404.9 сая төгрөгийн орлого олсон нь өмнөх оны мөн үеэс 2,5 сая зорчилтоор, орлого 2,333.3 сая төгрөгөөр, өмнөх сараас 1.0 сая зорчилтоор, орлого 1,031.2 тэрбум төгрөгөөр орлого тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2025 оны 04 дүгээр сард нийтийн тээврээр 14.3 сая зорчигч тээвэрлэн 5,019.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.6 сая зорчигч илүү тээвэрлэн 2124.4 сая төгрөг илүү төвлөрүүлсэн мэдээтэй байна.

## 3.2. Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гараашг барих НХТ 2025-111.

Орон нутгийн төсвийн 3,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гараашны барилгын зураг төслийг 2022 онд "Эрхэс констракшн" ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектураар батлуулсан.

Багануур дүүргийн "Тээвэр зохицуулалтын алба" ААТҮГ-ын Нийтийн тээврийн гараашны барилга барих ажлыг 2025 онд Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих ажлын гүйцэтгэгчээр Наран босголт ХХК шалгарч, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь заалтыг үндэслэн тус компанитай 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр гэрээ байгуулагдан 953.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажлын явц 30 хувьтай байна.





*Зураг №48. Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гараашг барих ажлын явц*

## 3.3.Хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлт хийж гүйцэтгэнэ.

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Юутонг бус ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу Yutong ZK6117H загварын их багтаамжийн MNS 4598:2011 стандартын 8.1.1 "Улс хоорондын, хот хоорондын, хот орчмын үйлчилгээнд ажиллах автобус нь 1-ээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар олон суудал, гар тээшний тавиураар тоноглогдсон, тээш хадгалах хонгил байна" дэх шаардлагыг хангасан 10 автобусыг 2025 оны 04 дүгээр 18, 24-ний өдрүүдэд 2 үе шаттай худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.



*Зураг №49. Шинээр нийлүүлэгдсэн 10 автобусыг хүлээн авч буй байдал*

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн  Х:18 “Тэнгэр плаза - Багахангай” чиглэлд 1, 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс Х:17 "Тэнгэр плаза - Багануур" чиглэлд 2, 05 дугаар сарын 02-ны өдрөөс  Х:19 “Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал - Сүхбаатарын талбайн төв зогсоол” чиглэлд 4, Х:20 "Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал - 5 шар" чиглэлд 3 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж эхэлсэн.




*Зураг №50. Шинээр нийлүүлэгдсэн 10 автобусаар үйлчилгээ үзүүлж буй байдал*

Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн Yutong маркийн дизель евро-5 хөдөлгүүртэй хот орчмын 10 автобусаар парк шинэчлэлт хийсэн.  Дээрх 10 тээврийн хэрэгсэл нь хот орчмын Багануур, Багахангай, Нисэх буудал /Хөшгийн хөндий/ чиглэлд  үйлчилгээ үзүүлж байна.

Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн Yutong маркийн дизель евро-5 хөдөлгүүртэй хот орчмын 10, skywell маркийн 15, zinhui маркийн 2, нийт 27 автобусаар парк шинэчлэлт хийсэн.

Хувийн хэвшлийн 6 аж ахуйн нэгж, байгууллага их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 84 автобусаар нөхөн хангалт хийсэн.

## 3.4.Нийтийн тээврийн мастер төлөвлөгөөнд санал тусгах НХТ 2025-98, НХТЖҮЧ-9.23.1

Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн Бүрэлдэхүүн хэсэг 3.1-ийн хүрээнд "Нийтийн тээврийн стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээ"-Т.Гандиймаа хэрэгжүүлэхээр Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн (Монгол), Far East BRT Planning (Хонг Конг) компанийн түншлэлтэй гэрээ байгуулан ажиллаж байна.

Тус зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын дагуу Эхлэлийн тайлан, Дүн шинжилгээний тайлан, Нийтийн тээврийн стратеги болон Нийтийн тээврийн стратегийн төлөвлөгөө тус тус боловсруулагдана. Зөвлөх багаас Улаанбаатар хотын "Нийтийн тээврийн дүн шинжилгээ"-ний тайланг оролцогч талуудын саналын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр тус газарт засварлан ирүүлсэн.

"Нийтийн тээврийн дүн шинжилгээ"-ний тайланг ирүүлсэнтэй танилцаж, тайланд анхаарч, нэмж тусгах саналыг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр 01/02/355 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Улаанбаатар хотын Нийтийн тээврийн стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээний STRA-C3 дугаартай гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан гэрээний хугацаа сунгах, санхүүжилтийн эх үүсвэрийг өөрчлөх, түншлэл хасах болон холбогдох голлох мэргэжилтнүүдийг солих нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулж, зөвлөх компаниас ирүүлсэн нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт, гэрээний төсөл болон хурлын тэмдэглэлийг төсөл хэрэгжүүлэгчээс хянан, зөвлөх үйлчилгээний гэрээний сунгалтын төслийг боловсруулан, 4 дүгээр сарын 29-ний өдөр Нийслэлийн засаг даргын тамгын газарт 195 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Гэрээний сунгалтын төслийг захиалагч талаас 5 дугаар сарын 19-ний өдөр баталгаажуулав. Зөвлөх багийн зарим гишүүд өөрчлөгдсөнтэй холбогдуулан, 5 дугаар сарын 29-ний өдөр уулзалт зохион байгуулж, цаашид хийх ажлын төлөвлөгөө, мөн зөвлөхүүдийн биечлэн ирж ажиллах хугацааны талаар хэлэлцэн, харилцан санал солилцсон. Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын дагуу Эхлэлийн, дундын тайлан, Дүн шинжилгээний тайлантай танилцсан.

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын баталсан техникийн дэмжлэг үзүүлэх ажлын хэсэг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр зөвлөх багтай уулзалт зохион байгуулж, стратеги төлөвлөгөөтэй танилцан холбогдох саналыг өгсөн. Мөн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр "Нийтийн тээврийн стратеги болон стратегийн төлөвлөгөө"-г Нийтийн тээврийн бодлогын газрын даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, холбогдох санал, зөвлөмжийг хүргүүлсэн.

2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр оролцогч талуудад хэлэлцүүлэг зохион байгуулж санал авч, Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээврийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн.

Төсөл хэрэгжүүлэгч нэгжээс 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар "Улаанбаатар хотын Нийтийн тээврийн стратеги болон стратегийн төлөвлөгөө"-г танилцуулж, дэмжигдсэн бөгөөд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар танилцуулж, цаашид Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүлж, батлуулахаар шийдвэрлэсэн.

2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Нийтийн тээврийн стратеги болон төлөвлөгөөг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Зөвлөлийн хуралдаанаар, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Хурал дахь МАН-ын бүлгийн хуралдаанаар тус тус танилцуулсан. Тус стратеги болон төлөвлөгөөг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр НИТХ дахь АН-ын бүлгийн хуралдаан, 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн НИТХ-ын Ээлжит бус VIII хуралдаанаар тус тус танилцуулахаар төлөвлөсөн.

Зөвлөх багтай 7 хоног тутмын Пүрэв гарагийн 9 цагаас уулзалт зохион байгуулж, зөвлөх үйлчилгээний ажлын явцын талаар хэлэлцэн, харилцан санал солилцдог. Төслийн нэгжээс Улаанбаатар хотын Нийтийн тээврийн стратеги төлөвлөгөө боловсруулах эцсийн тайланг боловсруулж ирүүлсэнтэй танилцан 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 01/02/2216 дугаартай албан бичгээр нэмэлтээр тусгах шаардлагатай 36 саналыг нэгтгэж хүргүүлсэн. Улаанбаатар хотын Нийтийн тээврийн стратегийн эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан. Ингэснээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны хурлаар хэлэлцүүлж батлуулах бэлтгэл ажил хангагдана.




*Зураг №51. Газрын даргын зөвлөлийн хурлаар Нийтийн тээврийн стратеги төлөвлөгөөний төслийг хэлэлцэв.*

## 3.5.Дүүжин замын тээвэр, Метро, BRT, Трамвай төслийг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд мэдээ, мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж хамтран ажиллах. НХТ 100, 101, 102, НХТЖҮЧ 9.21.1. МУХТ 2025-2.2.2.1, 2.2.2.2.

### 3.8.1.Тодорхой төрлийн нийтийн тээврийн төрөл, автозамын төсөл арга хэмжээний талаар.

Дүүжин тээвэр

Тээвэрлэх хурд 21 км/ц салхины тэсвэрлэлт 70км/ц, хүчин чадал 2320 хүн/ц, зогсоолын хэмжээ 20*30м, кабины багтаамж 10 зорчигч, аялах хугацаа 10 минут.

Уг төсөл нь Монгол Улс болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд хийгдэж байгаа дүүжин тээврийн 2 трасс бүхий замтай хийгдэхээр төлөвлөгдсөн.

Төслийн нэгдүгээр үе шатанд 2023-2025 онд хэрэгжих Хан-Уул дүүргийн Яармагийн Арцатын амнаас Сонгинохайрхан дүүргийн Өнөр хорооллыг холбосон трасс 2025 оны 02 сард барилга угсралтын ажлын бэлтгэл ажлыг хангаж, 2025 оны 02 дугаар сараас 2025 оны 08 дугаар сард 1-р шугамын барилга угсралтын ажил хийгдэж, 2025-2026 онд 2-р шугамын ажил хийгдэх төлөвлөлттэй. Одоогоор нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн тээврийн шугам байгуулах ажил Хан-Уул дүүргийн Яармагийн эцсийн зогсоолоос Сонгинохайрхан дүүрэг хүртэлх 4.2 км талбайд хийгдэж байна.

Төслийн хоёрдугаар үе шатанд 2025-2026 онд хэрэгжих бөгөөд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр Маршлын гүүр хотын төв Шангрила зочид буудлыг холбосон 3 зогсоолыг дайран өнгөрөх, 70-74 кабин бүхий 2.8 км үргэлжлэх дүүжин тээврийн 2 дахь трассын ажил нэгдүгээр трассын ажлын дараа үргэлжлэн хийгдэнэ.

Дүүжин замын тээвэр төслийн нэгдүгээр шугам буюу Яармаг, Арцат – Хархорин, Өнөр хороолол чиглэлд тулгуур багана байрлуулах ажил хийгдэж эхэлсэн. Туул голын ай сав газар байрлалтай 3-9 дүгээр тулгуур баганын нийт 28ш шон суурийн өрөмдлөг, арматурчлал, бетоны ажил хийгдсэн. Дүүжин замын тээврийн төрлийн Европын Холбооны стандартыг нутагшуулах зорилгоор “Хүн тээвэрлэх зориулалттай дүүжин замын тээврийн байгууламжийн аюулгүй байдлын шаардлага”-тай холбоотой 15 стандартыг СХЗГ-ын Авто тээврийн стандартчиллын техникийн хороогоор батлуулан, MNS бүртгэлд шилжүүлсэн. Газар чөлөөлөлтийн ажилд улс, нийслэлийн төсвөөс хөрөнгө зарцуулаагүй, аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд уг төслийг дэмжсэн. Мөн 13 дугаар тулгуурын нөлөөлөлд өртсөн газрын асуудлыг шийдвэрлэхээр тохирч “БҮК” ХК-тай сервитутын гэрээ байгуулсан.

Дүүжин замын тээврийн төслийн хоёрдугаар шугам буюу Үндэсний соёл амралтын хүрээлэнгээс Үндэсний цэцэрлэгт хүрээлэн чиглэлийн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил эхэлж, дэд бүтэц, суурь судалгааны ажлууд хийгдэж эхэлсэн. Дээрх хийгдсэн ажлын хүрээнд дүүжин замын тээвэр төслийн нэгжийг мэдээ мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна.




*Зураг №52.Дүүжин замын тээвэр*

Метро
Шугамын урт – 19,4 км
Өртөөний тоо- 14
Өртөө хоорондын зай- 1,3 км
Депо-1
Аялалын хугацаа- 27 минут
Дундаж хурд- 39,2 км/ ц
Цагт тээвэрлэх зорчигч-17,200
Хэрэгжих хугацаа 2024-2030 он
Трассын урт-17.7 км

2024-2030 онд хэрэгжих Амгалан эцэс-Толгойт эцэс чиглэлд 17.7 км урттай их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах ажлын хэсгийн 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигтэй танилцаж, хуралдсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Духуа Инженеринг ХК их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро барих төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерт шалгарсан.

Метро төслийн шинэчлэн боловсруулсан ТЭЗҮ-ийг холбогдох яамдын мэргэжлийн зөвлөл, НИТХ-ын салбар хороод, намын бүлгүүдээр үе шаттай хэлэлцэж дэмжсэн. Их багтаамжийн нийтийн тээвэр Улаанбаатар метро барих төслийн бүтээн байгуулалтын ажлын (EPC) гүйцэтгэгчийг шалгаруулах хоёрдугаар шатны тендерийн баримт бичигт санал, зөвлөмж өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, 2025 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар тендерийн баримт бичгийг хэлэлцэж холбогдох санал, мэдээллийг өгсөн.



*Зураг №53. Ажлын хэсгийн хурлаар тендерийн баримт бичгийг хэлэлцэж холбогдох санал, мэдээллийг өгч буй байдал*

Тус хөтөлбөртэй Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн холбогдох мэргэжилтнүүд танилцан, санал хүргүүлсэн. Одоогоор хамтарсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах болон хамтран ажиллах Бүгд Найрамдах Солонгос Улсын их сургуулийг тодорхойлох судалгаа, уулзалтууд хийгдсэн.




*Зураг №54. Улаанбаатар метро*

**“Тусгай замын их багтаамжийн автобус төсөл” (BRT)**

Трассын урт: 12км (Phase 1)

Буудлын тоо: 20

Автобусны тоо: 200

BRT чиглэлийн нийтийн тээврийн өдрийн зорчигч урсгал 25’000–35’000, автобусны дундаж хурд 20–25 км/ц болж нэмэгдэн, уг замналын дагуу үйлчилдэг нийтийн тээврийн хэрэгслийн одоогийн дундаж хүлээгдлийн хугацаа 11.5 минут, байгаа нь төсөл хэрэгжсэнээр 3-4 минут болж буурах тооцоолол төслийн нэгжээс хийгдсэн.




*Зураг №55. Тусгай замын их багтаамжийн автобус төслийн зураг төсөл*

Санхүүгийн эх үүсвэр Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлээр 2024-2028 онд хэрэгжих төлөвлөлттэй.

Нийслэл Улаанбаатар хотын тээврийн зорчилтыг нэмэгдүүлэх ТТ 6688 МОН төслийн хүрээнд хэрэгжүүлэх “Тусгай замын автобусны төлөвлөлт ба зураг төсөл сэдэвт семинар” 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уг семинарт Far East BRT Planning Co Limited Компани нийтийн тээврийн тусгай замын автобус зорчих трассын талаар танилцуулсан ба Far East Mobility зөвлөх компанийн урьдчилсан судалгаагаар 21-р хороолол, Толгойт–Ард Аюушийн өргөн чөлөөг холбох шинэ гудамж замын дагууд Их тойруу, Сансарын тойрог хүртэл 12.6 км трассыг урьдчилсан байдлаар тогтоосон.

Нийслэл хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр шалгарсан зөвлөх баг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай уулзалт хийж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.

Урьдчилсан байдлаар Ард-Аюушийн өргөн чөлөө, Их тойруу, Сүхбаатар талбай хүртэлх трассыг хийх ба 2025 оны 01 дүгээр сард загвар зураглалыг бэлэн болгож, 2025 оны 04 дүгээр сард нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулалтын ажлыг хийхээр төлөвлөсөн.

“Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн сайжруулалт” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтаар тусгай замын автобус төслийн үйл ажиллагаа, санхүү, дэд бүтцийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг хэлэлцсэн. Азийн хөгжлийн банк нь “Тусгай замын автобус BRT төсөл”-ийн санхүүжилтийн зээлийн судалгааны ажлын хэсэг байгуулан 2025 оны 04 дүгээр сарын 28-наас 5 дугаар сарын 09-ний хооронд Улаанбаатар хотод ажилласан. Тус томилолтын хүрээнд холбогдох байгууллагуудыг хамруулсан 10 өдрийн уулзалтыг зохион байгуулсан бөгөөд хэлэлцэх асуудлын хүрээнд 4 өдрийн уулзалтад оролцож, мэдээ мэдээлэл солилцож санал хүргүүлсэн.



*Зураг №56. “Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн сайжруулалт” сэдэвт зөвлөлдөх уулзалт*

**Тарамвай (LRT)**

Замын урт: Шугам-1: 10,2 км, Шугам-2: 14,1 км

Замын хөдөлгөөний дундаж хурд: Шугам-1: + 10,8%, Шугам-2: + 14.9%

Өртөөний тоо: Шугам-1: 16, Шугам-2: 25

Өртөө хоорондын зай: 500-700 метр

Өртөөний эцсүүд: Буянт-Ухаа – Д.Сүхбаатарын талбай-Зунжин

Хэрэгжих хугацаа: Шугам 1: 2025.01-2027 оны 10 сар, Шугам 2: 2025-2031 он

"Буянт-ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл", "Буянт-ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл "-үүдийн техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг төслийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ боловсруулахаар шалгарсан. Тус ажлын дагуу Трамвайн замын төлөвлөлтийн трассын зураг төсөлд тусгах саналыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/02/1003 дугаар албан бичгээр хүргүүлсэн.




*Зураг №57. Хөнгөн галт тэрэг Тарамвай (LRT) төслийн зураг төсөл*

“Улаанбаатар Трам” төслийн 1 болон 2 дугаар шугамын ТЭЗҮ-техник эдийн засгийн үндэслэлийг 2025 оны 7 дугаар сард Зам тээврийн яамны дэргэдэх Шинжлэх Ухаан Техникийн

дэд зөвлөлүүд, Зам Тээврийн Хөгжлийн Төвийн магадлал зэрэг мэргэжлийн зөвлөлүүдээр хэлэлцүүлэн батлагдсан байна.

**“Туул хурдны зам” төсөл**

Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр Эмээлтийн тойргоос Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр Улиастайн гүүрийг холбосон 33 км урт, 6 эгнээ, 8 байршилд гүүрэн байгууламж бүхий хурдны замын ТЭЗҮ хийгдэж байна.

Уг зам хийгдсэнээр уулзваруудын нэвтрүүлэх чадвар 7-23%-иар нэмэгдэх тооцоололтой.

**“Шинэ тойрог зам” төсөл**

Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих Шинэ тойрог зам нь Туулын хурдны замын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрийн төгсгөл хэсгээс Амгалан дэд төв, Сэлбэ дэд төв, Баянхошуу дэд төвүүдийг холбосон Сонгинохайрхан нутаг дэвсгэр Эмээлт хүрэх 3 байршилд олон түвшний огтлолцох, 4-6 эгнээ, 13.4 км урт замын ажил.

Уг төсөл нь 2028 онд хэрэгжиж дуусахаар ТЭЗҮ, Ажлын зураг боловсруулах төслийн тендер зарлагдсан.

Хавсралт 1. Улаанбаатар хотод төлөвлөж буй авто замын трасс




*Зураг №58. Улаанбаатар хотод төлөвлөж буй авто замын трасс*

Мөн Яармагийн шинэ зам (ойролцоогоор 8 км), Улаанхуарангийн замын өргөтгөл (ойролцоогоор 4 км) шинээр барих ажлын ТЭЗҮ боловсруулах, шинэчлэх, нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилгын хяналт хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний эхлэлийн тайлан, Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт тусгуулах саналаа төсөл хэрэгжүүлэх нэгжүүдэд хүргүүлсэн.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

### 4.1.2025 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу үндсэн үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Тус газрын 2025 оны 1-10 дугаар сарын гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого дараах байдалтай байна. Үүнд:

- Орлого зардлын зөрүү санхүүжилтээс 6,067.6 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 1-10 дугаар сарын гүйцэтгэлээр 488.5 сая төгрөг, бэлэн мөнгөний орлогоор 9,271.6 сая төгрөгийг тус тус төвлөрүүлж төлөвлөгөөг 60.8 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Түр зөвшөөрөлийн хураамжаас 840.6 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 1-10 дугаар сарын гүйцэтгэлээр 899.4 сая төгрөг төвлөрч, 107 хувийн гүйцэтгэлтэй байна.
- ТҮЦ машины орлогоос 253.8 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 192.7 сая төгрөг төвлөрч, 75.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

- Замын хуудасны хураамжаас 5.5 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 2.5 сая төгрөг төвлөрч 45.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Дээрх задаргаанаас авч үзвэл 2025 онд үндсэн үйл ажиллагааны орлого 7,167.5 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 1-10 дугаар сарын гүйцэтгэлээр 10,854.7 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 316.6 сая төгрөг, нийт 11,171.3 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний гүйцэтгэл 55.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

*График 2*




*График 10: Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /2025 он 10 сар өссөн дүнгээр, сая.төг/*




*График 11: 2025 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /ХБГ-ээр, сая.төг/*

### 4.2.2025 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний дагуу туслах үйл ажиллагааны орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу 2025 онд туслах үйл ажиллагааны орлого 221.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 01-10 дугаар сарын гүйцэтгэл 393.4 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэл 78.6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 113 хувиар давуулан биелүүлсэн байна.

*График 4*




*График 12: Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/2025 он 10 сар өссөн дүнгээр, сая.төг/*

*График 5*




*График 13: 2025 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /ХБГ-ээр, сая.төг/*

### 4.3.Улаанбаатар смарт карт ХХК-аас ирүүлсэн тухайн сарын ажлын гүйцэтгэл, шугамын орлого, зорчигчийн мэдээг хянаж машин цагийн зардлын санхүүжилтийг тооцон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад олгоно.

Нийтийн тээврийн бодлогын газар нь "Улаанбаатар Смарт карт" ХХК-иас ирүүлсэн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ажлын гүйцэтгэлийн тайлан, аж ахуйн нэгж, байгууллага тус бүрд хуваарилагдсан шугамын орлогын тайлан болон хуваарилагдсан нөхөн олговор, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 26 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/290 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүү санхүүжилтийн тооцоог гарган, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулан олгон ажиллалаа.

**Орлого, зардлын зөрүү санхүүжилтийн 2025 оны эхний хагас жилийн төсөв, гүйцэтгэл /ХБГ/:**

Батлагдсан төсөв
- 284,901.4 сая төгрөг

Гүйцэтгэл санхүүжилт/ХБГ
- 328,665.3 сая төгрөг

Төсвийн хэтрэлт
- 43,778.0 сая төгрөг

2025 онд машин цагийн зардлын санхүүжилтэд 284,901.4 сая төгрөг батлагдсанаас 2024 оны 12 дугаар сарын гүйцэтгэл 31,834.3 сая төгрөгийг, мөн 2025 оны эхний 10 сард 296,831.1 сая төгрөгийн гүйцэтгэлээс 253,053.1 сая төгрөг, нийт 284,887.4 сая төгрөгийг тус тус олгож, жилийн нийт батлагдсан төсвөөс 43,778.0 сая төгрөгөөр хэтэрсэн.

Эх үүсвэр дутагдаж, нийтийн тээврийн үйлчилгээ доголдох эрсдэлтэй байгаа талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 0/06/1454 дугаартай, 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01/06/1851 дугаартай албан бичгээр хүргүүлж, төсвийн тодотголд саналыг хянуулан тусгасан.

Төсөв хэтэрсэн шалтгаан нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/14 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн хэрэгслийн төлбөрийн хэмжээ"-г мөрдөж эхэлсэн, парк шинэчлэлтийн хүрээнд их багтаамжийн 15 цахилгаан автобус, хот орчмын зориулалттай 10 автобус нийлүүлэгдэж гаралт нэмэгдсэн зэрэг нь тус тус нөлөөлсөн байна.

*Хүснэгт 10: 2025 оны эхний 10 сарын санхүүжилтийн мэдээлэл /сая.төг/:*

| Д/д | ААНБ-ын нэр | Гүйцэтгэл | | |
|---|---|---|---|---|
| | | **Ажилласан машин цаг** | **Олгох санхүүжилт** | **Дутуу санхүүжилт** |
| 1 | Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ | 626396:41:30 | 40,175.0 | 4,398.8 |
| 2 | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ | 538514:36:00 | 30,364.7 | 3,406.7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ | 535983:32:30 | 36,652.5 | 3,623.4 |
| 4 | Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ | 381746:21:30 | 26,347.0 | 2,602.9 |
| 5 | Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ | 493907:40:30 | 32,164.9 | 3,374.0 |
| 6 | Автобус нэгдэл ХХК | 92875:55:00 | 5,836.0 | 587.8 |
| 7 | Автотерминал трейд ХХК | 176460:49:00 | 11,783.7 | 1,313.7 |
| 8 | Блюбус ХХК | 141302:13:30 | 8,077.2 | 815.4 |
| 9 | ГБУС ХХК | 84649:14:00 | 5,366.5 | 568.2 |
| 10 | ДЮЦ ХХК | 79600:04:00 | 5,012.1 | 493.3 |
| 11 | Мяралзаа ХХК | 83846:04:00 | 5,294.5 | 593.8 |
| 12 | Сайхан ирээдүй ХХК | 45147:07:00 | 3,039.0 | 392.4 |
| 13 | Сутайн буянт ХХК | 284098:33:30 | 16,786.8 | 1,692.2 |
| 14 | Трансбус ХХК | 294042:39:00 | 17,519.7 | 1,807.5 |
| 15 | Тэнүүн-Огоо 3-р бааз ХХК | 0:00:00 | 93.8 | - |
| 16 | Үнэгтийн уул ХХК | 35657:33:00 | 1,963.8 | 229.2 |
| 17 | Эмсид ХХК | 168082:27:00 | 9,644.5 | 815.4 |
| 18 | Эрдэм транс ХХК | 396132:30:30 | 24,214.7 | 2,571.4 |
| 19 | Эс Энд Эй Транс ХХК | 92547:33:30 | 5,091.4 | 483.9 |
| 20 | Улаанбаатар смарт карт ХХК | | 37.1 | (2.8) |
| 21 | Нийтийн тээврийн бодлогын газар | | 5,055.3 | 4,566.8 |
| 22 | Нийтийн тээврийг хөгжүүлэх сан | | 35,455.5 | 8,706.2 |
| 23 | Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК | | 2,689.9 | 738.8 |
| Нийт | | 4550991:35:00 | 328,665.3 | 43,778.0 |

*Хүснэгт 11: 2023-2025 оны эхний 10 сарын орлого, зардлын зөрүү санхүүжилтийн харьцуулалт /сая.төг/:*

| Сар | 2023 он | 2024 он | 2025 он | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| 1 сар | 13,079.0 | 14,000.0 | 63,005.9 | 49,005.9 | 350% |
| 2 сар | 12,883.5 | 14,454.5 | 26,170.2 | 11,715.7 | 81% |
| 3 сар | 14,244.6 | 24,833.0 | 29,263.8 | 4,430.8 | 18% |
| 4 сар | 13,788.9 | 26,440.9 | 28,755.9 | 2,315.0 | 9% |
| 5 сар | 14,358.7 | 28,630.1 | 30,148.6 | 1,518.5 | 5% |
| 6 сар | 14,015.7 | 27,033.8 | 29,230.1 | 2,196.3 | 8% |
| 7 сар | 12,798.1 | 28,162.1 | 29,822.5 | 1,660.4 | 6% |
| 8 сар | 12,964.7 | 28,007.2 | 30,099.9 | 2,092.7 | 7% |
| 9 сар | 12,994.4 | 28,750.4 | 29,949.5 | 1,199.1 | 4% |
| 10 сар | 13,553.8 | 29,822.9 | 32,219.0 | 2,396.1 | 8% |
| Нийт | 134,681.4 | 249,595.9 | 328,665.3 | 78,530.5 | 50% |

Дээрх хүснэгтээс харахад тайлант оны эхний 10 сард орлого, зардлын зөрүү санхүүжилт өмнөх оны мөн үеэс 50 хувиар нэмэгдсэн нь 2025 оны 01-02 дугаар сарын санхүүжилт өмнөх оны тухайн саруудаас огцом нэмэгдсэнтэй холбоотой байна.

2025 онд санхүүжилт нэмэгдэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн. Үүнд:

2024 оны 12 дугаар сарын гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сард олгосон.

Өмнөх оны 03 дугаар сараас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 26 дугаар тогтоол хэрэгжиж эхэлсэн.

Тайлант онд гүйцэтгэсэн машин цаг 390.0 мянган цагаар өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн байна.

### 4.4.Сургуулийн автобусны санхүүжилт:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1298 дугаар захирамжийн дагуу сургуулийн автобусны тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг удирдлага мэдээллийн

цахим төлбөрийн систем, Нийслэлийн боловсролын газраас ирүүлсэн мэдээллийг тус тус үндэслэн сургуулийн автобусны тээвэрлэлтийн зардлыг тооцдог.

Сургуулийн автобусны тээвэрлэлттэй холбоотой санхүүжилтэд 2025 оны эхний хагас жилээр 1,777.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас эхний 5 сарын гүйцэтгэлээр 1,763.0 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 246.1 сая төгрөг, нийт 2,009.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, санхүүжилт 232. сая төгрөгөөр хэтрэхээр байна.

*График 14*




## 4.5.Нийтийн тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж, орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийтийн тээврийн төлбөрийн систем нэвтрүүлнэ. НХТ-424.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар хуралдаанаар Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифт өөрчлөлт оруулах 25/14 дүгээр тогтоолыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж иргэд 1000 төгрөгөөр хугацаа харгалзахгүйгээр өдөрт 4 удаа зорчих боломжтой болсонтой холбоотойгоор 2025 оны эхний 10 дугаар сард шугамын орлого 46,652.1 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 67.1 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Энэхүү өсөлтөд зорчих тариф нэмэгдснээс гадна банкны картын 7,324.4 сая төгрөг, бэлэн мөнгөний орлогын 9,261.4 сая төгрөгийн орлогууд нөлөөлсөн байна.



| | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
|---|---|---|---|---|---|
| 1 сар | 1,244.5 | 2,374.8 | 2,432.3 | 2,526.5 | 3,215.1 |
| 2 сар | 1,074.0 | 2,144.9 | 2,218.0 | 2,071.6 | 4,358.7 |
| 3 сар | 2,076.8 | 3,082.1 | 2,857.0 | 2,697.7 | 4,375.4 |
| 4 сар | 1,201.1 | 3,094.9 | 2,866.8 | 2,894.8 | 4,999.3 |
| 5 сар | 2,046.8 | 3,065.3 | 3,049.0 | 2,899.4 | 5,076.6 |
| 6 сар | 2,237.3 | 2,592.1 | 2,609.1 | 2,674.8 | 4,578.7 |
| 7 сар | 1,944.5 | 2,136.7 | 1,983.9 | 2,448.5 | 3,671.4 |
| 8 сар | 2,620.6 | 2,925.7 | 2,731.1 | 3,029.3 | 4,682.3 |
| 9 сар | 3,083.2 | 3,238.0 | 3,024.8 | 3,144.1 | 5,985.4 |
| 10 сар | 3,107.7 | 3,010.3 | 2,915.3 | 3,196.4 | 5,716.0 |

*График 15: 2021-2025 оны эхний 10 сарын шугамын орлогын харьцуулалт /сая.төг/*




| | 2021 он | 2022 он | 2023 он | 2024 он | 2025 он |
|---|---|---|---|---|---|
| 1 сар | 5.0 | 9.4 | 10.4 | 10.9 | 12.7 |
| 2 сар | 4.3 | 9.0 | 9.4 | 9.6 | 12.6 |
| 3 сар | 8.2 | 13.1 | 12.7 | 12.7 | 12.9 |
| 4 сар | 4.7 | 13.3 | 12.8 | 13.7 | 15.1 |
| 5 сар | 7.9 | 13.4 | 13.6 | 13.7 | 15.2 |
| 6 сар | 8.7 | 11.1 | 11.3 | 11.6 | 12.9 |
| 7 сар | 7.6 | 8.9 | 8.4 | 9.6 | 10.4 |
| 8 сар | 10.0 | 11.7 | 11.3 | 11.7 | 15.9 |
| 9 сар | 11.9 | 13.5 | 13.3 | 13.5 | 16.9 |
| 10 сар | 12.4 | 13.0 | 13.4 | 14.0 | 16.5 |

*График 16: 2021-2025 оны эхний 10 сард тээвэрлэсэн зорчигчдын тоо /сая.хүн/*

Оны эхнээс 115 чиглэлд үйлчилгээнд ажиллаж байгаа их болон дунд багтаамжийн 1186 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж. давхардсан тоогоор 49245 тээврийн хэрэгсэлд 59208 зорчигчдыг шалгаж, бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлс төлөөгүй зэрэг нийт 98885 зөрчил илрүүлж, 37547 зорчигчийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс татгалзан, зорчуулахгүй буулгаж, 61946 зорчигчийн картанд Easy pay /изи пей/ посын цэнэглэлтээр 3.028.398.200 мянган төгрөгийн цэнэглэлт хийж ажилласан.

Өмнөх онд 1,774,500,000 төгрөгийн посын цэнэглэлт хийж ажилласан бол 2025 онд 3,028,398,200 төгрөгийн цэнэглэлт хийсэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40 хүртэл хувиар өссөн үзүүлэлттэй байна.



*Зураг №59. Шугам замд зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавьж байгаа байдал.*

### 4.6.Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ.

Нийтийн тээврийн бодлогын газар нь улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд дараах ажил арга хэмжээг зохион байгуулаад байна. Үүнд:

1. Нийтийн тээврийн хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/13 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн

НТБГ/20250103002 дугаартай Нийслэлийн Нийтийн тээврийн зогсоолын байгууламжийн чиглэлийн мэдээллийн зураглалыг автоматаар боловсруулах системийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг үндэслэн нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан. Тус тендерт хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн “Дата Дэүс” ХХК-тай 184.0 сая төгрөгөөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2.3 дахь заалтыг үндэслэн гэрээ байгуулах эрх олгоод байна.

2.Нийтийн тээврийн хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон “Юүтонг бус” ХХК-ийн хооронд байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36.1.3 дах заалтад заасныг баримтлан нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж талуудын хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн №НЗДТГ/202310014-03 дугаартай “Нийтийн тээврийн автобус нийлүүлэх нэмэлт гэрээ”-г байгуулж, 3,008.0 сая төгрөгөөр Евро-5 хөдөлгүүртэй их багтаамжийн 10 автобус худалдан авах ажлыг зохион байгуулсан.

3. Тус газрын 2025 оны урсгал зардлын батлагдсан төсөвт тээвэр шатахууны зардал 35.0 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд энэхүү төсвийн хөрөнгөөр шатахуун нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох НТБГ/20250102003 дугаар тендер шалгаруулалтыг хялбаршуулсан байдлаар цахимаар зарласан.

Тус тендерт хамгийн сайн үнэлэгдэн шалгарсан “Сод монгол групп” ХХК-тай 34.5 сая төгрөгөөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2.3 дахь заалтыг үндэслэн гэрээ байгуулж шатахуун худалдан авч байна.

### 4.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу төрийн худалдан авах ажиллагааны (tender.gov.mn) цахим системээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, худалдан авах үйл ажиллагааны чанарыг сайжруулах, ил тод байдлыг дээшлүүлэх талаар 2025 онд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Үүнд:

1. Тус газарт худалдан авах чиглэлээр шалгалт өгч, худалдан авах үйл ажиллагааны мэргэшсэн ажилтан байхгүй тул "Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх" сургалтад төсвөөс сургалтын төлбөрийг шийдвэрлэн 7 албан хаагчийг хамруулаад байна.

2. Олон нийтийн оролцоонд тулгуурласан хяналтыг сайжруулах зорилгоор зохион байгуулж байгаа худалдан авах үйл ажиллагааны үнэлгээний хороо болон ажлын хэсэгт 2-оос доошгүй төрийн бус байгууллагын мэргэшсэн ажилтнуудыг оруулан үйл ажиллагааны ил тод байдлыг нээлттэй, үр дүнтэй, чанартай зохион байгуулахад анхаарч ажиллалаа.

3. Бараа ажил үйлчилгээ худалдан авах ажлыг зохион байгуулахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу холбогдох заалтыг баримтлах, гэрээ хэлцэл байгуулан, үнийн харьцуулсан судалгаа хийн хяналт тавьж, тайлагнаж ажиллаж байна. Мөн Төрийн худалдан авах ажиллагааны газарт бүртгэлтэй цахим дэлгүүрээс худалдан авалт хийх, тухайн төрлийн бараа үйлчилгээ эрхэлж байгаа дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих чиглэлээр худалдан авалтыг хийх, 2025 оны батлагдсан төсвийн дагуу 20.0 сая төгрөгийн босго үнээс дээш гарч байгаа зардлыг ангилан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулан, цахимаар тендер зарлан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан ажиллаж байна.

Тус газраас төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр:

-Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/13 дугаар захирамжийн хүрээнд “Нийтийн тээврийн зогсоолын байгууламж дахь чиглэлийн мэдээллийн зураглалыг автоматжуулах систем байгуулах тухай”

-Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны А/58 дугаар тушаалын дагуу байгууллагын албан хэрэгцээнд шатахуун нийлүүлэгчийг сонгон шалгаруулах зэрэг ажлуудыг амжилттай зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

### 4.8.Холбогдох хуулийн дагуу нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих иргэдийн зорчилтын гүйцэтгэлд үндэслэн нөхөн олговрыг тээврийн үйлчилгээг эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад олгоно.

Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчсон иргэдийн нөхөн олговрын санхүүжилтийг Монгол улсын засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан журам болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 6/21 дугаар тогтоолоор батлагдсан журмаар тус тус зохицуулдаг.

Оюутан болон мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн суралцагчдын нөхөн олговрыг 2025 онд үнэ төлбөртэй болгохоор хуулийн зохицуулалт хийгдэж, хэрэгжиж эхэлсэн ба энэ оны төсөвт ахмад настай иргэний нөхөн олговорт нийт 29,761.1 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн олговорт 7,032.3 сая төгрөг, цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдыг үнэ төлбөргүй тээвэрлэх нөхөн олговорт 1,945.4 сая төгрөг, нийт нөхөн олговрын санхүүжилтэд 38,738.8 сая төгрөг батлагдсан.

**Нөхөн олговрын санхүүжилтийн 2025 оны эхний хагас жилийн төсөв, гүйцэтгэл /ХБГ/:**

Батлагдсан төсөв
•38,738.8 сая төгрөг

Гүйцэтгэл санхүүжилт/ХБГ
•35,268.6 сая төгрөг

Төсвийн хэтрэлт
•483.2 сая төгрөг

Жилийн нийт батлагдсан төсвөөс эхний 10 сард нийт 35,268.6 сая төгрөгийн гүйцэтгэл, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3,953.4 сая төгрөг, нийт 2025 онд 39,222.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарч тайлант оны батлагдсан төсвөөс 483.2 сая төгрөг хэтэрснийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 0/06/1454 дугаартай, 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01/06/1851 дугаартай албан бичгээр хүргүүлж, төсвийн тодотголд саналыг хянуулан тусгуулсан.

Төсөв хэтэрсэн нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/14 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн хэрэгслийн төлбөрийн хэмжээ"-г мөрдөж эхэлсэн, мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 246 дугаар тогтоолын 4.3 дахь хэсэгт Ахмад настны тухай хуулийн 8.1.6, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.8-д заасны дагуу нийтийн тээврээр зорчсон төлбөрийг нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ" гэж заасны дагуу төлбөрийг нийслэлийн/батлагдсан/ төсвөөс санхүүжүүлж эхэлсэн зэргээс шалтгаалсан байна.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад 2024 онд төсвийн жил дуусахтай холбоотойгоор нөхөн олговрын санхүүжилтийг хүлээгдэж буй гүйцэтгэлээр олгосныг 2025 оны 01 дүгээр сард бодит гүйцэтгэлд үндэслэн тооцож илүү олгосон 190.5 сая төгрөгийг суутган авлагыг бууруулсан.




*График 17: Нөхөн олговрын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн харьцуулалт /2022-2025 оны эхний 10 сар, сая.төг/:*

Дээрх графикаас харахад тайлант үед нөхөн олговрын санхүүжилтэд 35,268.6 сая төгрөгийг олгож, тухайн саруудын баталсан төсвөөс 588.9 сая төгрөгөөр хэтэрсэн.

Ахмад настны нөхөн олговроос дутагдаж буй эх үүсвэрийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, цагдаа, дотоодын цэргийн албан хаагчдыг үнэ төлбөргүй тээвэрлэх нөхөн олговрын хэмнэгдсэн төсвөөс шийдвэрлэн ажиллаж байна.




*График 18. Нөхөн олговрын 2025 оны нийт хүлээгдэж буй гүйцэтгэл /сая.төг/*

### 4.9.Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 24/33 дугаар тогтоолоор Нийтийн тээврийн бодлогын газрын 2025 оны төсөв 340,854.8 сая төгрөг, өөрийн орлого 7,389.5 сая төгрөгөөр баталсан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тус газрын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, шаардлагатай тохиолдолд зарим зардлын бүлэг хооронд зохицуулалт хийж, газрын хэвийн үйл ажиллагааг хангах, нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудаас үзүүлж байгаа тээврийн үйлчилгээг тасралтгүй явуулахад шаардлагатай татаасыг цаг хугацаанд нь олгох, машин цагийн зардлын зөрүү санхүүжилтийн төлөвлөлтийг сайжруулж, зардлыг бууруулах талаар дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

Оюутан болон мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн суралцагчдын нөхөн олговрыг 2025 онд үнэ төлбөртэй болгохоор хуулийн зохицуулалт хийгдсэнтэй холбоотойгоор хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Олон жилийн насжилттай өр, авлагыг барагдуулах чиглэлээр тодорхой төлөвлөгөө гарган, гэрээ хэлцэл хийх, шинэчлэх, эргэн төлөлтийн хуваарь гаргах, албан бичиг, албан шаардлага хүргүүлэх, шүүхэд хандан шийдвэрлэх зэргээр дэс дараатай арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 246 дугаар тогтоолд аймгийн Засаг дарга нарт нийслэл хотод 2017-2024 онд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчсон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хуримтлагдсан өр төлбөрөө барагдуулахыг даалгасан. Энэ ажлын хүрээнд 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/06/150-01/06/152, 01/06/154-01/06/169, 01/06/171, 01/06/172 дугаартай албан бичгүүдээр хүргүүлснээс Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрууд бүрэн төлж барагдуулаад байна. Төлбөрөө бүрэн гүйцэд барагдуулаагүй 19 аймгуудын Засаг даргын Тамгын газрууд руу 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 01/06/2279-01/06/2284 дугаартай албан бичгүүдээр, 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/06/2291-01/06/2296, 01/06/2301-01/06/2306 дугаартай албан бичгүүдээр төсвийн жилд багтаан тогтоолын хэрэгжилтийг хангаж үйлчилгээний төлбөрөө барагдуулж ажиллахыг мэдэгдэж, энэ талаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 01/06/2334 дугаартай албан бичгээр дурдаж төлбөр барагдуулахад дэмжлэг хүссэн. Мөн нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад

энэхүү нөхөн олговрын он дамжсан өр төлбөрийг 1,270.0 сая төгрөгийн төсвийг тус газрын 2025 оны төсөвт батлуулан олгож эхлээд байна.

Нийтийн тээврийн үйл ажиллагааг сайжруулах, чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа автобуснуудын парк шинэчлэлтийн зардлыг Нийтийн тээврийн хөгжүүлэх сангаас шийдвэрлэж элэгдлийн зардлаас санхүүжилтийг суутган тооцож байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2009 онд худалдан авсан их багтаамжийн 400 ширхэг автобусны өр төлбөрөөс 3 аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 1,705.1 сая төгрөгийн өр төлбөр барагдаад байна.

*Хүснэгт 12. Нийтийн тээврийн бодлогын газрын өглөг, авлагын барагдуулалтын мэдээ*

**Авлагын тайлан мэдээ**

*сая.төг*

| Авлагын товч утга | Эхний үлдэгдэл | Тайлан хугацаанд төлөгдсөн | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 2024 оны 12 сард олгосон нөхөн олговорын авлага 20 аж ахуй нэгж, байгууллагатай холбоотой | 206.4 | 190.6 | 15.8 |
| ЗГ-ын 197 дугаар тогтоолын хүрээнд үүссэн авлага 21 аймгаас авах нөхөн олговорын авлага | 1,285.1 | 22.7 | 1,262.4 |
| Гэрээний торгууль 18 аж ахуйн нэгжтэй холбоотой | 1,011.1 | 471.5 | 539.6 |
| Их багтаамжийн автобусны төлбөр (Юүтонгын 2024) 14 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой | 149,801.3 | 32,462.9 | 117,338.4 |
| Угсраа 31 автобусны урьдчилгаа төлбөр /4 удаагийн гүйлгээгээр/ | 23,230.6 | 23,230.6 | - |
| Лед дэлгэц суурилуулах зардал | 257.0 | | 257.0 |
| Байцаагч нарын нормын хувцас | 26.8 | | 26.8 |
| Даатгалын төлбөр 2 аж ахуйн нэгжтэй холбоотой | 376.6 | 376.6 | - |
| Бусад авлага 6 аж ахуйн нэгжээс авах | 21,356.7 | | 21,356.7 |
| Хувь хүнээс авах авлага | 1.4 | | 1.4 |
| **НИЙТ ДҮН** | **197,553.0** | **56,754.9** | **140,798.1** |

**Бусад тооцооны авлага** *сая.төг* *Хүснэгт 13.*

| Авлагын товч утга | Эхний үлдэгдэл | Тайлан хугацаанд төлөгдсөн | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 2009 оны 400 автобусны авлага | 26,854.00 | 1,705.1 | 25,148.9 |

**Өглөгийн тайлан мэдээ**

*Хүснэгт 14*
*сая.төг*

| Өглөгтэй байгууллагын нэр, товч утга | Эхний үлдэгдэл | Тайлан хугацаанд төлөгдсөн | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| 2024 оны 12 сард олгох ОЗЗС-ийн өглөг 17 аж ахуйн байгууллагатай холбоотой | 574.1 | 553.3 | 20.8 |
| Нийтийн тээврийг хөгжүүлэх санд өгөх өглөг 600 автобусны | 149,801.3 | 26,749.3 | 123,052.0 |
| Автобус бэлтгэн нийлүүлсэн 2 байгууллагын барьцаа төлбөр | 708.8 | | 708.8 |
| Бусад | 0.0 | | 0.0 |
| **Урт хугацаат өр төлбөр** | | | - |
| Сангийн яаманд /Оношлогооны тоног төхөөрөмжийн үнэ/ | 475.6 | | 475.6 |
| Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ /2016 оны парк шинэчлэлт/ | 3,866.9 | | 3,866.9 |
| **НИЙТ ДҮН** | **155,426.7** | **27,302.6** | **128,124.1** |

Тайлант хугацаанд шинээр нэмж өглөг, авлага үүсгээгүй хуримтлагдсан өмнөх оны авлагаас 29 хувийг, өглөгөөс 18 хувийг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд нийлүүлэгдсэн их багтаамжийн 400 ширхэг автобусны авлагаас 6 хувийг тус тус барагдуулсан байна.

### 4.10. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.

“Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 44, “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” 2021 оны 178 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилтийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нийтэд сурталчилж, мод тарьж, арчлан ургуулах ажлыг орон даяар зохион байгуулах зорилгын хүрээнд хаврын мод тарих арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын нийт албан хаагчид "Ногоон хот Иргэний оролцоо" уриатайгаар Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Баянгол цэцэрлэгт хүрээлэнд 80 хайлаас, 10 монос, 5 голт бор модыг тарьж гүйцэтгэв.



*Зураг №60. Мод тарьж буй байдал*




*Зураг№61. Мод тарьж буй байдал*

2. 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр албан хаагчдын өгсөн хандиваар 1.040.200 төгрөгийн 74 хайлаас, улиас 21 мод тус тус тарьж оролцсон.

### 4.11. Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.

Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд иргэн Ц.Цогтсайханы нэхэмжлэлтэй хэрэгт Нийслэлийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, хариу тайлбар, хүсэлт, холбогдох нотлох баримтыг хүргүүлэн тус шүүхийн шүүгчийн 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 128/ШЗ2025/1127 дугаартай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын захирамжийг түдгэлзүүлсэн шийдвэрийг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр давж заалдах шатны шүүхээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлүүлээд байна.

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд тус нэхэмжлэлтэй хэргийн шүүх хуралдаан 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр болж, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн эрүүгийн 2302006440349 тоот хэргийн шүүх хуралдаан даргалагч шүүгчид М.Түмэннастад энэхүү хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл, түүнийг Тэнүүн-Огоо ХХК-ийн захирал А.Ганхуягаас хэрхэн барагдуулсан талаарх танилцуулгыг хавсралтаар 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/08/757 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.



*Зураг 62. Итгэжлэл олгох тухай 2025 оны 01/67/95, 01/37/42, 01/489*

### 4.12.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн нөхцөлд Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Замын цагдаагийн газар, тус газар хамтран ажиллах гэрээний төслийг шинэчлэн боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 25/005 дугаартай гэрээг байгуулсан.

Нийтийн эмх замбараагүй байдал үүсэн нөхцөлд Цагдаагийн ерөнхий газрын Дотоодын цэргийн штабтай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн ХН25006 дугаартай гэрээг байгуулсан.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудад Зам тээврийн яамны улсын ахлах байцаагчийн 04-00-01/004/007/01 дугаартай зөвлөмжийн дагуу Улаанбаатар хот, хот доторх орчмын иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн ажилтан, иргэдэд тээвэрлэлтийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хамтран ажиллах талаарх зөвлөмжийг хүргүүлсэн.



НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТОД НИЙТИЙГ ХАМАРСАН
ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДАЛ БИЙ БОЛСОН ҮЕД
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2025 оны 04 дүгээр сарын 29 Дугаар Улаанбаатар хот

Нэг талаас Дотоодын цэргийн штаб /цаашид "А" тал гэх/ түүнийг төлөөлж Дотоодын цэргийн штабын дарга хурандаа М.Лувсандорж, нөгөө талаас Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Д.Отгонжаргал /цаашид "Б" тал гэх/ нар /цаашид хамтад "талууд" гэх/ харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хуулийн 476-482 дугаар зүйл, Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль болон холбогдох бусад хууль, захиргааны хэм хэмжээний актыг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гэрээний талууд нь нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд онц байдал зарласан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлж ажиллах дотоодын цэргийн бие, бүрэлдэхүүнийг заагдсан газарт тээвэрлэн хүргэх, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, зорчигчдын аюулгүй байдлыг хангах, эмх замбараагүй, аюултай нөхцөл байдлын хүрээг тэлэхгүй, массыг нэмэгдүүлэхгүй байх, аюулын голомт бүхий газраас иргэдийг зөөж шилжүүлэх, нийтийн тээврийн хэрэгслийг ашиглах, хөдөлгөөний замналыг аюулгүй байдлаар зохион байгуулах, нийтийн тээврийн үйлчилгээний том оврын автобус, троллейбус нь техникийн болон бусад гэмтэл зөрчлийн улмаас саатсан тохиолдолд хамгаалалтын бүсээс шилжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

1.2. Хамтын үйл ажиллагаа гэрээний салшгүй хэсэг болох "Хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө, тооцоолол"-д заасныг хэрэгжүүлнэ.

1.3. Талуудын удирдлага өөрчлөгдсөн нь гэрээний хэрэгжилтэд нөлөөлөхгүй бөгөөд гэрээний хавсралтад дурдсан албан тушаалтнууд өөрчлөгдсөн тохиолдол бүрт харилцан мэдээллийг даруй хүргүүлнэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Гэрээний ерөнхий хугацаа нь 3 жил байна.

*Зураг №63. Хамтран ажиллах гэрээ*



НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

2025.01.15 № 01/08/143

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД

Зам тээврийн яамны улсын ахлах байцаагчийн 04-00-01/004/007/01 дугаартай зөвлөмжийн дагуу Улаанбаатар хот, хот доторх орчмын иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн ажилтан, иргэдэд тээвэрлэлтийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хамтран ажиллана уу.

Хавсралт 4 хуудастай

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Даваанян ОТГОНЖАРГАЛ
2025.01.15 16:08

*Зураг №64.Албан бичиг 2025 он 01/08/43*

## 4.13.Тээврийн салбарын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хүрээнд:

Төрийн албаны тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Ахмад настны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар өгөгдсөн үүргийн хүрээнд тухай бүр танилцуулга, мэдээлэл, санал бэлтгэн ажилласан байна.

Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн нөхцөлд Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Замын цагдаагийн газар, тус газар хамтран ажиллах гэрээний төслийг шинэчлэн боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 25/005 дугаартай гэрээг байгууллаа.

Нийтийн эмх замбараагүй байдал үүсэн нөхцөлд Цагдаагийн ерөнхий газрын Дотоодын цэргийн штабтай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ХН25006 дугаартай гэрээг байгууллаа.

Нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмж, чанар нь олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргуулахаар Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ-тай байгуулах ажил гүйцэтгэх гэрээний төслийг боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн ХН25007 дугаартай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан хэрэгжилтийг хангаж байна.

Монгол Улсын Засгийн газар ба Нийслэлийн тээврийн газрын хооронд 2001 оны 08 дугаар сарын 01-ний өдөр байгуулагдсан "Дамжуулан зээлдэх гэрээний" өр төлбөрийн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд судалж, гэрээний төслийг боловсруулсан.

Багахангай, Багануур, Налайх дүүргүүдийн сургуулийн хүүхдийн автобусны тээвэрлэлтийн гэрээг боловсронгуй болгох зорилгоор санхүүжилт, гэрээний асуудлаар холбогдох хууль эрх зүйн дүгнэлт, судалгаа шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэсэн.

### 4.13.1.Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, сунгах, цуцлах, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулах;

Улаанбаатар хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй байгуулах ажил гүйцэтгэх (нийтийн тээврийн үйлчилгээ) гэрээний төслийг эцэслэн боловсруулан тэдгээрээс 2 удаа саналыг авч тусгай зөвшөөрөлтэйгөөр нийтийн зорчигч үйл ажиллагаа эрхлэгч 18 ААНБ-уудтай 5 жилийн хугацаатайгаар гэрээг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, такси үйлчилгээ эрхлэгч 5 хуулийн этгээдтэй гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.




*Зураг № 65. Нийтийн тээврийн үйл ажиллагаа эрхлэгч 18 ААНБ-уудтай 5 жилийн хугацаатайгаар гэрээг байгуулах үйл ажиллагаа*



*Зураг № 63. Нийтийн тээврийн үйл ажиллагаа эрхлэгч 18 ААНБ-уудтай 5 жилийн хугацаатайгаар гэрээг байгуулах үйл ажиллагаа*

Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар Хөлөг налайх хоршоо, Засгийн газрын авто бааз УТҮГ, Багануур дүүргийн тээвэр зохицуулалтын алба гэсэн 3 хуулийн этгээд тусгай зөвшөөрөл олгуулах хүсэлт тус газарт ирүүлсэн болович Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсэгт заасан, комиссын удирдамжаар баталсан нөхцөл, шаардлагыг хангасан талаарх материал огт ирүүлээгүй байсан.

Дээрх материалыг дахин ирүүлж шийдвэрлүүлэх боломжтой талаар мэдээлэл хүргүүлсэн. Хотын доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж, ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийг зөвшөөрлийн нэгдсэн сан license.mn цахим хуудсанд байршуулсан.

Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар "Юбикаб лийз" ХХК хуулийн этгээд такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгуулах хүсэлт ирүүлсэн болович Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9, 15.10 дахь хэсэгт заасан, комиссын удирдамжаар баталсан 10 нөхцөл, шаардлагаас 9 шаардлагыг хангаж, 1 шаардлагыг хангаагүй талаар магадлан шалгах ажлын хэсгээс танилцуулсныг комиссын хурлын шийдвэрээр 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр "Тусгай зөвшөөрөл олгох" боломжгүй тухай 01/03/2447 дугаар "Мэдэгдэл" хүргүүлсэн.

### 4.15.2.Санхүүжилтийн гэрээг байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

Нийтийн тээврийн үйлчилгээний гэрээнд "Нийтийн тээврийн санхүүжилтийн гэрээ"-г нэгтгэн боловсруулж батлуулсан байна.

4.15.2.1.Удирдлагын шийдвэрээр аливаа хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох;

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд "Таванбогд фүүдс" ХХК-ийн нэхэмжлэлтэй тус газарт холбох хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон захиргааны хэргийн хяналтын шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр 001/ХТ2025/0029 дугаартай тогтоолоор анхан болон давж заалдах шатны шүүхийн хэрэгсэхгүй болгосон магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Тус газар 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Энх Алтан соёмбо ХХК-тай байгуулсан дугаар ХН23033 "Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын авто тээврийн хяналтын улсын байцаагчийн хөдөлмөр хамгааллын дүрэмт хувцас шинээр бэлтгэн нийлүүлэх ажил гүйцэтгэх гэрээ"-ний хэрэгжилт хангагдаагүй байх тул хууль сахиулах байгууллагад шалгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

4.15.2.2.Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох.

Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд иргэн Ц.Цогтсайханы нэхэмжлэлтэй хэрэгт Нийслэлийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож хариу тайлбар, хүсэлт, холбогдох нотлох баримтыг хүргүүлэн тус шүүхийн шүүгчийн 2025.02.12-ны өдрийн 128/ШЗ2025/1127 дугаартай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын захирамжийг түдгэлзүүлсэн шийдвэрийг 2025.04.16 өдөр давж заалдах шатны шүүхээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлүүлээд байна.

Эрүүгийн 2302006440349 тоот хэргийн шүүх хуралдаан даргалагч шүүгч М.Түмэннастад энэхүү хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл, түүнийг Тэнүүн-Огоо ХХК-ийн захирал А.Ганхуягаас хэрхэн барагдуулсан талаарх танилцуулгыг хавсралтаар 2025.04.01-ны өдрийн 01/08/757 дугаартай албан бичгээр хүргүүлэв.




*Зураг №66. Ногоон автобус гэх тодотголтой шүүх хурлын үйл явц*

4.15.2.3.Газрын даргын шийдвэр бүтцийн нэгжийн удирдлага, албан хаагчдын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хэрэгжилтийг хууль хангаж буй үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар санал дүгнэлт боловсруулах, энэ чиглэлээр удирдлагыг мэдээллээр хангах;

Эрүүгийн 230006440349 тоот буюу "Ногоон автобус" тодотголтой хэргийн шүүхийн шийдвэрлэлттэй холбоотой танилцуулга, мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид хүргүүлсэн.

Эрүүгийн 230006440349 тоот хэргийг эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хянан шийдвэрлэсэнтэй холбоотойгоор тухайн төрийн албан хаагч нарын хөдөлмөрийн харилцааг хэрхэх судалж Газрын даргын зөвлөлийн хурлаар мэдээлэл, танилцуулга бэлтгэж Газрын даргад танилцуулж холбогдох арга хэмжээг авхуулаад байна.

Билэгтдэлгээн, Юбикаб, Тапа райд ХХК-ийн дуудлагын такси үйлчилгээний гэрээ байгуулах саналд Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу татгалзсан хариуг албан бичгээр хүргүүллээ.

4.15.2.4.Батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд холбогдох хууль, журмын дагуу ажилтнуудыг томилох, чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахад оролцох;

Ажлын байрны тодорхойлолт, түүнийг баталсан нөхцөл байдлын талаар Газрын хууль эрх зүйн дүгнэлт гарган Газрын дарга, Нийслэлийн Засаг даргын 1 дүгээр орлогчид танилцуулж, шийдвэрийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран ажиллаж байна.

4.15.2.5.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд батлагдсан төлөвлөгөөний дагуу Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн сахилга, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллах.

Төв аймгийн Хөшигтийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудалд үйл ажиллагаа явуулах авто тээврийн хяналтын улсын байцаагч нь Улсын ерөнхий прокурорын баталсан "Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага"-ыг хангасан дуу, дуу дүрсний бичлэг хийх зориулалт бүхий иж бүрэн камер бүхий өрөөнд ажиллах шаардлагыг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

Эрдэмтранс ХХК-иас улсын төсвийн 2009 оны санхүүжилтээр авсан автобусны 2,1 тэрбум төгрөгийн өр авлагыг барагдуулах хүсэлтийн дагуу Нийслэлийн Засаг даргын А/453 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдан төлбөрийг барагдуулах хэлцэл хийх Ажлын хэсэгт ажиллаж байна.

4.15.2.6.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргийн хэрэгжилтийг хангуулах, хуулийн үйлчлэлд хамрагдах албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө мэдээлэл өгөх, тайланг хугацаанд нь хүргүүлэх

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/121 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмын дагуу 22 захиргааны албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулж, хяналаа.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу 2 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хариуг авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Авлигатай тэмцэх газарт Нийтийн тээврийн бодлогын газрын албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 15-нд цахим болон албан бичгээр хүргүүллээ.

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн А/02 дугаар тушаалаар нийтийн тээврийн бодлогын газрын ёс зүйн хороог байгуулан үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### 4.15.3.Тээврийн салбарын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг боловсронгуй болгох үйл ажиллагааны хүрээнд:

4.15.3.1.Тээврийн салбарын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний хэрэгжилтийн үр дагаврыг судлах, тэдгээрийг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, төсөл боловсруулах, дээд шатны байгууллагад хүргүүлэх, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр төсөл боловсруулах ажлын хэсэгт оролцох;

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/15 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураамж тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай" захиргааны хэм хэмжээний актад Хууль зүй, Дотоод хэргийн сайдын зөвлөмжийн хүрээнд төслийг дахин боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

Зам, тээврийн сайдын 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/78 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам" шинэчлэгдэн захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгэгдэв.

Зөвшөөрлийн тухай хууль, Хувийн тэтгэврийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгатай нэг бүрчлэн танилцан тэдгээрт холбогдох саналыг гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газарт хүргүүлэн ажилласан байна.

Нийтийн тээврийн бодлогын газрын Ахмадын холбоо төрийн бус байгууллагын ахмад настны талаар авах арга хэмжээ хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг боловсруулж батлуулжээ.

Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Нийтийн тээврийн бодлогын газрын тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт хийх хууль зүйн үндэслэл, танилцуулгыг Хяналт шалгалтын хэлтэстэй хамтран бэлтгэж Нийслэлийн засаг даргын Тамгын газар хүргүүлсэн.

Нийслэлийн прокурорын газарт 2025.02.21-ний өдрийн 01/05/475 дугаартай албан бичгээр Нийтийн тээврийн бодлогын газрын автотээврийн хяналтын улсын байцаагчийн зөрчил шалган шийдвэрлэх хяналтын харьяаллыг өөрчлүүлэх тухай танилцуулга, төслийн хамт хүргүүлэн Улсын ерөнхий прокурорын тушаалаар Нийтийн тээврийн бодлогын газрын зөрчлийн шалган шийдвэрлэх харьяалал Тээврийн прокурорын харьяалалтай байхаар шийдвэрлэгдэв.

4.15.3.2.Нийтийн тээврийн дулаан зогсоол хотын стандартын төсөл боловсруулж батлуулах нөлөөллийн судалгаа явуулж, хамтран ажиллах;

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/15 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураамж тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай” захиргааны хэм хэмжээний актад Хууль зүй, Дотоод хэргийн сайдын зөвлөмжийн хүрээнд төслийг дахин боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

4.15.3.3.Нийтийн тээврийн стратеги төлөвлөгөөнд санал боловсруулж хүргэх; газарт “Чанарын менежмент”-ийг нэвтрүүлэх үйл үйл ажиллагааны хүрээнд гарын авлагад санал өгч төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хэлэлцүүлэг, сургалтад байгууллагын танилцуулгыг сурталчилсан байна.

4.15.3.4.Нийтийн тээврийн үйлчилгээний зорчих үнэ, тариф, машин цагийн зардлыг шинэчлэн тогтоох нөлөөллийн судалгааг хийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн төслийг боловсруулан хүргүүлэх.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтийг батлах тухай” А/1024 дугаар захирамжийн хүрээнд Нийтийн тээврийн үйлчилгээний үзүүлэлтүүдийг дүүрэг тус бүрээр, холбогдох задаргаа тооцооллын хамт гарган Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төв НТҮГ-т 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/02/2270 тоот албан бичгээр хүргүүлсэн.

| Дүүрэг/ Дэд үзүүлэлтүүд | НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ | | | |
|---|---|---|---|---|
| | Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж | Үйлчилгээний хүртээмж хувь | Автобусны хүчин чадал | Нийт зорчилт хөдөлгөөний тоо |
| Баянгол | 52 чиглэл | 94% | 636 автобус | 301,441 |
| Баянзүрх | 53 чиглэл | 87% | 520 автобус | 279,223 |
| Сүхбаатар | 54 чиглэл | 101% | 629 автобус | 336,708 |
| Сонгинохайрхан | 48 чиглэл | 76% | 466 автобус | 225,405 |
| Хан-Уул | 47 чиглэл | 85% | 401 автобус | 183,015 |
| Чингэлтэй | 41 чиглэл | 91% | 373 автобус | 187,049 |
| Багануур | 1 чиглэл | 80% | 2 автобус | 384 |
| Багахангай | 1 чиглэл | 75% | 1 автобус | 180 |
| Налайх | 4 чиглэл | 72% | 22 автобус | 14,148 |
| **Улаанбаатар** | **138 чиглэл** | **85%** | **1174 автобус** | **577,750** |

*Хүснэгт 15. Дүүрэг бүрийн хүртээмжийн индекс*

Бүгд найрамдах Солонгос улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй "Улаанбаатар хотын зам тээврийн ухаалаг дижитал мастер төлөвлөгөө" боловсруулах төслийн багт хамтран ажиллаж нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой мэдээллээр ханган холбогдох баримт бичигт санал тусган ажилласан.

### 4.15.4.Тээврийн салбарын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг сурталчлах үйл ажиллагааны хүрээнд:

4.15.4.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас баталсан "Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх" төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4.15.4.2.Тээврийн салбарын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний талаар албан хаагчдад болон иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл тогтмол хүргэх, сурталчлах ажлыг бүтцийн нэгжийн удирдлага, албан хаагчидтай хамтран зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах;

Зам, тээврийн яамнаас 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 07/1369 дугаартай албан бичгээр аюултай хог хаягдалтай холбоотой чиглэл хүргүүлсэн 2025 оны 04 сарын 01-ний өдрийн 01/08/760 дугаартай албан бичгээр нийтийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад уламжлан хүргүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудад Зам тээврийн яамны улсын ахлах байцаагчийн 04-00-01/004/007/01 дугаартай зөвлөмжийн дагуу Улаанбаатар хот, хот доторх орчмын иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдийн ажилтан, иргэдэд тээвэрлэлтийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, хамтран ажиллах талаар зөвлөмжийг албан бичгээр хүргүүлсэн.

Хяналт шалгалтын хэлтсийн авто тээврийн хяналтын улсын байцаагч болон бусад албан хаагч нарт Монголын Криминологичдын холбооны Удирдах зөвлөлийн дарга, хууль зүйн ухааны доктор, Б.Батзориг "Зөрчлийн хуулийн үзэл баримтлал", Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор М.Буяннэмэх, М.Гансувд нарын "Зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа" сэдвүүдээр сургалт явуулах ажлыг зохион байгуулсан.

4.15.4.3.Газрын албан хаагчдын ажлын хэрэгцээ шаардлага, тэдгээрийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг явуулах, хүний эрхийг хангах, хамгаалах ажилд манлайлан оролцох, зөвлөгөө өгөх.

Газрын даргын баталсан "Нийтийн тээврийн салбарын үйл ажиллагааны шинэчлэл" сэдэвт удирдамжаар газрын нийт албан хаагчдын дунд эсээ, илтгэлийн уралдаан зарлаж Газрын даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцэх гэж байна.

### **4.14.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.**

Жендерийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 04-ны өдөр батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Монгол Улсад автотээврийн салбар үүссэний 100 жил, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Бид нийтийн тээврийнхэн" эмэгтэй жолооч нарын уулзалт өдөрлөгийг 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Уг уулзалтад нийтийн тээврийн салбарт үйл ажиллагаа явуулдаг 19 аж ахуйн нэгжийн 206 эмэгтэй албан хаагчид оролцож, ажлын амжилт бүтээл, тулгарч буй бэрхшээл даван туулах гарцын талаар санал бодлоо хуваалцсан.

2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 24-ний өдрүүдэд нийтийн тээврийн бодлогын газар "Харилцан хүндэтгэе" нэг сарын аянд нэгдэж, "Хайраа хайрлая, хандлагаа өөрчилье, хамтдаа үлгэрлэе" уриан дор жендерийн талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 2 постер, 2 сургалт мэдээллийг www.facebook.com,

/www.transport.ub.gov.mn/ пэйж хуудсанд байршуулж, 1705 иргэнд цахимаар хүргэж ажилласан.




*Зураг №67. "Харилцан хүндэтгэе" аяны постер мэдээлэл*

## 4.15.Тээврийн хэрэгслийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагуудыг мөрдүүлж, хяналтыг сайжруулах. НХТ-426

Нийслэлийн алслагдсан дүүргүүдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх зорилгоор, 45 хүний суудалтай 10 автобусыг Багануур, Багахангай дүүрэг, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал чиглэлүүдийг шинээр нээж, үйл ажиллагааг жигдрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр, Хөшигтийн хөндийд байрлах Чингис хаан олон улсын нисэх буудал чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ явуулж эхэлснээр 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс Х:19 Чингис хаан олон улсын нисэх буудал- Сүхбаатарын талбай, Х:20 Чингис хаан олон улсын нисэх буудал- 5 шар чиглэлүүдэд Авто тээврийн хяналтын улсын байцаагч, шалгагч нарын бүрэлдэхүүнтэй газар дээр нь хяналт тавьж /хууль бус/ тээвэрлэлтийн гэрээгүйгээр зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд шалгалт хийж ажилласан.

Зөвшөөрөлгүй таксины үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг илрүүлэх, баримтжуулах ажлыг Тээврийн цагдаагийн албан хаагч, Нисэх буудлын тээвэр зохицуулагч нартай хамтран зохион байгуулж тээвэрлэлтийн гэрээгүйгээр таксийн үйлчилгээ эрхэлдэг 19 иргэнд холбогдох хуулийг сурталчлан таниулж, хууль бус үйл ажиллагаагаа зогсоох мэдэгдэл гардуулсан.

Чингис хаан олон улсын нисэх буудал, Улаанбаатар хотын чиглэлд тээвэрлэлтийн гэрээгүйгээр таксины үйлчилгээ байнга эрхэлдэг 40 иргэний судалгааг 8 үзүүлэлтийн дагуу гаргаж, мэдээллийг хяналт, шалгалтын ажилд ашиглаж байна.

Чингис хаан олон улсын нисэх буудал, Улаанбаатар хотын чиглэлд тээвэрлэлтийн гэрээгүйгээр нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлсэн 13 зөрчлийг илрүүлж 11 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт заасныг үндэслэн тус бүр 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, 2 аж ахуйн нэгж, байгууллагад тус бүр 1000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нийт 13 холбогдогчид 3,100,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулан ажилласан.

Багануур, Багахангай дүүргүүдэд 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс Х:18 Улаанбаатар /Тэнгэр плаза/-Багахангай эцсийн зогсоол, Х:17 Улаанбаатар /Тэнгэр плаза/-Багануур /Хэрлэн худалдааны төв/ эцсийн зогсоол чиглэлийн үйлчилгээнүүд нэвтэрсэнтэй холбоотой Автотээврийн хяналтын улсын байцаагч нар тухайн дүүрэгт байрлан хяналт тавьж ажиллаж байна.

Тухайн дүүргүүдэд зөвшөөрөлгүй таксины үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор тээвэрлэлтийн гэрээгүйгээр таксины үйлчилгээ эрхэлдэг 31 иргэнд холбогдох хуулийг сурталчлан таниулж, хууль бус үйл ажиллагаагаа зогсоох мэдээлэл өгч, орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор карт цэнэглэх, худалдах хүсэлтийг уламжилж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.




*Зураг №68. Нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавьж буй*

### 4.15.1.Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлнэ.

Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд холбогдох зорилт, үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Авто замын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Барилгын тухай хууль болон Монгол улсын нэгдэн орсон ОУ-ын гэрээ конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн саадгүй, аюулгүй хүртээмжтэй нийтийн тээвэр, MNS 6055:2009 Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага, MNS 5012:2021 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага, Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй автобуснуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, жирэмсэн эмэгтэй, хүүхдүүд зэрэг нийгмийн тусламж дэмжлэг шаардлагатай иргэдийн саадгүй, тав тухтай, зорчих нөхцөлийг хангаж буй эсэхэд хүртээмжийн үнэлгээ хийх зорилгоор Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны саадгүй хүртээмжийн ажилтан Б.Ганбаатар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Тамир, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн О.Гаасүрэн, Нийтийн тээврийн бодлогын газрын Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ч.Бадамханд нарын бүрэлдэхүүнтэй 2025 оны 05 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ийн автобуснуудад техникийн 7, мэдээллийн 10 асуумжаар 5 төрлийн автобусанд ХБИ-ий хүртээмжийн үнэлгээ хийж ажиллалаа.



*Зураг №69. Нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавьж буй*

### 4.17.2. Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажилд хяналт шалгалт хийнэ.

Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр баталсан “Хүүхэд тээвэрлэх автобус ба үйлчилгээнд хяналт, шалгалт хийх тухай шалгалтын удирдамж”-ийн хүрээнд Авто тээврийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Хүүхэд тээвэрлэх автобус ба үйлчилгээнд тавих шаардлага. MNS 6440:2014, Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2025 улсын стандартын шаардлагуудыг хангуулахаар нийслэлийн нутаг дэвсгэрт хүүхэд тээвэрлэлтийн үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний үйл ажиллагаанд Авто тээврийн хяналтын улсын байцаагч нар баталсан хуваарийн дагуу хяналт шалгалт хийлээ.

Шалгалтыг: Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх сургуулиудад хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 12 дахь заалтыг үндэслэн 9 аж ахуйн нэгж, байгууллагад 1.000 нэгж, 49 иргэнийг 100 нэгжтэй тэнцэх төгрөгөөр, 1 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтыг үндэслэн 500 нэгжтэй тэнцэх төгрөгөөр тус тус торгуулийн арга хэмжээ тооцож ажиллалаа.




*Зураг №70. Хүүхдийн автобус шалгасан байдал.*

### 4.17.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгслийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавина.

Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ-ын дарга Ч.Хувьзаяа, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын теле хяналт, замын хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Ч.Батболд нарын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Нийслэл Улаанбаатар хотод тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад хамтран үзлэг, шалгалт зохион байгуулах ажлын удирдамж”-ийн дагуу Нийслэл хотын дотор тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд хамтарсан хяналт, шалгалтын ажил хийж гүйцэтгэсэн.

Шалгалтыг Авто тээврийн тухай хууль, Зам тээврийн сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалаар баталсан Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх дүрмийн хэрэгжилт, “Авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг 1-р хэсэг. Ерөнхий шаардлага” MNS 4410-1:20021, “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2025 улсын стандартын шаардлага, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/101 дүгээр тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах” журам, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны “Нийслэл Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийг зориулалтын авто машинаар зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах болон эдгээр үйл ажиллагааны төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай” 33/35 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хийсэн.

Шалгалтад тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг 16 аж ахуйн нэгж, байгууллагын 96 тээврийн хэрэгсэл, 86 жолооч хамрагдсанаас:

1. 13 аж ахуйн нэгж байгууллага тээвэрлэлтийн ажил, үйлчилгээнд тухайн ангиллаар мэргэшээгүй 36 жолоочийг ажиллуулсан нь Автотээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн 10.2.21 -д заасныг зөрчсөн;

2. 16 аж ахуйн нэгж, байгууллага тээврийн хэрэгслүүдийн өнгө, үзэмж муу, техникийн хувьд урд гэрэл, оврын гэрэл, ухрахын гэрэл, тоормосны гэрэл бүрэн бус гэх 185 зөрчилтэй байгаа нь “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2025 улсын стандартын 5.5-д заасан шаардлагыг хангаагүй байна.

Тээвэрлэлтийн ажил, үйлчилгээнд тухайн ангиллаар мэргэшээгүй 36 жолоочийг ажиллуулсан 13 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.1-д заасныг үндэслэн тус бүр 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.

Замналын зогсоолд байрлуулсан суудлын тээврийн хэрэгслийн эзэмшигчтэй нь холбогдох зогсоол чөлөөлөхийг мэдэгдэж, утасны дугаараа үлдээгээгүй 9 тээврийн хэрэгслийг ачилтын машинаар ачуулсан.

### 4.17.4. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах ажлын хүрээнд сургалт зохион байгуулна. Дүрмийн 4.1.18

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч “Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТҮГ-ын 60 жолоочид 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 11:00-12:30 цагийн хооронд сургалт зохион байгууллаа.

Сургалтыг Нийтийн тээврийн бодлогын газар, Тээврийн цагдаагийн алба, ICT Групп, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-уудтай хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтыг дараах агуулгаар хийсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээний соёл

Нийтийн тээврийн автобусанд суурилуулсан хяналтын камераар зөрчлийг хэрхэн баталгаажуулж, зураг авах

Илэрсэн зөрчлийг шилжүүлэх, хяналтын камерын өнцгийн тохиргоо

Замын хөдөлгөөний дүрэм журмыг баримтлан замын хөдөлгөөний аюулгүй байдалд оролцох

Үйлчилгээнд тавигдах хууль, дүрэм, журам, стандарт шаардлагыг хангуулах

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам

"Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" (MNS 4598:2020)

"Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээний ерөнхий шаардлага" (MNS 5012:2021) стандартуудын голчлон зөрчигддөг зүйл, заалтууд

Сургалт нь нийтийн тээврийн жолооч нарын мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдал, үйлчилгээний чанарыг сайжруулах, хууль, дүрэм, стандартыг мөрдүүлэхэд чухал ач холбогдолтой сургалт болсон.

Нийтийн тээврийг үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах нь сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Эрдэмтранс ХХК-ийн 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Блюбус ХХК-ийн жолооч нарт зохион байгуулж нийт 58 жолооч хамрагдсан.




*Зураг №71.Нийтийн тээврийг үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах нь сургалтын үйл ажиллагаа*

### 4.16. Сонгинохайрхан дүүрэг /Тахилт/ 110 нийтийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний авто бааз барих ажилд санал хүргүүлнэ.

Тус газраас 2025 оны 02 дугаар сарын 06-ний өдрийн 01/07/345 дугаартай Сонгинохайрхан дүүрэг /Тахилт/ 110 нийтийн тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний авто бааз барих ажлын явцын талаар мэдээ тайланг ирүүлэх тухай албан бичгийг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ хүргүүлсэн.

“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр тайлан ирүүлсэн. Автобус паркийн барилгын дулаан гараашны барилга угсралтын багц-1 ажлын гүйцэтгэл 88%, багц-2 ажлын гүйцэтгэл 43%, тос тосолгооны агуулахын барилга угсралтын ажил 67 %, хөдөлгөөний удирдлагын төвийн барилгын ажил 89%, зам талбайн барилгын ажил 80%, харуулын байр, хашаа, дэд бүтцийн барилгын ажил 88%, сэлбэг аж ахуйн агуулахын барилгын ажил 88%, автобус баазын засвар үйлчилгээний төвийн барилгын ажил 20%-ийн гүйцэтгэлтэй байна.

Ажлын гүйцэтгэлийн дундаж 70,3 хувьтай байна.




*Зураг №72. “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-аас 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/196 дугаартай албан бичгээр*

### 4.17. Нийтийн тээврийн бүлэг хотын стандартыг мөрдүүлэхэд чиглэсэн сургалт, арга зүйгээр хангах, хяналт шалгалт зохион байгуулах.

Хотын стандартыг мөрдүүлэхэд чиглэсэн нийт 24 удаагийн сургалтыг зохион байгуулж 1919 ажилтан албан хаагчдыг хамруулсан. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 6 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран 6 удаагийн сургалт зохион байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллалаа.




*Зураг №73. Автотээврийн салбарт мөрдөх хууль тогтоомж, стандартууд”, сэдвээр Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын жолооч нарт сургалт зохион байгуулсан*










*Зураг №74. Нийтийн тээврийн салбарын өнөөгийн байдал, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх сэдэвт сургалт*

Тус газраас Улаанбаатар хотын стандартууд, MNS 4598:2025 Авто тээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага шинэчлэгдсэн стандартыг байгууллагын албан хаагчид болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлсэн. Сонгинохайрхан дүүргийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтран Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын инженер, техникийн ажилтан албан хаагч, жолооч нийт 205 албан хаагчийг 2025 оны 02 дугаар сарын 11-нээс 15-ны өдрүүдэд сургалтад хамруулсан.

Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-тай уг сургалтыг хамтран зохион байгуулж нийт 16 аж ахуйн нэгж, байгууллагын 174 жолооч хамрагдсан.

Сургалтаар:

-Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотойгоор иргэдээс гомдол санал хүлээн авдаг 70044040 утас, Засгийн газрын 1111 тусгай дугаар, цахим вэбсайт, сошиал сүлжээгээр ирүүлсэн санал хүсэлт, гомдлын талаар;

-Жолооч нарын өнөөгийн тулгамдаж буй асуудал, нийтлэг зөрчлийг багасгах, урьдчилан сэргийлэх арга зам;

-Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам

-MNS 4598:2025 Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага, MNS 5012:2021 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээний ерөнхий шаардлага стандартуудын хэрэгжилт, хяналт, шалгалтын явцад илэрдэг зөрчлүүд, иргэд болон аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн санал гомдлын шийдвэрлэлт зэрэг сэдвээр мэдлэг олгосон.

### 4.18. Нийтийн тээврийн стандарт, нормын талаар албан хаагчид, нийтийн тээврийн байгууллагуудад сурталчлан таниулах.

Нийтийн тээврийн үйлчилгээний стандарт дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр нийт 28 удаагийн сургалтыг зохион байгуулж 1942 жолооч, инженер техникийн ажилчдыг хамруулсан байна.



НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ АВТО ТЭЭВРИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Э.МӨНХНАСАН ТАНАА

Авто тээврийн салбарын эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, шинэчлэх хүрээнд боловсруулсан "Зорчигч тээвэрлэлт. Ангилал ба Ерөнхий шаардлага" MNS 5012:2025 стандартын төсөлд тусгуулах саналыг нэгтгэн хүргүүлэв.

Хавсралт 37 хуудастай.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Давааням ОТГОНЖАРГАЛ
2025.06.24 15:46

*Зураг №75. 01/07/855 дугаартай албан бичиг, 01/07/870 дугаартай албан бичиг, 01/07/1417 дугаартай албан бичиг*

Тус газраас Улаанбаатар хотын стандартууд, MNS 4598:2025 Авто тээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага шинэчлэгдсэн стандартыг байгууллагын албан хаагчид болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн.

Сонгинохайрхан дүүргийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтран Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын инженер, техникийн ажилтан албан хаагч, жолооч нийт 205 албан хаагчдыг2025 оны 02 дугаар сарын 11-нээс 15-ны өдрүүдэд сургалтад хамруулсан.

Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр "Тээврийн хэрэгслийн жолоодох эрх дуусгавар болох, жолоодох эрхийг сэргээх журам" сэдэвт сургалтад Трансбус ХХК-ийн 13 жолоочийг хамруулсан.

Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын жолооч нарт Хан-Уул дүүргийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтарч Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган хөдөлгөөнд оролцох талаар сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж нийт 42 жолооч хамрагдсан.

Тээврийн цагдаагийн алба, Цагаан шонхрын жигүүр ТББ-тай хамтран 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Блюбус ХХК-ийн жолооч нарт "Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрэм, Зөрчлийн тухай хуулийн /Сэтгэл санааны хохирол гэж юу вэ?, Жолоочид хамаарах заалтууд, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль/ зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж 35 албан хаагчийг хамруулсан.

Нийт 4 сэдвээр, 7 удаагийн сургалтад 253 албан хаагчдыг хамруулсан.

### 4.18.1. Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хүрээнд.

Нийтийн тээврийн салбарт ажиллагсдад 2025 оны 06 дугаар сарын байдлаар 4 чиглэлээр 24 удаагийн сургалтаар нийт 2330 инженер, техникийн ажилтан, жолооч, захиргааны ажилчдыг сургалтад хамруулсан байна. Үүнд:

Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа жолооч нарт 16 сургалтаар 1174 жолооч;

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр 2 сургалтаар 118 инженер, техникийн ажилтан;

Салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн чиглэлээр 5 сургалтаар 98 инженер, техникийн ажилтан;

Нийтийн тээврийн салбарын бусад чиглэлээр 6 сургалтаар 40 инженер, техникийн ажилтан, ерөнхий боловсролын 900 сурагч.

Сургалтыг Нийслэлийн Боловсролын газар, Тээврийн цагдаагийн газар, Сонгинохайрхан дүүргийн Замын цагдаагийн хэлтэс, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, Нийслэлийн Онцгой байдлын газар, Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны ҮЭ-үүдийн холбоо, ICT групп, Грийн энержи моторс ХХК, Ерөнхий боловсролын 84 дүгээр сургууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий

газар нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.

2022-2025 оны эхний 06 сарын байдлаар сургалт зохион байгуулсан тоо болон хамрагдсан инженер, техникийн ажилтан жолооч, захиргааны албан хаагчдыг хамруулсан байдлыг харьцуулсан байдал.

2022-2025 онд хийгдсэн сургалтын мэдээлэл

*Хүснэгт 16.*

| Хугацаа | Сургалтадхамрагдсан албан хаагчдын нийт тоо | Сургалтын тоо |
|---|---|---|
| 2022 он | 1215 | 21 |
| 2023 он | 1560 | 32 |
| 2024 он | 2389 | 41 |
| 2025 он | 3331 | 44 |

Нийтийн тээврийн салбарт 2025 онд зохион байгуулагдсан сургалтын товч мэдээлэл

*Хүснэгт 17.*

| Д/д | Сургалтын нэр | Зохион байгуулагдсан газар | Хамтарч зохион байгуулсан байгууллага, хэлтэс | Хамрагдсан хүний тоо | Зохион байгуулагдсан өдөр |
|---|---|---|---|---|---|
| 1 | Албан бичиг хэргийн сургалт | Нийтийн тээврийн бодлогын газрын хурлын танхим | Захиргаа, удирдлагын хэлтэс | Нийт 17 ААНБ-ын 40 хүн хамрагдсан. | 2025 оны 01 дүгээр сарын 08,09 |
| 2 | Нийтийн тээврийн үйлчилгээний соёл, замын хөдөлгийний дүрэм | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Сонгинохайрхан дүүргийн Замын цагдаагийн хэлтэс | Нийт 53 жолооч | 2025 оны 01 дүгээр сарын 10 |
| 3 | Цахилгаан автобусны Засвар үйлчилгээний сургалт | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Грийн энержи моторс ХХК | ААНБ-ын нийт 63 инженер техникийн албан хаагчид | 2025 оны 01 дүгээр сарын 21-23-нд |
| 4 | Хүүхлийн аюулгүй байдал, хүүхэд хамгаалалын мэдлэгийг нэмэгдүүлэх нь | Нийслэлийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн хурлын заал | Нийслэлийн Боловсролын газар, Тээврийн цагдаагын газар | Сургуулийн автобусны жолооч, хүүхэд зохицуулагч 117 хүн | 2025 оны 01 дүгээр сарын 24-нд |
| 5 | Нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой иргэдээс ирүүлсэн санал гомдол, анхаарах асуудал | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын Захиргаа, удирдлагын хэлтэс | Нийт 205 жолооч | 2025 оны 02 дугаар сарын 11-14 нд |
| 6. | Нийтийн тээврийн Төлбөр тооцооны үндсэн системийн санхүүгийн тооцоолол хийх нь сургалт | Нийтийн тээврийн бодлогын газрын хурлын танхим | ICT групп | 19 ААНБ-ын 35 албан хаагч оролцов | 2025 оны 02 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. |
| 7 | ААНБ-ын ХАБЭА-н сургалт | Нийтийн тээврийн бодлогын газрын хурлын танхим | | 20 ААНБ-ын 26 ажилтан хамрагдсан. | 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр |
| 8 | ЕБС-ийн сурагчдад Замын хөдөлгөөнд болон нийтийн тээврийн үйлчилгээний соёл | Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургууль | Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ | 84 дүгээр сургуулийн 39 бүлгийн 900 сурагч хамрагдсан. | Нийт 2025 оны 03 дугаар сарын 17-21 хооронд нийт 5 өдөр |
| 9 | Нийтийн тээврийн хэрэгсэлд суурилуулсан хяналтын камераар зөрчил илрүүлэх нь сургалт | Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ-ийн хурлын танхим, Сутайн буянт ХХК-ийн хурлын танхим | Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, ICT групп | 18 ААНБ-ын 303 жолооч хамрагдсан. | 2025 оны 04 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд төрийн өмчийн, 04 дүгээр сарын 15-ны өдөр |
| 10 | Нийтийн тээврийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх нь | Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний | 60 | 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | удирдлагын төв НӨҮГ, ICT групп | | |
| 11 | Нийтийн тээврийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь сургалт | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор Б блок 2 давхар 201 тоот | Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны ҮЭ-үүдийн холбоо, Нийслэлийн Онцгой байдлын газар | 92 | 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр |
| 12 | "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж хөдөлгөөнд оролцох нь" сургалт | ААНБ-ууд дээр зохион байгуулагдана. | 20 минутын хот үндэсний хороо, Тээврийн цагдаагийн алба, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар. | 436 | 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийг дуустал нийт 17 удаагийн сургалт хийгдэнэ. |
| 13 | "Тээврийн үйлчилгээнд шалгагч нарын оролцоо" сургалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-ын албан хаагчид мэдээлэл өгсөн. | 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 14:00-17:00 цагт Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төв ордон Б байр. 207 тоот | Хяналт шалгалтын хэлтэс | 48 | |
| 14 | Нийтийн тээврийн стратеги болон Нийтийн тээврийн стратегийн төлөвлөгөөний төслийг боловсруулах Зөвлөх багаас танилцуулга хийж харилцан санал солилцох уулзалт | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төв ордон Б байр. 201 тоот | Төслийн нэгж | 76 | |
| 15 | Хүүхдийн хөгжил, гэр боловсролын төвөөс монгол орон даяар хэрэгжиж байгаа "Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо" сэдэвт сургалтыг Нийтийн тээврийн бодлогын газрын албан хаагчдад зохион байгуулав. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төв ордон Б байр. 205 тоот | | Нийтийн тээврийн бодлогын газрын 18 албан хаагч оролцов. | |
| 16 | "Нийтийн тээврийн салбарын өнөөгийн байдал, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх нь" сургалт | Танан эвент холл | ЖАЙКА ОУБ, төгсөгчдийн дунд зохион байгуулсан FOLLOW UP сургалтын төсөлд хамрагдан шалгарч уг сургалтыг зохион байгуулах санхүүжилтээр зохион байгуулагдсан. | 97 | |
| 17 | Нийтийн тээврийг үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах нь сургалт | Эрдэмтранс ХХК | | 32 | |
| 18 | Нийтийн тээврийг үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах нь сургалт | Блюбус ХХК | | 26 | |
| 19 | Газрын даргын 2025 оны А/84 дүгээр тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлөөс хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр албан хаагчдад сургалт орсон. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төв ордон Б байр. 205 тоот | Хуулийн хэлтэс | 55 | |
| Нийт | | | | 3331 | Нийт 44 удаа сургалт хийсэн |

### 4.18.2. Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэж буй ажлууд:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, холбогдох стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.Үүнд:

1.Нийтийн тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-уудын ХАБЭА-н чиглэлээр хийж, хэрэгжүүлж байгаа ажлуудад хяналт тавьж, заавар, зөвлөмжийг өгч ажилласан.

2.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлийн албан хаагчдын мэдлэг, чадварыг сайжруулах чиглэлээр сургалтууд зохион байгуулсан.

-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян-2025 үйл ажиллагааны хүрээнд "Нийтийн тээврийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах нь" сургалтыг мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаач нартай хамтран Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Удирдамжийн дагуу нийтийн тээврийн салбарт ажиллагсдыг ажлын нөхцөлөөс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн харилцаа болон нөхцөлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан.

Сургалтад үндсэн чиглэлийн 18, такси үйлчилгээний 3, буухиа үйлчилгээний 2 нийт 23 аж ахуйн нэгж байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн ажилтан, эмч, хүний нөөцийн асуудал хариуцсан нийт 92 ажилтан хамрагдсан.

-Ерөнхий боловсролын 900 сурагчдад Замын хөдөлгөөнд соёлтой оролцох, Нийтийн тээврийн үйлчилгээний соёл, зорчигчийн аюулгүй байдлаа хангаан үйлчлүүлэх талаар соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулсан.

Цаашид Нийслэлийн Боловсролын газар болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургуулийн сурагчдад дээрх чиглэлээр олон нийтийн хамарсан соён гэгээрүүлэх ажлуудыг зохион байгуулах саналтай байна.

3.Нийтийн тээвэр.Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5012:2021 стандартын 7.5-д заасан MNS ISO 45001 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо. Шаардлага стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна гэж заасны дагуу бэлтгэл ажлыг хангуулахаар 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/03/08 дугаартай албан бичгээр үндсэн чиглэлийн үйлчилгээ эрхлэгч 18 ААНБ-уудад албан бичиг хүргүүлсэн.

Мөн Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй асуудал хариуцсан инженер, техникийн ажилтнуудад 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт, ISO стандартын талаарх сургалт болж 26 ажилтан, албан хаагч хамрагдсан.

4.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудаас ХАБЭА-н үйл ажиллагаанд техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж БӨХБАТ ЦАХИМ ПРОГРАММ-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд бусад ААНБ-ууд туршлага судалж, 1-2 байгууллагууд туршилтын журмаар үйл ажиллагаандаа ашигласан боловч төлбөрөөс шалтгаалан тууштай хэрэгжиж чадахгүй байна.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын зүгээс Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх ажлыг эрчимжүүлж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т "Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна." гэж заасныг хэрэгжүүлэн 2025 оны ажлыг төлөвлөгөөг батлан тус газарт ирүүлэх чиглэлийг өгч 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/03/08 тоот албан бичгийг хүргүүлсэн.



НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

2025.01.03 № 01/03/08

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аливаа осол гэмтэлд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор 2025 онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийх жилийн ажлын төлөвлөгөөнд дараах зүйлийг тусган шинэчлэн баталж 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлнэ үү. Үүнд:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т "Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна." гэж заасныг хэрэгжүүлэх;

2.Нийтийн тээвэр Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5012:2021 стандартын 7.5-д заасан MNS ISO 45001 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо. Шаардлага стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна гэж заасны дагуу бэлтгэл ажлыг хангах талаар;

3.Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг тогтмол өгөх, хэрэгжилтэд хяналт тавих талаар;

4.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр хууль дүрэм, журам, стандартыг сурталчилсан сургалт зохион байгуулах;

5.Гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих;

6.Нийт ажилтан, ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, ажлын байрны онцлогоос шалтгаалан хордлого тайлах нэмэлт бүтээгдэхүүнээр хангах;

7.Ажилчдыг ажлын хувцас хэрэгслээр хангах;

Жилийн ажлын төлөвлөгөөний дагуу сар бүр хийсэн ажлын тайланг тухайн сарын 30-ны дотор тус газарт ирүүлнэ үү.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Дэваанямы ОТГОНЖАРГАЛ
2025.01.03 13:18



НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

2025.01.03 № 01/03/08

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аливаа осол гэмтэлд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор 2025 онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийх жилийн ажлын төлөвлөгөөнд дараах зүйлийг тусган шинэчлэн баталж 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлнэ үү. Үүнд:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т "Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшингээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна." гэж заасныг хэрэгжүүлэх;

2.Нийтийн тээвэр Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5012:2021 стандартын 7.5-д заасан MNS ISO 45001 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо. Шаардлага стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна гэж заасны дагуу бэлтгэл ажлыг хангах талаар;

3.Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг тогтмол өгөх, хэрэгжилтэд хяналт тавих талаар;

4.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн чиглэлээр хууль дүрэм, журам, стандартыг сурталчилсан сургалт зохион байгуулах;

5.Гал унтраах хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих;

6.Нийт ажилтан, ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, ажлын байрны онцлогоос шалтгаалан хордлого тайлах нэмэлт бүтээгдэхүүнээр хангах;

7.Ажилчдыг ажлын хувцас хэрэгслээр хангах;

Жилийн ажлын төлөвлөгөөний дагуу сар бүр хийсэн ажлын тайланг тухайн сарын 30-ны дотор тус газарт ирүүлнэ үү.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Дэваанямы ОТГОНЖАРГАЛ
2025.01.03 13:18

*Зураг №76. ААНБ-уудад хүргүүлсэн албан бичиг*



ХУДАЛДАА ҮЙЛДВЭР ҮЙЛЧИЛГЭЭ НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН "СУТАЙН БУЯНТ" ХХК

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАРТ

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажилласан тайлан хүргүүлэх тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аливаа осол гэмтэлд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор 2025 оны 05 дугаар сард дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ. Үүнд:

1.Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг тухай бүрд нь өгсөн бөгөөд 2025 оны 05 дугаар сард 47 ажилтанд давтан зааварчилгаа, зам тээврийн осол гаргасан 4 жолоочид ээлжит бус давтан зааварчилгаа, шинээр ажилд орсон 5 ажилтанд урьдчилсан зааварчилгаа өгч ажилласан.

2.Нийт жолооч нарт 2025 оны 05 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд замын хөдөлгөөний дүрэм, замын хөдөлгөөний аюулгүй байдал болон харьцаа хандлагын талаар хурал, сургалт зохион байгуулсан.

Инженер техникийн хэлтсийн ажилчид болон захиргааны ажилчдад 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулж, гарын үсгээр баталгаажуулсан.

3.Тээврийн хэрэгслүүд болон объектуудад байрлуулсан 92 ширхэг гал унтраагуурт 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр үзлэг хийж, хэвийн ажиллагааг шалгаж, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан.

Мөн 2025 оны 05 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд 83 тээврийн хэрэгслийн иж бүрдэлд үзлэг хийж шалгасан.

4.Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/293 дугаар тушаалын дагуу өдөр бүрийн урьдчилан сэргийлэх үзлэгийг давхардсан тоогоор 2108 жолооч, 96 ажилтанд хийсэн.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/340 дүгээр тушаалын дагуу ажилчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2025 оны 05 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд нийт 150 ажилтныг хамруулсан.

Хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажилладаг инженер, техникийн ажилчид болон





үйлчилгээний ажилчдын хордлогыг тайлах зорилгоор сүү, сүүн бүтээгдэхүүнийг өдөр бүр олгосон.

Жолооч болон зорчигч нарт эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэхэд шаардлагатай 27 нэр төрлийн эм тариа, ороох боох материалыг татан авч, автобусны эмийн сангуудад байрлуулсан.

5.Жолооч болон ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцсыг хуваарийн дагуу 2025 оны 05 дугаар сард малгай 142, саарал цамц 6, хантааз 14, цагаан цамц 7 ширхгийг тус тус олгосон.

6.Байгууллагын орчинд өөрсдийн тарьсан 3 нэр төрлийн 112 модыг өдөр бүр арчилж, усалгааг хийн ажиллаж байна.

Сутайн буянт ххк
Удирдлага
Захирал
Балданшарав ЛХАГВАДУЛАМ

*Зураг №77. Сутайн буянт ХХК-иас тайлан ирүүлсэн байдал*

Цаг үеийн шаардлагатай мэдээллийг ААНБ-уудад хүргэж ажилласан. Үүнд:

1.Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай" А/133 дугаар захирамжийг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01/03/344 дугаартай албан бичгээр Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудад хүргүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч үндсэн чиглэлийн 18 аж ахуйн нэгж, байгууллагууд 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд нийт 83034 автобусны цэвэрлэгээ хийгдсэн бол гадна угаалга 46682, дотор угаалга 66573, цонх хана, таазны угаалга 12902, суудлын бүрээс угааж, сольсон 1988, автобусны дээврийн угаалга 24605 тус тус хийгдсэн бол нийт 14695 удаагийн ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдсэн байна.

### 4.18.3. Салбарын сургалтын чиглэлээр хийгдсэн ажлууд

1.Нийтийн тээврийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангаж байгаа талаар:

Нийтийн тээврийн хэрэгсэл худалдан авах техникийн тодорхойлолтод хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих боломжийг хангах талаар нэмэлт шаардлагыг 2015 оноос тавьж байна.

Ингэснээр нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа 1288 тээврийн хэрэгслүүд 100 хувь харааны бэрхшээлтэй зорчигчдод зориулсан дуу хоолойгоор зарлах болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан лед дэлгэцээр чиглэлийн хаягийг мэдээлэх төхөөрөмжөөр тоноглогдсон бол 77.4 % нь нам шалтай, налуу тавцантай болсноор тэргэнцэртэй иргэн үйлчлүүлэх боломжийг хангаж байна.

2023 онд нийтийн тээврийн мэдээллийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 31.5 % нь налуу тавцантай байсан бол 2025 оны 06 дугаар сарын байдлаар 77.4% болж 45.9 %-иар нэмэгдсэн.

Нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмжийн мэдээлэл

*Хүснэгт 18.*

| Он | Нийт тээврийн хэрэгслийн тоо | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэх хүртээмжтэй байдал | |
|---|---|---|---|
| | | Сонсголын болон харааны бэрхшээлтэй иргэн зорчих боломжийг хангасан байдал | Тэргэнцэртэй иргэн зорчих боломжийг хангасан байдал |
| 2023 | 1320 | 100 % | 417 тээврийн хэрэгсэл буюу 31.5% |
| 2025 | 1288 | 100 % | 1005 тээврийн хэрэгсэл буюу 77.4% |

2.“Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах:

20 минутын хот үндэсний хорооны ажлын албаны ажилтан н.Наранбаасантай 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр уулзаж Нийтийн тээврийн жолооч нарт сургалт явуулах талаар санал солилцсон.

Сургалтад Тээврийн цагдаагийн газраас Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Д. Ганхуяг “Замын хөдөлгөөний аюулгүй байдал”, Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Тэлмэн “Зам тээврийн осолд нөлөөлөх хүчин зүйлс”, Зам тээврийн хяналт, төлөвлөлт зохион байгуулалтын хэлтсийн зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Э.Тэмүүжин “Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал” сэдвээр ХБХХЕГ-ын Сургалт, нөлөөллийн ажил хариуцсан мэргэжилтэн Г.Гэрэлтуяа, Статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн О.Гаасүрэн нар “Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцахад анхаарах зүйл” сэдвээр, Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ц.Мягмар “Цахим хяналтын үр нөлөө, гадаад орны туршлага” мэргэжилтэн Ч.Бадамханд “Нийтийн тээврийн жолооч нарын гаргадаг нийтлэг зөрчил, анхаарах асуудлууд” сэдвээр сургалтыг зохион байгуулсан.



Зураг №78. Ажлын албаны гишүүнтэй уулзалт хийв.



БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ОТГОНЖАРГАЛ
2025 оны 6 сарын 5 өдөр

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖОЛООЧ НАРТ ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СУРГАЛТЫН ХУВААРЬ

| Д/д | Сургалт зохион байгуулагдах газар | Сургалтанд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагын нэрс | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ | 2025.06.09 |
| 2 | Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ | 2025.06.10 |
| 3 | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ | 2025.06.12 |
| 4 | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ | 2025.06.13 |
| 5 | Эрдэмтранс ХХК-ийн сургалтын танхим | Эрдэмтранс ХХК | 2025.06.16 |
| 6 | Эрдэмтранс ХХК-ийн сургалтын танхим | Эрдэмтранс ХХК | 2025.06.17 |
| 7 | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ | 2025.06.18 |
| 8 | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ | 2025.06.19 |
| 9 | Сутайн буянт ХХК-ийн хурлын танхим | Сутайн буянт ХХК, Эс Энд Эй транс ХХК, ДЮЦ ХХК, Эмсид ХХК, Гбус ХХК, Мерапзаа ХХК, Блюбус ХХК, Автобус нэгдэл ХХК, Үнэгтийн уул ХХК, Сайхан иралдуй ХХК | 2025.06.20 |
| 10 | Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ | 2025.06.23 |
| 11 | Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын сургалтын танхим | Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ | 2025.06.24 |

Зураг №79. Сургалтын хуваарь

Сургалт хуваарийн дагуу зохион байгуулагдаж 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар нийт 436 жолооч Сургалтад хамрагдаад байна.



*Зураг №80. Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын жолооч нар сургалтад хамрагдаж байна.*

3.Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг цахимжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах талаар:

1.Нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд эрсдэлгүй хүргэх, автобусны жолооч нарыг ажилд гаргах үед биеийн байдлыг хэрхэн хянадаг талаарх мэдээллийг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн NTV телевизийн мэдээнд Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн ярилцлага өгсөн.




*Зураг №81. NTV телевизийн мэдээгээр Нийтийн тээврийн үйлчилгээний талаар мэдээлэл өгөв.*

Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн ААНБ-уудын тухайн ажлыг хариуцсан албан хаагчдыг оролцуулсан цэвэрлэгээ, ариутгалын вайбер групп нээн ажиллуулж харилцан мэдээлэл солилцож байна.Үүнд:




*Зураг №82. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-ууд өдөр тутмын цэвэрлэгээ, үйлчилгээний талаар мэдээлэл өгч байгаа нь.*

4.Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн боловсролын газар, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газартай хамтран сургуулийн автобусны үйлчилгээнд ажиллах ААНБ-ын жолооч нарт зохион байгуулсан сургалтын талаар.

“Хүүхдийн автобус“ төслийг хэрэгжүүлж буй ажилтан албан хаагч, жолооч, хүүхэд зохицуулагч нарт “Хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хамгааллын мэдлэгийг нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Нийслэлийн боловсролын газар, Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-тай хамтран зохион байгуулав.

Сургалтад жолооч, хүүхэд зохицуулагч 117 хүн сургалтад хамрагдсан.




*Зураг №83. Сургуулийн автобусны жолооч нар сургалтад хамрагдаж байгаа нь*

“Хүүхдийн автобус“ төслийг хэрэгжүүлж буй ажилтан албан хаагч, жолооч, хүүхэд зохицуулагч нарт хүүхдийн эрхэнд суурилсан харилцаа, хандлага сэдэвт сургалтыг 2024 оны 01дүгээр сарын 22-ны өдөр Нийслэлийн боловсролын газар, Тээврийн цагдаагийн албатай хамтран зохион байгуулав.

Цахим хуудсанд байршуулсан сургалтын мэдээлэл:

Нийтийн тээврийн хэрэгслийн хүртээмжийн үнэлгээ хийгдэж байгаатай холбоотой мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байрлуулсан.




*Зураг №84. Нийтийн тээврийн хэрэгсэлд хүртээмжийн үнэлгээ хийж байгаа нь.*

Дасгалын цаг 10 минут'' өглөөний дасгал хийх санаачилга гарган 2025 оны 01-03 дугаар сард хэрэгжүүлж мэдээллийг Нийслэлийн Биеийн тамир спортын газар болон байгууллагын фэйсбүүк фэйж дээр мэдээлсэн.




*Зураг №85. ''Дасгалын цаг 10 минут'' санаачилгын талаар цахим хуудсаар мэдээлсэн байдал*

5. ААНБ-уудын хүний нөөц хариуцсан ажилтнуудад зохион байгуулсан "Ажилтан, ажил олгогч хоорондын хөдөлмөрийн харилцаа, хууль эрх зүйн хэм хэмжээ" сэдэвт сургалтын талаар:

Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Удирдамжийн дагуу нийтийн тээврийн салбарт ажиллагсдыг ажлын нөхцөлөөс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн харилцаа болон нөхцөлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор "Нийтийн тээврийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаан ажиллах нь" сургалтыг мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаач нартай хамтран зохион байгуулсан.



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ОТГОНЖАРГАЛ

НИЙТИЙН ТЭЭВРИЙН САЛБАРТ АЖИЛЛАГСДЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАХ НЬ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

2025 оны 04 дүгээр сарын 21 Улаанбаатар хот

**Нэг. Зорилго.**
Автотээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жил, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян-2025 үйл ажиллагааны хүрээнд нийтийн тээврийн салбарт ажиллагсдыг ажлын нөхцөлөөс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн харилцаа болон нөхцөлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх.

**Хоёр. Хамрах хүрээ.**
Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн ажилтан, эмч, хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнууд

**Гурав. Зохион байгуулагчид.**
3.1 Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар
3.2 Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны ҮЭ-үдийн холбоо

**Дөрөв. Хугацаа, байршил.**
2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын цогцолбор Б блок 2 давхар 201 тоот 14:00-16:30 цагт зохион байгуулна

**Тав. Үйл ажиллагааны хөтөлбөр**

| Д/д | Сургалтын сэдэв | Хугацаа | Хариуцагч |
|---|---|---|---|
| 1 | Бүртгэл | 13:40-14:00 | Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар |
| 2 | Нээлт | 14:00-14:10 | Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Д.Отгонжаргал |
| 3 | Мэргэжлээс шалтгаалах өвчин, ажилтай холбоотой эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулах нь | 14:10-15:00 | Хор, хордлого судлалын салбар зөвлөлийн гишүүн, Мэргэжлийн өвчин судлаач эмч, клиникийн профессор Д.Ганчимэг |
| | Завсарлага | | 15:00-15:10 |
| 4 | Хөдөлмөрийн харилцаа, нөхцөл | 15:10-15:40 | Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны ҮЭ-үдийн холбооны дарга М.Болдсайхан |
| 5. | Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь | 15:40-16:20 | Нийслэлийн Онцгой байдлын Газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга дэд хурандаа Д.Хадбаатар |
| 6 | Хаалт | 16:20-16:30 | Зорчигч тээврийн хэлтсийн дарга Б.Дөлгөөн |

**Зургаа. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудаас үйл ажиллагаанд оролцох оролцогчдын тоо**

| № | ААНБ-ын нэр | Үйл ажиллагаанд оролцогчдын тоо |
|---|---|---|
| 1 | Зорчигч тээврийн нэг ОНӨААТҮГ | 6 |
| 2 | Зорчигч тээврийн хоёр ОНӨААТҮГ | 6 |
| 3 | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ | 6 |
| 4 | Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ | 6 |
| 5 | Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ | 6 |
| 6 | Автобус нэгдэл ХХК | 3 |
| 7 | Автотерминал трейд ХХК | 3 |
| 8 | Блюбус ХХК | 3 |
| 9 | Гбус ХХК | 3 |
| 10 | ДЮЦ ХХК | 3 |
| 11 | Мяралзаа ХХК | 3 |
| 12 | Сайхан Ирээдүй ХХК | 3 |
| 13 | Сутайн буянт ХХК | 5 |
| 14 | Трансбус ХХК | 5 |
| 15 | Эмсид ХХК | 3 |
| 16 | Эрдэмтранс ХХК | 6 |
| 17 | Эс Энд Эй транс ХХК | 3 |
| 18 | Үнэгтийн Уул ХХК | 3 |
| | Такси үйлчилгээ | |
| 1 | Тэбэ сервис ХХК | 2 |
| 2 | ВИП такси ХХК | 2 |
| 3 | Юбикаб бригада хоршоо ХХК | 2 |
| 4 | Мөнх такси ХХК | 2 |
| 5 | Стар авто трейд"ХХК | 2 |
| | Бууxиа үйлчилгээ | |
| 1 | Буянт хөлгийн жолоо ХХК | 2 |
| 2 | Юнайтэд бра ХХК | 2 |
| | Нийт | 90 |

*Зураг №86. Сургалтын удирдамж*

Сургалтад үндсэн чиглэлийн 18, таксины 3, буухиа үйлчилгээний 2 нийт 23 аж ахуйн нэгж байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн ажилтан, эмч, хүний нөөцийн асуудал хариуцсан нийт 92 ажилтан хамрагдсан.

Сургалтын үйл ажиллагааг газрын дарга Д.Отгонжаргал нээж, Хор, хордлого судлалын салбар зөвлөлийн гишүүн, Мэргэжлийн өвчин судлаач эмч, клиникийн профессор Д.Гангаамаа Мэргэжлээс шалтгаалах өвчин, ажилтай холбоотой эрүүл мэндийн асуудалд анхаарал сэдвээр, Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны ҮЭ-үүдийн холбооны дарга М.Болдсайхан Хөдөлмөрийн харилцаа, нөхцөл, хууль эрх зүйн актуудын талаар хичээл орсон.




*Зураг №87. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь чиглэлээр*

6.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын жолооч нарт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, харилцаа хандлага, ёс зүйн чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтын талаар:

2025 оны эхний хагас жилд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, харилцаа хандлага, ёс зүйн чиглэлээр нийт 10 удаагийн сургалтаар нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа 738 жолоочийг сургалтад хамруулав.




*Зураг №88.Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын жолооч нар сургалтад хамрагдаж байна.*

7.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын инженер техникийн ажилтан, жолооч нарт “Автотээврийн салбарт мөрдөх хууль тогтоомж, стандартууд”, “Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системийн тоног төхөөрөмжийн ашиглалт” сэдвээр төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалтын талаар:

1.2025 оны 04 дүгээр сарын 03,04-ний өдрүүдэд нийслэлийн өмчийн, 04 дүгээр сарын 15-ны өдөр хувийн хэвшлийн ААНБ-уудын жолооч нарт зориулсан сургалтыг Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, Ай Си Ти групп ХК-тай хамтран зохион байгуулж нийтийн тээврийн үндсэн чиглэлийн 18 ААНБ-ын 303 жолооч хамрагдсан.



*Зураг №89. Камерын хяналтыг сайжруулах нь сургалт явагдаж байна.*

2.“Нийтийн тээврийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын жолооч нарт 2025 оны 04 дүгээр сарын 15,16-ны өдрүүдэд Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, Ай Си Ти групп ХК-тай хамтран зохион байгуулж 60 хүн хамрагдсан.




*Зураг №90. Нийтийн тээврийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх нь сургалтын явц*

3.Автотээврийн салбарт мөрдөх хууль тогтоомж, стандартууд”, сэдвээр Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын жолооч нарт Сонгинохайрхан дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн албан хаагчидтай хамтарсан сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 08,09,10-ны өдрүүдэд зохион байгуулж 53 жолооч хамруулсан.

8. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-ын инженер техникийн ажилтнуудад Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны суурь ойлголт, Галын аюулгүй ажиллагаа, Цахилгаан аюулгүй ажиллагаа, Аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ, ХАБЭА-н шаардлага зэрэг сэдвүүдээр зохион байгуулсан сургалт талаар:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аян-2025 үйл ажиллагааны хүрээнд Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Удирдамжийн дагуу нийтийн тээврийн салбарт ажиллагсдыг ажлын нөхцөлөөс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн харилцаа болон нөхцөлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор "Нийтийн тээврийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах нь" сургалтыг мэргэжлийн байгууллагууд, эрдэмтэн судлаач нартай хамтран зохион байгуулсан.

Сургалтад үндсэн чиглэлийн 18, таксины 3, буухиа үйлчилгээний 2 нийт 23 аж ахуйн нэгж байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн ажилтан, эмч, хүний нөөцийн асуудал хариуцсан нийт 92 ажилтан хамрагдсан.

2.Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-аас Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах, аврах 29 дүгээр ангитай хамтран 2025 оны 05 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Гал түймэр унтраах тактикийн дадлага сургалтыг нийт 259 ажилтан албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.





*Зураг №91.Үзүүлэх сургалтын үйл явцаас*

9. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын шалгах механик нарт Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS4598:2020, MNS5012:2021 стандарт болон холбогдох стандартуудаар зохион байгуулсан сургалтын талаар:

БНХАУ-д үйлдвэрлэгдэн "Скайвелл" маркийн тээврийн хэрэгслийг эзэмшигч Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-аас тус автобусыг нийлүүлэгч байгууллагаас инженерүүдэд зориулсан засвар үйлчилгээний сургалт зохион байгуулах хүсэлт 2025 оны 03-3/10 дугаартай албан бичгээр ирүүлсэн тул Грийн энержи моторс ХХК-тай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд сургалтыг зохион байгуулав.

Сургалтаар Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS4598:2011 стандартын хэрэгжүүлэлт болон БНХАУ-ын Скайвелл автобусны үйлдвэрээс ирсэн мэргэжилтэн цахилгаан автобусны засвар үйлчилгээний талаар мэдлэг, мэдээлэл өгсөн.

Сургалтад төрийн өмчийн 5 аж ахуйн нэгж, байгууллагын 63 инженер, механикууд хамрагдсан.







*Зураг №92.Сургалт, дадлагын үйл явцаас*

2025 оны эхнээс 18 удаагийн сургалтаар нийт 994 инженер, техникийн ажилтан, жолооч, захиргааны ажилчдыг сургалтад хамруулсан бөгөөд эдгээр сургалтын явцад нийтийн тээврийн үндсэн стандарт MNS 5012:2021-ийн талаар мэдээлэл өгч ажилласан.




*Зураг №93.Нийтийн тээврийн үйлчилгээний стандартын хэрэгжилт сургалтын явцаас*

10.Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа шалгагч, хяналтын ажилтнуудад зохион байгуулсан сургалтын талаар;

2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийтийн тээврийн төлбөр өөрчлөгдөж байгаатай холбоотой “Нийтийн тээврийн үйлчилгээний хөлс төлөлтийн өөрчлөлт“ сэдвээр Хяналт шалгалтын хэлтсийн шалгагч нарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Ай Си Ти групп ХК-тай хамтарсан сургалт зохион байгуулж менежер Б.Чулуунбат сургалтыг удирдан явуулсан. Нийт 55 шалгагч хамрагдсан.

11. Нийтийн тээврийн ААНБ-уудын дотоод сургалтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах чиглэлээр:

- Трансбус ХХК-ийн жолооч нарт 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн хэлтэстэй хамтарсан “Тээврийн хэрэгслийн жолоодох эрх дуусгавар болох, жолоодох эрхийг сэргээх журам“ сэдэвт сургалт зохион байгуулагдаж нийт 13 жолооч хамрагдсан.

- Гбус ХХК-ийн жолооч нарт 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр “Үйлчилгээний ажилтны харилцааны соёл, жолоочийн хариуцлага“сэдэвт сургалт зохион байгуулагдаж нийт 18 жолооч хамрагдсан.

- Блюбус ХХК-ийн жолооч нарт мэргэжлийн ур чадвар олгох зорилгоор “Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрэм, Зөрчлийн тухай хуулийн /Сэтгэл санааны хохирол гэж юу вэ?, Жолоочид хамаарах заалтууд, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль/ зэрэг сэдвүүдээр Тээврийн цагдаагийн алба, Цагаан шонхрын жигүүр ТББ-тай хамтарсан сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж 35 хүн хамруулсан.



*Зураг 94.Жолооч нарын сургалт явагдаж байгаа нь*

12.Нийтийн тээврийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг мөрдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын талаар:

1.Нийтийн тээврийн үндсэн стандарт болох “Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага” MNS 5012:2021 стандартын 12-т заасан Зорчигдод тавих шаардлагыг хангуулах зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн ахлах ангийн 900 сурагчдад Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-тай хамтарч Замын хөдөлгөөнд болон нийтийн тээврийн үйлчилгээнд соёлтой оролцох нь сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 17-21-ний хооронд нийт 5 өдөр зохион байгуулсан.



"ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВ" ОНӨТҮГ
Нийслэлийн засаг захиргааны V байр,
Бээжингийн гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7011 1642 (976-51) 26 07 70
Цахим шуудан: info@ubtraffic.mn
Цахим хуудас: www.ubtraffic.mn

2025.03.13 № 01/249

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАРТ

Хамтран ажиллах тухай

Цаг агаар дулаарч байгаатай холбоотойгоор замын хөдөлгөөнд оролцож буй өсвөр насны хүүхдүүд анхаарал болгоомжгүй замын зорчих хэсэг дээр унадаг дугуй, цахилгаан скүүтэрийг унаж замын хөдөлгөөнд оролцож аюулгүй байдлыг хангаагүйн улмаас зам тээврийн осолд өртөж, цаашлаад эрүүл мэнд, амь насаараа хохирч байгаа статистик тоо мэдээлэл жилээс жил ирэх тусам нэмэгдэж байна.

Иймд "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ болон "ТЦА-ны замын цагдаагийн газрын замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс" байгууллагууд хамтран 2025 оны 03 дугаар сарын 14,17,18,19,20-ны өдрүүдэд Нийслэлийн 84 дүгээр сургуулийн 10,11,12 дугаар ангийн 39 ахлах бүлгийн 900 сурагчдад дараах сэдвээр:

1.МУ-ын замын хөдөлгөөний дүрэм,
2.Нийслэлд байрладаг хяналтын камер, гэрлэн дохионы тухай ойлголт,
3.Замын хөдөлгөөнд аюулгүй зорчих зааварчилгаа,
4.Нийтийн тээврээр зорчиход анхаарах зүйлүүд зэрэг соён гэгээрүүлэх, сурталчлан таниулах сургалтыг зохион байгуулах гэж байна.

Тус сургалтад нийтийн тээвэртэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө, зааварчилгаа өгөх мэргэжилтнийг томилж уг үйл ажиллагаанд хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт 1 хуудастай.

Замын хөдөлгөөний удирдлагын төв
Удирдлага
Захирал
Чулуунхүү ХУВЬЗАЯА
2025.03.13 15:55



"Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-ын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/249 дугаар албан бичгийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН 84 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН АХЛАХ АНГИЙН СУРАГЧДАД
"ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРЭМ" ХӨДӨЛГӨӨНД АНХААРАЛ БОЛГООМЖТОЙ ОРОЛЦОХ
ТАЛААР МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр — Улаанбаатар хот

| Д/д | Сургалтын нэр | Үргэлжлэх хугацаа | Хамтран ажиллах хэлтэс (албан байгууллага) | Сургалт орох мэргэжилтний нэр | Он, сар | Үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Нэг. Төлөвлөгөөт ажил үйлүүд | | | | | | |
| 1.1 | "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-ын үйл ажиллагааны товч танилцуулга, замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох зөвлөмж | 20 минут | "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ | Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах мэргэжилтэн Л.Баярцэцэг | 2025.03.14 17.18.19.20 | Тус сургалтыг нааш ерөнхий боловсролын сурагчид замын хөдөлгөөнд зөв, соёлтой оролцох, замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй байдлын талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлж, зөв дадлыг суулгах үйлдлээ хэвшүүлэх үр дүнтэй юм |
| 1.2 | Замын хөдөлгөөний дүрэм, зорчих хэсэгт скүүтер, унадаг дугуй унаж хөдөлгөөнд оролцох зөвлөмж | 20 минут | ТЦА-ны Замын цагдаагийн газрын замын хөдөлгөөний удирдлагын хэлтэс | Цагдаагийн ахлагч, дэслэгч зохицуулагч М.Тэрмүүн | 2025.03.14 17.18.19.20 | |
| 1.3 | Нийтийн тээврийн мэдээлэл болон Нийтийн тээврээр зорчихдоо анхаарах зүйл | 20 минут | Нийтийн тээврийн бодлогын газар | Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ч.Бадамханд | 2025.03.14 17.18.19.20 | |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
СУРГАЛТ, СУДАЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ
ХАРИЛЦАХ МЭРГЭЖИЛТЭН Л.БАЯРЦЭЦЭГ

*Зураг №95.Сургалтын хөтөлбөр*

2.Нийтийн тээврийн “Төлбөр тооцооны үндсэн системийн санхүүгийн тооцоолол хийх нь” сургалтыг Ай Си Ти групп ХК-тай хамтран 2025 оны 02 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулж 19 ААНБ-ын 35 албан хаагчийг оролцуулав.






*Зураг №96. Төлбөр тооцооны үндсэн системийн санхүүгийн тооцоолол хийх нь сургалтын үйл явцаас*

13.Нийтийн тээврийн бүлэг хотын стандартыг мөрдүүлэхэд чиглэсэн сургалт арга зүйгээр хангах чиглэлээр:

1. Улаанбаатар хотын стандартууд, Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS4598:2025 шинэчлэгдсэн стандартын байгууллагын албан хаагчид болон Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудын удирдлагууд инженер, техникийн ажилтнуудад файлаар өгсөн.

2. Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-уудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хамтарсан сургалт зохион байгуулж, арга зүйгээр хангаж ажилласан.

14.Нийтийн тээврийн стандарт, нормын талаар албан хаагчид, нийтийн тээврийн байгууллагуудад сурталчлан таниулах сургалт арга зүйгээр хангах.

1. Нийтийн тээврийн стандарт, нормын талаар албан хаагчид, нийтийн тээврийн байгууллагуудад сурталчлан таниулах ажлын хүрээнд Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-ын удирдлагуудтай хамтран 2025 оны 02 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулж тус байгууллагын нийт 205 жолооч хамрагдсан. Автотээврийн хяналтын улсын байцаагч Б.Мягмардорж 2024 онд нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой иргэдээс ирүүлсэн санал, гомдол анхаарах асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч Зөрчлийн хуультай холбоотой арга зүйн зөвлөгөө өгөв.




*Зураг №97.Сургалтын мэдээлсэн байдал*

## 4.19. Нийтийн тээврийн дулаан зогсоол хотын стандартын төсөл боловсруулж батлуулахад шаардлагатай тоон мэдээ, судалгаа гаргаж санал өгч хамтран ажиллах

Нийтийн тээврийн дулаан зогсоол хотын стандартын төсөл боловсруулж батлуулахад шаардлагатай тоон мэдээллийг 2024 оны 12 дугаар сард гарган өгч, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/10 дугаар тогтоолоор USC1601A:2025 Нийтийн тээврийн зогсоолын зорчигчийн хүлээлгийн танхимд тавигдах ерөнхий шаардлагыг батлуулсан.

Энэ онд Нийслэл Улаанбаатар хотын 3 байршилд шинээр хийгдсэн дулаан зогсоолыг байнгын ашиглалтад оруулсан.Үүнд:

- Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас захиалсан Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхорын эцсийн автобусны зогсоолын тохижилтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр;

- Хан-Уул дүүргийн 13-р хороо Туул тосгоны шинэ эцэс, хуучин эцэст дулаан автобусны зогсоолыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Улсын комисст ажиллан байнгын ашиглалтад тус тус хүлээн авсан.

-Нийтийн тээврийн автобусны дулаан зогсоолуудыг камерын нэгдсэн хяналттай болгох зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 01/02/1058 тоот бичгээр дүүргүүдээс шинээр хийгдсэн дулаан зогсоолуудын мэдээллийг авч автобусны зогсоолын мэдээллийн сан бүрдүүлж УБЗАА-нд нэгдсэн камерын хяналттай болгох санал хүргүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Улаанбаатар хотоос зүүн аймаг, дүүрэг рүү чиглэх зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүртээмжтэй хүргэхэд 2025 оноос MNS 6300: 2011 стандартын "В"ангилал стандартад нийцсэн өдөрт 5000 хүртэл хүнд үйлчлэх хүчин чадалтай зорчигч болон дотоодын ачаа тээврийн цэгийг байгуулахаар төслийн ажил эхлүүлэх гэж байгаа мэдээллийг “Тэнгэр” ХХК-иас ирүүлсэн. Уг ажил нь хотын алслагдсан Багануур, Багахангай дүүргийн иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэг нөлөө үзүүлэхээр байгаа тул төслийг дэмжиж Хот байгуулалтын газарт 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/02/1022 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.

Тус газраас Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/618 дугаар захирамжаар байгуулагдсан Нийтийн тээврийн эцсийн зогсоолыг иж бүрэн тохижуулах, одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, төлөвлөлтийн шийдэл боловсруулах, хөрөнгө оруулалтын судалгааг гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Ажлын хэсэгт нийтийн тээврийн үйлчилгээний жолооч нарын ажлын нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор эцсийн зогсоолуудын ариун цэврийн өрөөний судалгааг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 байгууллагаас авч нэгтгэн, ажлын хэсэгт эхний ээлжид 25 эцсийн зогсоолын байршилд капсул байршуулах тооцооллыг танилцуулсан.

Нийтийн тээврийн зогсоолын байгууламж дахь чиглэлийн мэдээллийн зураглалын боловсруулалтыг автоматжуулах ажлын хэрэгцээ шаардлагыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, тус ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах 200,000,000 (хоёр зуун сая) төгрөгийг Нийтийн тээврийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/13 дугаар захирамжаар батлуулсан.

Тус захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Нийтийн тээврийн зогсоолын байгууламжийн чиглэлийн мэдээллийн зураглалыг автоматаар боловсруулах ажил үйлчилгээний даалгавар, Нийтийн тээврийн бодлогын газрын 2025 оны худалдан авах төлөвлөгөөг боловсруулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан.

Нийтийн тээврийн бодлогын газрын https://www.transport.ub.gov.mn/ цахим хуудас болон цахим нүүр хуудаст нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдөж буй нийтийн тээврийн чиглэлийн мэдээллийн зураглалыг боловсруулах системийг нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгох нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох урилгыг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байршуулсан.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн зогсоолын байгууламжийн чиглэлийн мэдээллийн зураглалыг автоматаар боловсруулах систем” НТБГ/20250103002 дугаартай тендер шалгаруулалтад 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр зарлагдаж Дата дэүс ХХК-ний тендерийн санал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарч хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтыг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гэрээ байгуулагдсан.

## ТАВДУГААР БҮЛЭГ. “ДҮРЭМ”-ЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: /А/536/

### 5.1. Газрын “Дүрэм”-ээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд хүргүүлж ажиллана.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн тээврийн бодлогын газрын “Дүрэм”-ээр хүлээсэн 18 үүргийн хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гарган 2025 эхний хагас жилийн тайланг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/01/1460 дугаартай албан бичгээр, 2025 оны жилийн эцсийн тайланг 2025 оны 12 дугар сарын 05-ны өдрийн 01/01/2550 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.


НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.АМГАЛАН ТАНАА

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар батлагдсан "Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм"-ээр хүлээсэн үүргийн биелэлтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган хүргүүлж байна.

Хавсралт 10 хуудастай.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Даваажав ОТГОНЖАРГАЛ
2025 07 01 08 29

*Зураг №98. 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/01/1460 дугаартай албан бичиг*

## 5.2. Нийтийн тээврийн үйлчилгээний зорчих үнэ, тариф, машин цагийн зардлыг шинэчлэн тогтоох талаар шаардлагатай тооцоо, судалгааг хийж санал боловсруулах, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, хяналт тавина. Дүрмийн 4.1.1.1

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар "Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай" 25/14 дүгээр тогтоолыг баталсан.

Шинээр батлагдсан тарифыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлж, иргэд өдөрт 1000 төгрөгөөр хугацаа харгалзахгүйгээр өдөрт 4 удаа зорчих нөхцөлийг бүрдүүлж, зорчигч төлбөрийн олон төрлөөс сонгон төлбөрөө төлөх боломжийг бүрдүүлсэн.

Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-аас 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 03-4/229 дугаартай албан бичгээр цахилгааны үнэ тариф нэмэгдсэнтэй холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан машин цагийн зардлын тарифт өөрчлөлт оруулах тухай хүсэлт ирүүлсэн.

Ирүүлсэн хүсэлтийг тооцооллын хамт хянаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025 оны Нийслэлийн Засаг даргын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01/06/827 дугаартай албан бичгээр уламжилсан.

Мөн нийтийн тээврийн салбарын машин цагийн зардлын төлөвлөлтийг сайжруулж, зардлыг бууруулах талаар Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Даваадалайд орлого, зорчигчийн тоо, санхүүжилтийн мэдээллийг нэгтгэж танилцуулахад холбогдох тооцооллыг хийсэн.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/344 дугаар захирамжаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн шинэчлэлтийн ажлын хүрээнд нийтийн тээврийг үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын зардлын санхүүжилтийг "Үр дүнд суурилсан үнэлгээ" (KPI) тогтолцоонд шилжүүлэх судалгаа хийх Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогчийн ахалсан ажлын хэсэг холбогдох танилцуулга, мэдээлэл, судалгааг гүйцэтгэн ажиллаж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 632 дугаар тогтоолоор цахилгааны үнэ тариф 41.7 хувиар нэмэгдсэн. Үүнтэй холбогдуулан их багтаамжийн цахилгаан автобусаар үйлчилгээ үзүүлдэг Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03-4/89 дугаартай албан бичгээр, мөн 225 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 03-4/229 дугаартай албан бичгүүдээр цахилгаан автобус цэнэглэхтэй холбогдон гарах эрчим хүчний зардал тус байгууллагын зардлыг өсгөж, санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл үүсгээд байгаа Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан машин цагийн зардлын тарифт өөрчлөлт оруулах хүсэлтийг ирүүлснээр холбогдох тооцоо, судалгааг хийж Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн.

Цахилгаан автобусны тарифыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 25/116 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан.

Энэхүү тогтоолд:

-Их багтаамжийн цахилгаан автобус/энгийн/-ны машин цагийн зардлын тарифыг 79,162 төгрөг,

- Их багтаамжийн цахилгаан автобус/давхар/ 90,970 төгрөг,

- Троллейбус-60,817 төгрөг гэж тус тус өөрчилсөн. Дээрх тогтоолыг Төсвийн тухай хуулийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

*Хүснэгт 19: Нийтийн тээврийн үйлчилгээний нэг машин цагийн зардлын тарифын өөрчлөлт /төгрөг/*

| № | Тээврийн хэрэгслийн төрөл | НИТХ 2024 оны 26 дугаар тогтоол | НИТХ 2025 оны 25/116 дугаар тогтоол | Нэмэгдсэн зөрүү |
|---|---|---|---|---|
| 1. | Угсраа автобус | 84,471 | 84,471 | - |
| 2. | Троллейбус | 56,588 | 60,817 | 4,229 |
| 3. | Их багтаамжийн автобус/Дизель евро-5 хөдөлгүүртэй/ | 80,807 | 80,807 | - |
| 4. | Их багтаамжийн автобус | 68,947 | 68,947 | - |
| 5. | Их багтаамжийн байгалийн хийн хөдөлгүүртэй автобус | 68,695 | 68,695 | - |
| 6. | Их багтаамжийн цахилгаан автобус | 70,417 | 79,162 | 8,745 |
| 7. | Давхар автобус/цахилгаан/ | 80,564 | 90,970 | 10,406 |
| 8. | Дунд багтаамжийн автобус | 58,984 | 58,984 | - |
| 9. | Дунд багтаамжийн автобус /Парк шинэчлэлт/ | 63,467 | 63,467 | - |

## 5.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангах Дүрмийн 4.1.2.1

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, хүлээгдлийн хугацааг багасгах, нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын шугамын цаг, рейсийн нэгдсэн даалгаврыг нийт 46 удаа шинэчлэн батлуулж, нийт 32 чиглэлийн үйлчлэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлж, 6 чиглэлийг шинээр нээж, 2 чиглэлийг сэргээж, 5 чиглэлд өөрчлөлт оруулсан байна.

Нийтийн тээврийн бодлогын газрын 57 шалгагч Энхтайваны өргөн чөлөөнд байрлах нийтийн тээврийн 30 замналын зогсоолд хуваарийн дагуу ажиллаж, нийтийн тээврээр үйлчлүүлж байгаа зорчигчдод чиглэл замналын мэдээлэл, шинээр нэвтэрсэн төлбөрийн системтэй холбоотой мэдээ, мэдээллийг зорчигчдод таниулах, зорчигчийн хөлс төлөлтийн байдалд хяналт шалгалтыг тогтмол хийж, 5139 зорчигчдод шинэ системийн нэвтрэлтийн талаар болон UB card аппликейшн гар утсанд хэрхэн суулгаж, ашиглах аргачлал, заавар зөвлөгөөг өгч ажилласан.

Нийтийн тээврийн цагийн хуваарьтай холбоотой 4, зам засварын ажилтай холбоотой чиглэл өөрчлөгдсөн тухай 17, шинээр чиглэл нээгдсэнтэй холбоотой 4 удаа буюу нийт 25 удаа мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан.

Чиглэлийн өөрчлөлт, зам засвар, үйл ажиллагаа, төлөвлөлтийн талаар байгууллагын цахим хуудсанд нийт 38 удаагийн хэвлэлийн мэдээ бэлтгэн байршуулсан. Мөн 30 удаагийн телевизийн мэдээ, хэвлэлийн хуралд ярилцлага өгч иргэдийг мэдээллээр хангаж ажилласан байна.




*Зураг №99. Б.Амарзаяа "Монголын мэдээ"*




*Зураг №100. Б.Энэбиш Монгол HD тв мэдээ*




*Зураг №101. Э.Тэгэлдэр Чиглэлийн үйлчилгээний талаар*



*Зураг №102. О.Хонгорзул Зогсоолын мэдээллийн самбарын шинэчлэлийн талаар*

### 5.3.1. Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ, чиглэлийг оновчилж, хүн амын нягтаршилд тохируулан нийтийн тээврийн хэрэгслийг хүртээмжтэй байдлаар төлөвлөх ажлын хүрээнд:

Энэ 2025 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч төрийн ОНӨААТҮГ-ын 5, хувийн хэвшлийн 14 буюу нийт 18 аж ахуйн нэгж байгууллага 133 чиглэлд ажлын өдөр 1097, амралтын өдөр 945 тээврийн хэрэгслийн гаралттай, 1280 автобусны зогсоолыг дайран өнгөрч өдөрт 450-500 мянган зорчигчдод үйлчилгээ үзүүлж байна.

Тус газраас иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, түгжрэлээс шалтгаалсан нийтийн тээврийн хүлээгдлийн хугацааг багасгах зорилгоор богино эргэлтийн чиглэлүүдийг төлөвлөх ажлыг эхлүүлсэн. Үүнд: Энхтайваны өргөн чөлөө дагуу М:1а "5 шар- Мөнгөн завьяа", М:1б "Офицеруудын ордон- Сүхбаатарын талбай" чиглэлийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр нээсэн.

Үндсэн М:1 "5 шар-Офицеруудын ордон" чиглэлийн энэ оны 01 дүгээр сарын зорчилт 1,357,280 байсан нь 04 дүгээр сард зорчилт нэмэгдсэн чиглэлүүдийн нийлбэрийн хамт 1,485,809 болж 128,529 зорчилтоор буюу 9.4 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.

Мөн Хан-Уул дүүрэгт зорчдог иргэдийн нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор богино эргэлтийн Ч:7А "Нисэх-5 Богд компани", М:3А "Архивын ерөнхий газар-Таван богд компани" чиглэлийн үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс шинээр нээсэн.

Нийслэл Улаанбаатар хотод шинээр баригдсан Сонгинохайрхан дүүргийн 14, 21, 31, 43-р хороо, Баянгол дүүргийн 10, 22-р хороо, Баянзүрх дүүргийн 17,18,19, 27-р хороодын гэр хорооллын дундах 14 байршлын авто замын нөхцөл байдлыг 2025 оны 05 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд газар дээр нь судалж холбогдох төлөвлөлтийг боловсруулсан.

Судалгаанд хамрагдсан гэр хорооллын 14 байршлын дундах авто замын 12 байршилд хороолол дундах замын нөхцөл байдал болон дэд бүтцээс үүдэлтэй нийтийн тээврийн дунд оврын автобус үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна. Авто замын хэвтээ, босоо тэмдэглэлийн сайжруулалт хийж, дундын болон эцсийн зогсоол хийсний дараа 2 байршилд нийтийн тээврийн дунд оврын автобус үйлчлэх боломжтой нь тодорхойлогдсон.

Одоогоор гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээ хүрээгүй суурьшлын цэгүүдэд 8 чиглэлд дунд багтаамжийн 17 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна.

Нийтийн тээврийн чиглэлүүд нэршлээр:

Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ төлөвлөлтөөр Нийслэл Улаанбаатар хотын хойноос урагш, баруун зүүн цэгүүдийг холбосон төвийн "М:..." буюу магистрал-9,

Төвийн гол чиглэлүүдийг холбосон үндсэн "Ч:..." чиглэлийн 77, "Ү:..." чиглэлийн 11,

Хот орчмын "Х:..." чиглэлийн 20, дунд багтаамжийн тээврийн хэрэгслийн "Д:..." чиглэлийн 8,

Шөнийн үйлчилгээний "ШҮ:..." чиглэлийн 3,

Ажилчдын "АТ:..." чиглэлийн 2 буюу нийт 133 чиглэлээр иргэдэд зорчигч тээврийн үйлчилгээг хүргэж байна.

Улаанбаатар хотын гол гудамж замууд болох Энхтайваны өргөн чөлөөгөөр 7 чиглэлийн 150 автобус, Чингисийн өргөн чөлөөгөөр 11 чиглэлийн 157 автобус, Их тойруугаар 13 чиглэлийн 161 автобус, Нарны замаар 5 чиглэлийн 53 автобус үйлчилж байна.

Энэ оны 06 сарын байдлаар үндсэн чиглэлүүдийн үйлчилгээний дундаж хүлээгдлийн хугацаа 8.1 минут байгаа нь 2023 оны харьцуулахад 12%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Нийтийн тээврийн орлогыг нэмэгдүүлж, зардал бууруулах ажлын хүрээнд Нийтийн тээврийн бодлогын газрын даргын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралд нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл бүрийн багтаамж ашиглалтын коэффициентийг гаргаж тээврийн хэрэгслийн хуваарилалтын оновчлох санал танилцуулсан. Нийтийн тээврийн үйлчилгээний 138 чиглэлээс 41% буюу 57 чиглэлийн багтаамж ашиглалтын коэффициент

0-59, 35% буюу 48 чиглэлийн багтаамж ашиглалтын коэффициент 60-100, 24% буюу 33 чиглэлийн багтаамж ашиглалтын коэффицент 101-с дээш байна.

| *Өнгө* | *Багтаамж ашиглалтын үзүүлэлт* | *Үзүүлэлт* | *Чиглэлийн тоо* | *Эзлэх хувь* |
|---|---|---|---|---|
| | *0-59* | *Бага* | *57* | *41%* |
| | *60-99* | *Оновчтой* | *48* | *35%* |
| | *100 с дээш* | *Хэтэрсэн* | *33* | *24%* |
| *Дүн* | | | *138* | *100%* |

*Хүснэгт 20. Багтаамж ашиглалтын үзүүлэлт*

Тайлант хугацаанд нийтийн тээврээр 141,373,350 зорчигч үйлчлүүлсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 12,7%-иар өссөн үзүүлэлттэй байна.

| Сар | 2024 | | 2025 | |
|---|---|---|---|---|
| | Зорчигч | Картын орлого | Зорчигч | Картын орлого |
| 1 | 10,988,751 | 2,526,492,500 | 11,080,684 | 2,686,598,130 |
| 2 | 9,607,269 | 2,071,590,300 | 12,012,507 | 3,783,338,330 |
| 3 | 12,769,698 | 2,697,730,900 | 14,046,448 | 3,531,498,500 |
| 4 | 13,749,619 | 2,894,802,300 | 14,181,772 | 4,051,317,100 |
| 5 | 13,662,396 | 2,888,013,800 | 14,147,178 | 4,068,747,600 |
| 6 | 11,221,032 | 2,484,834,500 | 11,951,938 | 3,553,608,200 |
| 7 | 9,258,700 | 2,211,593,500 | 9,548,827 | 2,870,173,100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | 11,206,437 | 2,742,258,000 | 15,506,665 | 7,199,152,101 |
| 9 | 12,844,119 | 2,840,193,300 | 15,587,054 | 4,886,578,170 |
| 10 | 13,290,643 | 2,827,240,700 | 15,401,457 | 4,834,046,010 |
| 11 сарын 16 | 6,816,824 | 1,402,352,800 | 7,908,820 | 2,583,811,140 |
| **Нийт** | **125,415,488** | **27,587,102,600** | **141,373,350** | **44,048,868,381** |

*Хүснэгт 21. Зорчигч урсгалын тоон мэдээлэл*

5.3.2. Нийтийн тээврийн үйлчилгээнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, бодит шийдэл гаргах, сүлжээний төлөвлөлтийн оновчтой хувилбар, загварыг боловсруулах систем хөгжүүлэлтийг хийлгэн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн судалгаа, шинжилгээний байгууллагуудтай холбогдох уулзалтуудыг зохион байгуулж ажилласан талаар:

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/405 дугаар захирамжаар байгуулагдсан "Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн сүлжээ төлөвлөлтийг судалж, санал дүгнэлт боловсруулах" ажлын хэсэг, 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/344 дугаар захирамжаар байгуулагдсан "Үр дүнд суурилсан үнэлгээ" (KPI) тогтолцоонд шилжүүлэх танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгээс нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийг математик загварчлалаар оновчлох систем хөгжүүлэлтийг хийлгэж ашиглах нь зүйтэй гэж дүгнэсэн.

Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/75 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлаас нийтийн тээврийн сүлжээний төлөвлөлтийг оновчлох систем хөгжүүлэлтийн ажлыг шуурхай зохион байгуулж хийлгэхийг тус газарт даалгасан.

Дээрх ажлын хүрээнд их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны 10 гаруй байгууллагад нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийн оновчлол, зорчигч урсгал, хүртээмж, үйлчилгээний чанарын үнэлгээ зэрэгт судалгаа, дүн шинжилгээ хийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах санал тавин албан бичиг хүргүүлж, хариуг авч нэгтгэсэн.

Тус газраас Нийтийн тээврийн бодлогын газрын хурлын танхимд 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр "Нийтийн тээврийн салбарт тулгамдаж байгаа асуудал", "Нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлт, чиглэлийн оновчлол" сэдвээр төр, хувийн хэвшлийн аж, ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөлтэй харилцан мэдээлэл солилцсон уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад Нийслэлийн Ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Д.Бадарсан, Нэгдсэн төслийн удирдлагын газрын дарга Х.Өнөржаргал, МУИС-ийн багш М.Мэнд-Амар нар болон холбогдох албаны хүмүүс оролцсон.

Мөн Тус газраас нийтийн тээврийг оновчлон тээврийн хэрэгслийн цаг даалгавар, хуваарь боловсруулах системийн хөгжүүлэлтийг хийх хүсэлтээ илэрхийлсэн 3 компанийн мэдээлэлтэй танилцсан.

Уг системийг нэвтрүүлж, хөгжүүлэлт хийгдсэнээр цугларсан дата мэдээллүүдийг бүрэн ашиглан дүн шинжилгээ, симуляц хийгдэж, нийтийн тээврийн зорчигч урсгалын загварчлал, оновчлол бүхий нийтийн тээврийн чиглэлийн хуваарь, төлөвлөгөө боловсруулагдан, иргэдэд хүргэх нийтийн тээврийн чанар хүртээмж дээшилж, нийтийн тээврээр үйлчлүүлэхийг сонгох иргэдийн тоо нэмэгдэнэ.

Мөн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын гүйцэтгэлийг KPI систем рүү шилжүүлснээр үйл ажиллагааг бодитоор үнэлэх, хянах, өөрчлөлт хийх, идэвхжүүлэх, үйлчилгээний чанар сайжрах, өрсөлдөх чадварыг бий болгох, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт хийхэд чухал нөлөөтэй.

Уг ажлын хүрээнд "Нийтийн тээврийн чиглэлийг оновчлох, хуваарь төлөвлөгөөг боловсруулах систем хөгжүүлэлтийн ажил"-ын даалгаврыг боловсруулсан бөгөөд хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгох нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлан гүйцэтгүүлэх, санхүүжилтийн зардлыг Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангаас гаргуулах саналыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/02/1238 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн зөвлөлийн хуралд танилцуулан шаардагдах хөрөнгийг нийтийн тээврийг хөгжүүлэх сангаас гаргахаар дэмжигдэж шийдвэрлэгдсэн.

### 5.4. Хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн сүлжээ, төлөвлөлт, үйлчилгээний чиглэлийг тогтоох, чиглэл, зогсоолыг шинээр нээх, хаах, өөрчлөх, бүртгэл хийх, цагийн хуваарь тогтооно. Дүрмийн 4.1.2.2

#### 5.4.1 Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх ажлын талаар:

Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн парк шинэчлэлтийн хүрээнд 2025 онд Багануур, Багахангай дүүрэг болон Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал руу иргэдэд хүргэх нийтийн тээврийн үйлчилгээнд зориулж БНХАУ-ын үйлдвэрлэгчээс Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011 стандартын 8.1.1 "... Улс хоорондын, хот хоорондын, хот орчмын үйлчилгээнд ажиллах автобус нь 1-ээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар олон суудал, гар тээшний тавиураар тоноглогдсон, тээш хадгалах хонгил байна." дэх шаардлагыг хангасан 10 автобусыг худалдан авах ажиллагааг зохион байгуулагдсан. Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээнд тээвэрлэлт гүйцэтгэдэг их багтаамжийн автобус 25 зорчигчийн суудалтай байдгаас даруй 20 суудлаар их буюу 45 зорчигчийг тээвэрлэх боломжтой болсон.

Уг тээврийн хэрэгслүүдээр 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс Х:18 "Тэнгэр плаза-Багахангай" чиглэлд, 4 дүгээр сарын 30-ны өдрөөс Х:17 "Тэнгэр плаза-Багануур", Чингис хаан олон улсын нисэх буудал руу 05 дугаар сарын 02-ны өдрөөс Х:19 "ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол", Х:20 "ЧХНОУНБ-5 шар" чиглэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс иргэдэд үйлчилж байна.

Энэ 2025 оны эхний 6 сарын байдлаар дагуул хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор түр зогсоосон нийтийн тээврийн чиглэлийг сэргээн, 2 чиглэлд их багтаамжийн нийтийн тээврийн чиглэлийг шинээр нээсэн. Үүнд:

Х:17 "Тэнгэр плаза-Багануур" чиглэлийн үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс, Х:18 "Тэнгэр плаза-Багахангай" чиглэлийн үйлчилгээг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс шинээр эхлүүлж;

Х:19 "Чингис хаан ОУНБ-Сүхбаатарын талбай", Х:20 "Чингис хаан ОУНБ-Буянт-Ухаа спорт цогцолбор" чиглэлийн үйлчилгээг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс сэргээсэн.

Мөн иргэдийн зорчих эрэлтийг хангах зорилгоор хот орчмын нийтийн үйлчилгээний 2 чиглэлийн замналд өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/48 дугаар тушаалаар Багануур дүүргийн чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг Х:17 Улаанбаатар (Дүнжингарав худалдааны төв) – Багануур чиглэлийн замналд өөрчлөлт оруулж Х:17 Улаанбаатар (Тэнгэр плаза) – Багануур чиглэл болгон;

Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/49 дугаар тушаалаар Х:18 "Улаанбаатар (Дүнжингарав худалдааны төв) – Багахангай" чиглэлийн замналд өөрчлөлт оруулж Х:18 "Улаанбаатар (Тэнгэр плаза) – Багахангай" чиглэл болгон шинэчилсэн.

2.4 Цаг үеийн шинжтэй чиглэлийн төлөвлөлтийн ажлын талаар:

Нийтээр тэмдэглэх баяр ёслол, бусад цаг үеийн ажилтай холбоотойгоор тайлант хугацаанд нийт 9 удаа нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын шугамын цаг, рейсийн даалгаварт өөрчлөлт оруулсан. Үүнд:

1. "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль, "Мазаалай" олон улсын цас мөсний наадамд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээ 2025 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 22-ны өдрүүдэд зохион байгуулагдсантай холбогдуулан ажлын өдөр 4 тээврийн хэрэгсэл, амралтын өдөр 6 тээврийн хэрэгсэл нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллахаар нэгдсэн даалгаварт тусгаж,

2. Сар шинийн баярын үеэр 2025 оны 03 дугаар сарын 01-05-ны өдрийг бүх нийтийн амралтын өдөр болгосонтой холбоотойгоор амралтын өдрөөр ажиллахаар нэгдсэн даалгаварт өөрчлөлт оруулж,

4. “Дугуйтай Улаанбаатар марафон 2025” арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдсантай холбоотойгоор нийтийн тээврийн 42 чиглэлд график цаг, эргэлтийн хугацаанд өөрчлөлт оруулж,

5. Авто худалдааны цогцолбор төвд 2025 оны 05 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд 13 дахь удаагийн 'POWER EXPO & FESTIVAL-2025' наадам зохион байгуулагдах үеэр иргэдийн нийтийн тээврээр үйлчлүүлэх эрэлт хэрэгцээг хангах зорилгоор Ү:22 чиглэлийн ажил, амралтын өдрүүдэд 2 тээврийн хэрэгсэл үйлчлэх төлөвлөлттэй байсныг 6 болгон нэмэгдүүлж

6. “Улаанбаатар Марафон 2025" гүйлтийн арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсантай холбоотойгоор нийтийн тээврийн 50 чиглэлийн эргэлтийн хугацаа, маршрутад өөрчлөлт оруулж,

7. Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг тохиолдуулан "Нисэх хүчин-100 жил” эйр шоу арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсантай холбоотойгоор тус өдөр Ч:9, Ч:15 чиглэлүүдэд тус тус 1, Ч:7 чиглэлд 2 гаралтыг тус тус нэмэгдүүлж,

8. Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ой, Монгол Улсад хүүхдийн төлөө байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд "Монгол хүү 2025" хүүхдийн баярын арга хэмжээ Хүй долоон худагт 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулагдсан. Уг арга хэмжээний хүрээнд Хүй7:2 “МУБИС – Хүй 7 худаг” чиглэлд иргэдэд 4 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлсэн.

9. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн баярын арга хэмжээ 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсантай холбоотойгоор талбайн баруун, зүүн тал, Гэндэнгийн гудамжны авто замуудыг хаахад М:1А, М:1Б, М:3, Х:19, Ү:30 чиглэлүүдийн эргэлтийн хугацаа маршрутад өөрчлөлт тус тус оруулж нэгдсэн даалгаварт тусгасан.

10. "Автомашингүй өдөр 2025" арга хэмжээний үеэрх төлөвлөлт

11. Их эзэн Чингис хааны мэндэлсний 862 жилийн ой 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр тохиож байгаатай холбоотой.

12. Бүгд найрамдах улс тунхагласны 101 жилийн ойн өдрийг тохиолдуулан хийгдсэн төлөвлөлтийг тус тус тусган нэгдсэн даалгавар шинэчлэн батлуулсан.

Чиглэлийн өөрчлөлт, зам засвар, үйл ажиллагаа, төлөвлөлтийн талаар байгууллагын цахим хуудсанд нийт 19 удаагийн хэвлэлийн мэдээ бэлтгэн байршуулсан. Мөн 15 удаагийн телевизийн мэдээ, хэвлэлийн хуралд ярилцлага өгч иргэдийг мэдээллээр хангасан байна.Жишээлбэл: “Улаанбаатар марафон 2025” тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдахтай холбоотойгоор тус хэлтсийн мэргэжилтнүүд 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр UBS телевизийн “Өдрийн хөтөлбөр” нэвтрүүлгээр тэмцээний үеэрх нийтийн тээврийн чиглэл, маршрутад хэрхэн өөрчлөлт орж байгааг талаарх мэдээллийг өгсөн.

Мөн Монгол Улсын Авто тээврийн тухай хуулийн 15.9.6 (Авто тээврийн хэрэгсэл нь үйлдвэрлэснээс хойш 10-аас дээш жил ашиглагдаагүй байх)-д зааснаар нийтийн тээврийн бүртгэлийн сангаас 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 98 тээврийн хэрэгсэл насжилтаар хасагдсан. Парк шинэчлэлт хийсэнтэй холбогдуулан 12 чиглэлийн 19 тээврийн хэрэгслийг буцаан нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна.

Энэ оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 66,594,347 зорчигч нийтийн тээврээр үйлчлүүлсэн нь өмнөх 2024 оны мөн үеийн 58,385,896 зорчилттой харьцуулахад нийтийн тээврээр үйлчлүүлсэн зорчигчийн тоо 8,9%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг сааруулах, улсын хэмжээнд лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг 800 гаруй ажилтны аюулгүй зорчих, ажлын цаг ашиглалтыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор холбогдох судалгааг хийж, Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар АТ:4 “Нисэх- 5 шар – Гандан- Халдварт өвчин судлалын үндэсний төв”, АТ:5 “Улиастайн шинэ эцэс- Улаанхуаран- Халдварт өвчин судлалын үндэсний төв” чиглэлүүдийг нээж 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс үйлчилгээг эхлүүлсэн.

2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/17 дугаар тушаалаар Налайх дүүргийн 1 дүгээр хороо, Налайх дүүргийн 6 дугаар хорооны иргэдийн нийтийн тээврийн хүртээмжтэй

| Байгууллага | I баг | II баг | III баг |
|---|---|---|---|
| Нийтийн тээврийн бодлогын газар | А.Гансүх | Б.Энэбиш | Б.Амарзаяа |
| | Д.Нямготов | Г.Базарсад | О.Сүхбаатар |
| Тээврийн цагдаагийн алба | А.Чинзориг | Д.Юра | Ч.Бямбадавга |
| Нийслэлийн замын хөгжлийн газар | Ж.Бахберген | Г.Доржхандмаа | М.Өлзийбаяр |
| Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар | М.Энхболд | Д.Тулга | Б.Бат-Очир |
| Жолоочийн нэр, автомашины улсын дугаар | Нарангэрэл | Соронзонболд | Эрдэнэбаатар |

*Хүснэгт 22. Үзлэгт ажилласан багийн хуваарилалт*




*График 19. Зогсоолын үзүүлэлт*




*График 20. Дүүрэг бүрт хамаарах зогсоол*




*График 21. Зогсоолын зэрэглэл*

*График 22. Дулаан зогсоолын үзүүлэлт*

Мөн зогсоолын үзлэг хийсэн 1282 автобусны зогсоолын мэдээллийг Улаанбаатар хотын хот нийтийн аж ахуйн, инженерийн дэд бүтцийн ашиглалт, үйлчилгээний нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем UB Enginering-д оруулсан.



*Зураг №104. UB engineering сиситемд оруулсан байдал*



*Зураг №105. Зогсоолын үзлэг явуулж буй байдал*

### 5.6. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулна. Дүрмийн 4.1.2.4

Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах ажлын хүрээнд нийт 5 сэдвээр 14 удаагийн сургалт зохион байгуулсан. Үүнд:

-Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, Ай Си Ти групп ХК-тай хамтран нийтийн тээврийн хэрэгслүүдэд суурилуулсан хяналтын камерын тусламжтайгаар нийтийн тээврийн хэрэгсэл чөлөөтэй зорчих боломжийг бүрдүүлэх зорилгоор ирүүлсэн зөрчлийн зурган мэдээлэл шаардлага хангахгүй байгаа талаар 2025 оны 04 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдэд нийт 303 жолооч,

-Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ, Ай Си Ти групп ХК-тай хамтран "Нийтийн тээврийн үйлчилгээний соёлыг дээшлүүлэх нь" сэдэвт сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын 60 жолооч,

-Сонгинохайрхан дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн албан хаагчидтай хамтран Нийтийн тээврийн үйлчилгээний соёл, замын хөдөлгөөний дүрэм сэдвээр сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 08, 09, 10-ны өдрүүдэд 53 жолооч,

-Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ-тай хамтран Замын хөдөлгөөнд болон нийтийн тээврийн үйлчилгээнд соёлтой оролцох нь сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 17-ноос 21-ний өдрүүдэд Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 900 сурагчдад,

-Ай Си Ти групп ХК-тай хамтран "Төлбөр тооцооны үндсэн системийн санхүүгийн тооцоолол хийх нь" сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулж 35 албан хаагчийг тус тус хамруулсан.

ЖАЙКА ОУБ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдсан төгсөгчдийн дунд зохион байгуулсан FOLLOW UP сургалтын төсөлд хамрагдан шалгарч уг сургалтыг зохион байгуулах санхүүжилт авч "Нийтийн тээврийн салбарын өнөөгийн байдал, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх нь'' сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 28-д зохион байгуулсан.

Сургалтад нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 22 аж ахуйн нэгж, байгууллагын 87 инженер техникийн ажилтан, урилгаар 4, зохион байгуулалтад 6 нийт 97 оролцогч үйл ажиллагаанд оролцсон байна.






Үйл ажиллагааны хөтөлбөр

| Д/Д | Үйл ажиллагааны нэр | Оролцогч | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Бүртгэл | Нийт оролцогчдыг бүртгэх, сургалтын мэдээлэл бичих дэвтэр үзэг өгөх. | 12:30-13:00 |
| 2 | Урлагийн үзүүлбэр | Улаанбаатар театрын уран бүтээлчид | 13:00-13:05 |
| 1 | Үйл ажиллагааг нээж, мэндчилгээ дэвшүүлэх | Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга Д.Отгонжаргал | 13:05-13:10 |
| 2 | Мэндчилгээ | ЖАЙКА-ын төлөөлөл | 13:10-13:15 |
| 3 | Зорилтот бүлгийн зорчигч нарт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нь | ЖАЙКА-ын сургалтын төгсөгч Нийтийн тээврийн бодлогын газар, Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Ч.Бадамханд | 13:45-14:15 |
| 4 | Тогтвортой хотын тээвэр | ЖАЙКА-ын сургалтын төгсөгч Дэлхийн банкны Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн зохицуулагч Х.Булгаа | 13:15-13:45 |
| 5 | Завсарлага / Цай кофе/ | | 14:15-14:45 |
| 6 | Нийтийн тээврийн эрэлтийг тодорхойлох, судалгаа төлөвлөлт | ЖАЙКА-ын сургалтын төгсөгч Нийтийн Тээврийн бодлогын газар, Тээврийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн О.Хонгорзул | 14:45-15:15 |
| 7 | Багийн ажиллагаа | Нийт оролцогчдыг 10 баг хуваан Нийтийн тээврийн салбарт тулгамдаж байгаа асуудал, шийдэл саналаа чөлөөт хэлэлцүүлэг. | 15:15-16:00 |
| 8 | Хаалтын ажиллагаа | Сургалтанд оролцогчид болон зохион байгуулагчдын сэтгэгдэл Зохион байгуулагчид | 16:30-16:55 |
| 9 | Урлагийн үзүүлбэр | Улаанбаатар театрын уран бүтээлчид | 16:55-17:00 |
| Нийт хөтөлбөрийн цаг 4 цаг 30 минут | | | |

*Зураг №106.Сургалтын Урилга, Хөтөлбөр*

ЖАЙКА ОУБ-ын Төлөөлөгчийн газрын орлогч дарга Ёшимура Токүжи мэндчилгээ дэвшүүлсэн. Сургалтын эхний хэсэгт ЖАЙКА-ын сургалтын төгсөгч Нийтийн тээврийн бодлогын газрын мэргэжилтэн Ч.Бадамханд Зорилтот бүлгийн зорчигч нарт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нь сэдвээр танилцуулга мэдээлэл өгсөн.

ЖАЙКА-ын сургалтын төгсөгч Дэлхийн банкны Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн зохицуулагч Х. Булгаа Тогтвортой хотын тээвэр сэдвээр, ЖАЙКА-ын сургалтын төгсөгч Нийтийн тээврийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн О.Хонгорзул Нийтийн тээврийн эрэлтийг тодорхойлох, судалгаа төлөвлөлт сэдвээр танилцуулга мэдээлэл өгсөн.

### Сургалтын үр дүн

Нийтийн тээврийн салбарт ажилладаг инженер техникийн ажилтан, албан хаагчдад ЖАЙКА-ын сургалтын явцад олж авсан мэдлэг мэдээлэл болон тээврийн менежмент, зохион байгуулалт болон олон улсын туршлагын талаар хуваалцсан.

Сургалтад оролцогчид нийтийн тээврийн салбарын арын албанд ажилладаг засварчин, механик, шалгах механикчид байсан.

Дээрх инженер техникийн ажилчдад нийтийн тээврийн салбарын хөгжил, Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад өөрсдийн зүгээс хэрхэн хувь нэмрээ оруулах талаар санал солилцож, засвар үйлчилгээг чанаржуулах талаар харилцан туршлага солилцсон.

2025 оны 12 дугаар сарын байдлаар 26 удаагийн сургалтаар нийт 2037 инженер, техникийн ажилтан, жолооч, захиргааны ажилчдыг сургалтад хамруулсан бөгөөд эдгээр сургалтын явцад нийтийн тээврийн үндсэн стандарт MNS5012:2021 талаар мэдээлэл өгч ажилласан.

### 5.7. Нийтийн тээврийн хэрэгсэл, сургуулийн болон ажилчдын автобус, нийслэлийн төр, захиргааны автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах. Дүрмийн 4.1.2.5

Нийслэлийн нийтийн тээврийн бодлогын газрын Даргын "Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай" 2025 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан

хуваарийн дагуу хаврын ээлжит техникийн хяналтын үзлэгийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулан ажилласан.

Нийт өссөн дүнгээр нийт 1507 тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийгдсэн. Үүнээс:

| | |
|---|---|
| Ажилчдын автобус-206 | ***<u>Тэнцсэн-1491,</u>*** |
| Хүүхдийн автобус-213 | ***<u>Тэнцээгүй-16.</u>*** |
| Үндсэн чиглэл-584 | ***<u>Хувь-99%</u>*** |
| Төр захиргааны тээврийн хэрэгсэл-281 | |
| Таксийн чиглэл-199 | |
| Буухиа-24 байна. | |



НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 03 өдөр Дугаар А/38 Улаанбаатар хот

Хаврын ээлжит техникийн хяналтын
үзлэг зохион байгуулах тухай

1725020191

*Зураг №107. "Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай" тушаал*

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Нийслэлийн алслагдсан дүүргүүдэд техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулах тухай" А/56 дугаар тушаалын дагуу нийслэлийн алслагдсан дүүрэг болох Багануур, Налайх дүүргүүдэд явуулын төвөөр 88 тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулж ажилласан. Тэнцсэн-88, Хувь-100%



НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 05 өдөр Дугаар А/56 Улаанбаатар хот

Нийслэлийн алслагдсан дүүргүүдэд
техникийн хяналтын үзлэгийг зохион
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам батлах тухай" А/199 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/536 дугаар захирамжаар батлагдсан "Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм"-ийн 4.1.2.5, 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн төр, захиргааны болон тухайн дүүргүүдийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын эзэмшилд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 2025 оны техникийн хяналтын үзлэг, оношилгоог явуулын төвөөр зохион байгуулах хуваарийг нэгдүгээр хавсралтаар, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн явуулын төвөөр гүйцэтгэх хуваарьт хугацааг тээврийн хэрэгсэл эзэмшигч байгууллага болох дүүргийн төр, захиргааны байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, үзлэг оношилгоо зохион байгуулах байрны бэлэн байдал, явуулын төвийн техникийн бэлэн байдлыг хангуулах, үзлэгийн мэдээ, тайланг тус газрын Даргын зөвлөлийн ээлжит хуралд танилцуулж ажиллахыг Бүртгэл, техник технологийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.

3.Алслагдсан дүүргүүдэд ажиллах тээврийн хэрэгслийн шатахууны болон холбогдох зардлыг тооцож олгохыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Б.Бадамдорж)-т зөвшөөрсүгэй.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

1725020…

Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ний өдрийн А/56 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЛСЛАГДСАН ДҮҮРГҮҮДИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД
ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ ХУВААРЬ

*Зураг №108. Газрын даргын А/56 дугаар тушаал*





*Зураг №109. Тээврийн хэрэгслийн явах эд ангийн үзлэг хийж байгаа нь*






*Зураг №110. Тээврийн хэрэгслийн явах эд ангийн үзлэг хийж байгаа нь*

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Намрын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай” А/103 дугаар тушаалаар батлагдсан хуваарийн дагуу 10 дугаар сарын 08-ны өдрөөс 11 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 920 тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийгдэхээс 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар нийт 849 тээврийн хэрэгсэл хамрагдсан. Үүнд:

- Үндсэн чиглэлийн автобус 664 — Тэнцсэн-847
- Таксины чиглэлийн 162, — Тэнцээгүй-3,Хувь-92,1%
- Буухиа чиглэлийн 23 тээврийн хэрэгсэл тус тус хамрагдсан.



НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 07 өдөр — Дугаар А/103 — Улаанбаатар хот

Намрын ээлжит техникийн хяналтын үзлэг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар батлагдсан "Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм"-ийн 4.1.2.5, 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн нийтийн тээврийн их, дунд багтаамжийн автобус, жижиглэн автобус болон такси үйлчилгээний тээврийн хэрэгслүүдийн Техникийн хяналтын намрын ээлжит үзлэгийг 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс 11 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж, техникийн хяналтын үзлэгт хамрагдах хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх үйл ажиллагааг Автотээврийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тээврийн хэрэгслүүдийг хуваарьт хугацаанд бүрэн хамруулж, холбогдох стандартын шаардлагуудыг бүрэн хангуулж, үзлэгт хамрагдаагүй болон тэнцээгүй тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг Tbox.ubcc.mn программ хангамжид тухай бүрд нь оруулах, тэнцээгүй тээврийн хэрэгслийг тухайн өдөрт нь дахин оруулахгүй байх, техникийн хяналтын үзлэгийн тээвэр тоног төхөөрөмжийн бэлэн байдал, программ хангамжийн хэвийн ажиллагаанд шалгалт, тохируулга хийж, үзлэгийн дүн мэдээг удирдлагад тайлагнах холбогдох хэлтсүүдийг мэдээллээр шуурхай хангаж ажиллахыг Техник, технологийн хэлтэс Техникийн хяналтын үзлэгийн тасаг (Э.Өлзий)-д даалгасугай.

3.Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдэд холбогдох стандартын шаардлагуудыг бүрэн хангуулж, тээврийн хэрэгслийн өнгө үзэмж, цэвэрлэгээ, их бүрдэл, зөөлөн эд, хаяг, бүрээс, гарааш дугаар зэрэг хөтөлбөрт шаардлагуудын хэрэгжилт хангагдсан эсэхэд онцгой анхаарч тушаалаар батлагдсан хуваарьт хугацаанд багтаан техникийн хяналтын үзлэгт жигд, шуурхай хамруулахыг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад даалгасугай.



4.Техник хяналтын үзлэгийн нэгдсэн тайлан мэдээг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Даргын зөвлөлийн хурлаар танилцуулахыг Бүртгэл, Техник технологийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т тус тус болгосугай.

ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

*Зураг №111. “Газрын даргын А/103 дугаар” тушаал*

Нийтийн тээврийн бодлогын газар нь 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 2809 тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулан ажиллалаа. Үүнээс:

- Үндсэн чиглэлийн автобус 1245
- Ажилчдын автобус 354,
- Сургуулийн автобус 500,
- Төр, захиргааны байгууллагын 290,
- Таксины чиглэлийн 366,
- Буухиа чиглэлийн 54 тээврийн хэрэгсэл тус тус /давхардсан тоогоор/ хамрагдсан.

## ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН ТӨВИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

*Хүснэгт 23. 2024 оны мөн үетэй харьцуулбал:*

| *Д/д* | *1* | *2* | *3* | *4* | *5* | *6* | *НИЙТ* |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Үзүүлэлт* | *Үндсэн чиглэл /Том, дунд/* | *Буухиа чиглэл /бага/* | *Такси чиглэл /суудлын/* | *Ажилчдын автобус* | *Төр захиргааны тээврийн хэрэгсэл* | *Хүүхдийн автобус* | *-* |
| *2024 он* | *1223* | *28* | *406* | *305* | *104* | *259* | *2325* |
| *2025 он* | *1245* | *54* | *366* | *354* | *290* | *500* | *2809* |

*Хүснэгт 24. 2025 оны орлогын мэдээлэл:*

| Сар | Төлөвлөгөө | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|
| 1 Сар | 11,400,000 | 1,945,000 | 17% |
| 2 Сар | 11,400,000 | 5,361,000 | 47% |
| 3 Сар | 11,400,000 | 8,538,500 | 75% |
| 4 Сар | 14,700,000 | 21,029,000 | 125% |
| 5 Сар | 14,700,000 | 5,224,000 | 42,8% |
| 6 Сар | 11,400,000 | 2,358,000 | 20,2% |
| 7 Сар | 5,000,000 | 1,776,000 | 35,5% |
| 8 Сар | 5,000,000 | 5,927,000 | 118,5% |
| 9 Сар | 14,700,000 | 3,231,000 | 22% |
| 10 Сар | 14,700,000 | 24,963,500 | 169,3% |
| 11 Сар | 11,400,000 | 3,200,000 | 28% |
| 12 Сар | 11,400,000 | | |
| НИЙТ | 137,245,000 | 84,233,000 | 61% |

*Хүснэгт 25. 2024 оны мөн үетэй харьцуулбал:*

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2024 он | 179,904,900 | 58,729,400 | 33% |
| 2 | 2025 он | 137,245,000 | 84,233,000 | 61% |










*Зураг № 112. техникийн хяналтын үзлэг хийх ажлыг хийж буй байдал*

### 5.8. Аюултай болон тусгай ачаа тээврийн зохицуулалтыг төлөвлөж, бүртгэх, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангана. Дүрмийн 4.1.2.6

Автотээврийн хэрэгслээр хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй Аюултай ачааг тээвэрлэхэд холбогдох хууль тогтоомж, журам стандартын мэдлэг олгох, урьдчилан сэргийлэх талаарх хэлэлцүүлгийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Тус газраас зохион байгуулсан.

Сургалтад Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар, Нийслэлийн хяналт шалгалтын алба, Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн онцгой байдлын газар, Нийтийн тээврийн бодлогын газрын авто тээврийн хяналтын улсын байцаагч нар, Шатахуун тээвэрлэгчдийн залгамж холбоо, Монголын хийн түлшний холбооны төлөөлөл зэрэг байгууллагын нийт 45 албан хаагч, цахимаар 41 аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллүүд оролцсон.



*Зураг №113. Аюултай болон тусгай ачаа тээврийн зохицуулалтын сургалтын үер*

2025 онд шинэчлэн батлагдсан Нийслэлийн Засаг даргын А/322 дугаар захирамж “Нийслэлийн нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах, дэмжлэг үзүүлэх журам”-д аюултай ачааны тээвэрлэлтийн гүйцэтгэх үүргийг онцгойлон тусгаж өгсөн. Үүнд:

3.2.1.Аюултай ачааг тээвэрлэхэд улсын ахлах байцаагчаар шалгуулж тээврийн хэрэгслийг ашиглахыг зөвшөөрсөн тухай дүгнэлт;

3.2.2.Аюултай ачааны таних тэмдэг болон аюулын шинж чанарын тухай санамж байрлуулсан байдлын баталгаажуулалт;

3.2.3.Торхны болон баллоноор тээвэрлэлт гүйцэтгэх тохиолдолд тэдгээрийн баталгаажуулалт;

3.2.4.Цагдаагийн байгууллагын тогтоосон замнал;

3.2.5.Тээврийн цагдаагийн албанаас зөвшөөрсөн тээврийн хэрэгсэл;

3.2.6.Энэ журмын 7.4-т заасан шаардлагын хэрэгжилт

3.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуулийн этгээд нь энэ журмын 3.2-т заснаас гадна дараах бичиг баримтыг бүрдүүлж, цахим мэдээллийн санд илгээнэ.

3.3.1.Дагалдан явах хамгаалалтын машины дугаар, гэрчилгээ;

5.1.1.Аюултай болон тэсэрч дэлбэрэх ачаа тээвэрлэх хуулийн этгээд нь тухайн тээврийн хэрэгсэлд "GPS" буюу байршил тогтоогч болон зайлшгүй тохиолдолд эрх бүхий байгууллага албан тушаалтанд "SOS" буюу тусламж мэдээлэл өгөх төхөөрөмжийг суурилуулж, төрийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системд холбогдсон байх;

7.4.Аюултай болон тэсэрч дэлбэрэх ачаа тээвэрлэх хуулийн этгээд нь тухайн тээврийн хэрэгслийн "GPS" буюу байршил тогтоогчийг төрийн байгууллагын нэгдсэн системд бүртгүүлнэ, зайлшгүй тохиолдолд эрх бүхий албан байгууллага, албан тушаалтнаас "SOS" буюу тусламж мэдээлэл хүсэхэд Нийслэлийн Шуурхай удирдлага, зохицуулалтын төв хянаж зохион байгуулалтын арга хэмжээг авах үүрэгтэй: тус тус заалтуудыг шинээр оруулж батлуулсан.

Дээрх журмын 5.1.1 болон 7.4-т заасан заалтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор "ICT групп" ХК-д Нийтийн тээврийн бодлогын газрын "Тээврийн удирдлагын төв"-ийн системд аюултай болон тусгай ачаа тээврийн зохицуулалтын хяналтын нэгдсэн системийг шинээр хөгжүүлэхтэй холбогдуулан хамтран ажиллах тухай 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 01/04/1105 дугаартай албан бичгийг хүргүүлж ажилласан. Уг албан бичгийн дагуу ICT групп ХК нь 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн Нийтийн тээврийн газрын 418 тоот хурлын зааланд программ хангамжийн талаарх шаардлагатай мэдээллийг танилцуулж, талууд санал солилцон ажиллаа.

Хүрсэн үр дүн: 2025 онд шинэчлэн батлагдсан Зам, тээврийн сайдын А/78 дугаар тушаал батлагдсан "Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам", Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага. MNS4978:2025 стандартыг хэрэгжилтийг ханган ажиллах тухай аюултай ачаа тээвэрлэгч 19 аж ахуйн нэгж, байгууллагуудад Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/04/1102 дугаартай албан бичгийн хүргүүлэн ажиллаа.



*Зураг №114. Аюултай ачаа тээвэрлэлтийн хяналтын программын талаарх уулзалт*

Энэ оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар аюултай ачаа тээвэрлэгч 5 аж ахуйн нэгж, байгууллагын 176 тээврийн хэрэгсэл "ЕС", "ТҮР" замын хуудас авсан байна.

Нийслэлийн Засаг даргын А/322 дугаар захирамж, мөн MNS 4978:2025 "Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих еренхий шаардлага" стандартыг Аюултай ачаа тээвэрлэх замын хуудас авсан 19 аж ахуйн нэгж, байгууллагад 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 01/04/2125 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Судалгааны явцад албан бичиг хүргүүлсэн 19 аж ахуйн нэгж, байгууллагаас аюултай ачаа тээвэрлэх үйл ажиллагаагаа зогсоосон нэг аж ахуйн нэгж /Их эргэлт ХХК/ байсан бөгөөд үлдсэн 18 аж ахуйн нэгж, байгууллагуудад 18 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/04/2397 дугаар албан бичгээр тухайн байгууллагын тээврийн хэрэгслийн тоо, тэдгээрээс "GPS" төхөөрөмжтэй тээврийн хэрэгслийн судалгааг авч нэгтгэж байна. Энэ оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 9 аж ахуйн нэгж, байгууллагын 156 тээврийн хэрэгсэл GPS суурилуулсан судалгаа ирүүлээд байна.



НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

2025.11.14 № 01/04/2397

АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД

Тус газраас 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 01/04/2125 дугаартай "Зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгийг хүргүүлсэн.

Иймд танай байгууллагаас тээврийн хэрэгслүүдэд "GPS" төхөөрөмж суурилуулсан талаар мэдээллийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хавсралт хүснэгтийн дагуу гарган албан бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудастай.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Даваанямы ОТГОНЖАРГАЛ
2025.11.14 07:59



Нийтийн тээврийн бодлогын газрын даргын
2025 оны ........ сарын .... -ны өдрийн
.................. албан бичгийн хавсралт

АЮУЛТАЙ АЧАА ТЭЭВЭРЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН СУДАЛГАА

Жишээ нь:

| № | Байгууллагын нэр | Байгууллагын РД | Байгууллагын хаяг | Байгууллагын тээврийн хэрэгслийн тоо (Тээврийн хэрэгслийн Улсын дугаар ) | Байгууллагын тээврийн хэрэгсэл "GPS" төхөөрөмжтэй эсэх, тадгээрийн тоо /тийм, үгүй/ | Холбогдох утас (2-с доошгүй) | Байгууллагын И-мэйл хаяг |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ********* ХХК | 5731*** | Сүхбаатар дүүрэг **-р хороо олимп гудамж ** тоот | 8 | 3 | 9695**** | ******@gmail.com |
| 2 | ********* ХХК | 5732*** | ХУД, *-р хороо, ** тоот | 30 | 20 | 9695**** | ******@gmail.com |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 5 | | | | | | | |

Холбогдох утас: Ачаа тээвэр, Авто үйлчилгээний хэлтэс- 11323629

*Зураг№115. 01/04/2397 дугаар албан бичиг,судалгааны хүснэгт*

"GPS" төхөөрөмжтэй тээврийн хэрэгслийн судалгаа

*Хүснэгт 26*

| Д/Д | ААНБ нэр | Албан бичгийн Огноо, Дугаар | Тээврийн хэрэгслийн тоо | GPS-тэй тээврийн хэрэгслийн тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Шунхлай трейдинг ХХК | 2025.11.20 Т/3155 | 38 | 38 |
| 2 | Ник ХХК-н шатахуун тээврийн салбар | 2025.11.19 52 | 34 | 34 |
| 3 | Горгаз ХХК | 2025.11.18 02/780 | 24 | 24 |
| 4 | Синчи Ойл ХХК | 2025.11.19 25/457 | 5 | 5 |
| 5 | Синчи Газ ХХК | 2025.11.19 25/457 | 3 | 3 |
| 6 | Тод петролиум ХХК | 2025.11.20 328-25 | 3 | 3 |
| 7 | Юнигаз ХХК | 2025.10.23 564 | 16 | 16 |
| 8 | Дашваанжил групп ХХК | 2025.11.19 25/1115 | 27 | 27 |
| 9 | Акума-Эрин ХХК | 2025.11.24 25/292 | 6 | 6 |
| Нийт | 9 ААНБ | | 156 | 156 |

Авто тээврийн хяналтын 10 улсын байцаагч Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэгч, тээвэрлүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад Авто тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтарсан "Авто тээврийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх гэрээ"-ний үүргийн биелэлтийн хүрээнд "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2025 улсын стандартын үзүүлэлт шаардлагыг хангуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх чиглэлээр шугам замд 235 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 90 аж ахуйн нэгж, байгууллагад 33,050,000 төгрөгийн, 16 иргэнд 950,000 төгрөг, нийт 106 зөрчилд 34,000,000 төгрөгийн торгох шийтгэл ногдуулж ажилласан байна.

### 5.9.Ачаа тээвэр, логистикийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ачаа тээврийн үйлчилгээг зохион байгуулах, хөгжүүлнэ. Дүрмийн 4.1.2.8

НИТХТ-ийн 2014 оны 102 дугаар тогтоолоор батлагдсан захиргааны хэм хэмжээний актад бүртгэгдээгүй "Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах, түр замын хуудас олгох журам"-ыг хэрэгжүүлэн ажилласан. 2024 оны 09 дүгээр сард НИТХ-ийн 125 дугаар тогтоолоор хүчингүй болсон. Иймд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд нийцүүлэн Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн "Журам батлах тухай" А/322 дугаар захирамжаар "Нийслэлийн нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах, дэмжлэг үзүүлэх журам" батлагдаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7202 дугаарт бүртгэгдэн хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Шинэчлэн батлагдсан журмыг хэрэгжүүлэх ажиллах тухай Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба, Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ, Нийслэлийн замын хөгжлийн газарт тус Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 01/04/924, 01/04/925, 01/04/926 дугаартай албан бичиг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газар, Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ-т Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/04/1103, 01/04/1104 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлэн ажиллаа.

Мөн 2025 онд шинэчлэн батлагдсан Зам, тээврийн сайдын А/78 дугаар тушаал батлагдсан "Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам", Аюултай ачаа. Ангилал. Техникийн ерөнхий шаардлага. MNS4978:2025 стандартыг хэрэгжилтийг ханган ажиллах тухай аюултай ачаа тээвэрлэгч 19 аж ахуйн нэгж, байгууллагуудад газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/04/1102 дугаартай албан бичгийн хүргүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны С/05 дугаар тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн ангилал. Техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS4598:2025 стандарт, Нийслэлийн Засаг даргын А/322 захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах, дэмжлэг үзүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангах ажиллах тухай Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч 413 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ntg.achaateever@gmail.com и-мэйл хаягаар тус тус хүргүүлэн ажилласан.

Зам тээврийн сайдын 2024 оны А/159 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах гэрээ, 2025 онд Авто үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлэн хамтран ажиллах 3 бүлэг 12 заалттай төлөвлөгөөг Зам, тээврийн яаманд хүргүүлж хамтран ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/311 дугаар захирамжаар "Нийслэлийн

зүүн хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн төв" байгуулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийн гүйцэтгэгчээр "Туушин" ХХК, нийслэлийн хүлээсэн эрх, үүргийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/02 дугаартай хамтран ажиллах гэрээгээр "Улаанбаатар хотын хөгжлийн корпорац" ХК хариуцан ажиллаж байна. Улаанбаатар хотын хэмжээнд ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй томоохон 11 терминалын байршил, тээвэрлэлтийн маршрут болон хүчин чадлын үзүүлэлтийн судалгааг боловсруулан танилцуулга бэлтгэн ажиллаа.

Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 277 тоот "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг 01/04/950 тоот албан бичгээр 2022 оноос 2025 оны 01 дүгээр улирал хүртэлх хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлэн ажилласан.

Ачаа тээврийн өдөр тутмын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж, 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс "Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем" программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлж ЕС, ТҮР замын хуудас олгох үйлчилгээг нэг

цонхонд байршуулж цахимаар олгосноор "ЕС" замын хуудас +38,0%, "ТҮР" замын хуудас +26,3% -аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.Зүүн ачааны логистик-"Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистик төв" байгуулах төслийн хүрээнд Туушин ХХК, Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-тай хамтран ажлын явцын талаар мэдээлэл авч, ачаа тээвэрлэлтийн тоон мэдээллээр хангаж ажиллана.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/311 дугаар захирамжаар "Нийслэлийн зүүн хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн төв" байгуулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийн гүйцэтгэгчээр "Туушин" ХХК, нийслэлийн хүлээсэн эрх, үүргийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/02 дугаартай хамтран ажиллах гэрээгээр "Улаанбаатар хотын хөгжлийн корпорац" ХК хариуцан ажиллаж байна.

ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ УИХ-ЫН 36 ДУГААР ТОГТООЛЫН 2022-2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/Д | НЗД-ын 2023 оны А/161 захирамжийн төлөвлөгөөний заалт | Зарцуулсан төсөв | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Тулгамдаж буй асуудал | Шийдвэрлэх боломж |
|---|---|---|---|---|---|---|
| | | мөнгөн дүн (сая.төгрөг) | эх үүсвэр | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Хотын баруун, зүүн талд худалдааны логистикийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах | - | Төр хувийн хэвшлийн түншлэл | Зүүн логистик: Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/311 дугаар захирамжаар "Нийслэлийн зүүн хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн төв" байгуулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийн гүйцэтгэгчээр "Туушин" ХХК, нийслэлийн хүлээсэн эрх, үүргийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/02 дугаартай хамтран ажиллах гэрээгээр "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК хариуцан ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Монголын Тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо, тээвэр зуучийн компаниудын захирлуудын хамтран тээвэр логистикийн салбарт тулгамдаж буй асуудлууд болон тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх боломжийг эрэлхийлэх уулзалтыг 2024.12.26-ны өдөр зохион байгуулж уулзалтад "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК, Туушин" ХХК оролцон мэдээлэл авч ажилласан. Баруун логистик: Олон улсын худалдаа, логистикийн төв ХК нь баруун хэсэгт | Монгол Улсын Сайд, Нийслэл Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга, Нийслэлийн Засаг дарга нараас хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог хангах талаар холбогдох шийдвэрийг гаргуулах. | Нийслэлийн Засаг даргын 2012 оны А/469 захирамжаар Хүнсний түргэн муудах эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэх "Тусгайлсан зөвшөөрөл"-ийг тус газраас олгодог байсан нь Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1037 захирамжаар хүчингүй болсныг сэргээх; |

*Зураг №116. Төлөвлөгөө*

2.Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 277 тоот "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлан хүргүүлэх тухай албан бичгийн дагуу "Улаанбаатар хотын хөгжлийн корпорац" ХК, "Туушин" ХХК-тай холбогдон зүүн ачааны логистик төв байгуулах төслийн ажлын явцын талаар мэдээлэл авч 01/04/950 тоот албан бичгээр 2022 оноос 2025 оны 01 дүгээр улирал хүртэлх хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлэн ажилласан.

3.Улаанбаатар хотын хэмжээнд ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй томоохон 11 терминалын байршил, тээвэрлэлтийн маршрут болон хүчин чадлын үзүүлэлтийн судалгааг нэгтгэн ажиллалаа.

**Улаанбаатар хот дахь терминалуудын нийт хүчин чадал**

| № | Гаалийн хяналтын талбайн нэр | Гадна талбайн хэмжээ м2 | Хүлээн авах чингэлгийн тоо (TEU) | Хүлээн авах вагоны тоо (Фронтын урт) | Гүүрэн кран | | Агуулахын хэмжээ м2 | Хүлээн авах төмөр замын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоо | Даац (тонн) | | |
| 1 | Амгалан ложистик ХХК | 45000 | 500 | 36 | 1 | 32 | 6400 | 2 |
| 2 | Туушин ХХК | 35000 | 300-350 | 10 | 1 | 32 | 8778 | 1 |
| 3 | Материал импекс ХХК | 20000 | 300-350 | 36 | 3 | 12-32-50 | 5210 | 4 |
| 4 | Прогресс Транс ХХК | 16492 | 300 | 12 | 1 | 32 | 2680 | 1 |
| 5 | АБТЭМА | 15220 | 700-750 | 33 | 2 | 24-50 | 4240 | 4 |
| 6 | Техник Импорт ХХК | 14600 | 450-500 | 15 | 2 | 32-50 | 2620 | 2 |
| 7 | Интердесижи ХХК | 12144 | 400-450 | 18 | 1 | 50 | 900 | 3 |
| 8 | Монгол Экспресс ХХК | 8750 | 250 | 10 | 1 | 32 | 1400 | 2 |
| 9 | Монгол Транс ХХК | 7000 | 450-500 | 55 | 1 | 32 | | 2 |
| 10 | Эрин Интернэшнл ХХК | 7000 | 200 | 30 | 1 | 32 | | 3 |
| 11 | Ти Ай Ложистик | 7000 | 300-350 | 30 | 1 | 26 | 6700 | 1 |
| | Нийт | 188206 | 4150- 4500 | 285 | 15 | | 38928 | 25 |

**Улаанбаатар хот дахь терминалуудын тээврийн хэрэгсэл, ачааны төрөл**

| № | Терминалын нэр | Байршил | Тээврийн хэрэгсэл | | Ачааны төрөл |
|---|---|---|---|---|---|
| | | | Ангилал | Тоо | |
| 1 | Амгалан Ложистик ХХК | Амгалан, БЗД | Түрээс | | Хөдөө аж ахуйн бараа, хүнс, аж үйлдвэрийн өргөн хэрэглээний бараа, электрон бараа, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 2 | Туушин ХХК | БГД | B-12,C-4,CE-4 | 20 | |
| 3 | Материал Импекс ХХК | БГД | CE | 2 | Хүнс- сахар |
| 4 | Прогресс Транс ХХК | БГД | "Папа логистик" ачаа тээврийн платформтой хамтарч ажилладаг | | Барилгын материал, хүнс, бусад |
| 5 | АБТЭМА | БЗД | Түрээс | | Хөдөө аж ахуйн бараа, хүнс, аж үйлдвэрийн өргөн хэрэглээний бараа, электрон бараа, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 6 | Техник Импорт ХХК | ХУД | CE | 7 | Барилгын материал, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 7 | Интердесижи ХХК | БГД | Түрээс | | Хүнс |
| 8 | Монгол Экспресс ХХК | БГД | Түрээс | | Эм эмнэлгийн хэрэгсэл, хүнс бараа, авто машин сэлбэг, хувийн ачаа |
| 9 | Монгол Транс ХХК | СХД | CE | 37 | Барилгын материал, хүнс, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 11 | Эрин Интернэшнл ХХК | БГД | CE | 1 | Аж үйлдвэрийн өргөн хэрэглээний бараа, электрон бараа, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 12 | Ти Ай Ложистик | БГД | 0 | 0 | Барилгын материал, хөдөө аж ахуйн бараа, хүнс, бусад |

Тус 11 терминалын 45.4% нь өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслээр ачаа түгээлт хийдэг бол 54.6% нь хүргэлтийн компанитай хамтран ажиллаж байна.

*Зураг № 117. терминалын хүчин чадлын танилцуулга*

4. Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 731 тоот "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг 01/01/2164 тоот албан бичгээр 2025 оны 03 дугаар улирал хүртэлх хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлэн ажилласан.

5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан "Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна" заалтын дагуу "Улаанбаатар хотын хөгжлийн корпорац" ХК-т 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/04/2405 дугаар хамтран ажиллах тухай албан бичиг явуулж ажлын явцын талаарх хэрэгжилтийг нэгтгэн Захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан.

2.Баруун ачааны логистик - "Төмөр замын гаалийн хяналтын бүс","Хангарди Терминал" төслийн хүрээнд Олон улсын худалдаа логистикийн төв ХК -тай хамтран ажлын явцын талаар мэдээлэл авч, ачаа тээвэрлэлтийн тоон мэдээллээр хангаж ажиллана.

Баруун ачааны логистик –"Хангарди зорчигч тээврийн терминал" төслийн хүрээнд Олон улсын худалдаа логистикийн төв ХК-тай хамтран ажлын явцын талаар мэдээлэл авч, ачаа тээвэрлэлтийн тоон мэдээллээр хангаж ажиллана.

Олон улсын худалдаа, логистикийн төв ХК нь баруун хэсэгт төрөлжсөн логистикийн "Хангарди терминал", "Төмөр замын хяналтын бүс", "Хүнс, бараа бүтээгдэхүүний бөөний худалдааны төв" төслүүдийн гүйцэтгэгчээр ажиллаж байна.

1."Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд баруун логистик төв байгуулах ажлын хүрээнд зохих саналыг тусган хүргүүлэн ажилласан.

2. Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 277 тоот "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлан хүргүүлэх тухай албан бичгийн дагуу "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК -д холбогдон баруун ачааны логистик төв байгуулах төслийн ажлын явцын талаар мэдээлэл авч 01/04/950 тоот албан бичгээр 2022 оноос 2025 оны 01 дүгээр улирал хүртэлх хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлэн ажилласан.

3. Улаанбаатар хотын хэмжээнд ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй томоохон 11 терминалын байршил, тээвэрлэлтийн маршрут болон хүчин чадлын үзүүлэлтийн судалгааг нэгтгэн ажиллалаа.




*Зураг №118. 11 терминалын байршил*

4. Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 731 тоот "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлан хүргүүлэх тухай албан бичгийн дагуу "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК -тай холбогдон баруун ачааны логистик төв байгуулах төслийн

ажлын явцын талаар мэдээлэл авч 01/01/2164 тоот албан бичгээр 2025 оны 03 дугаар улирал хүртэлх хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлэн ажилласан.



"ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА, ЛОГИСТИКИЙН ТӨВ" ХК

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАРТ

Мэдээлэл хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.5.5 дахь хэсэгт "Хотын зүүн, баруун хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн бөөний худалдааны төв байгуулна." гэж заасан.

Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолоор "нийслэлийн 2025 оны төсөв"-ийн 110 дахь хэсэгт "Улаанбаатар хотын баруун хэсэгт логистикийн төв байгуулах ажлын зураг төсөв (Улаанбаатар хот)" 960.0 сая төгрөгийн төсөв тусгагдсан хэдий ч 2025 оны 25/50 дугаар тогтоолоор төсвийн тодотголоор хасагдсан тул зураг төсөл боловсруулах ажил хийгдээгүй болно.

Олон улсын худалдаа, логистикийн төв ХК
Удирдлага
Гүйцэтгэх захирал
Санжаа Бямбасүрэн
2025.11.20 11:47

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

"ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА ЛОГИСТИКИЙН ТӨВ" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.БЯМБАСҮРЭН ТАНАА

Хамтран ажиллах тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг танилцуулах эцсийн хугацаа болсон байна.

Иймд хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр гаргаж, санхүүжилтийн эх үүсвэр, мөнгөн дүн, нотлох баримтыг заалт тус бүрээр гаргаж, 11 дүгээр сарын 19-ний дотор ирүүлэн хамтран ажиллана уу.

Холбогдох ажилтан: Логистикийн төлөвлөлт, судалгааны ажилтан Ц.Мөнхцэцэг, утас: 11323629

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Даваанямын ОТГОНЖАРГАЛ
2025.11.17 13:25

*Зураг №119. Албан бичиг*

5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан "Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна" заалтын дагуу "Олон улсын худалдаа, логистикийн төв" ХК-т 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/04/2405 дугаар хамтран ажиллах тухай албан бичиг явуулж ажлын явцын талаарх хэрэгжилтийг нэгтгэн Захиргаа, удирдлагын хэлтэст хүргүүлэн ажилласан.

**Улаанбаатар дахь ачаа тээврийн томоохон терминалуудын харьцуулсан хүснэгт:**

*Хүснэгт 27*

| № | Гаалийн хяналтын талбайн нэр | Талбайн хэмжээ | Хүлээн авах чингэлгийн тоо (TEU) | Хүлээн авах вагоны тоо (Фронтын урт) | Гүүрэн кран | | Агуулгын хэмжээ | Хүлээн авах төмөр замын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоо | Даац (тонн) | | |
| 1 | "Амгаланложистик" ХХК | 45000 | 500 | 36 | 1 | 32 | 6400 | 2 |
| 2 | "Туушин" ХХК | 35000 | 300-350 | 10 | 1 | 32 | 8778 | 1 |
| 3 | "Материал импекс" ХХК | 20000 | 300-350 | 36 | 3 | 12-32-50 | 5210 | 4 |
| 4 | "Прогресс Транс" ХХК | 16492 | 300 | 12 | 1 | 32 | 2680 | 1 |
| 5 | "АБТЭМА" | 15220 | 700-750 | 33 | 2 | 24-50 | 4240 | 4 |
| 6 | "Техник Импорт" ХХК | 14600 | 450-500 | 15 | 2 | 32-50 | 2620 | 2 |
| 7 | "Интердесижи" ХХК | 12144 | 400-450 | 18 | 1 | 50 | 900 | 3 |
| 8 | "Монгол Экспресс" ХХК | 8750 | 250 | 10 | 1 | 32 | 1400 | 2 |
| 9 | "Монгол Транс" ХХК | 7000 | 450-500 | 55 | 1 | 32 | | 2 |
| 10 | "Эрин Интернэшил" ХХК | 7000 | 200 | 30 | 1 | 32 | | 3 |
| 11 | "Ти Ай Ложистик" | 12269 | 300-350 | 30 | 1 | 26 | 6700 | 2 |
| | **Нийт** | **193475** | **4150- 4500** | **285** | **15** | | **38928** | **26** |

Улаанбаатар хотын хэмжээнд ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй томоохон 11 терминалын байршил, тээвэрлэлтийн маршрут болон хүчин чадлын үзүүлэлтүүдийг танилцуулж байна.

**Улаанбаатар дахь ачаа тээврийн томоохон терминалуудын байршил, тээвэрлэлтийн маршрут болон хүчин чадлын үзүүлэлтүүдийг харьцуулсан хүснэгт:**

*Хүснэгт 28*

| № | Терминалын нэр | Терминалын байршил | Тээврийн хэрэгслийн ангилал ба тоо | Ачааны төрөл |
|---|---|---|---|---|
| 1 | АБТЭМА | Баянзүрх дүүрэг, Улаанбаатар | | Хөдөө аж ахуйн бараа, хүнс, аж үйлдвэрийн өргөн хэрэглээний бараа, электрон бараа, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 2 | Амгалан Ложистик ХХК | Амгалан, Баянзүрх дүүрэг | | |
| 3 | Техник Импорт ХХК | Хан-Уул дүүрэг | | Барилгын материал, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 4 | Туушин ХХК | Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 1-р хороо, Энгельсийн гудамж, Туушин ХХК-ийн Тээвэр Үйлчилгээний цогцолбор | В ангиллын 12<br>С ангиллын 4<br>СЕ ангиллын 4 | Хөдөө аж ахуйн бараа, хүнс, аж үйлдвэрийн өргөн хэрэглээний бараа, электрон бараа, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 5 | Материал Импекс ХХК | Баянгол дүүрэг | СЕ ангиллын 2 | Хүнс- сахар |
| 6 | Монгол Транс ХХК | Сонгинохайрхан дүүрэг 20-р хороо | СЕ ангиллын 37 | Барилгын материал, хүнс, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 7 | Прогресс Транс ХХК | Баянгол дүүрэг, 20-р хороо, Дунд голын гуд, Прогресс транс ХХК-ний байр | Хувийн машин байхгүй “Тапа” хүргэлтийн компанитай хамтарч ажилладаг. | Барилгын материал, хүнс, бусад |
| 8 | Монгол Экспресс ХХК | Баянгол дүүрэг | | |
| 9 | Эрин Интернэшил ХХК | Баянгол дүүрэг | | Аж үйлдвэрийн өргөн хэрэглээний бараа, электрон бараа, техникийн бараа, тоног төхөөрөмж, бусад |
| 10 | Интердесижи ХХК | Сонсголонгийн гудамж 15-1, Үйлдвэрийн баруун бүс, Баянгол дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар, 16102, Mongolia | | Хүнс |
| 11 | Ти Ай Ложистик | Баянгол дүүрэг 24-р хороо. | | Барилгын материал, хөдөө аж ахуйн бараа, хүнс, бусад |

## 5.10.Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах Дүрмийн 4.1.3.1

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, нийт 19 аж ахуйн нэгж, байгууллагаас 16 нь буюу 84 хувь нь тохирлын үнэлгээ хийлгэж, ангиллаа тогтоолгосон байна.

Үүнд:
- Зорчигч Тээвэр Нэг ОНӨААТҮГ
- Автотерминал Трейд ХХК
- Эс Энд Эй Транс ХХК
- Автобус Нэгдэл ХХК
- Эмсид ХХК
- Зорчигч Тээвэр Тав ОНӨААТҮГ
- “Сайхан ирээдүй” ХХК
- “Сутайн буянт” ХХК
- “Эрдэм транс” ХХК
- “Дюц” ХХК
- “Блюбус” ХХК
- “Мяралзаа” ХХК

- "Трансбус" ХХК (БЗД)
- "Трансбус" ХХК (СХД)
- "Үнэгтийн Уул" ХХК
- "Гбус" ХХК

Хүрсэн үр дүн: Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч нийт 19 аж ахуйн нэгж, байгууллагаас 16 нь буюу 84 хувь нь тохирлын үнэлгээ хийлгэж, ангиллаа тогтоолгосон байна.

### 5.11.Нийтийн тээврийн салбарт дэвшилтэт шинэ техник, технологи болон шинэ төрлийн тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлэх, хөгжүүлэх, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлнэ. Дүрмийн 4.1.3.2

1.Дүүжин замын тээвэр төслийн нэгдүгээр шугам буюу Яармаг, Арцат – Хархорин, Өнөр хороолол чиглэлд тулгуур багана байрлуулах ажил хийгдэж эхэлсэн. Туул голын ай сав газар байрлалтай 3-9 дүгээр тулгуур баганын нийт 28ш шон суурийн өрөмдлөг, арматурчлал, бетоны ажил хийгдсэн. Европын Холбооны стандартыг нутагшуулах зорилгоор "Хүн тээвэрлэх зориулалттай дүүжин замын тээврийн байгууламжийн аюулгүй байдлын шаардлага"-тай холбоотой 15 стандартыг Стандарт, хэмжилзүйн газрын Автотээврийн стандартчиллын техникийн хороогоор батлуулан, MNS бүртгэлд шилжүүлсэн.

Дүүжин замын тээврийн төслийн хоёрдугаар шугам буюу Үндэсний соёл амралтын хүрээлэнгээс Үндэсний цэцэрлэгт хүрээлэн чиглэлийн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил эхэлж, дэд бүтэц, суурь судалгааны ажлууд хийгдэж эхэлсэн.

2.Метро төслийн шинэчлэн боловсруулсан ТЭЗҮ холбогдох яамдын мэргэжлийн зөвлөл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын салбар хороод, намын бүлгүүдээр үе шаттай хэлэлцэж дэмжсэн. Их багтаамжийн нийтийн тээвэр Улаанбаатар метро барих төслийн бүтээн байгуулалтын ажлын (EPC) гүйцэтгэгчийг шалгаруулах хоёрдугаар шатны тендерийн баримт бичигт санал, зөвлөмж өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилготой ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, 2025 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар тендерийн баримт бичгийг хэлэлцэж холбогдох санал, мэдээллийг өгсөн.

3."Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн сайжруулалт" сэдэвт зөвлөлдөх уулзалтаар 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Тусгай замын автобус төслийн үйл ажиллагаа, санхүү, дэд бүтцийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг хэлэлцсэн. Азийн хөгжлийн банк нь "Тусгай замын автобус BRT төсөл"-ийн санхүүжилтийн зээлийн судалгааны ажлын хэсэг байгуулан 2025 оны 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд Улаанбаатар хотод ажилласан. Тус газраас хамрах асуудлын хүрээнд 4 өдрийн уулзалтад оролцож, санал хүргүүлж ажилласан.

4."Буянт-ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл "-ийн техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг төслийг боловсруулахаар "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ шалгарсан. Тус газраас Трамвайн замын төлөвлөлтийн трассын зураг төсөлд тусгах саналыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/02/1003 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

### 5.12. Дэвшилтэт техник технологид суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн цогц үйлчилгээ, тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх, нийтийн тээврийн хөтөлбөрийн менежментийн систем, тоног төхөөрөмжийг суурилуулж бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, засвар үйлчилгээний ажлыг зохион байгуулна; Дүрмийн 4.1.3.3

Нийтийн тээврийн бодлогын газар, "Гэрэгэ киоск" ХХК-тай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс "ЕС" болон "ТҮР" замын хуудсыг "ХУР" системтэй холбосон "Ачаа тээвэрлэлтийн цахим систем"-ийг нэвтрүүлээд байна.

Иргэн хуулийн этгээдэд хүндрэл чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор "Тайлан", "ЕС", "ТҮР" замын хуудас олгох үйлчилгээг "Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем"-ээр дамжуулан нэг цонхоос авах боломжийг бүрдүүлэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

"ЕС", "ТҮР" замын хуудас олгох шинэчилсэн програм хангамжийн давуу талууд:




*Зураг №120.  Киоск машин болон цахимаар "ЕС" замын хуудас авах боломжтой болсон.*

"Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем"-ээр дамжуулан ачаа тээврийн үйлчилгээг нэг цонхноос цахимаар авах нөхцөл бүрдсэн.

*Зураг №123.Нэг цонхонд 3 үйлчилгээ багтсан байдал*

## "НИЙСЛЭЛИЙН АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН НЭГДСЭН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН "ЕС", "ТҮР" ТАЙЛАН ГАРГАХ НӨХЦӨЛҮҮД

1. Тээврийн хэрэгслээр ангилах:
   - ✓ B,C,M,E ангиллаар гарах
   - ✓ Дээрх мэдээлэл ИРГЭН, ААНБ гарах, т/х гэрчилгээ дээрх мэдээллээр гарах
   - ✓ Марк, загвар, Үйлдвэрлэсэн улс, марк загвар, тэнхлэг даац
   - ✓ Мэргэшсэн жолоочийн мэдээлэл, т/х бүрээр
2. Тээвэрлэсэн ачааны төрөл
   - ✓ Хүнс тоо
   - ✓ Барилга
   - ✓ Ачаа үүсэх цэгийн хувьд
   - ✓ Ачаа шингэх цэгийн хувьд
   - ✓ Дүүргээр Жишээ нь: ХУД- 150, СХД-500, БГД-230, гэх мэт
   - ✓ Хөдөө орон нутаг руу гарч, орж байгаа ангилан гаргах. /Хамгийн их төвлөрч байгаа цэгийг гаргах/
   - ✓ Зах худалдааны төвүүдээр хайх боломжтой байх
3. Ачаа эргэлт хэмжээ
   - ✓ Өдөрт тээсэн ачаа тээвэрлэлт нэгдсэн дүнгээрээ /тонн/
     Өдөрт хамгийн их, бага тээсэн ачааны хэмжээ
   - ✓ Өдөрт туулсан зайн хэмжээ /км/
     Өдөрт хамгийн их, бага туулсан зайн хэмжээ
   - ✓ Өдөрт тээвэрлэлт хийсэн давтамж  нэгдсэн дүнгээрээ /тоо/
     Өдөрт хамгийн их, бага тоо хэмжээ
4. Иргэн, ААНБ-ын мэдээлэл
   - ✓ Нэр (Иргэний овог нэр, байгууллагын нэр)

- ✓ Регистрийн дугаар/ хуулийн этгээд байгууллагынх
- ✓ И-мэйл хайг
- ✓ Холбоо барих утасны дугаар
- ✓ Байршил хаягийн мэдээлэл (аймаг, сум, дүүрэг, хороо гэх мэт
    - ➢ Аж ахуйн нэгж байгууллага
        - Дулаан, ил зогсоолын хэмжээ
        - Техникийн үйлчилгээний засварын байртай, хэмжээ
        - Мэргэжилийн инженер, техникийн ажилтан

5. Зөрчлийн төрлийг ангилах
    - ✓ Даац хэтэрч тээвэрлэлт хийсэн
    - ✓ ЕС, ТҮР зөвшөөрөлгүй тээвэр хийсэн
    - ✓ Маршрут зөрчсөн
    - ✓ MNS 4598:2020 стандартын шаардлага хангаагүй
    - ✓ Хуулийн заалт зөрчсөн
    - ✓ Т/х ангилал бүрээр зөрчлийн давтамж гарах
    - ✓ Зөрчлийн дагуу авсан арга хэмжээ /холбогдох байгууллагад харагдах/
6. Он оноор хадгаламжийн архив үүсгэх.
7. Дээрх үзүүлэлтүүд диаграм, график, диаграмм, эксел дээр татагддаг болсон.

Тус газраас "Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем"-ийг Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨТҮГ-ын хяналтын системтэй холбох замаар Замын хуудас аваагүй тээврийн хэрэгслүүдэд цахимаар торгууль илгээх ажлыг зохион байгуулахаар 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/04/2228 дугаартай "Хамтран ажиллах тухай" албан бичгийг "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-т, мөн Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-т оношилгоонд тэнцсэн ачааны зориулалттай тээврийн хэрэгслийн тоо мэдээллийг холбох тухай 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/04/2407, Нийслэлийн автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв ОНӨААТҮГ-т 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/04/2408 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн.

"Тээврийн удирдлагын төв"-ийн системд аюултай ачаа болон тусгай ачаа тээврийн зохицуулалтын хяналтын нэгдсэн системийг шинээр хөгжүүлэхэд холбогдох танилцуулга, үнийн саналыг "Ай Си Ти групп" ХК, "Гэрэгэ киоск" ХХК-иас тус тус ирүүлсэн. Тус газраас системийг хийхэд шаардлагатай 206.000.000 төгрөгийг 2026 оны нийслэлийн төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн.

"Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-гийн программ хангамжийг 2022 онд хэрэглээнд нэвтрүүлсэн боловч программ хангамж нь ашиглалтын шаардлага хангахгүй тул шинэчлэх зорилгоор шаардагдах 100.000.000 төгрөгийг 2026 оны нийслэлийн төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн. "Ай Си Ти групп" ХК-иас шинээр хийгдэх программын танилцуулга, үнийн саналыг танилцуулах уулзалт зохион байгуулж, ажлын даалгавар боловсруулахад хамтран ажилласан.

Тайлант хугацаанд www.autobox.mn сайтад нийт бүртгэлтэй 586 үүнээс нэвтрэх эрхээ авсан авто засварын үйлчилгээ эрхэлдэг өссөн дүнгээр 172 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тайлант хугацаанд 684 автотээврийн хэрэгсэлд хийгдсэн засвар, үйлчилгээний мэдээллээ оруулан засвар үйлчилгээний мэдээллийг бүртгэлдүүлж байгаад хяналт тавьж ажилласан.

Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг хэлэлцэн шинэчлэн баталсантай холбоотойгоор холбогдох хөгжүүлэлтийн ажлыг бэлтгэж, батлагдсан төлбөрийн хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр системд түгээлтийг хийх талаар Улаанбаатар смарт ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01/02/263 дугаар албан бичгээр хэрэглэгчийн шаардлагыг хүргүүлсэн.

Нийтийн тээврийн удирдлагын дэд систем /monitoring.ubcard.mn/ болон Тээврийн хэрэгслийн систем /transport.khamuga.com/ шинэ программтай танилцан хөгжүүлэлт хийх шаардлагатай цэсүүдэд сайжруулалтын 27 санал өгч тусгуулсан. Улаанбаатар смарт карт

ХХК-д дундын эх авч байгаа чиглэлийн төлөвлөгөөт цагийн даалгаварт оруулсан дундын эх авалтын зогсоолуудын байршлаас хамаарч гар аргаар хийгдсэн эргэлтийн хугацаагаар даалгавар цагийг тооцож байхаар системийн хөгжүүлэлт хийх CSR (Customer Service Request) хүргүүлсэн.



*Зураг №121. Системийн харагдах байдал*

Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн систем төсөл арга хэмжээний хүрээнд Нийслэл Улаанбаатар хотод нийтийн тээврийн үйлчилгээний 100 киоск төхөөрөмжийг байрлуулах байршлын судалгааг гарган өгч Улаанбаатар хотын хөгжлийн корпорацид 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/02/68 тоот бичгээр хүргүүлсэн.

Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн систем төсөл арга хэмжээний хүрээнд 100 байршилд киоск машин, зорчигч урсгал ихтэй 100 байршилд лед дэлгэц байршуулсан.




*Зураг №122. Киоск төхөөрөмж*

Чиглэлийн мэдээллийн зураглалын боловсруулалтыг автоматжуулах “Дата Дэүс” ХХК-ийн /https://pt.web.datadues.mn/ системтэй танилцан хөгжүүлэх шаардлагатай саналыг өгсөн.




*Зураг №123. Дата дэүс програмд ажиллаж буй байдал*

Нийтийн тээврийн зогсоол дээр ирж байгаа иргэдийн цагаас хамаарсан эрэлтийг тооцоолох, Нийтийн тээврийн маршрут төлөвлөгөөний дагуу гүйцэтгэл хэрхэн явж байгаа

судлах, симуляци болон загварын шаардлага тодорхойлох, хөгжүүлэлтийг хийх ажлыг Дата Дэүс ХХК хэрэгжүүлэн ажилласантай холбоотой загварын тест, үйл ажиллагааны үр дүнд санал өгсөн. Мөн тус компани хэрэгжүүлж буй нийтийн тээврийн автобусны зогсоолын чиглэлийн мэдээллийн самбаруудад байршуулдаг мэдээллийн загварыг өөрчилж, чиглэлийн тээврийн хэрэгслүүдийн маршрутыг газрын зураг дээрээс зурган хэлбэрээр, ойлгомжтой байдлаар иргэд харах боломжийг бүрдүүлэх зорилгоор систем хөгжүүлэлтийн ажлын хүрээнд санал мэдээлэл солилцон ажилласан.

### 5.13.Нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах, өргөжүүлэх, программ хангамжийг сайжруулах, төлбөр төлөх системд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгч болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. Дүрмийн 4.1.3.4

Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулахаар Улаанбаатар смарт карт ХХК-тай хамтран ажилладаг бөгөөд системийн ажиллагаа доголдсонтой холбогдуулан хэвийн ажиллагааг хангуулахаар тайланд хугацаанд уг компанид 01/03/724, 01/03/729 тоот албан бичгүүдийг хүргүүлж ажилласан.

Нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн менежментийн системийг нэвтрүүлэх ажлыг 2024 оны 02 дугаар сараас эхлэн гүйцэтгэж, программ хөгжүүлэлтийн хэрэглэгчийн шаардлагуудыг өгч гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд зорчих тарифын өөрчлөлт 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжихтэй холбогдуулан 2 систем нэвтрүүлэгч байгууллагуудтай 3 удаа уулзалт зохион байгуулж, тоног төхөөрөмжид тохиргоог хийж холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

Мөн иргэдэд зориулсан гар утасны аппликейшнийг 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс хэрэглээнд нэвтрүүлж, төлбөрийг бүх төрлийн банкны карт болон QR кодын тусламжтайгаар нийтийн тээврээр зорчих төлбөрөө төлөх боломжтой болсон.

Мөн төсөл хэрэгжүүлэгч компанийн холбогдох албан тушаалтнуудтай 7 хоног бүр уулзалт зохион байгуулж хөгжүүлэлтийн явцтай танилцаж холбогдох үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавьж хөгжүүлэлтийн ажлыг туршиж, санал солилцон ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/105 дугаар захирамжаар байгуулагдсан Нийслэлийн Засаг дарга болон Датаком консорциумын хооронд 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн систем нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх гэрээ”-ний хүрээнд байгуулсан Улаанбаатар смарт карт ХХК-ийн хувьцааны 55 хувийг нийслэлд шилжүүлэх ажил 2024 онд хэлцэл хийгдэж, 2025 оны 05 дугаар сард эрх шилжүүлэх гэрээ хийгдсэн. Ингэснээр нийслэл хот уг компанийн хувьцааны 79 хувийг эзэмших болсон. Мөн уг компанийн Жижиг хувьцаа эзэмшигчидтэй хувьцаа худалдан авах хэлцэл хийгдэхээр 2025 оны 2 дугаар сард Нийслэлийн Засаг даргын А/212 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

#### 5.13.1. “Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн систем”, Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн системийн программ хангамжид хөгжүүлэлт хийх санал боловсруулан хүргүүлж, хөгжүүлэлтийн явцад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.

“Ажлын гүйцэтгэлийг хялбарчлах, цагийг нөхөж олгох ажлыг түргэн шуурхай болгох” хэрэглэгчийн шаардлагыг Улаанбаатар смарт карт ХХК-д 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/03/2866 дугаартай албан бичгээр хүргүүлж хөгжүүлэлттэй холбоотой 3 удаагийн хамтарсан уулзалт зохион байгуулж нэмэлт хөгжүүлэлт хийлгэх жагсаалт гаргаж хүргүүлсэн.



*Зураг №124. Ажлын гүйцэтгэл хялбарчлах тухай Улаанбаатар смарт карт ХХК-д хүргүүлсэн хэрэглэгчийн шаардлага, албан бичиг.*

Тус хөгжүүлэлттэй холбоотой 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар смарт карт ХХК-ийн холбогдох албан тушаалтнууд солонгос талын хөгжүүлэгч нартай хийсэн хамтарсан 3 дахь уулзалтын хүрээнд хөгжүүлэлтийн тест дээр 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр тээвэр зохицуулагч нарын хамт ажиллаж нэмж хөгжүүлэлт хийлгэх саналын жагсаалтыг 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар смарт карт ХХК-ийн хөгжүүлэлт хариуцсан ажилтанд цахимаар хүргүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-аас ирүүлсэн хүсэлтийг судалж “Мэдээлэл дамжуулах товч (SOS)-ыг дарсан тохиолдолд батлах товч тийм, үгүй гэсэн сонголтыг дарж баталгаажуулах” хэрэглэгчийн шаардлагыг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/03/1324 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.



Ажлын гүйцэтгэл хялбарчлах, цагийг нөхөж олгох ажлыг түргэн шуурхай болгох хөгжүүлэлтийн хүрээнд нэмж хөгжүүлэлт хийлгэх саналын жагсаалт

2025.03.20

| Д/д | Хөгжүүлэлтийн санал | Тайлбар |
|---|---|---|
| 1 | ТВОХ системийн Судалгааны тайлангууд цэсэнд сонгосон цаг, сонгосон буудал дээр зогссон бүх чиглэл, автобусуудыг гарааш дугаараар харагддаг байх. | Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа 1136 тээврийн хэрэгслийн авто замын ачааллаас үүсэн түгжрэлийг системээс шууд харах нь ААНБ-с ирүүлсэн хүсэлтийг баталгаажуулахад баримт нотолгоо болох; Өдөр тутмын хөдөлгөөнд хяналт тавихад бодьтой болно. |
| 2 | ТВОХ системийн Гүйцэтгэл цэсний Ажлын гүйцэтгэл /ААНБ-ТХ тэрлээр/ (0.5 цэснээс гадна ААНБ-ын чиглэлүүдээр ЗХХХЦ харагддаг байхаар нэмэлт цэс нэмүүлж хөгжүүлэлт хийж өгөх. /ЗХХХЦ дээр дарахад 0.5-тайгаа адилхан харагддаг байх/. | Түгжрэлийн цагийг тодорхойлох, бусад чиглэлүүдийг харьцуулахад хялбар болно. |
| 3 | Бүртгэх цэсний хугацааны сонголт хэсэг дээр Зогсоол гэсэн сонголт нэмэх-А-Б зогсоолуудын нэршил болон тогтоосон цаг өглөө, орой бусад цагууд харагддаг байх. | Тогтоосон өглөө, орой, бусад цагуудын аль хугацаанд хамаарагдах нь харагддаг байх, түгжирсэн цагийг системээр тооцож гаргадаг байх. Нэмэлт тайлбар Зураг №1-ыг харах |
| 4 | Аж ахуйн нэгж байгууллагын зохицуулагчаас ирүүлэх ЗХХХЦ-ын хүсэлт дээр Зогсоол хоорондын тогтоосон хугацаа хэтрээгүй тохиолдолд хүсэлт явуулах боломжийг нь хязгаарлах /хүсэлт явуулах боломжгүй болгох/. | ААНБ-уудаас ЗХХХЦ-ыг бүх тээврийн хэрэгслүүд гэж мэйлээр ирүүлдэг зохицуулалтыг хязгаарлах, багасгах. |
| 5 | Нийтийн тээврийн бодлогын газрын Тээвэр зохицуулагч нарын хянах цэсэнд Зогсоолуудын нэршил, тогтоосон цагууд харагдах багана нэмэх. | 1. А зогсоолоос Б зогсоолуудын /2 –с дээш буудал/ нэршил болон тогтоосон цаг өглөө, орой, бусад гэсэн цагууд харагддаг байх; 2. Түгжрэл үүссэн зогсоолуудын тогтоосон цаг өглөө, орой, бусад гэсэн цагууд харагддаг байх; 3. Түгжирсэн цаг системээр тооцоологдож гарсан байх. Нэмэлт тайлбар Зураг №2-ыг харах |

Саналыг нэгтгэсэн
АГХ-ын мэргэжилтэн Н.Янжинлхам



**Зураг 1 тайлбар:**
Бүртгэх → Зогсоол гэж чагтлахад А зогсоолоос Б зогсоолуудын нэршил болон тогтоосон цаг өглөө, орой, бусад гэсэн цагууд харагддаг байх;
Мөн аль хугацаанд хамаарагдах нь харагддаг байх, түгжирсэн цагийг системээр тооцож гаргадаг байх;
2. Системээр тооцож гарсан түгжрэлийн цаг нь тогтоосон цагаас бага бол уг хүсэлтийг ААНБ-с илгээх боломжгүй байх.




**Зураг 2 тайлбар:**
1. Хүсэлт гаргагч баганы ард зураг 1 тайлбарын бүртгэх цэсэнд нэмүүлэх түгжирсэн зогсоол А-Б, 2-оос дээш буудал харагдах
2. Дараагийн багана /нэмүүлэх/Түгжрэл үүссэн буудлын тогтоосон цагууд харагддаг байх/
3. Хэрэгжүүлэх хугацаа баганы ард түгжирсэн цаг тооцоологдож гарсан байх

*Зураг №125. Ажлын гүйцэтгэл хялбарчлах нэмэлт хөгжүүлэлтийн санал*

Нийтийн тээврийн удирдлагын дэд системийн хөгжүүлэлтийн хүрээнд ажлын гүйцэтгэл тооцох, хяналт тавих, тайлан мэдээ гаргах чиглэлээр хүргүүлсэн хэрэглэгчийн шаардлагын дагуу хийгдэж байгаа хөгжүүлэлтийн явцын талаар 7 хоног бүр мэдээлэл солилцож, сайжруулах хөгжүүлэлтийг тухай бүр хийлгэж хяналт тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд ажлын хэсгийн хуралд 3 удаа, Ай Си Ти групп ХК-аас системийн хөгжүүлэлтийн талаар танилцуулах 7 хоног бүрийн баасан гаригт зохион байгуулдаг уулзалтад 16 удаа оролцож ажлын гүйцэтгэл, тайлан мэдээний хөгжүүлэлтийг 2 удаа хамтарсан тест хийж тухай бүр нэмэлт хөгжүүлэлтийн саналаа тусгаж ажилласан.

Үйл ажиллагааны үр дүн:

Хэрэглэгчийн шаардлагын дагуу системд хөгжүүлэлт хийгдсэн боловч тайлант хугацаанд нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын гүйцэтгэл А/42 дугаар тушаалаар батлагдсан ажлын гүйцэтгэл тооцох журам, аргачлалын дагуу ажлын гүйцэтгэл 100 хувь үнэн зөв тооцогдохгүй,алдаатай байгаа талаар нэмж сайжруулах хөгжүүлэлтийг тухай бүр төсөл хэрэгжүүлэгч компанид мэдээлэл солилцож ажиллаж байна.

### 5.13.2. Тээвэр зохицуулагч нарт өдөр тутам заавар зөвлөмж өгч мэдээ мэдээлэлд хяналт тавьж ажилласан.

Тээвэр зохицуулагч нарт өдөр тутам заавар зөвлөмж өгч мэдээ мэдээлэлд хяналт тавьж ажиллаж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч 18 аж ахуйн нэгж, байгууллагуудын нийтийн тээврийн үйлчилгээнд тээвэр зохицуулагч нар чиг үүргийн дагуу хяналт тавьж зөрчил илрүүлсэн болон зохицуулалт хийж богино эргүүлсэн тээврийн хэрэгслүүдийн мэдээлэлд системээр хяналт тавьж, тайлант хугацаанд ажлын гүйцэтгэл тооцох тухай нийт 188 удаагийн албан бичгийг Улаанбаатар смарт карт ХХК-д хүргүүлэн ажлын гүйцэтгэлд тооцуулсан.

2025 оны эхний 11 сарын байдлаар 326,351 тээврийн хэрэгсэл 4,550,992 машин цаг, 2,351,655 рейс гүйцэтгэсэн байна.

Тээвэр зохицуулагч нараас 7 хоног бүр ажил үйлчилгээ сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн мэдэгдлийн хүрээнд сар тутам ажлын гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллаж байна.

2025 онд нийт 61,385 дуудлага ирснээс Тээврийн бодлого, судалгааны хэлтэст 284, Хяналт шалгалтын хэлтэст  580, Зорчигч тээврийн хэлтэст 1, Захиргаа, удирдлагын хэлтэст 1 шилжүүлж, санал гомдлын ажилтан, тээвэр зохицуулагч нар 60,519 дуудлагад маршрут чиглэл, цагийн хуваарь, үйлчилгээтэй холбоотой бусад мэдээллийг өгч ажилласан.

Нийт дуудлагаас  301 гомдол 275  саналыг холбогдох хэлтэст шилжүүлсэн байна. Иргэдээс ирсэн 580 гомдлыг хүлээн авч 572 гомдолд Авто тээврийн хяналтын улсын байцаагч нар арга хэмжээ тооцон ажилласан байна.

Үйл ажиллагааны үр дүн:

Нийтийн тээврийн чиглэлүүдэд хийсэн шуурхай зохицуулалтын үед ажлын гүйцэтгэл үнэн зөв тооцогдох нөхцөлийг бүрдүүлж, ажлын гүйцэтгэлд системээр хяналт тавьж ажилласан.

### 5.13.3. Нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг тооцох журам, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон, шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллана;

Газрын даргын 2023 оны А/42 тушаалаар батлагдсан ажлын гүйцэтгэл тооцох журам, аргачлалын дагуу гүйцэтгэл тооцогдож байгаа байдалд хяналт тавьж аж ахуйн нэгж байгууллагуудын сар бүрийн машин цаг, рейсийн гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулж ажилласан.

Үйл ажиллагааны үр дүн:

2025 оны эхний 10 сарын тээврийн хэрэгслийн гүйцэтгэл 100 хувь буюу 2.2 хувиар өссөн, машин цагийн гүйцэтгэл 97.7 хувь буюу 4.6 хувиар өссөн, рейсийн гүйцэтгэл 75.0 хувь буюу 7.1 хувь өссөн үзүүлэлттэй байна.

Машин цагийн гүйцэтгэл /хувь/

(2024-2025 оны эхний 10 сар)

*Хүснэгт 29.*

| Үзүүлэлт | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | **Дундаж хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2024 | 83.1 | 82.8 | 92 | 95.3 | 95.9 | 96.2 | 97 | 96.1 | 96.1 | 96.9 | **93.1** |
| 2025 | 97.9 | 98.1 | 97.9 | 98 | 97.3 | 97.1 | 97.1 | 97.6 | 98 | 98.4 | **97.7** |




*График 12.2024-2025 оны 1-10 сарын машин цагийн гүйцэтгэл*

2025 оны эхний 10 сарын байдлаар 4,550,992 машин цаг буюу 97,8 хувь, рейсийн гүйцэтгэл 2351655.5 буюу 74,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Рейсийн гүйцэтгэл /хувь/

(2024-2025 оны эхний 10 сар)

*Хүснэгт 30.*

| Үзүүлэлт | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | **Дундаж хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2024 | 60 | 60.1 | 71.1 | 71.4 | 68.8 | 73.8 | 69 | 70.1 | 66.9 | 67.7 | **67.9** |
| 2025 | 79.5 | 70.6 | 77.3 | 75.3 | 71.9 | 73.8 | 79 | 74 | 75.8 | 72.3 | **75.0** |




*График 23.2024-2025 оны 1-10 сарын рейсийн гүйцэтгэл*

2025 оны эхний 10 сарын байдлаар рейсийн гүйцэтгэл 75.0 хувь буюу 7.1 хувь өссөн үзүүлэлттэй байна.

Тээврийн хэрэгслийн тоо

(2024-2025 оны эхний 10 сар)

*Хүснэгт 31.*

| Үзүүлэлт | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | **Дундаж хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2024 | 90.4 | 91.9 | 98.3 | 99.4 | 99.3 | 99.7 | 100 | 99.7 | 99.7 | 99.8 | **97.8** |
| 2025 | 99.9 | 100 | 100 | 100 | 100 | 99.9 | 99.9 | 100 | 100 | 99.8 | **100.0** |




*График 24.2024-2025 оны 1-10 сарын тээврийн хэрэгслийн гүйцэтгэл*

2025 оны эхний 10 сарын тээврийн хэрэгслийн гүйцэтгэл 100 хувь буюу 2.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2025 оны эхний 10 сарын тээврийн хэрэгслийн гүйцэтгэл 100 хувь буюу 4.1 хувиар өссөн, машин цагийн гүйцэтгэл 98 хувь буюу 8.2 хувиар өссөн, рейсийн гүйцэтгэл 75.5 хувь буюу 9.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

5.13.4. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын өдөр, сар, жилийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана;

Улаанбаатар смарт карт ХХК-иас гарган баталгаажуулж ирүүлсэн 2025 оны эхний 05 сарын ажлын гүйцэтгэлийн нэгтгэлийн дүнг өдөр тутмын ажлын гүйцэтгэлийн нэгтгэл болон Удирдлага мэдээллийн цахим төлбөрийн системийн машин цаг, рейс, тээврийн хэрэгсэл, нэмэгдэж хасагдсан цагийн дүнтэй тулган хяналт тавьж ажилласан.

2025 оны сарын нэгдсэн гүйцэтгэлд хяналт тавих хуудас

*Хүснэгт 32.*

| д/д | Он, сар | тээврийн хэрэгслийн тоо | | машин цаг | | рейс | | гүйцэтгэлийн хувь | | | Ажлын гүйцэтгэлд | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | даалгавар | гүйцэтгэл | даалгавар | гүйцэтгэл | даалгавар | гүйцэтгэл | тээврийн хэрэгсэл | цаг | рейс | нэмэгдсэн цаг | хасагдсан цаг |
| 1 | 2025.01 | 32297 | 32273 | 459836:44:30 | 450250:38:00 | 308927.5 | 245451.5 | 99.9 | 97.9 | 79.5 | 573:15:30 | 109:04:00 |
| 2 | 2025.02 | 29802 | 29797 | 424572:04:30 | 416585:17:00 | 285704 | 201669 | 100.0 | 98.1 | 70.6 | 211:14:30 | 125:37:00 |
| 3 | 2025.03 | 32788 | 32787 | 461191:32:00 | 451617:46:30 | 311301.5 | 240749 | 100.0 | 97.9 | 77.3 | 123:06:00 | 201:37:00 |
| 4 | 2025.04 | 32629 | 32621 | 465218:35:00 | 456060:06:30 | 314041.9 | 236616 | 100.0 | 98.0 | 75.3 | 142:34:00 | 258:30:00 |
| 5 | 2025.05 | 34117 | 34114 | 485605:23:00 | 472603:47:30 | 327783 | 235680 | 100.0 | 97.3 | 71.9 | 675:06:30 | 138:54:00 |
| 6 | 2025.06 | 32210 | 32176 | 461135:25:30 | 448012:42:00 | 309377 | 228449.5 | 99.9 | 97.2 | 73.8 | 755:09:00 | 114:51:00 |
| 7 | 2025.07 | 31937 | 31894 | 453030:54:00 | 440019:15:30 | 304437.5 | 240497.5 | 99.9 | 97.1 | 79.0 | 820:23:00 | 155:05:00 |
| 8 | 2025.08 | 32538 | 32535 | 467497:12:00 | 456221:40:00 | 315833 | 233862 | 100.0 | 97.6 | 74.0 | 1010:32:00 | 154:53:00 |
| 9 | 2025.09 | 33240 | 33240 | 476529:01:00 | 466852:41:30 | 321803 | 243798.5 | 100.0 | 98.0 | 75.8 | 787:09:30 | 146:29:00 |
| 10 | 2025.10 | 34918 | 34914 | 500800:23:30 | 492767:40:30 | 339109 | 244882.5 | 100.0 | 98.4 | 72.2 | 278:33:00 | 200:07:00 |
| **Нийт дүн** | | **326476** | **326351** | **4655417:15:00** | **4550991:35:00** | **3138317.4** | **2351655.5** | **100.0** | **97.8** | **74.9** | **5377:03:00** | **1605:07:00** |

Нийтийн тээврийн үйлчилгээнд 2025 оны эхний 10 сарын байдлаар 326,351 тээврийн хэрэгсэл 4,550,992 машин цаг, 2,351,655 рейс гүйцэтгэсэн байна.

2025 оны эхний 10 сарын байдлаар 5,377,0 цаг ажлын гүйцэтгэлд нэмэгдэж 1605,0 цаг ажлын гүйцэтгэлээс хасагдсан.

Тээвэр зохицуулагч нараас өдөр тутам ирүүлдэг зохицуулалтын мэдээ, замын түгжрэл, зам засвараас шалтгаалж зөрчилд тооцогдсон цагуудыг системээр хянаж Улаанбаатар смарт карт ХХК-д ажлын гүйцэтгэл тооцуулах тухай албан бичгийг өдөр бүр явуулж тухайн өдрийн гүйцэтгэлд тооцуулдаг.

Машин цаг, рейсийн гүйцэтгэл
/2025 оны эхний 10 сар/

*Хүснэгт 33.*

| Үзүүлэлт | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Рейс /мян.рейс/ | 245451.5 | 201669.0 | 240749.0 | 236616.0 | 235680 | 228449.5 | 240497.5 | 233862.0 | 243798.5 | 244883 | **2351655.5** |
| Машин цаг /мян.цаг/ | 450251.0 | 416585.0 | 451618.0 | 456060.0 | 472604.0 | 448013.0 | 440019.0 | 456222.0 | 466853.0 | 492768.0 | **4550993.0** |




*График 25. 2025 оны эхний 10 сарын машин цагийн гүйцэтгэл*

**Үйлчилгээнд ажилласан тээврийн хэрэгслийн тоо**
/2025 оны эхний 5 сар/

*Хүснэгт 34.*

| Үзүүлэлт | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| Тээврийн хэрэгслийн тоо | 32273 | 29797 | 32787 | 32621 | 34114 | 161,592 |

2025 оны эхний 10 сарын байдлаар 4,550,992 машин цаг буюу 97,8 хувь, рейсийн гүйцэтгэл 2351655.5 буюу 74,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Үйлчилгээнд ажилласан тээврийн хэрэгслийн тоо**
/2025 оны эхний 10 сар/

*Хүснэгт 35.*

| Үзүүлэлт | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тээврийн хэрэгслийн тоо | 32273 | 29797 | 32787 | 32621 | 34114 | 32176 | 31894 | 32535 | 33240 | 34914 | **326,351** |




*График 26.2025 оны эхний 10 сарын тээврийн хэрэгслийн тоо*

2025 оны эхний 10 сарын байдлаар 326,351 тээврийн хэрэгсэл буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

## Ажлын гүйцэтгэлд нэмэгдэж, хасагдсан хасагдсан цаг

/2025 оны эхний 10 сар/

*Хүснэгт 36*

| Үзүүлэлт | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10-р сар | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэмэгдсэн цаг | 573:15:30 | 211:14:30 | 123:06:00 | 142:34:00 | 675:06:30 | 755:09:00 | 820:23:00 | 1010:32:00 | 787:09:30 | 278:33:00 | **5377:03:00** |
| Хасагдсан цаг | 109:04:00 | 125:37:00 | 201:37:00 | 258:30:00 | 138:54:00 | 114:51:00 | 155:05:00 | 154:53:00 | 146:29:00 | 200:07:00 | **1605:07:00** |

## Ажлын гүйцэтгэлд нэмэгдсэн цаг

/2025 оны эхний 10 сар/

*Хүснэгт 37*

| Үзүүлэлт | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэмэгдсэн цаг | 573.0 | 211.0 | 123.0 | 143.0 | 675.0 | 755.0 | 820.0 | 1,011.0 | 787.0 | 279.0 | **5,377.0** |




*График 27.Ажлын гүйцэтгэлд нэмэгдсэн цаг*

## Ажлын гүйцэтгэлээс хасагдсан цагийн гүйцэтгэл

/2025 оны эхний 10 сар/

*Хүснэгт 38.*

| Үзүүлэлт | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хасагдсан цаг | 109.0 | 126.0 | 202.0 | 259.0 | 139.0 | 115.0 | 155.0 | 155.0 | 146.0 | 200.0 | **1,606.0** |




*График 28. Ажлын гүйцэтгэлээс хасагдсан цаг*

Үйл ажиллагааны үр дүн:

Нийтийн тээврийн чиглэлүүдэд хийсэн шуурхай зохицуулалтын үед ажлын гүйцэтгэл үнэн зөв тооцогдох нөхцөлийг бүрдүүлж, ажлын гүйцэтгэлд системээр хяналт тавьж ажилласан.

Ажлын нэгдсэн гүйцэтгэл, нэмэгдэж хасагдсан цагийн тооцоололд өдөр тутам тавих хяналт тавьж, сар бүр нэгдсэн мэдээлэл бэлтгэсэн.

Удаан зогссон автобуснуудын гүйцэтгэлд тээвэр зохицуулагчид болон ажлын гүйцэтгэлийн хяналтын мэргэжилтнүүд давхар хяналт тавьснаар техникийн саатал болон бусад шалтгаанаар сул зогссон тээврийн хэрэгслүүдийн гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан.

## 5.14. Нийтийн тээврийн салбарт мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлт, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Автотээврийн улсын хяналт хэрэгжүүлнэ. Дүрмийн 4.1.4.1

### 5.14.1. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;

Тус газраас нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгслүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, жирэмсэн эмэгтэй, хүүхдүүд зэрэг нийгмийн тусламж дэмжлэг шаардлагатай иргэдийн саадгүй, тав тухтай, зорчих нөхцөлийг хангаж буй эсэхэд хүртээмжийн үнэлгээ хийх зорилгоор Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газруудын холбогдох албан хаагчдын бүрэлдэхүүнтэй 2025 оны 05 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Зорчигч тээвэр хоёр, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ын автобуснуудад техникийн 7, мэдээллийн 10 асуумжаар 5 төрлийн автобусанд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийн үнэлгээ хийж ажилласан.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад автобусанд байрлуулсан хяналтын камерын ашиглалт хамгаалалтын хэвийн ажиллагаа хангаж байгаа эсэхэд шалгалт хийх ажлыг 2025 оны 03 дугаар сарын 24-нөөс 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Шалгалтад 17 аж ахуйн нэгж, байгууллагын 652 тээврийн хэрэгслийг хамруулснаас жолооч руу чиглэсэн камерын харах өнцөг өөрчилсөн зөрчил ихээр илэрч байна. Үүнд:

Автобус нэгдэл ХХК 11, Автотерминал трейд ХХК 8, Блюбус ХХК 15, Гбус ХХК 8, Дюц ХХК 7, Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ 60, Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ 41, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ 65, Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ 37, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ 38, Мяралзаа ХХК 3, Сайхан-Ирээдүй ХХК 2, Сутайн буянт ХХК 35, Трансбус ХХК 28, Үнэгтийн Уул ХХК 2, Эмсид ХХК 13, Эрдэмтранс ХХК 28 тээврийн хэрэгслүүд зөрчилтэй байна.

Дээрх 17 аж ахуйн нэгж, байгууллага улсын байцаагчийн зөрчил арилгуулах 7 хоногийн хугацаатай албан шаардлага хүргүүлж 2025 он 04 дүгээр сарын 14-нөөс 16-ны өдрийн хооронд гүйцэтгэлийн шалгалт хийж зөрчил бүрэн арилгаагүй 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь заалтын дагуу арга хэмжээ тооцож ажилласан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас боловсруулсан удирдамжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Авто замын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Барилгын тухай хууль болон Монгол улсын нэгдэн орсон ОУ-ын гэрээ конвенцод хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн саадгүй, аюулгүй хүртээмжтэй нийтийн тээвэр, MNS 6055:2009 Иргэний

барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага, MNS 5012:2021 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага, Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй автобуснуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, жирэмсэн эмэгтэй, хүүхдүүд зэрэг нийгмийн тусламж дэмжлэг шаардлагатай иргэдийн саадгүй, тав тухтай, зорчих нөхцөлийг хангаж буй эсэхэд хүртээмжийн үнэлгээ хийлгэж ажиллаа.

Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны саадгүй хүртээмжийн ажилтан Б.Ганбаатар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Тамир, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн О.Гаасүрэн, Нийтийн тээврийн бодлогын газрын Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Ч.Бадамханд нарын бүрэлдэхүүнтэй баг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ, Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ-ийн 5 төрлийн автобусанд техникийн 7, мэдээллийн 10 шалгуураар хүртээмжийн үнэлгээг хийж, дараах үнэлгээг гаргав.



Зураг №126. Хүртээмжийн үнэлгээ хийсэн байдал.

1. Golden Dragon Xiamen XML6105J15C автобус-95.6%
2. Yutong ZK6116HG автобус-95.6%
3. Zhuhui GTQ6126BEVBT20 автобус-84.4%
4. Yutong E18PRO автобус-82.2%
5. Skyworth NJL6106BEV автобус 57.8%,
6. Skyworth NJL6100GSEV автобус 68.9% тус тус хангасан гэж үнэлсэн.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас Golden Dragon Xiamen XML6105J15C загварын болон Yutong ZK6116HG загварын автобуснууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийтийн тээврээр үйлчлүүлэх техникийн болон мэдээллийн хүртээмжийн үнэлгээг хийлгэхэд 95.6% буюу маш сайн гэж үнэлэгдсэн тул Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас Талархал дэвшүүлсэн.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТАЛАРХАЛ

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХАМТ ОЛОНД

Нийтийн тээврийн үйлчилгээнд нийслэлийн иргэдэд үйлчилдэг БНХАУ-д үйлдвэрлэсэн Golden Dragon Xiamen XML6105J15C маркийн автобусанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх техникийн болон мэдээллийн хүртээмжийн үнэлгээг MNS 6055:2009–Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, Үндсэн шаардлага MNS 5012:2021–Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага стандартын дагуу 15 үзүүлэлтээр шалгаж үнэлэхэд 95.6% буюу **"маш сайн"** гэж үнэлэгдсэн тул талархал илэрхийлэв.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ГЭРЭЛ

2025.06.12

Зураг №127. Талархал.

Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн "Техникийн тодорхойлолт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай" А/13 тоот тушаалын дагуу Нийслэл Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт, нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд

нийлүүлэгдэх троллейбусны техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд автотээврийн хяналтын улсын байцаагч Д.Тумбааш ажилласан.

Ажлын хэсэг 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр хуралдаж нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр худалдан авах шаардлагатай их багтаамжийн троллейбусны техникийн үзүүлэлт бүхий ажлын даалгаврыг Автотээврийн тухай хууль, Монгол улсын Замын хөдөлгөөний дүрэм, "Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй шаардлага, норм" MNS 5566:2020, Нийтийн зорчигч тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1603В:2022, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020, Нийтийн тээврийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл, JEA 800 маркийн троллейбусны угсрах, ашиглах үндсэн параметр ба техникийн ерөнхий шаардлага MNS 5773:2007, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5012:2021 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүн эргономикийн үзүүлэлтүүд MNS 4599:2003 улсын стандартуудын үзүүлэлт шаардлагын дагуу боловсруулж, 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр батлуулж ажилласан.

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ
2025 оны ... дугаар сарын ... өдөр

**УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ШИНЭЭР ХУДАЛДАН АВАХ ШААРДЛАГАТАЙ ИХ БАГТААМЖИЙН ТРОЛЛЕЙБУСНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**
**АЖЛЫН ДААЛГАВАР**

2025 оны 02 дугаар сарын 05 — Улаанбаатар хот

| № | Техникийн шаардлага | | Троллейбусны үзүүлэлт | Үндэслэл |
|---|---|---|---|---|
| 1 | Хууль, дүрэм, стандартын шаардлага | | Монгол Улсын авто тээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлага" MNS 4598:2020, "Авто тээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономик үзүүлэлтүүд" MNS 4599:2003, "Нийтийн тээврийн ангилал ба үйлчилгээнд тавих шаардлага" MNS 5012:2021, "Цахилгаан автомашин, Аккумляторын батарейгаар ажилладаг цахилгаан автомашин, хийц, аюулгүй байдалд тавих шаардлага" MNS 6728:2018, "Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл троллейбусны техникийн шаардлага" MNS 5773:2007, "Нийтийн тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1603B:2022, Монгол Улсын бусад стандартууд, Олон Улсын бусад стандартын шаардлага хангасан байна. | |
| 2 | Үйлдвэрлэсэн он | | 2025 онд шинээр үйлдвэрлэсэн | Шинээр үйлдвэрлэсэн байх |
| 3 | Жолооны хүрдний байрлал | | Зүүн талд байрлалтай (Зөв) байна. | Авто тээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг |
| 4 | Багтаамж (зорчигчийн тоо) | Суудлын тоо | 25-31 (+1) | "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.8.1.1 дэх заалт |
| | | Зогсоо зорчигчийн тоо | 60 аас дээш | |
| | | Нийт зорчигчийн тоо | 85-аас дээш | |
| 5 | Оврын хэмжээ | Урт метр | 11,5 м -13 м | "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2020 стандартын 5.8.1.2 дахь заалт |
| | | Өргөн метр | 2.45 м - 2.50 м (+- 0.05 м байж болно) | |
| | | Өндөр метр | 3.45 м - 3.5 м (+- 0.5 м байж болно) | |

*Зураг №128. Ажлын даалгавар.*

### 5.14.2. Хүүхдийн болон ажилчдын автобусны үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;

Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Д.Отгонжаргалын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр баталсан "Хүүхэд тээвэрлэх автобус ба үйлчилгээнд хяналт, шалгалт хийх тухай шалгалтын удирдамж"-ийн хүрээнд Автотээврийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Хүүхэд тээвэрлэх автобус ба үйлчилгээнд тавих шаардлага. MNS 6440:2014, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2020 улсын стандартын шаардлагуудыг хангуулахаар нийслэлийн нутаг дэвсгэрт хүүхэд тээвэрлэлтийн үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалтыг Автотээврийн хяналтын улсын байцаагч нар баталсан хуваарийн дагуу хийлээ.

Шалгалтыг: Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт хүүхэд тээвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тээврийн хэрэгслүүдэд явуулсан.

Шалгалтаар илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийг үндэслэн 2 аж ахуйн нэгж, байгууллагыг 650 нэгжтэй тэнцэх төгрөгөөр, 8 иргэнийг 800 нэгжтэй тэнцэх төгрөгөөр, ерөнхий боловсролын Күнз сургууль, Дэмоод ХХК-иудыг Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтыг үндэслэн тус тус 500 нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгож, нийт 1.450.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож ажиллалаа.

### 5.14.3. Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийх;

Газрын даргын баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах, үзлэг шалгалтын ажлын удирдамж”-ийн хүрээнд Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Багахангай дүүргүүдийн нутаг дэвсгэрт авто засвар, авто угаалга ажиллуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам”, “Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам”, “Авто үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага” MNS 5025:2020, “Авто машины угаалгын үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага” MNS 5347:2003 улсын стандартуудын шаардлага хангаж байгаа, техникийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын заавар журам мөрдөж байгаа эсэхэд авто тээврийн хяналтын улсын байцаагч нар хяналт шалгалтыг хийж ажиллалаа.





*Зураг №129. Авто үйлчилгээ шалгасан байдал*

Шалгалтад авто үйлчилгээ эрхлэгч 253 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж Авто үйлчилгээ эрхлэх ангиллын гэрчилгээ авсан эсэх, стандартуудын хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд шалгалт хийж илэрсэн зөрчилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч газар дээр нь арилгуулах боломжтой зөрчлүүдийг арилгуулж, ангиллын гэрчилгээ аваагүй 19 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 13 дэх хэсэгт зааснаар 4,550,000 төгрөгөөр торгох арга хэмжээ тооцож ажилласан.

5.14.4. Нийслэлийн нутаг дэвсгэрт автотээврийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын байцаагч нарыг хуваарилан ажиллуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр мэдэгдэл, албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

Авто тээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2025, “Нийтийн тээвэр. Ангилал ба үйлчилгээнд тавих. Ерөнхий шаардлага” MNS 5012:2021 улсын стандартын үзүүлэлт, шаардлагыг хангуулах, чиглэлийн хаяг болон мэдээ, мэдээллийн бичвэр батлагдсан хэмжээ, өнгө, загварын дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавьж ажилласан.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг 19 аж ахуйн нэгж байгууллагын 351 тээврийн хэрэгсэл шалгаж илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, давхардсан тоогоор 54 аж ахуйн нэгж байгууллагад Авто тээврийн хяналтын улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч, 49 аж ахуйн нэгжид гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, албан шаардлагын биелэлт хангаагүй 5 аж ахуйн нэгж, байгууллагад зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1-д заасны дагуу 3,750,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа.

*Хүснэгт 39 Албан шаардлага*

| № | Байцаагчийн Нэр | Төрөл | Гаргасан албан шаардлагын тоо | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Орлого төвлөрүүлэлт | Камер хяналт | tbox систем-ийн бүртгэлээр эх авалт | Өглөөны эх авалт шалгалт | Удирдамжтай шалгалтын | Торгуулийн дүн |
| 1 | О.Батцоож | Нийтийн тээвэр | | | | 1 | | |
| 2 | Ж.Бум-Эрдэнэ Б.Ууганбаатар | Нийтийн тээвэр | 10 | | | | | 500,000 |
| | | Хүүхдийн автобус | | | | | 1 | |
| 3 | Б.Бэхбол Б.Мягмардорж | Нийтийн тээвэр | | 17 | | | | 250,000 |
| 4 | М.Мөнхзул | Нийтийн тээвэр | | 7 | 9 | | | 3,000,000 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Д.Тумбааш | Нийтийн тээвэр | | 8 | | | | |
| 6 | Б.Ууганбаатар О.Сүхбаатар | Нийтийн тээвэр | | | | 1 | | |
| НИЙТ | | | 54 | | | | | 3750000 |

5.14.5. Авто тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын тайлан, улсын байцаагчийн дүгнэлтэд үндэслэн тээвэрлэлтийн болон бусад төрлийн гэрээг цуцлах, гэрээний хариуцлага /анз/ хүлээлгэх, хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэх чиглэлээр санал танилцуулах;

Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл, маршрут, цагийн хуваарь мөрдөлт, баримт бичгийн бүрдэл, гэрээний үүргийн биелэлт, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд авто тээврийн хяналтын улсын 10 байцаагч хяналт тавьж, 642 зөрчилд зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлд заасны дагуу 32 аж ахуйн нэгж, байгууллагад 14.300.000 төгрөг, 610 иргэн, жолоочид 15.495.000 төгрөг буюу нийт 29.795.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллаа.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 18 аж ахуйн нэгж, байгууллагад 103 заалт бүхий 53 албан шаардлага хүргүүлж ажилласан.

Албан шаардлагын биелэлт хангаагүй 5 аж ахуйн нэгж, байгууллагад зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1-д заасны дагуу 3.750,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулсан байна.

5.14.6. Автотээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн болон төрийн хяналт шалгалтын бусад байгууллагатай хамтран ажиллах;

Хяналт, шалгалтын хэлтсээс баталсан хуваарийн дагуу Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлага, үйл ажиллагаа эрхлэгч нарт Зөрчлийн тухай хууль, Автотээврийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилт, Авто үйлчилгээ ангилал, Ерөнхий шаардлага MNS 5025:2010 улсын стандарт, "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам"-ын холбогдох зүйл, заалтуудаар Автотээврийн хяналтын улсын байцаагч Б.Мягмардорж, Авто үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Т.Үүрийнсолонго нар бусад мэргэжлийн байгууллагын ажилтан, албан хаагчидтай хамтран сургалт явуулсан. Үүнд:

1. 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн сургалтын танхимд тус дүүргийн Авто үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн А.Бямбацолмон, Онцгой байдлын хэлтсийн Хэвлэл, мэдээллийн ажилтан ахмад Г.Сарантуяа нартай хамтарч авто үйлчилгээ эрхлэгч 85 иргэн, 18 аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтнуудыг хамруулан "Авто үйлчилгээний байгууллагуудад тавигдах нөхцөл шаардлагууд", "Галын аюулгүй байдлыг хангуулах нь" сэдвүүдээр;

2. 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Хан-Уул дүүргийн сургалтын танхимд тус дүүргийн авто үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Г.Ариунтуяа, Онцгой байдлын хэлтсийн Галын хяналтын хяналтын улсын байцаагч хошууч Б.Лхагвадорж нартай хамтарч авто үйлчилгээ эрхлэгч 77 иргэн, 9 аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтнуудыг хамруулан "Авто үйлчилгээний байгууллагуудад тавигдах нөхцөл шаардлагууд", "Галын аюулгүй байдлыг хангуулах нь" сэдвүүдээр тус тус сургалт хийсэн.

5.14.7. Автотээврийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа явуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах, мэдээ мэдээлэл бэлтгэн хүргэх, нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын жолооч нарт 20 минутын хот үндэсний хороо, Тээврийн Цагдаагийн албатай хамтран газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд хуваарийн дагуу 17 удаагийн сургалтыг зохион байгуулав.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагуудтай 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр уулзалт зохион байгуулж тухайн байгууллагаас сургалтад хамрагдах жолооч нарын тоо болон сургалтыг зохион байгуулах өдрийн саналыг авч хуваарийг боловсруулж, батлагдсан хуваарийн дагуу албан хаагч нарыг сургалтад хамруулллаа.

Сургалтын сэдэв, удирдсан албан хаагч нар. Үүнд:

1. Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад Д. Ганхуяг Замын хөдөлгөөний аюулгүй байдал сэдвээр
2. Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Тэлмэн Зам тээврийн осолд нөлөөлөх хүчин зүйлс сэдвээр
3. Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газрын мэргэжилтэн Ч.Бадамханд, “Нийтийн тээврийн салбарт мөрдөгддөг үндсэн стандартууд сэдвээр,
4. Автотээврийн хяналтын улсын байцаагч Б.Мягмардорж ”Цахим хяналтын үр нөлөө, гадаад орчин”, ”Нийтийн тээврийн жолооч нарын гаргадаг нийтлэг зөрчил, анхаарах асуудлууд” сэдвээр тус тус сургалтыг удирдан явуулсан.

*Хүснэгт 40 Сургалтад хамрагдсан жолооч нарын ирцийн мэдээлэл*

| Д/д | ААНБ-ын нэрс | Сургалт зохион байгуулагдсан өдөр | Сургалтад хамрагдсан жолоочийн тоо |
|---|---|---|---|
| | Үндсэн чиглэл | | |
| 1 | Зорчигч тээвэр нэг ОНӨААТҮГ | 2025.06.09-10 | 129 |
| 2 | Зорчигч тээвэр хоёр ОНӨААТҮГ | 2025.06.12, 2025.06.13 | 221 |
| 3 | Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ | 2025.06.23-24 | 247 |
| 4 | Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ | 2025.06.09-10 | 130 |
| 5 | Зорчигч тээвэр тав ОНӨААТҮГ | 2025.06.26-27 | 245 |
| 6 | Автотерминал трейд ХХК | 2025.06.20, 2025.07.03 | 71 |
| 7 | Автобус нэгдэл ХХК | 2025.06.20, 2025.06.30 | 25 |
| 8 | Эрдэмтранс ХХК | 2025.06.16-17 | 86 |
| 9 | Блюбус ХХК | 2025.06.20, 2025.06.30 | 14 |
| 10 | ГБУС ХХК | 2025.06.20, 2025.06.30 | 12 |
| 11 | ДЮЦ ХХК | 2025.07.01 | 19 |
| 12 | Мяралзаа ХХК | 2025.07.01 | 20 |
| 13 | Сайхан ирээдүй ХХК | 2025.06.20 | 5 |
| 14 | Сутайн буянт ХХК | 2025.06.20, 2025.06.30 | 80 |
| 15 | Трансбус ХХК | 2025.07.01 | 66 |
| 16 | Үнэгтийн Уул ХХК | 2025.07.01 | 6 |
| 17 | ЭМСИД ХХК | 2025.07.01 | 34 |
| 18 | Эс Энд Эй  транс ХХК | 2025.06.20, 2025.06.30 | 30 |
| | Такси | | |
| 1 | ВИП такси сервис ХХК | 2025.07.02 | 31 |
| 2 | Тэбэ сервис ХХК | 2025.07.02 | 2 |
| 3 | “Юбикаб бригада хоршоо” ХХК | 2025.07.02 | 20 |
| 4 | Мөнх такси ХХК | 2025.07.01 | 5 |
| 5 | "Стар авто трейд" ХХК | 2025.07.01 | - |
| | Буухиа | | |
| 1 | Буянт хөлгийн жолоо ХХК | 2025.07.01 | 4 |
| 2 | Юнайтэд бра ХХК | 2025.07.01 | - |
| | Нийт хамрагдсан жолоочийн тоо | | 1502 |




*Зураг №130. Сургалтын талаар цахим орчинд тавьсан мэдээлэл*

Сургалтад хамрагдсан жолооч нараас түгжрэлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой гаргасан санал

Жолооч нарын зүгээс замын хөдөлгөөнд түгжрэлийг үүсгэхээс гадна, замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа тулгамдсан асуудал

1. Автобусны дундын зогсоол болон эцсийн зогсоолууд дээр хувийн суудлын автомашин олноор зогсдог.
2. Зорчигч нар зогсоолын бус газар бууж, суух шаардлага тавьдаг.
3. Цахилгаан дугуй, скүүтер-ээр зорчиж байгаа иргэдийг тодорхой хэмжээгээр дүрэм, журамтай болгох эдгээр асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Сургалтын үр дүн: Нийтийн тээврийн салбарт томоохон парк шинэчлэлт хийгдсэн, жолооч нарын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой нийтийн тээврийн жолооч нарын ажлын орчин, нөхцөл сайжирсан.

Мөн жолоочийн дутагдалтай байдлыг арилгах зорилгоор улсаас сургалтын зардлыг хариуцан зохион байгуулж байгаа сургалтын хүрээнд сурч төгссөн нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр ажиллаж байгаа жолооч нарт шаардлагатай мэдлэг, мэдээллийг өгсөн.

Зорчигчдод соёлтой, аюулгүй үйлчилгээг хүргэх, үйлчилгээний чанарыг сайжруулах тал дээр анхаарч ажиллаж байгаа энэ цаг үед чухал ач холбогдолтой сургалт болсон.

Иймд дээрх байгууллагуудын хамтарсан сургалтыг жил бүр нийтийн тээврийн үйлчилгээнд ажилладаг жолооч нарт жилд 1 удаа зохион байгуулах нь ач холбогдолтой юм.

### 5.14.8. Нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр зорчих иргэдийн төлбөр төлөх байдалд шалгалт явуулж, хуульд заасны дагуу шаардлага тавих, хөлс төлөөгүй зорчигчийг тээвэрлэхээс татгалзах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, шалгагч нарыг гудамж замд хуваарилан ажиллуулах;

Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний хөлс төлөлтийн байдалд хяналт тавих шалгалтын ажлыг Авто тээврийн хяналтын улсын байцаагч болон шалгагч нар хамтран зохион байгуулж ажиллаа.

Энэ оны 11 сарын байдлаар өссөн дүн, давхардсан тоогоор нийт 8428 чиглэлийн их болон дунд багтаамжийн 49245 тээврийн хэрэгсэл, 59208 зорчигчдыг шалгаж, бэлэн мөнгөөр зорчсон, U money картын үлдэгдэл хүрэлцээгүй, зорчих картгүй, зорчих хөлс төлөөгүй зэрэг нийт 98885 зөрчил илрүүлж, 37547 зорчигчийг нийтийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхээс татгалзан, зорчуулахгүй буулгаж, зорчих хөлсөө төлөөгүй 56 иргэнийг зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн 560,000 төгрөгөөр торгож, 61946 зорчигчийн картад Easy pay /изи пей/ ПОС-ын цэнэглэлтээр 3.028.398.200 мянган төгрөгийн цэнэглэлт хийн ажиллалаа.





*Зураг №131. Карт цэнэглэлт.*

5.14.9. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хялбаршуулах, орчин үеийн цахим техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж ашиглах зэргээр ажлын бүтээмжийг сайжруулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчих хүсэлт өгсөн хүүхэд болон ажилчдыг тээвэрлэх үйлчилгээ үзүүлэгч 19 аж ахуйн нэгж, байгууллагын 18 хүсэлтийг хүлээн авч төрийн хяналт шалгалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Хүүхэд тээвэрлэх автобус ба үйлчилгээнд тавих шаардлага. MNS 6440:2014, Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS4598:2020 улсын стандартын  шаардлагуудыг хангасан 15 аж ахуйн нэгж, байгууллагын  27 тээврийн хэрэгсэлд 281 заалт бүхий 17 техникийн дүгнэлтийг гаргаж, дугаарын хязгаарлалтаас чөлөөлж нэгдүгээр эгнээгээр зорчих эрх олгосон байна.

5.14.10. Автотээврийн үйлчилгээ эрхлэх явцад зам тээврийн осол гарсан тохиолдолд холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, дахин зөрчил гаргахгүй байхад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, уг зам тээврийн осол, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тогтоож, буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

Трансбус ХХК-ийн Ч:51 Дүүхээ дэлгүүр-Дүнжингарав худалдааны төв чиглэлд 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр үйлчилгээнд ажиллаж байсан 11-067 гарааш дугаартай автобусны жолооч Т.Эрдэнэ-Очир нь зам тээврийн осолд холбогдсон бөгөөд тухайн үед ослын газарт Автотээврийн хяналтын улсын байцаагч ажиллаж холбогдох мэдээ мэдээллээр газрын удирдлагыг хангаж шуурхай арга хэмжээ авч ажилласан.

Зам тээврийн осол, зан харилцааны зөрчил гаргасан нийтийн тээврийн үйлчилгээний 5 жолоочийг гаргасан зөрчлийг арилгах хүртэл автотээврийн хяналтын улсын байцаагчийн илтгэх хуудасны дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах эрхийг түр идэвхгүй болгож, сургалтад суух үүрэг даалгавар өгч ажиллалаа.

5.14.11. Нийслэлийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаарх тоон мэдээллийг хөтөлж, цахим сангийн баяжилтыг хийх, энэ чиглэлээр дээд шатны байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах;

“Зөрчлийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Авто тээврийн тухай” хуулиуд болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, Ангилал ба түүнд тавигдах шаардлага” MNS 5012:2021, “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2025, “Такси үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5122:2013, холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор мөн тус газрын даргын баталсан тушаал шийдвэр хэрхэн биелэгдэж байгаад авто тээврийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж, 9 зөрчлийн хэрэг, 896 хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн зөрчилд арга хэмжээ авч ажилласан зөрчлийн хэрэг материалын сүүлийн 6 жилийн бүртгэл судалгааг хөтөлж, дэлгэрэнгүй мэдээллийн сан үүсгэн Нийслэлийн прокурорын газар, Тээврийн прокурорын газарт тус тус хянуулж ажилласан.

Шуурхай ажиллагааны багийн үүрэг чиглэлийн дагуу Замын хөдөлгөөний удирдлагын төвийн Хөдөлгөөн зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, Тээврийн цагдаагийн алба хаагч нартай хамтран Энхтайваны өргөн чөлөөнд хөдөлгөөнд оролцож буй нийтийн тээврийн 2686 хэрэгслийг 1 дүгээр эгнээгээр чөлөөтэй нэвтрүүлэх зохицуулалт хийж, замын түгжрэлээс шалтгаалан нийтийн тээврийн 12 хэрэгслийг богино эргэлт хийлгэж, зохицуулалт хийсэн.

Автотээврийн хяналтын улсын байцаагч, шалгагч нар шугам замын хяналтаар нийтийн тээврийн чиглэлийн автобусны зогсоолд түр болон удаан зогсож буй 3363 тээврийн хэрэгслийг чөлөөлж, чиглэлийн автобусны зогсоол дээр удаан зогссон 2298 тээврийн хэрэгслийн зөрчлийг илрүүлж E-police апп-р илгээж, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний 76 автомашин шалгаж, мэргэшсэн жолоочийн үнэмлэхгүй, цагийн хуваарь зөрчсөн, зөвшөөрлийн хугацаа дууссан зэрэг 39 зөрчил илрүүлж зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу арга хэмжээг авч ажилласан.

Дээрх ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний зорчигч урсгал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4%-иар өссөн. М:1 “5 шар-Офицеруудын ордон” чиглэлийн үндсэн үзүүлэлт болох ашиглалтын хурд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20%-иар өссөн үр дүн үзүүлсэн байна.



*Зураг №132. Нэгдүгээр эгнээ чөлөөлөх ажлын хүрээнд хийсэн ажил.*

Ажиллах хугацаандаа зогсоолын бус газар зогсож зорчигч суулгаж буулгасан зөрчил гаргасан нийтийн тээврийн 7 жолоочид Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйл 9 дэх хэсэгт зааснаар нийт 75,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, замналын зогсоолд байрлуулсан суудлын тээврийн хэрэгслүүдийн эзэмшигчтэй холбогдож зогсоол чөлөөлөхийг мэдэгдэж, утасны дугаараа үлдээгээгүй 9 тээврийн хэрэгслийг ачилтын машинаар ачуулсан.

### 5.16.Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, ачаа тээврийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулна. Дүрмийн 4.1.4.4

Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар, Гэрэгэ киоск ХХК-тай хамтран “Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем”-ийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хоёр үе шаттайгаар хөгжүүлэлт хийгдэн хэрэглээнд нэвтрүүлээд байна.

1.Иргэн хуулийн этгээдэд хүндрэл чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор “Тайлан”, “ЕС”, “ТҮР” замын хуудас олгох үйлчилгээг “Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем”-ээр дамжуулан нэг цонхноос авах боломжийг бүрдүүлэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

2.Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлангийн мэдээлэлд үндэслэн ачаа тээвэрлэлтийн нэгдсэн цахим мэдээллийн сан үүсгэх боломж бүрдсэн.

Үүнд:
Тээврийн хэрэгслээр ангилах;
Ачаа үүсэх, шингэх цэг;
Тээвэрлэсэн ачааны төрөл;
Тээвэрлэлт хийх давтамж;
Туулсан зайн мэдээлэл /км/

Тээвэрлэсэн ачаа эргэлт /тонн/
Иргэн, ААНБ-ын мэдээлэл;
Зөрчлийн төрлөөр ангилах;
Он оноор хадгаламжийн архив үүсгэх;

Нийт 9 дэд бүлгийн 30-40 гаруй мэдээлэл дэлгэрэнгүйгээр гарах, мөн тоон динамик үзүүлэлтүүд диаграмм, график загварчлалаар, хүснэгтэн мэдээлэл microsoft excel рүү хуулбарлан холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжтой байхаар хөгжүүлэлт хийгдэн хэрэгжүүлэх шатандаа ажиллаж байна.

“ЕС”, “ТҮР” замын хуудсыг “Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем” цахимаар авах нөхцөл бүрдсэнээр зарцуулах хугацаа өмнөх онуудтай харьцуулахад 1-2 өдөр зарцуулж байсан бол 45 минутад гурван үйлчилгээг нэг цонхноос зэрэг авах боломж бүрдсэн.

“Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨҮГ, Тээврийн цагдаагийн албатай хамтран баталсан “Нийслэл Улаанбаатар хотод тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад хамтран үзлэг, шалгалт зохион байгуулах ажлын удирдамж”-ийн дагуу Нийслэл хотын дотор тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих хууль тогтоомж, стандарт шаардлага хангаж байгаа эсэхэд хамтарсан хяналт, шалгалтыг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрүүдэд хийж, 16 аж ахуйн нэгж, байгууллагын 96 тээврийн хэрэгсэл, 86 жолооч хамруулсан.

Шалгалтаар 13 аж ахуйн нэгж байгууллага тээвэрлэлтийн ажил, үйлчилгээнд тухайн ангиллаар мэргэшээгүй 36 жолоочийг ажиллуулсан, 16 аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгслүүдийн өнгө, үзэмж муу, техникийн хувьд урд гэрэл, оврын гэрэл, ухрахын гэрэл, тоормосны гэрэл бүрэн бус гэх 185 зөрчил илэрсэн.

Тээвэрлэлтийн ажил, үйлчилгээнд тухайн ангиллаар мэргэшээгүй 36 жолоочийг ажиллуулсан 13 аж ахуйн нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.1-д заасныг үндэслэн тус бүр 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан.

### 5.17. Газар нь хариуцсан чиг үүргийн хүрээнд Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, чиг үүргийн удирдлагаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу ажиллана. Дүрмийн 6.5

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан 2025 оны хариуцлагын гэрээний хэрэгжилт, түүний хавсралт болох байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/01/1294 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.



НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

2025.06.06 № 01/01/1294

танай 2025.06.05 -ны № 03-3688 -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.АМГАЛАН ТАНАА

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын удирдлагатай байгуулах хариуцлагын гэрээний биелэлт, гүйцэтгэлийн биелэлт, хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг эхний хагас жилийн байдлаар гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 65 хуудастай.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Даваанямын ОТГОНЖАРГАЛ
2025.06.06 16:04



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугаар сарын 03 — Улаанбаатар хот

| № | Гэрээгээр хүлээсэн үүрэг | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Хувь |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | 2.1.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах. | [illegible] | 85 |
| 2 | 2.1.2.Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2025 онд хамтран ажиллах гэрээнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангах, гэрээнд заасан хугацаанд тайлагнах. | [illegible] | 85 |
| 3 | [illegible] | [illegible] | 100 |

*Зураг №133. гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/01/1294 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн байдал*

### 5.18. Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, дүрэм, журам баталж мөрдүүлнэ. Дүрмийн 7.1.1

Газрын даргын тушаал шийдвэр:




-А тушаал-126:

Хөрөнгө бүртгэж өр авлагыг данс бүртгэлд тусгах тухай-1, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэл нээх тухай-9, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлд өөрчлөлт оруулах тухай-17, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийн замналд, зогсоол нэмэх тухай-8, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийн замналд, зогсоолын нэршил солих тухай-1, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэлийн замналд, зогсоол хасах тухай-1, Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чиглэл хаах тухай-2, Сургуулийн автобусны чиглэлд өөрчлөлт оруулах тухай-3, Сургуулийн автобусны шинэ чиглэл нээх тухай -2, Томилолтоор ажиллуулах тухай-7, Авто үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд ангилал тогтоож гэрчилгээ олгох тухай-13, Хэвлэмэл хуудас хүчингүй болгох тухай-1, Ажлын хэсэг байгуулах тухай-17, Ёс зүйн дэд хороо шинэчлэн батлах тухай-1, Ёс зүйн дэд хорооны нарын бичгийн дарга томилох тухай-1, Ёс зүйн дэд хорооны гишүүнийг нөхөн томилох тухай-1, Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай-1, Техникийн тодорхойлолт боловсруулах тухай-2, Үнэлгээний хороо байгуулах тухай-7, Нэр бүхий албан хаагчдыг сургалтад хамруулах тухай-1, Ээлжийн амралтын хуваарь батлах тухай-2, Хөрөнгө бүртгэх тухай-1, Хөдөлмөрийн хэм хэмжээ батлах тухай-1, Спортын хамтлагийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай-1, Автотээврийн салбарын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд явган аялал зохион байгуулах тухай-1, Нийслэлийн алслагдсан дүүргүүдэд техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай-1, Спортын арга хэмжээ зохион байгуулах тухай-1, Зардал гаргах тухай-3, Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай-2, Эргүүл жижүүр ажиллуулах тухай-2, Хавар, намрын ээлжит техникийн хяналтын үзлэг зохион байгуулах тухай-2, үндсэн ба эргэлтийн хөрөнгийн хагас жилийн тооллогын ажил зохион байгуулах тухай-1, ЕС түр замын хуудасны загвар шинэчлэн батлах тухай-1, Шуурхай ажиллагааны баг байгуулах тухай -1, журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай-1, Эргэлтийн хөрөнгө устгах , данс бүртгэлээс хасах тухай-1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл-1, Орон тооны бус байнгын комиссыг шинэчлэн байгуулах тухай-1, Жагсаалт загвар батлах тухай-1, Тушаал хүчингүй болгох тухай-1, Хөрөнгө гаргах тухай-1, Хөрөнгө бүртгэх тухай-1, Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого зарцуулах тухай-1 тушаалыг крилл болон Монгол бичгээр хэвлэмэл хуудсанд буулгасан

-Б тушаал-202:

Ахмадын бүртгэлд авах тухай-1, Чөлөө буцалтгүй тусламж олгох тухай-13, Цалинтай чөлөө олгох тухай-5, тэтгэмж олгох тухай-10, Ажилд томилох тухай-56, Ажлаас чөлөөлөх тухай-46, Чөлөө олгох тухай-33, Албан хаагчдын цалингийн хэмжээ шинэчлэн батлах тухай-1, Албан хаагчдыг үргэлжлүүлэн ажиллуулах тухай-3, Ур чадварын нэмэгдэл олгох тухай-11, Ажил үүргийг хавсран гүйцэтгэх нэмэгдэл олгох тухай-7, зардал гаргах тухай-1, Сахилгын шийтгэл ногдуулах тухай-2, Сахилгын шийтгэлгүйд тооцох тухай-3, Хүүхэд асрах чөлөө дуусаж үргэлжлүүлэн ажиллуулах тухай-1, Зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай-2. Төрийн албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох тухай-1, Шилжүүлэн ажиллуулах тухай-1, жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай-1, хүүхэд асрах чөлөө дуусгавар

болгох тухай-1, Хүүхэд асрах чөлөө олгох тухай-2, тушаал хүчингүй болгох тухай-1 тушаалыг крилл болон Монгол бичгээр хэвлэмэл хуудсанд буулгасан.

2025 оны 562 хуудас 336 тушаалыг сканердаж цахим файл үүсгэсэн.

*2024 оны тушаалыг 2025 оны мөн үетэй харьцуулбал*

*Хүснэгт 42.*

| Д/Д | | 2024 он | 2025 он |
|---|---|---|---|
| 1 | А | 148 | 126 |
| 2 | Б | 240 | 202 |







### 5.19. Батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд холбогдох хууль журмын дагуу ажилтнуудыг томилох, чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулна. Дүрмийн 7.1.2

2025 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн чиглэлээр Б/202 тушаалыг холбогдох хууль, журам, дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

Ахмадын бүртгэлд авах тухай-1, Чөлөө буцалтгүй тусламж олгох тухай-13, Цалинтай чөлөө олгох тухай-5, тэтгэмж олгох тухай-10, Ажилд томилох тухай-56, Ажлаас чөлөөлөх тухай-46, Чөлөө олгох тухай-33, Албан хаагчдын цалингийн хэмжээ шинэчлэн батлах тухай-1, Албан хаагчдыг үргэлжлүүлэн ажиллуулах тухай-3, Ур чадварын нэмэгдэл олгох тухай-11, Ажил үүргийг хавсран гүйцэтгэх нэмэгдэл олгох тухай-7, зардал гаргах тухай-1, Сахилгын шийтгэл ногдуулах тухай-2, Сахилгын шийтгэлгүйд тооцох тухай-3, Хүүхэд асрах чөлөө дуусаж үргэлжлүүлэн ажиллуулах тухай-1, Зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай-2. Төрийн албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох тухай-1, Шилжүүлэн ажиллуулах тухай-1, жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай-1, хүүхэд асрах чөлөө дуусгавар

болгох тухай-1, Хүүхэд асрах чөлөө олгох тухай-2, тушаал хүчингүй болгох тухай-1 тушаалыг крилл болон Монгол бичгээр хэвлэмэл хуудсанд буулгасан.

### 5.20. Хэлтэс /нэгж/-ийн дарга, төрийн захиргааны албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Дүрмийн 7.1.3

Нийтийн тээврийн бодлогын газрын төрийн захиргааны 29 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, шинээр томилогдсон төрийн үйлчилгээний 50 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.



*Зураг №134. Албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулсан байдал*

### 5.21. Сахилга, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. Дүрмийн 7.1.4

Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Нийслэлийн төр, захиргааны байгууллагын ажлын цагийн хуваарь зохицуулалт хийх тухай” А/630 дугаар захирамжийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд ажлын цаг 07:00-16:00 цаг, 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 08:00-17:00 цаг байхаар тогтоосны дагуу байгууллагын албан хаагчдад танилцуулж, “ERP” цахим системд ажлын цагийн өөрчлөлт оруулан цаг ашиглалтад хяналт тавьж ажиллаж байна.



*Зураг №138. Албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулсан байдал*

Прокурорын байгууллага, Зам тээврийн яам, бусад хууль хяналтын байгууллагаас тус газарт ирүүлсэн шаардлага, мэдэгдэл нэг бүрийг судалж хууль ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоон тухай бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.

### 5.22. Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд мэргэшүүлэх багц сургалт болон холбогдох сургалтад албан хаагчдыг хамруулна. Дүрмийн 7.1.5

Удирдлагын академийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагчийг хамруулж, газрын даргын 2025 оны Б/73 дугаар тушаалын дагуу 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл долоо хоног бүрийн ажлын 1 өдөр чөлөө олгож сурах нөхцөлийг бүрдүүлсэн.

Удирдлагын академийн төрийн захиргааны мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2 албан хаагч хамрагдаж, 1 албан хаагч Удирдлагын академийн захирлын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/141 тоот тушаалаар R2790 сертификатыг аваад байна. Хугацаа болоогүй 1 албан хаагчийн байна.

Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс зохион байгуулагдах сургалтад төлөвлөгөөний дагуу 50 албан хаагч, Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”, Засгийн газрын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Архивын газар Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр “Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх” сэдэвт сургалтад 10 албан хаагчийг хамруулсан байна.

Удирдлагын академийн төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч хамрагдаж Удирдлагын академийн захирлын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/387 тоот тушаалаар Е1555 сертификатыг авсан.

Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III” Засгийн газрын 2022 оны 07дугаар тогтоолоор батлагдсан “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хэлтсийн албан хаагчид 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 02 дугаар сарын 14 хүртэл хугацаанд дунд шатны 12 удаагийн 30 цагийн сургалтад хаагч танхимаар хамрагдаж “Гэрчилгээ” авч өдөр тутмын албан бичиг хос бичгээр боловсруулан явуулж хэвшсэн. Амжилттай суралцсан 90 албан хаагчдаас 88 албан хаагчид Нийслэлийн Боловсролын газраас сертификат олгосон.




*Зураг №135. .ХАБЭА-н чиглэлээр хийгдсэн ажлын тойм мэдээлэл*

### 5.23. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Дүрмийн 7.1.11

#### 5.23.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны хэрэгжилт

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, баримт бичгийн эмх цэгц бүрдэл, хадгалалт ашиглалтыг сайжруулах, стандартыг дагаж мөрдүүлэх зорилгоор үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, баримт бичгийн эмх цэгц бүрдэл, хадгалалт ашиглалтыг сайжруулах зорилгоор үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.




#### 5.23.2. Архив, албан хэрэг хөтлөлтөд мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн дүрэм, журмын хэрэгжилтийн талаар;

Архив, албан хэрэг хөтлөлтөд мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн дүрэм, журмын хэрэгжилтийн талаар;

-MNS 5140:2021 Монгол Улсын стандарт "Албан хэрэг хөтлөлт"

-2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Монгол улсын Засгийн газрын 246 тогтоол "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-г,

-2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/111 захирамж "Албан хэрэг хөтлөлтийн eDoc систем ашиглах журам батлах тухай",

-Монгол улсын засгийн газрын 2021 оны 226 Тогтоол "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 222 дугаар тушаал "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам,

-Архивын ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/91 тушаал "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай"

-2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Монгол улсын Засгийн газрын 214 тогтоол “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-г,

-2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/52 “Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”-г erp.ulaanbaatar.mn/ байршуулан албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.

### 5.23.3. Дээд газраас ирсэн захирамж, тогтоол, албан даалгавар, тушаал:

Дээд газраас ирсэн захирамж, тогтоол, албан даалгавар, тушаалуудыг тухай бүр бүртгэн авч удирдлагад танилцуулан ажиллаж байна. 2025 онд жилийн байдлаар нийт 63 Монгол улсын засгийн газрын Тогтоол-2, Монгол улсын ерөнхий сайдын албан даалгавар-3, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн тогтоол-8, Нийслэлийн Засаг даргын захирамж-41, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл-4, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт шинжилгээний зөвлөмж-2, Зам тээврийн сайдын тушаал-1, Зам тээврийн яамны улсын ахлах байцаагчийн зөвлөмж-1, Нийслэлийн архивын газрын Албан шаардлага-1, Нийслэлийн архивын газрын зөвлөмж-1, Нийслэлийн прокурорын газрын прокурорын шаардлага-1, ирснийг тус тус бүртгэн зохион байгуулалтын нэгжүүдэд хувилж тараан мэдээллийн шуурхай байдлыг хангаж ажиллаж байна.

-2025 оны 65 тогтоол захирамжийг газрын даргад танилцуулан 474 хуудас

65 тогтоол, захирамжийг сканердаж цахим файл үүсгэсэн.




### 5.23.4.Дээд, болон бусад байгууллагуудаас ирсэн албан бичиг шийдвэрлэлтийн талаар:

Тус газарт 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дээд, болон бусад байгууллагуудаас нийт 4407 албан бичиг ирснээс Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 36 бичиг, байгууллагаар бүртгэгдсэн 274 албан бичиг, хариутай 299 албан бичиг , хариугүй 4108 албан бичиг хүлээн авч газрын дарга болон холбогдох албан тушаалтанд танилцуулж, хүлээлгэн өгч хяналт тавьж ажилласнаас хугацаандаа шийдвэрлэгдсэн 4230, шийдвэрлэлтийн шатандаа 106, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн 71, Зөрчил тооцогдсон 119 албан бичиг, байгууллагын хэмжээнд ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн дүн 95,31%, Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 4,55-тай байна. Байгууллагад ирсэн 824 хуудас 172 албан бичгийг сканердаж программд шивж даргад шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллав.

Байгууллагад ирсэн 4407 бичгийг хэлтсээр нь авч үзэхэд:

-Удирдлага 1 албан бичиг 100% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 0;

-Захиргаа удирдлагын хэлтэс 421 албан бичиг 95,2% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 3,99;

-Санхүү аж ахуйн хэлтэс 342 албан бичиг 85,9% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 6,02;

-Тээврийн бодлого судалгааны хэлтэс 436 албан бичиг 94,9% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 12,47;

-Зорчигч тээврийн хэлтэс 2467 албан бичиг 98,4% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 2,76;

-Хяналт шалгалтын хэлтэс 143 албан бичиг 99,12% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 10,31;

-Ачаа тээвэр авто үйлчилгээний хэлтэс 87 албан бичиг 99,73%, Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 4,8;

-Бүртгэл, техник технологийн хэлтэс 345 албан бичиг 95% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 3,74 ;

Хуулийн хэлтэс 165 албан бичиг 97,04% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 5,33 ;

Нийт 4407 албан бичиг 95,31% Шийдвэрлэлтийн дундаж хугацаа (хоногоор) 4,55;

2025 оны 01 дүгээр сард албан бичигт зөрчил тооцогдсон 5 хэлтсийн 13 албан хаагч 23 зөрчил (Явцын тэмдэглэл хөтлөөгүй – 11, Харилцагч байгууллагын нэр буруу сонгосон-3, Албан бичгийн шийдвэрлэх хугацааг программд буруу сонгосон-2, Ирсэн бичгийн шийдвэрлэлт хангалтгүй шийдвэрлэж цуцлагдсан-6 Монгол бичгээр хөрвүүлээгүй –1 тооцогдсон тул зөрчил арилгах мэдэгдэл өгсөн.

2025 оны 02 дугаар сард албан бичигт зөрчил тооцогдсон 6 хэлтсийн 11 албан хаагч 14 зөрчил (Монгол бичгээр хөрвүүлээгүй – 4, Явцын тэмдэглэл хөтлөөгүй – 8, Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-2) программд тооцогдсон тул зөрчил арилгах мэдэгдэл өгсөн.

2025 оны 03 дугаар сард албан бичигт зөрчил тооцогдсон 5 хэлтсийн 6 албан хаагч 7 зөрчил (Явцын тэмдэглэл хөтлөөгүй – 5, Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-1, Хугацаа хэтэрч шилжүүлсэн-1) программд тооцогдсон тул зөрчил арилгах мэдэгдэл өгсөн.

2025 оны 04 дүгээр сард албан бичигт зөрчил тооцогдсон 3 хэлтсийн 5 албан хаагч 5 зөрчил (Явцын тэмдэглэл хөтлөөгүй – 3, Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-2) программд тооцогдсон тул зөрчил арилгах мэдэгдэл өгсөн.

2025 оны 05 дугаар сард албан бичигт зөрчил тооцогдсон 5 хэлтсийн 13 албан хаагч 30 зөрчил (Явцын тэмдэглэл хөтлөөгүй – 3, Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-2)

2025 оны 06 дугаар сард албан бичигт зөрчил тооцогдсон 3 хэлтсийн 6 албан хаагч 6 зөрчил (Явцын тэмдэглэл хөтлөөгүй – 4, Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-2)

2025 оны 07 дугаар сард албан бичигт зөрчил тооцогдсон 2 хэлтсийн 4 албан хаагч 4 зөрчил (Явцын тэмдэглэл хөтлөөгүй – 1, Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн-3)

программд тооцогдсон тул зөрчил арилгах мэдэгдэл өгсөн.

Нийт 2025 оны албан бичигт зөрчил тооцогдсон 8 хэлтсийн 50 албан хаагч (давхардсан тоогоор) 92 зөрчил тооцогдсон тул зөрчил арилгах мэдэгдэл өгсөн.

Албан хэрэг хөтлөлтийн edoc.ulaanbaatar.mn программаар ирсэн байгууллагын нэр буруу-8, Албан бичиггүй-1, үг үсгийн алдаатай-1, хавсралт файл стандартын шаардлага хангахгүй-10, Гарын үсэг тамга тэмдэггүй-1, шийдвэрлэх хугацаагүй ирсэн-5, Монгол бичиггүй ирсэн 4 албан бичиг ирснийг буцаасан. 22 албан бичгийн шийдвэрлэх хугацааг сунгуулсан.

Программаар ирсэн 9 бичгийг шийдвэрлэсэн.

## Ирсэн албан бичгийг хэлтэс тус бүрээр илэрхийлж үзүүлбэл:




**2024 оны ирсэн албан бичгийг**
**2025 оны мөн үетэй харьцуулбал:**

*Хүснэгт 43*

| Д/Д | 2024 | 2025 он | тоо |
|---|---|---|---|
| 1 | 4541 | 4407 | -134 |




**Ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг алба, хэлтсүүдийн дүнгээр үзүүлбэл:**

| № | Зохион байгуулалтын нэгж | Нийт ирсэн бичгийн тоо | Хариугүй | Хариутай | Хугацаандаа шийдвэрлэгсэн бичгийн тоо | Шийдвэрлэх шатандаа байгаа бичгийн тоо | Хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн бичгийн тоо | Хугацаа хэтэрсэн, огт шийдвэрлэгдээгүй бичгийн тоо | Шийдвэрлэлтийн дундаж хугацаа /хоногоор/ | Нийт ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Удирдлага | 1 | 0 | 1 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 100% |
| 2 | Захиргаа удирдлага хэлтэс | 421 | 327 | 94 | 370 | 36 | 15 | 0 | 3,99 | 95,2% |
| 3 | Тээврийн бодлого судалгааны хэстэс | 436 | 377 | 59 | 409 | 10 | 17 | 0 | 12,5 | 94,9% |
| 4 | Зорчигч тээврийн хэлтэс | 2467 | 2415 | 52 | 2423 | 42 | 2 | 0 | 2,76 | 98,4% |
| 5 | Хяналт шалгалтын хэлтэс | 143 | 136 | 7 | 131 | 0 | 12 | 0 | 10,31 | 99,1% |
| 6 | Бүртгэл, Техник технологийн хэлтэс | 345 | 329 | 16 | 342 | 1 | 2 | 0 | 3,74 | 95% |
| 7 | Ачаа тээвэр авто үйлчилгээний хэлтэс | 87 | 76 | 11 | 82 | 3 | 2 | 0 | 4,8 | 99,7% |
| 8 | Санхүү, аж ахуйн хэлтэс хэлтэс | 342 | 312 | 30 | 317 | 6 | 19 | 0 | 6,02 | 85,9% |
| 9 | Хуулийн хэлтэс | 165 | 136 | 29 | 155 | 8 | 2 | 0 | 5,33 | 97,04 |
| | Байгууллагын дүн | 4407 | 4108 | 299 | 4230 | 106 | 71 | 0 | 4,55 | 95,3% |

*Хүснэгт 44*

### 5.23.5.Ирсэн бичгийн шийдвэрлэлтэд хяналт хийсэн талаар:

www.edoc.ub.gov.mn цахим программаар ирсэн бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Хяналтаар нийт 4039 албан бичигт хяналт хийснээс дахин хянасан-50, Үг

үсгийн алдаатай-5, хангалтгүй шийдвэрлэсэн-74 нийт-50 албан бичгийн шийдвэрлэлтийг цуцлан дахин шийдвэрлүүлэв.

*График 30*




**Ирсэн бичигт хийсэн хяналтын харьцуулалт**

*Хүснэгт 45*

| Д/Д | 2024 он | 2025 он | тоо |
|---|---|---|---|
| 1 | 3603 | 4039 | 436 |

*График 31*




5.23.6. Гадны байгууллагад явуулсан бичиг:

Гаднын байгууллагад явсан 2497 (крилл), 2497 (Монгол бичиг) албан бичгийн хэвлэмэл хуудсанд буулгасан.

Гаднын байгууллагад явуулсан 2497 албан бичгийг Монгол бичгээр хэвлэмэл хуудсанд буулгаж сканердаж программд шивж оруулан программаар илгээсэн.

Гаднын байгууллагад явуулсан албан бичгийг тоон гарын үсэг зурж баталгаажсаны дараа тус байгууллагуудад цаг тухайд нь илгээж ажилласан.

Гаднын байгууллагад явуулсан 156 албан бичигт бүртгэл үйлдэн хаяглаж шуудангаар хүргүүлэн ажиллаж байна.

**2024 оны явсан албан бичгийг**
**2025 оны мөн үетэй харьцуулбал:**

*Хүснэгт 46*

| Д/Д | 2024 он | 2024 он | тоо |
|---|---|---|---|
| 1 | 3072 | 2497 | -575 |

*График 32*




**2025 оны жилийн тогтоол, захирамж, ирсэн,**
**явсан албан бичиг**




**2025 оны байгууллагын баримт бичгийн эргэлтийн хэмжээг тооцоолбол**

*Хүснэгт 47*

| Баримт бичиг | Баримт бичгийн тоо | | Нийт |
|---|---|---|---|
| | Эх хувь | Олшруулсан хувь | |
| 1 | 2 | 3 | 4 |
| Дээд газраас ирсэн захирамж | 63 | 126 | 189 |

| | | | |
|---|---|---|---|
| Албан даалгавар (крилл) | 1 | 2 | 3 |
| Албан даалгавар (Монгол бичиг) | 1 | 2 | 3 |
| Тушаал (крилл) | 328 | 656 | 984 |
| Тушаал (монгол бичиг) | 328 | 656 | 984 |
| Ирсэн баримт бичиг | 4407 | 8814 | 13221 |
| Явуулсан баримт бичиг(крилл) | 2497 | 4994 | 7491 |
| Явуулсан баримт бичиг(монгол бичиг) | 2497 | 4994 | 7491 |
| Бүгд | 10122 | 20244 | 30366 |

### 5.23.7. Байгууллагын хэвлэмэл хуудас ашиглалтын талаар:

Нийслэлийн архивын газраар хянуулан https://edoc.ulaanbaatar.mn/- системээр болон албан бичгээр А5-1000ш (крилл), А5-2500ш (монгол бичиг), А4-3500ш (крилл), А4-1500ш (монгол бичиг), Тушаал-400ш (крилл), Тушаал-1000ш (монгол бичиг), Албан даалгавар-100ш (монгол бичиг), Захиргааны зөвлөлийн хурлын тэмдэглэл-100ш (монгол бичиг), Албан шаардлага-400ш (крилл), тодорхойлолт-500 (крилл), тодорхойлолт-200 (монгол бичиг), захиалж хэвлүүлсэн.

Хэвлэмэл хуудасны бүртгэл хөтөлж, тооцоог тухай бүр гарган ажиллаж байна.

2024 оны хүчингүй болгосон хэвлэмэл хуудас А5-27ш, А4-56ш тушаал-114ш, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт-44ш, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлага-22ш, Нийт 243 хэвлэмэл хуудсыг 2025 оны 03 дугаар сарын 12-ны А/28 тушаалаар хүчингүй болгосон. Хүчингүй болгосон 243 хэвлэмэл хуудсыг устгалд оруулсан.

2025 оны хэвлэмэл хуудсыг ашиглалтад бэлтгэн, төрлөөр нь ялгаж дугаарлан ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж, бүртгэлийн тэмдэг дардсыг зааврын дагуу Тушаал, А4, А5 хэвлэмэл хуудасны бүртгэлийн тэмдэг дардсыг даран дугаарласан.

(А5-1-1016-1016Ш (крилл) , А5-1-1016-1016Ш (монгол бичиг), А4-1-2140-2140Ш (крилл), А4-1-2140-2140Ш (монгол бичиг) , Тушаал--1-617-617ш (крилл), Тушаал--1-617-617ш (монгол бичиг) Хэвлэмэл хуудасны бүртгэл хөтөлж ажилласан.

2025 оны хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээ

*Хүснэгт 48*

| Д/д | Хэвлэмэл хуудасны нэр төрөл | Зарцуулсан хэвлэмэл хуудасны тоо | Үүнээс хүчингүй болгосон хэвлэмэл хуудас | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | | тоо | индекс | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Тушаал (крил) | 617 | 21 | 03,04,35,36,43,44,76,77,86,87,92,125,132,133,216,<br>17,253,254,468, 469,575 | |
| 2 | Тушаал (Монгол бичиг) | 617 | 3 | 132,133,575 | |
| 3 | А4 (Крил) | 2140 | 31 | 44,351,352,406,407,420,421,424,425,446,447,460, 680,681,709,761,777,819,820,351,352, 1376,1377,1378, 1379, 1466,1467,1469,1477, 1511,1949, | |
| 4 | А4 (Монгол бичиг) | 2140 | 20 | 351,352,406,407,421,447,460,601,680,681, 709,761,777,819,820,1378,1379,1449,1502, 1949 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | А5 (крил) | 1016 | 15 | 264,284,449,481,518,617,628,629,753,754, 786,796,807,808,818, | |
| 6 | А5 (Монгол бичиг) | 1016 | 10 | 284,395,449,481,518,608,753,754,807,808 | |

5.23.8. Нөхөн бүрдүүлэлтийн талаар:

2025 оны эхний хагас жилд 2024 оны баримтыг эмхэлж цэгцлэх, үдэж хавтаслах, дотоод товьёг үйлдэх, баталгаа болон хадгаламжийн нэгжийн нүүр хуудас бичих зэрэг техник боловсруулалт хийж Явуулсан албан бичиг 177 боть, Ирсэн бичиг-14 боть, Дээд газраас ирсэн захирамж тогтоол-1, Дээд газраас ирсэн хурлын тэмдэглэл, тушаал-1, Бичиг хэргийн ажилтны тайлан-1, Төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт-1, бүртгэлийн дэвтэр-6, Ирсэн бичгийн бүртгэл хяналтын карт-3, ирсэн бичгийн шийдвэрлэлийн мэдээ-1 боть, А-тушаалын саналын хуудас 6 боть, Б.Тушаалын саналын хуудас 4 боть, Хэвлэмэл хуудасны ашиглалт зарцуулалтад хийсэн тооцоо-1 боть, Баримт бичгийн эргэлтийн мэдээ-1 боть нийт 217 боть баримт үдэж, хавтаслан хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивд нөхөн бүрдүүлэлт хийсэн.

**5.24. Тээвэрлэлт гүйцэтгэх шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулах сунгах, цуцлах, шаардлагатай мэдээ, мэдээллийг гаргуулна. /Санхүүжилтийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих/ Дүрмийн 7.1.12**

Улаанбаатар хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй байгуулах ажил гүйцэтгэх (нийтийн тээврийн үйлчилгээ) гэрээний төслийг эцэслэн боловсруулан тэдгээрээс 2 удаа саналыг авч тусгай зөвшөөрөлтэйгээр нийтийн зорчигч үйл ажиллагаа эрхлэгч 18 аж ахуйн нэгж байгууллагуудтай 5 жилийн хугацаатайгаар гэрээг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр, такси үйлчилгээ эрхлэгч 5 хуулийн этгээдтэй гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр байгуулан гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

**6.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэлд ЕС, ТҮР зөвшөөрлийг "Нийслэлийн ачаа тээвэрлэлтийн цахим систем" ашиглан цахимаар олгоно.**

Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэлт хийж буй ачааны төрлийн автомашинуудад "ЕС" зөвшөөрөл олгох ажлыг холбогдох стандарт, дүрэм, журмыг хангуулан зохион байгуулж ажилласан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа тээвэрлэх эрх бүхий "ЕС" зөвшөөрлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар "ЕС" замын хуудсыг 15106 тээврийн хэрэгсэлд олгосноос В ангиллын 7014, С ангиллын 7591, М ангиллын 13, СЕ ангиллын 488 тээврийн хэрэгсэлд тус тус олгож, төрийн санд 193.960.000 төгрөгийг төвлөрүүлсэн.

"ЕС" ЗАМЫН ХУУДАС АВСАН АВТОМАШИНЫ ТОО

/2025.01.01-2025.11.30/

*Хүснэгт 49.*

| Ангилал | Тээврийн хэрэгслийн Тоо | Орлого /мян.төг/ |
|---|---|---|
| **В ангилал** | 7014 | 70,140,000 |
| **С ангилал** | 7591 | 113,865,000 |
| **СЕ ангилал** | 488 | 9,760,000 |
| **М ангилал** | 13 | 195,000 |
| **Нийт** | **15106** | **193,960,000** |

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн "Журам батлах тухай" А/322 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд ачааны, түгээлт, хүргэлтийн үйлчилгээний автомашиныг хязгаарлалттайгаар оролцуулах, дэмжлэг үзүүлэх журам"-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах “Түр” зөвшөөрлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 5476 зөвшөөрөл олгосон. Үүнээс В ангиллын 1195, С ангиллын 4158, Е ангиллын 120, М ангиллын 3 тээврийн хэрэгсэлд олгож төрийн санд 897.383,500 төгрөг төвлөрүүлсэн.

"ТҮР" ЗАМЫН ХУУДАС АВСАН АВТОМАШИНЫ ТОО

/2025.01.01-2025.11.30/

*Хүснэгт 50.*

| д/д | Эзэмшигч | Хүлээн авч, олгосон | Орлого /мян.төг/ |
|---|---|---|---|
| | | **В ангилал** | |
| 1 | Байгууллага | 409 | 53,913,500 |
| 2 | Иргэн | 786 | 96,698,000 |
| | **Нийт дүн** | **1195** | **150,611,500** |
| | | **С ангилал** | |
| 3 | Байгууллага | 1360 | 259,541,000 |
| 4 | Иргэн | 2798 | 461,235,500 |
| | **Нийт дүн** | **4158** | **720,776,500** |
| | | **Е ангилал** | |
| 5 | Байгууллага | 20 | 4,306,000 |
| 6 | Иргэн | 100 | 21,392,500 |
| | **Нийт дүн** | **120** | **25,698,500** |
| | | **М ангилал** | |
| 7 | Байгууллага | 1 | 100,500 |
| 8 | Иргэн | 2 | 196,500 |
| | **Нийт дүн** | **3** | **297,000** |
| 9 | **ТҮР замын хуудас нийлбэр дүн** | **5476** | **897,383,500** |

**Хүрсэн үр дүн:** 2025 онд нийт 20582 тээврийн хэрэгсэлд “ЕС”, “ТҮР” замын хуудсыг олгож, 1.091,343,500 төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн.

### 6.2.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч болон авто үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад ангилал тогтоох, бүртгэх үйл ажиллагааг Нийслэлийн хэмжээнд зохион байгуулна.

Зам, тээвэр хөгжлийн сайдын 2022 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зөвлөн туслах, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулан ажиллаа.

Энэ онд хяналт, шалгалтын ажлыг холбогдох газруудтай хамтран 5 удаа зохион байгуулсан. Үүнд:

1.Нийслэлийн цагдаагийн удирдах газартай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ, их биеийн засварын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт, гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулах удирдамж”;

2.НЭМГ, дүүргүүдийн ЗДТГ, дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсүүдтэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр баталсан “Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийх тухай удирдамж удирдамж;

3.Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайгийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр баталсан ”Хоёрдогч түүхий эд авах, тос тосолгооны материал худалдаалах, авто засвар, авто угаалга, дугуй засварын газруудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай удирдамж”;

4.Нийтийн тээврийн бодлогын газрын дарга Чингэлтэй дүүргийн Засаг дарга нарын хамтран 2025 дугаар сарын 07-ны өдрийн баталсан "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамж;

5.Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, Байгаль орчны газрын дарга, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдийн Засаг даргатай хамтран 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан удирдамжийн дагуу "Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын удирдамж"-ийн дагуу тус тус зохион байгуулсан.

Нийт 668 иргэн, аж ахуй нэгж, байгууллагат хяналт шалгалт хийж, 11 иргэн, 8 аж ахуйн нэгж, байгууллагад 4,550.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Зөвлөн туслах, хяналт шалгалтын ажлын үр дүнд нийт 69 иргэн, 92 аж ахуйн нэгж, байгууллага ангиллаа тогтоолгосон.

**Хүрсэн үр дүн:** Нийт 628 иргэн, аж ахуй нэгж, байгууллагат хяналт шалгалт хийж, 11 иргэн, 8 аж ахуйн нэгж, байгууллагад 4,550,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, нийт 161 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ангилал тогтоолгож, гэрчилгээ авсан.


БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА

БАТЛАВ

БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.ЦЭРЭН

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр | Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Хоёр. Хамрах хүрээ

Гурав. Бүрэлдэхүүн, хугацаа


Дөрөв. Хийгдэх ажил

Тав. Хүрэх үр дүн

Зураг №136. Хяналт, шалгалтын ажлын удирдамж



Зураг №137. Баянзүрх дүүргийн хяналт шалгалтын явцаас




*Зураг №138. Баянгол дүүргийн хяналт шалгалтын явцаас*

## 2025 ОНД АВТО ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АНГИЛАЛ ТОГТООЛГОСОН ТООН ҮЗҮҮЛЭЛТ ДҮҮРГЭЭР

*Хүснэгт 51.*

| № | Дүүрэг | Нийт | ААНБ | Иргэн |
|---|---|---|---|---|
| 1 | Баянгол | 37 | 22 | 15 |
| 2 | Баянзүрх | 43 | 26 | 17 |
| 3 | Хан-Уул | 21 | 17 | 4 |
| 4 | Сонгинохайрхан | 37 | 19 | 18 |
| 5 | Чингэлтэй | 7 | 2 | 5 |
| 6 | Налайх | 1 | 0 | 1 |
| 7 | Сүхбаатар | 14 | 6 | 8 |
| 8 | Багахангай | 0 | 0 | 0 |
| 9 | Багануур | 1 | 0 | 1 |
| | Нийт | **161** | **92** | **69** |

# АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЛАЛ ТОГТООЛГОСОН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

*Хүснэгт 52.*

| № | Ажил үйлчилгээний төрөл | Нийт | ААНБ | Иргэн | Баянгол | Баянзүрх | Хан-Уул | Сонгинохайрхан | Чингэлтэй | Сүхбаатар | Багахангай | Багануур | Налайх |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Агрегат зангилаа механизмын оношлогоо, засвар | 62 | 46 | 16 | 11 | 21 | 9 | 10 | 4 | 7 | 0 | 0 | 0 |
| 2 | Техникийн үйлчилгээ | 70 | 49 | 21 | 12 | 25 | 9 | 11 | 4 | 9 | 0 | 0 | 0 |
| 3 | Хөдөлгүүрийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 73 | 55 | 18 | 12 | 25 | 11 | 10 | 4 | 11 | 0 | 0 | 0 |
| 4 | Түлшний систем засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 30 | 27 | 3 | 5 | 11 | 6 | 7 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| 5 | Ажилласан хий (утаа)-г зайлуулах систем, яндангийн дуу, чимээ намсгагч, ажилласан хийг гаргах систем (EGR), DFP, DOC, катализаторын хувиргагч гэх мэт оношлогоо, засвар, техникийн үйлчилгээ, тохиргоо, зүгшрүүлэлт | 10 | 10 | 0 | 1 | 2 | 3 | 2 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| 6 | Радиатор, хөргөлт, агааржуулалтын системийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 15 | 15 | 0 | 2 | 4 | 4 | 3 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| 7 | Хурдны хайрцаг, хүч дамжуулах ангийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар | 17 | 14 | 3 | 2 | 4 | 3 | 6 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| 8 | Жолооны механизм, явах ангийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 25 | 21 | 4 | 3 | 8 | 5 | 5 | 0 | 4 | 0 | 0 | 0 |
| 9 | Их биеийн засвар | 17 | 11 | 6 | 3 | 6 | 4 | 4 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 10 | Угаалга, цэвэрлэгээ үйлчилгээ | 44 | 22 | 22 | 7 | 11 | 7 | 15 | 0 | 3 | 0 | 1 | 0 |
| 11 | Цахилгаан систем, түүний тоноглол, хэрэгсэл болон цахилгаан хөдөлгүүрийн системийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт | 1 | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 12 | Резин дугуй засвар, дугуйн баланс тохируулга, зүгшрүүлэлт | 13 | 6 | 7 | 4 | 3 | 1 | 3 | 0 | 1 | 0 | 0 | 1 |
| 13 | Автомашины шил засварлах, суурилуулах үйлчилгээ | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 14 | Автотээврийн хэрэгсэл | 21 | 15 | 6 | 5 | 4 | 4 | 5 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| 15 | Автотээврийн хэрэгслийн сэлбэг, хэрэгсэл | 67 | 40 | 27 | 17 | 24 | 6 | 10 | 7 | 9 | 0 | 0 | 0 |
| 16 | Тос, тосолгооны болон ашиглалтын бусад материал | 72 | 47 | 25 | 17 | 20 | 8 | 10 | 6 | 11 | 0 | 0 | 0 |
| 17 | Оёдол доторлогоо үйлчилгээ | 4 | 4 | 0 | 2 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 18 | Тээврийн хэрэгслийн резин дугуй, обуд | 9 | 6 | 3 | 3 | 3 | 0 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 19 | Авто зогсоол | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 20 | Тээврийн хэрэгслийн агрегат зангилаа, эд анги, сэлбэг, хэрэгсэл хадгалах | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| | **Нийт** | **550** | **389** | **161** | **107** | **171** | **81** | **107** | **25** | **57** | **0** | **1** | **1** |

Хүрсэн үр дүн: Тайлант хугацаанд нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгч иргэн 69, аж ахуйн нэгж байгууллага 92 буюу нийт 161 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 550 ажил үйлчилгээнд ангилал тогтоон гэрээ байгуулан ажилласан.

Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэгч авто үйлчилгээний иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын нэгдсэн шинэчилсэн судалгааг гаргах;

Мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн бүртгэлтэй болох зорилгоор 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгааг шинэчлэн ирүүлэх талаар 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/04/520 дугаартай албан бичгийг хүргүүлж мэдээллийг нэгтгэн мэдээллийн санг баяжуулан ажилласан.



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Судалгаа ирүүлэх тухай

Тус газар нь Зам, тээврийн хөгжлийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны А/112 дугаартай тушаалаар батлагдсан "Авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох журам"-ын хэрэгжилтийг хангуулахаар нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудад ангилал тогтоох үйл ажиллагааг зохион байгуулан мэдээ тайланг хагас болон бүтэн жилээр Зам, тээврийн яаманд хүргүүлэн ажилладаг.

Иймд дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын судалгааг 2025 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн дотор албан бичгээр тус газарт ирүүлж хамтран ажиллана уу.

Хавсралт 1 хуудастай.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Даваанем ОТГОНЖАРГАЛ
2025 02 27 10:40

*Зураг №139. Дүүргүүдэд хүргүүлсэн албан бичиг*

## НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ АВТО ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛЖ БУЙ ИРГЭН, АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДЫН СУДАЛГАА 2025 ОН

*Хүснэгт 53.*

| № | ДҮҮРЭГ | АВТО ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИД | | | ТӨРӨЛ | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | НИЙТ | ААНБ | ИРГЭН | АГРЕГАТ | ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ | ДУГУЙ ЗАСВАР | ГАГНУУР | КУЗОВ ЗАСВАР | АВТО УГААЛГА | АВТОМАШИНЫ | АВТОМАШИН, СЭЛБЭГ | АВТО ЗОГСООЛ ИЛ | АВТО ЗОГСООЛ БИТҮ | НИЙТ ТӨРӨЛ |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| 1 | БАЯНЗҮРХ | 194 | 71 | 123 | 89 | 175 | 0 | 0 | 28 | 9 | 0 | 104 | 12 | 0 | 417 |
| 2 | СОНГИНО ХАЙРХАН | 331 | 77 | 254 | 86 | 10 | 76 | 1 | 36 | 101 | 7 | 73 | 2 | 1 | 393 |
| 3 | БАЯНГОЛ | 322 | 113 | 209 | 68 | 25 | 28 | 0 | 44 | 64 | 5 | 129 | 0 | 0 | 363 |
| 4 | ЧИНГЭЛТЭЙ | 147 | 27 | 120 | 111 | 75 | 18 | 0 | 39 | 20 | 4 | 74 | 21 | 0 | 362 |
| 5 | СҮХБААТАР | 150 | 48 | 102 | 78 | 58 | 15 | 0 | 25 | 30 | 1 | 87 | 15 | 0 | 309 |
| 6 | ХАН-УУЛ | 196 | 80 | 116 | 44 | 32 | 57 | 9 | 26 | 63 | 1 | 39 | 18 | 22 | 311 |
| 7 | БАГАНУУР | 26 | 2 | 24 | 9 | 8 | 10 | 4 | 4 | 6 | 1 | 15 | 10 | 10 | 77 |
| 8 | НАЛАЙХ | 25 | 5 | 20 | 1 | 5 | 13 | 0 | 0 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 24 |
| 9 | БАГАХАНГАЙ | 3 | 0 | 3 | 0 | 0 | 3 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 3 |
| | Нийт | | 423 | 971 | 486 | 388 | 220 | 14 | 202 | 298 | 19 | 521 | 78 | 33 | 2259 |
| | | | 1394 | | | | | | | | | | | | |

Хүрсэн үр дүн: Нэгдсэн судалгаагаар 2025 онд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт 1394 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс Хан уул дүүрэг 64.7 хувь, Сүхбаатар дүүрэг 19 хувь, Баянгол дүүрэг 14,5 хувиар тус тус өссөн, Баянзүрх дүүрэг 54 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үйлчилгээний нэр төрлөөр харьцуулбал Агрегат 50,9 хувь, Авто машины сэлбэг хэрэгсэл 37.8 хувиар тус тус өссөн, Гагнуур 71,4 хувь, Авто угаалга 6,5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Товч танилцуулахад:

Хан-Уул дүүрэг +64.7%,

Сүхбаатар дүүрэг + 19% хувиар тус тус өссөн,

Баянзүрх дүүрэг -54% буурсан үзүүлэлттэй байна.

Үйл ажиллагааны төрлөөр: Агрегат засвар 486, тос солих үйлчилгээ 388, гагнуур-14, дугуй засвар-220, кузов засвар 202, авто угаалга 298, автомашины оёдол доторлогоо 19, автомашин, сэлбэг хэрэгсэл, тос тосолгооны болон ашиглалтын худалдаа 521, авто зогсоол 78, битүү зогсоол 33 нийт 2259 төрлийн ажил үйлчилгээ үзүүлж байна.

Авто үйлчилгээ эрхлэгчдээс үүсэж буй авто тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэх шингэн болон хатуу хог хаягдлын нэгдсэн судалгааг гаргах;

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Авто үйлчилгээ эрхлэгчдийн ажил үйлчилгээнээс үүсэж буй энгийн болон аюултай хог хаягдлын төрөл, тоон хэмжээний мэдээллийг нэгтгэх, үүсэж буй хог хаягдлыг устгах, дахин боловсруулах саналуудад дүн шинжилгээ хийн ажилладаг.

Тус газраас 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 01/04/868 дугаартай хог хаягдлын судалгаа ирүүлэх тухай албан бичгийг 9 дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Уг судалгаанд 9 дүүргийн 816 авто үйлчилгээ эрхлэгчид хамрагдсан. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 01/04/1875 дугаартай албан бичгийг Баянгол, Баянзүрх, Чингэлтэй үүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Судалгаанд 9 дүүргийн 1158 иргэн, аж ахуй нэгж байгууллага оролцсон.


НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР

ДҮҮРГҮҮДИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Судалгаа ирүүлэх тухай

Тус газар нь Зам, тээврийн хөгжлийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны А/112 дугаартай тушаалаар батлагдсан "Авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох журам"-ын хэрэгжилтийг хангуулахаар нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ангилал тогтоох үйл ажиллагааг зохион байгуулан мэдээ тайлант хагас болон бүтэн жилээр Зам, тээврийн яаманд хүргүүлэн ажилладаг.

Иймд дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлын судалгааг 2025 оны 05 дугаар сарын 15-ны дотор албан бичгээр тус газарт ирүүлж хамтран ажиллана уу.

Хавсралт 1 хуудастай.

Нийслэлийн 9 дүүргийн хог хаягдлын судалгаа

| Д/д | Харьяа дүүрэг | Судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ | Хатуу хог хаягдал | | | | | | | | | Шингэн хог хаягдал | | | | | | Аюултай хог хаягдал | | Бохир ус /л/ | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шил /кг/ | төмөр /кг/ | хөнгөн цагааны хайлш /кг/ | гэрэл /ш/ | суудал /ш/ | цахилгааны утас /кг/ | хуванцар /кг/ | пилтэр уут /кг/ | хаягдал цаас /кг/ | Тоормосны шингэн /л/ | гидрийн шингэн /л/ | хөдөлгүүрийн ашиглагдсан тос /л/ | хурдны хайрцагны ашиглагдсан тос /л/ | хөргөлтийн шингэн /л/ | амортизаторын шингэн /л/ | Батарей /ш/ | Аккумлятор /ш/ | | |
| 1 | Баянзүрх | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Баянгол | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Сүхбаатар | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Сонгинохайрхан | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Багахангай | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Багануур | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 7 | Чингэлтэй | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 8 | Налайх | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 9 | Хан-Уул | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | Нийт | | | | | | | | | | | | | | | | | | | | |

*Зураг №140. Нийслэлийн 9 дүүргийн Хог хаягдлын судалгааг ирүүлэх албан бичиг*

Шинэчилсэн судалгаагаар 9 дүүргийн нийт 1394 авто үйлчилгээ эрхлэгчдийн 83.07% буюу 1158 иргэн, аж ахуйн нэгж байгууллага судалгаанд хамрагдсан. Үүнээс:

-Хатуу хог хаягдал-200324.6 /кг, ш/;

-Шингэн хог хаягдал-81224 /л/;

-Аюултай хог хаягдал-6965 /ш/;

-Бохир ус-1559980 /л/;

-Бусад хог хаягдал-111224 /кг.

**Нийслэлийн 9 дүүргийн хог хаягдлын судалгаа**

| Д/д | Харьяа дүүрэг | Судалгаанд хамрагдсан иргэн, ААНБ | Хатуу хог хаягдал | | | | | | | | | Шингэн хог хаягдал | | | | | | Аюултай хог хаягдал | | Бохир ус /л/ | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шил /кг/ | төмөр /кг/ | хөнгөн цагааны хаі /кг/ | гэрэл /ш/ | суудал /ш/ | цахилгааны утас /| | хуванцар /кг/ | гялгар уут /кг/ | хаягдал цаас /кг/ | тоормосны шингэн | гидрийн шингэн /л | хөдөлгүүрийн ашиглагдсан тос / | хурдны хайрцагнь ашиглагдсан тос / | хөргөлтийн шингэн | амортизаторын шингэн /л/ | Батарей /ш/ | Аккумлятор /ш/ | | |
| 1 | Баянзүрх | 50 | 3000 | 6000 | 2000 | 1200 | 20 | 200 | 600 | 100 | 400 | 60 | 20 | 200 | 40 | 0 | 0 | 200 | 15 | 10000 | 0 |
| 2 | Баянгол | 104 | 0 | 4300 | 5200 | 15970 | 24 | 4780 | 6754 | 2865 | 16570 | 250 | 1897 | 18510 | 7149 | 6510 | 0 | 1410 | 2100 | 145800 | 0 |
| 3 | Сүхбаатар | 114 | 6484 | 4375 | 2250 | 1911 | 578 | 1293 | 4085 | 5395 | 15841 | 693 | 3459 | 4706 | 697 | 1334 | 273 | 305 | 161 | 1285057 | 687 |
| 4 | Сонгинохайрхан | 327 | 8473 | 10269 | 9264 | 1715 | 1245 | 16667 | 12560 | 0 | 0 | 1453 | 1483 | 10247 | 5327 | 10278 | 15 | 1000 | 719 | 85000 | 106172 |
| 5 | Багахангай | 1 | 0 | 60 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 20 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 6 | Багануур | 14 | 70 | 655 | 73 | 65 | 148 | 315 | 425 | 34.5 | 152.5 | 0 | 33 | 419 | 108.5 | 76.1 | 5 | 220 | 58 | 25000 | 101.5 |
| 7 | Чингэлтэй | 81 | 560 | 9122 | 7112 | 218 | 96 | 12 | 283 | 14 | 40 | 0 | 60 | 0 | 0 | 0 | 86 | 0 | 0 | 1920 | 3000 |
| 8 | Налайх | 17 | 0 | 1900 | 0 | 0 | 40 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 450 | 0 | 150 | 0 | 0 | 3 | 15 | 0 |
| 9 | ХанУул | 110 | 544 | 2336 | 420 | 400 | 128 | 251 | 1301 | 486.5 | 675.5 | 452 | 194.4 | 1242 | 652 | 894 | 341 | 577 | 142 | 17158 | 1264 |
| | Нийт | 818 | 19131 | 39017 | 26319 | 21479 | 2279 | 23518 | 26008 | 8895 | 33679 | 2908 | 7146 | 35794 | 13974 | 19242 | 720 | 3712 | 3198 | 1569950 | 111224 |

*Зураг №141. Хог хаягдлын судалгаа*

### Арга хэмжээ 2.5. Холбогдох журмын дагуу “Авто үйлчилгээ”-ний талаарх статистик мэдээ тайланг хагас болон бүтэн жилээр гаргах;

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР
Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас/Факс: (976-11) 32 79 68
Цахим хуудас: www.transport.ub.gov.mn

2025.12.05 № 01/04/2538
танай -ны №-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Х.ОЮУНТУЯА ТАНАА

Зам, тээврийн яам, Нийтийн тээврийн бодлогын газартай "Авто үйлчилгээний чиглэлээр 2025 онд хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний биелэлт, тайлан, Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг тус тус гаргаж хавсралтаар хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

Хүндэтгэсэн,

Хавсралт 32 хуудастай.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Даваанян ОТГОНЖАРГАЛ
2025.12.05 08:43

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗАР
Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас/Факс: (976-11) 32 79 68
Цахим хуудас: www.transport.ub.gov.mn

2025.12.05 № 01/04/2537
танай -ны №-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА Э.МӨНХНАСАН ТАНАА

Зам, тээврийн яам, Нийтийн тээврийн бодлогын газартай "Авто үйлчилгээний чиглэлээр 2025 онд хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний биелэлт, тайлан, Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээ эрхлэгчдийн судалгааг тус тус гаргаж, хавсралтаар хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

Хүндэтгэсэн,

Хавсралт 32 хуудастай.

Нийтийн тээврийн бодлогын газар
Удирдлага
Дарга
Даваанян ОТГОНЖАРГАЛ
2025.12.05 08:36

*Зураг №142. Зам, тээврийн яаманд “Авто үйлчилгээ”-ний талаарх статистик мэдээ тайланг хүргүүлсэн албан бичиг*

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/88 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Авто үйлчилгээ”-ний талаарх статистик мэдээ тайланг Зам, тээврийн яамны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт, Зам, тээврийн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/04/1386, жилийн эцсийн байдлаар 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/04/2538 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний ангилал тогтоон, гэрээ байгуулан үйлчилгээ үзүүлж байгаа авто үйлчилгээ эрхлэгчдийн мэдээ /2025 он/

| | Иргэн | ААНБ | Авто үйлчилгээ эрхлэгчид. Бүгд | Техник оношилгоо, үйлчилгээ, засвар: Агрегат зангилаа механизмын оношилгоо, засвар – Иргэн | ААНБ | Техникийн үйлчилгээ – Иргэн | ААНБ | Хөдөлгүүрийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт – Иргэн | ААНБ | Түлшний систем засвар, тохиргоо, зүгшрүүлэлт – Иргэн | ААНБ | асаалтын системийн засвар, тохиргоо зүгшрүүлэлт – Иргэн | ААНБ | Ажиллагсан хий (утаа)-г зайлуулах систем, яндангийн дуу, чимээ намсгагч, ажиллаган хийг гаргах – Иргэн | ААНБ | Радиатор, хөргөлт, агааржуулалтын системийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо – Иргэн | ААНБ | Хурдны хайрцаг, хүч дамжуулах ангийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар – Иргэн | ААНБ | Жолооны механизм, явах ангийн оношлогоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт – Иргэн | ААНБ | Их биеийн засвар – Иргэн | ААНБ | Угаалга, цэвэрлэгээ үйлчилгээ – Иргэн | ААНБ | Цахилгаан систем, түүний тоноглол, хэрэгсэл болон цахилгаан хөдөлгүүрийн системийн оношлогоо – Иргэн | ААНБ | Резин дугуй засвар, дугуйн баланс тохируулга, зүгшрүүлэлт – Иргэн | ААНБ | Автомашины цэл засварлах, сэргээлүүлэх үйлчилгээ – Иргэн | ААНБ | Нийт – Иргэн | ААНБ | Автотээврийн хэрэгсэл түүний сэлбэг, хэрэгсэл, эд ангийн худалдаа: Автотээврийн хэрэгсэл – Иргэн | ААНБ | Автотээврийн хэрэгслийн сэлбэг, хэрэгсэл – Иргэн | ААНБ | Тос, тосолгооны болон ашиглалтын бусад материал – Иргэн | ААНБ | Өөдөл доторлогоо үйлчилгээ – Иргэн | ААНБ | Тээврийн хэрэгслийн резин дугуй, обуд – Иргэн | ААНБ | Нийт – Иргэн | ААНБ | Автотээврийн хэрэгсэл, түүний эд…: Авто зогсоол – Иргэн | ААНБ | Тээврийн хэрэгслийн агрегат зангилаа, эд анги, сэлбэг, хэрэгсэл хадгалах – Иргэн | ААНБ | Нийт – Иргэн | ААНБ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Баянгол | 6 | 11 | 17 | 1 | 7 | 2 | 7 | 2 | 6 | 0 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 1 | 0 | 2 | 0 | 0 | 2 | 1 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 0 | 7 | 32 | 0 | 3 | 3 | 9 | 2 | 8 | 0 | 1 | 0 | 0 | 5 | 21 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Баянзүрх | 5 | 8 | 13 | 2 | 6 | 2 | 7 | 1 | 7 | 1 | 6 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 1 | 0 | 1 | 1 | 0 | 0 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 10 | 31 | 0 | 3 | 1 | 5 | 1 | 5 | 0 | 1 | 0 | 1 | 2 | 15 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Багануур | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Сүхбаатар | 2 | 2 | 4 | 2 | 0 | 2 | 1 | 2 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 7 | 4 | 1 | 0 | 2 | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 5 | 4 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Сонгинохайрхан | 3 | 6 | 9 | 1 | 3 | 1 | 3 | 0 | 3 | 1 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 1 | 0 | 1 | 0 | 1 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 7 | 13 | 0 | 2 | 0 | 4 | 0 | 3 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 11 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Чингэлтэй | 3 | 0 | 3 | 2 | 0 | 2 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 6 | 0 | 0 | 0 | 3 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хан-Уул | 2 | 9 | 11 | 0 | 8 | 0 | 8 | 0 | 8 | 0 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 2 | 2 | 2 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 2 | 37 | 0 | 4 | 0 | 5 | 0 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 14 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Багахангай | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Налайх | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Нийт | 23 | 36 | 59 | 8 | 24 | 9 | 26 | 7 | 25 | 2 | 19 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 3 | 2 | 1 | 3 | 5 | 1 | 2 | 8 | 7 | 0 | 0 | 1 | 5 | 0 | 0 | 41 | 117 | 1 | 12 | 9 | 25 | 7 | 23 | 0 | 2 | 0 | 3 | 17 | 65 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

*Зураг №143. Статистик тайлан  мэдээ хүргүүлсэн байдал*

Арга хэмжээ 2.6. Өндөр технологийн цахим үйлчилгээг авто үйлчилгээний салбарт нэвтрүүлэх, авто үйлчилгээ эрхлэгчдийн чанар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

"Авто үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан"-гийн программ хангамжийг 2022 онд хэрэглээнд нэвтрүүлсэн боловч программ хангамж нь ашиглалтын шаардлага хангаагүй тул шинэчлэх зорилгоор шаардагдах хөрөнгийг Нийслэлийн 2026 оны төсөвт 100.000.000 төгрөгийг тусгахаар саналыг хүргүүлсэн.

Нийтийн тээврийн бодлогын газрын www.transport.ub.gov.mn цахим хуудасны "Авто үйлчилгээ" цэсэд 2025 онд ангилал тогтоолгосон 161 авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг байршуулсан.




*Зураг №144. Мэдээлэл байршуулсан байдал*

**Хүрсэн үр дүн:** Мөн www.autobox.mn сайтад нэвтрэх эрхээ авсан авто засварын үйлчилгээ эрхэлдэг 586 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өссөн дүнгээр 87684 тээврийн хэрэгсэлд хийгдсэн засвар, үйлчилгээний мэдээллийг тогтмол оруулж, бүртгэл үүсгэж буй эсэхэд хяналт тавин ажилласан.

**Арга хэмжээ 2.7. Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэгч авто үйлчилгээний аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Автотээврийн тухай хууль, дүрэм, журам, стандартын талаарх мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулах;**

Нийслэлийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдөх хууль, дүрэм, журам, стандартуудын талаар мэдээлэл олгох сургалтыг нийслэлийн 9 дүүрэгт 2025 онд нийт 9 удаа зохион байгуулсан.

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдөр баталсан "Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох хууль, дүрэм журам, стандартын талаар мэдлэг олгох сургалтын удирдамж"-ийн дагуу 2025 оны 09 дүгээр сарын 08-наас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Сургалтад Баянзүрх 30, Сүхбаатар 30, Хан-Уул 57, Баянгол 23, Чингэлтэй 31, Багануур 14, Багахангай 3, Налайх 4, Сонгинохайрхан 41 буюу нийт 9 дүүргийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 233 холбогдох албан хаагч хамрагдсан.

Арга хэмжээ 2.8. Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд "Зөвлөн туслах" үйлчилгээ үзүүлэх;

**Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд "Зөвлөн туслах" үйлчилгээ үзүүлэх;**



*Зураг №145. Баянзүрх дүүргийн авто үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж буй байдал*

Зам, тээвэр хөгжлийн сайдын 2022 оны А/112 дугаар тушаалаар баталсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам"-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зөвлөн туслах үйлчилгээг 2025 онд 3 удаа буюу 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 04 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэл, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр баталсан "Нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх" удирдамж, Нийслэлийн Багахангай, Налайх, Багануур дүүргүүдэд 10 дугаар сарын 23, 24, 29, 30-ны өдрүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж нийт 1084 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.




*Зураг №146. Баянгол дүүргийн авто үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж буй байдал*

2.Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт авто худалдаа, засвар, үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад авто үйлчилгээнд мөрдөх хууль, дүрэм, журам, стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөх туслах үйлчилгээ 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 2025 оны 04 сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан нийт 137 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан.




*Зураг №147. Баянзүрх дүүргийн авто үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж буй байдал*

3.Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт авто худалдаа, засвар, үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудад авто үйлчилгээнд мөрдөх хууль, дүрэм, журам, стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөх туслах үйлчилгээ 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 2025 оны 04 сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан нийт 97 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан.




*Зураг №148. Чингэлтэй дүүргийн авто үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж буй байдал*

4.Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт авто худалдаа, засвар, үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад авто үйлчилгээнд мөрдөх хууль, дүрэм, журам, стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөх туслах үйлчилгээ 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 2025 оны 04 сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан нийт 103 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан.



*Зураг №149. Сүхбаатар дүүргийн авто үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж буй байдал*

5.Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт авто худалдаа, засвар, үйлчилгээ эрхлэгч иргэн аж ахуйн нэгж байгууллагуудад авто үйлчилгээнд мөрдөх хууль, дүрэм, журам, стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөх туслах үйлчилгээ 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 2025 оны 04 сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсан нийт 50 иргэн, аж ахуй нэгж байгууллага хамрагдсан.




*Зураг №150. Хан-Уул дүүргийн авто үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж буй байдал*

Нийт 765 иргэн, 319 аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, “Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид зориулсан хууль, эрх зүйн эмхэтгэл”, “Авто үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан гарын авлага” тарааж, үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэл хийн ажилласан.

**Хүрсэн үр дүн:** Нийт 9 дүүргийн 1394 авто үйлчилгээ эрхлэгчээс 1084 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, 77%-д зөвлөн туслах үйлчилгээг үзүүлээд байна.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:

### 7.1.Автотээврийн салбарын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд:

Монгол Улсад авто тээврийн салбар үүссэний 100 жил, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Бид нийтийн тээврийнхэн” эмэгтэй жолооч нарын уулзалт өдөрлөгийг зохион байгуулсан.

Автотээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жил, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Нийтийн тээврийн салбарт ажилладаг эмэгтэй жолооч нарт урам зориг өгөх, мэргэжил нэгт эмэгтэйчүүдтэй танилцах, ажлаараа бахархах сэтгэл төрүүлэх зорилготой “Бид нийтийн тээврийнхэн” өдөрлөгийг 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Олон улсын Найрамдал төвд зохион байгуулсан.

Нийтийн тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг үндсэн чиглэлийн үйлчилгээ эрхлэгч 17, таксины үйлчилгээ эрхлэгч нэг нийт 18 ААНБ-ын нийт 175 жолооч болон эмэгтэй албан хаагчид хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцогч 31 нийт 206 хүн оролцсон.

Үйл ажиллагааг Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газар, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор, Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд хамтран зохион байгуулсан.



*Зураг 151. Өдөрлөгийн явцаас*

Ажил үйлсээрээ шалгарсан шилдэг жолооч, ажилтнуудыг Монголын Залуучуудын Холбооны “Хөдөлмөрийн алдар“ , “Тэргүүний залуу“ медаль, Монголын Эмэгтэйчүүдийн холбооны 100 жилийн ойн “Талархал”-аар шагнаж урамшуулав.



*Зураг №152. Шилдэг жолооч нарт шагнал гардуулав.*



*Зураг №153.Өдөрлөгийн үйл явцаас.*

Автотээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан мэдлэг сорих тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр болсон. Тэмцээнд нийт аж ахуйн нэгж, байгууллагуудын нийт 11 багийн 33 албан хаагчид оролцсон.

Тус тэмцээний талаар мэдээ, мэдээлэл 1, видео-3 бэлтгэж хүргэсэн.




*Зураг №154. Мэдлэг сорих тэмцээн*

**Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Автотээвэр 100 жил” сэдэвт шатрын тэмцээн зохион байгуулах ажлын хүрээнд:**

Авто тээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийн дунд шатрын тэмцээнийг зохион байгуулах удирдамж бэлтгэн ерөнхий зохион байгуулагчаар ажилласан.

Шатрын тэмцээнийг 2025 оны 05 дугаар 30-нд зохион байгуулж, нийт 11 байгууллагын 71 хүүхэд оролцож, 2 насны ангиллаар нийт 6 байр эзлүүлж, өргөмжлөл мөнгөн шагналаас гадна эхний хоёр байрт автобусны модель дурсгал болгон өгсөн.





*Зураг №155. Салбарын хүүхдүүд оролцсон шатрын тэмцээн*

**Салбартай танилцах аялал зохион байгуулах ажлын хүрээнд:**

Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийг 2025 оны 06 дугаар сарын 08-ны өдөр нийтийн тээврийн салбартай танилцуулах аяллыг зохион байгуулав.

Нийт 12 аж ахуйн нэгжийн 104 хүүхэд “Зорчигч тээвэр тав” ОНӨААТҮГ-ын баазын үйл ажиллагаатай танилцаж, Хүй долоо худагт болж буй “Уран жолоодлого-2025” тэмцээнийг үзэж сонирхов.





*Зураг №156. Салбартай танилцах аялал*

**Нийтийн тээврийн байгууллагуудын дунд “Уран жолоодлогын тэмцээн” зохион байгуулах ажлын хүрээнд:**

Авто тээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд “Уран жолоодлого-2025” тэмцээнийг 2025 оны 06 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд Хүй долоо худагт амжилттай зохион байгууллаа.

Газрын даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу “Уран жолоодлого-2025” тэмцээнийг олон нийтэд нээлттэй, шударга зохион байгуулах үүднээс бүтэн хоёр өдрийн турш лайв дамжуулалт хийх үүрэг өгсөн.

Энэ дагуу шууд дамжуулалтыг хоёр өдөр чанарын өндөр түвшинд Orgil Media компанийн хамт олонтой хамтран ажилласан.





*Зураг №157. Уран жолоодлого-2025 тэмцээнийг Orgil Media компанитай хамтран зохион байгуулав*

"Уран жолоодлого-2025" тэмцээнийг нийт 5 удаагийн лайваар дамжуулж, нийт 160 гаруй мянган үзэгч үзсэн байна.

Тус тэмцээний лайв дамжуулалтын үеэр оролцогч, зохион байгуулагч, автобус баазын төлөөллөөс нийт 35 богино хэмжээний видео яриа авч, тусад нь тасалж олон нийтэд хүргэсэн.

Уг видео мэдээллийг нийт 218.2 мянган иргэн үзсэн байна.

Тус тэмцээнтэй холбоотой 3 постер бэлтгэж, нийт 42 лайв, видеог нийт 378.2 мянган иргэн үзэж, 1142 шэйр хийсэн байна.



*Зураг №158. Уран жолоодлого-2025 тэмцээнийг шууд дамжуулж, богино хэмжээний видео бэлтгэн хүргэсэн*

**"Байгууллагын 2025 оны аварга" шалгаруулах тэмцээн зохион байгуулах ажлын хүрээнд:**

2025 оны 05 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулсан "Байгууллагын 2025 оны аварга" шалгаруулах тэмцээнд сагсан бөмбөг, гар бөмбөгийн төрөлд оролцсон.




*Зураг №159. Байгууллагын спорт арга хэмжээнд оролцсон*

**"Автотээвэр-Цэцээ гүн 2025" явган аяллыг зохион байгуулах ажлын хүрээнд:**

Автотээврийн салбарын 100 жилийн ойн арга хэмжээг угтсан ажлын хүрээнд "Автотээвэр-Цэцээ гүн 2025" явган аяллыг 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан.

Нийтийн тээврийн салбарын ажилчдын эв нэгдлийг сайжруулах, биеийн тамир спортоор хичээллэх, оюуны алжаалыг тайлах, бие бялдрыг чийрэгжүүлэх, спорт аяллыг сурталчлах, харилцан ойлголцох хамтын харилцааг бэхжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа юм.

Нийтийн тээврийн бодлогын газрын хамт олон энэхүү аяллыг санаачлан зохион байгуулж

"Зорчигч тээвэр нэг" ОНӨААТҮГ

"Зорчигч тээвэр хоёр" ОНӨААТҮГ
"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ
"Зорчигч тээвэр дөрөв" ОНӨААТҮ
"Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ
"Сутайн буянт" ХХК, "Блюбус" ХХК, "Эрдэм транс" ХХК, "ЭМСИД" ХХК, "Трансбус" ХХК, "Үнэгтийн уул" ХХК, "Автобус нэгдэл" ХХК, "Виптакси сервис" ХХК, "Мяралзаа" ХХК-ийн 75 тамирчин оролцож байна. Төв аймгийн Манзуширын хийдээс Цэцээ гүний оргил хүртэл 11 км замыг туулсан юм. Энэхүү явган аялалд 15 байгууллагын 75 тамирчин амжилттай оролцож "Сутайн буянт" ХХК тэргүүлж, дэд байранд "Зорчигч тээвэр нэг" ОНӨААТҮГ гутгаар байранд "Эрдэм транс" ХХК-ийн тамирчид шалгарлаа.







*Зураг №160 "Автотээвэр-Цэцээ гүн 2025" явган аяллыг 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан.*

**"Автотээврийн салбарын аварга шалгаруулах" спортын тэмцээн зохион байгуулах ажлын хүрээнд:**

Монгол Улсад Автотээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулж буй "Автотээврийн салбарын аварга шалгаруулах" спортын наадам 2025 оны зургаадугаар сарын 16-18-ны хооронд Буянт-Ухаа спорт цогцолборт болсон.








**“Автотээвэр-100” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлын хүрээнд:**

Монгол Улсад Автотээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан “Автотээвэр-100” сэдэвт эрдэм шинжилгээний хурал 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр болж тус газрын албан хаагчид оролцлоо.





**“Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээ”-ний хүрээнд:**

Нийслэлийн засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/354 дугаар захирамж “Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээ”-ний хүрээнд Нийтийн тээврийн бодлогын газрын Ачаа тээвэр, авто үйлчилгээний хэлтсийн 6 албан хаагч Хяналт шалгалтын хэлтсийн 30 албан хаагч нар хамтран 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж “Төв бассейнаас Бээжингийн гудамж хүртэл сэлбэ голын баруун талын зам” дагуу 1000 мкв нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэсэн.






*Зураг №161. Их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж буй байдал*

Арга хэмжээ 5.8. Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/33 дугаар захирамж, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын зуухны бүрэн бүтэн байдал, галлагааны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч хориглосон эд зүйлс шатааж буй эсэхэд хяналт шалгалт хийж, судалгаа гаргах, зөвлөмж зөвлөгөө хүргэх ажлыг холбогдох хууль дүрэм, журам, тогтоол,шийдвэр, стандартын хүрээнд хийж гүйцэтгэн илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, арилгуулах зорилгын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд 09:00-18:00 цагуудын хооронд батлагдсан хуваарийн дагуу Баянзүрх дүүргээр судалгаа авч ажилласан.





*Зураг №162. Агаарын бохирдлын судалгаа*

Арга хэмжээ 5.10. Нийслэлийн Засаг бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/132 дугаар захирамжийг хэрэгжүүлэх;

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Скай резорт” ХХК-тай хамтран “Улаанбаатарын өвлийн наадам” арга хэмжээг 02 дугаар сарын 15-16-ны өдөр “Скай резорт” цанын баазад зохион байгуулагдаж, өвлийн улирал, ёс заншил, өв уламжлал, дахин давтагдашгүй өвөрмөц

соёлыг сурталчлан таниулахын зэрэгцээ залуу үедээ өвлүүлэн үлдээх, шинэ тутам хөгжиж буй өвлийн улирлын экстрим спорт, аяллын төрлүүдийг нийслэлчүүддээ таниулах, амралтын өдрүүдийг гэр бүлээрээ аз жаргалтай өнгөрүүлэхэд тус наадмын зорилго оршино. Нийтийн тээврийн бодлогын nгазрын залуус “Улаанбаатар өвлийн наадам”-д амжилттай оролцож алхалтын төрөлд 2-р байр эзэлсэн.



*Зураг №163. Цасны баяр*

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/33 дугаар захирамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны 5 дугаар хэсгийн айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудын зуухны бүрэн бүтэн байдал, галлагааны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгаж заавар зөвлөмж өгч, хяналт шалгалт хийн ажиллаа.



*Зураг №164. Судалгаа хийж буй явцаас*

2025 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Төрийн албаны зөвлөл үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын “Бүтээмж ба шийдэл” мэтгэлцээний IV тэмцээнд нь амжилттай оролцон 5 дугаар байр эзэлсэн.



*Зураг №165. Илтгэлийн тэмцээ*

## НАЙМДУГААР БҮЛЭГ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН САНАЛ.

Нийтийн тээврийн бодлогын газраас дараах ажлуудыг хэрэгжүүлэх саналтай байна. Үүнд:

Тээврийн бодлого, судалгааны хэлтсийн чиг үүрэгт хамаарах үндсэн ажлын хүрээнд 2026 онд доорх ажлуудын хэрэгжилтэд анхаарах;

"Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу тус газрыг корпорацын зарчмаар ажиллах эрх зүйн болон эдийн засгийн боломж, нөхцөлийн талаар судлах;

**Нийтийн зорчигч тээврийн салбарын бодлогын хүрээнд:**

1.Нийтийн тээврийг хөгжүүлэх байгууллагын мастер төлөвлөгөөг боловсруулах сонгон шалгаруулах ажилд анхааран, ажлын явцыг эрчимжүүлэх;

2.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050 бодлогын баримт бичгийн хүрээнд Салбарын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах;

**Тээврийн салбарын стандартын ажлын хүрээнд:**

1.Салбарын хэмжээнд ашиглагдаж буй стандартыг шинэчлэх саналыг гарган холбогдох өөрчлөлтийн саналыг холбогдох хэлтэс, байгууллагуудад тухай бүр хүргүүлэх, санал өгөх;

**Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолын төлөвлөлтийн хүрээнд:**

1.2026 онд Автозамын сангийн хөрөнгөд нийтийн тээврийн үйлчилгээний зогсоол байгуулах хөрөнгийг тусгуулах арга хэмжээ авах;

2.Нийтийн тээврийн зогсоол шинээр байгуулах ажлын сонгон шалгаруулалтын ажилд анхаарч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

3.Эцсийн зогсоолын бие засах газрын асуудлыг шийдвэрлүүлэх, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

**Улаанбаатар хотын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний судалгаа шинжилгээний ажлын хүрээнд:**

1.Хотын зах, шинэ суурьшлын бүсүүдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах;

2.Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлж, шийдүүлэх арга хэмжээ авах;

3.Нийтийн тээврийн төлбөрийн менежментийн систем төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдэж байгаа системийн шинэчлэлийн ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй тээврийн хэрэгслийн цагийн хуваарийг динамик байдлаар боловсруулах талаар идэвх санаачилгатай ажиллах. Төслийг гүйцэтгэгч ICT компанитай хамтарч ажиллах;

4.Шинээр нэвтрүүлж байгаа төлбөрийн менежментийн системийн хүрээнд хийгдэж байгаа Удирдлагын дэд төлөвлөлтийн системд ажиллах чадварыг албан хаагчдад эзэмшүүлэх, системийг нутагшуулахад анхаарч ажиллах;

5.Нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээний төлөвлөлтийг оновчлох систем хөгжүүлэлтийн ажлын сонгон шалгаруулалтын үр дүнд шалгарсан компанитай хамтран ажиллах, мэдээллээр хангах, ажлын явцыг эрчимжүүлэх;

6.Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ төлөвлөлтийг бодит тоон мэдээлэлд үндэслэн боловсруулахад мэдээллийн big data-тай болох замаар өрхийн зорчилтын судалгааг зохион байгуулах, судалгааны тооцооллыг хийж шаардагдах санхүүжилтийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

7.Нийтийн тээврийн үйлчилгээний үйл ажиллагаатай холбоотой хийгддэг судалгаанууд буюу эргэлтийн хугацааны судалгаа, зогсоол хоорондын хугацаа, зорчигч урсгалын судалгаа, эрэлтийн судалгаа, сэтгэл ханамжийн судалгаа, орлогын судалгаа, давхцалын судалгаа,

гудамж замын ашиглалтын хурдны судалгааг 7 хоногоор, 14 хоногоор, сараар, улирлаар, жилээр гарган дүн шинжилгээ харьцуулалтуудыг хийж судалгааны мэдээллийн санг үүсгэх;

**Салбарын эдийн засгийн төлөвлөлт, тооцооллын ажлын хүрээнд:**

1.Нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифын бодит тооцоо судалгааг хийж, цаашид орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан холбогдох хэлтэстэй хамтран танилцуулан шийдвэрлүүлэх;

2.Зорчигчийн хөлс төлөлтөд хяналт тавих байгууллагын судалгаа тайланг шинжлэх, хамтран судалгааны ажил зохион байгуулж шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;

**Мэдээллийн сангийн ажлын хүрээнд:**

1.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний зогсоол, чиглэл, автобусны паркийн байршлын мэдээллийг Arc GIS программд оруулан Нийслэлийн дундын мэдээллийн санд холбох;

2.Систем хөгжүүлэгч байгууллагууд руу хүргүүлсэн хэрэглэгчийн шаардлагуудыг дагуу хөгжүүлэлтийг хийлгэх ажилд хяналт тавих. Чиг үүргийн хамааралтай бусад хэлтсийн ажлыг эрчимжүүлэх;

3.Сургуулийн автобусны үйлчилгээнд ажиллаж байгаа тээврийн хэрэгслүүдийг 100 хувь бүртгэлийн төхөөрөмжтэй болгуулах шаардлагатай. Ажлын гүйцэтгэл үнэн зөв тооцогдоход нөлөөлнө;

4.Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл хэрэгжүүлэгч нэгжтэй хамтран ажиллаж, төслүүдийг эрчимжүүлэх;

5.Нийтийн тээврийн төлбөрийн систем, нийтийн тээврийн удирдлагын дэд системийн хөгжүүлэлт хийгдэх ажилд хяналт тавих;

6.Стандартын шаардлага хангасан дунд багтаамжийн автобус, таксигаар парк шинэчлэлт, паркийн нөхөн хангалт хийсэн байгууллагуудын мэдээллийн санг шинэчлэн бүртгэх;

7.Нийтийн тээврийн үйлчилгээний ptd.ub.gov.mn, tbox.uscc.mn болон бусад системүүдэд бүртгэлтэй жолооч нарын мэдээллийг сар бүр шинэчлэх;

8.Мэдээллийн нэгдсэн сангийн хүний нөөцийн мэдээллийн тулгалтыг хийж, аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн ажилтнаар бүртгэлийг шинэчлүүлэх ажлыг хийх;

**Бусад:**

1.Нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагуудын 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах;

2.Тээвэр зохицуулагч нарын өдөр тутмын хяналт тавьж, ажлыг эрчимжүүлэх;

3.Хүүхэд тээвэрлэх болон ажилчдын автобусны зөвшөөрөл олгодог харилцааг өөрчлүүлэх, зөвшөөрөл гэдэг нэрийг өөрчлөн хуулийн хэлтэс санал гарган хамтран шийдвэрлэх;

4.Сургалт, судалгааны мэргэжлийн байгууллагуудаас төлбөртэй сургалт авах зардлыг шийдвэрлүүлэх, сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах /Зөөврийн компьютер гэх мэт/;

5.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн чиглэлээр сургалтад хамрагдах, мэргэжлийн байгууллагаас нийт ажилтны сургалт авах;

6.Сэтгэл судлал, хүний хөгжил, зан харилцаатай холбоотой мэргэшсэн сургагч эсвэл сэтгэл зүйчтэй болох, сургалтын үйл ажиллагаа явуулахтай холбоотой зардлыг шийдвэрлэх;

7.Сургалтын үйл ажиллагаанд холбогдох хэлтсүүдийн албан хаагчдыг идэвхтэй оролцуулж хамтарч ажилладаг байх;

8.Шугамын үйлчилгээнд ажиллаж буй жолооч нарын цайны цаг богинохон учраас /20 минут/ цайндаа орж чаддаггүй, мөн бие засах газар байхгүй учраас хүндрэлтэй байдаг бөгөөд эцсийн 26 зогсоолыг жолооч нарын эрүүл ахуйн шаардлага хангасан кабсултай болгох;

9.Нийтийн тээврээр зорчигч иргэдийн харилцааны соёлыг дээшлүүлэх талаар нийтийг хамарсан соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах;

10.Ажилд гарахын өмнөх жолооч нарт өгдөг Хөдөлмөрийн аюулгүй байдлын болон тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварчилгааг цахимжуулах;

11.Тээврийн төлөвлөлтийн чиглэлээрх судалгаа, шинжилгээ боловсруулалтыг сайжруулж, чиглэлийн төлөвлөлтийг боловсронгуй болгох;

12.Шугам замд хяналт тавьж буй Хяналт шалгалтын хэлтсийн албан хаагчид, Автотээврийн хяналтын улсын байцаагч нарын ажлыг эрчимжүүлж, чанаржуулах, хариуцлагажуулах;

13.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын дотоодын хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх ажлыг тогтмол хийлгэж, эрчимжүүлэх, үйл ажиллагаанд нь мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, жолооч нарын замын хуудасны бүртгэлд хяналт тавих талаар гэрээнд тодорхой тусгаж, гэрээг шинэчлэн байгуулах, дүгнэхээс өмнө улсын байцаагч нараар асуудлыг нь шийдүүлж дуусгах;

**Ажиллагсдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар:**

1.Автотээврийн хяналтын улсын байцаагчдыг байгууллагаас гэрээ хийн даатгалд хамруулах;

2.Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын байгууллагын эмч нарын үзлэгт байцаагч нараа хамруулж, ажлын байрны дүгнэлт гаргуулж, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн ажлыг хүнд хортой нөхцөлд оруулах асуудалд дэмжлэг үзүүлэх;

3.Залуучуудын мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх чиглэлээр суралцахад нь байгууллагаас тодорхой хувийн мөнгөн дэмжлэг туслалцаа үзүүлэх, олон улсын болон орон нутгийн ижил чиг үүрэгтэй байгууллагуудын ажил байдалтай танилцуулж, туршлага судлуулах ажил зохион байгуулах;

4.Автотээврийн хэрэгслийн жин тонн шалгах явуулын тоног төхөөрөмж болон утааны тортог хэмжих үзлэгийн явуулын автомашин, багаж, тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлж, шалгалтын хүрээг тэлэх;

ТАНИЛЦСАН:

ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ХТҮ6986 9024050915 2117428

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БОЛОРЦЭЦЭГ